



**ПЕТРОМАТАД ХХК-НИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭТ МАТАД-ХХ ТАЛБАР  
ГАЗРЫН ТОСНЫ АШИГЛАЛТЫН ТӨСӨЛ**

**2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧИЛ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БНӨЛӨЛТҮЙН ТАЙЛАМ**

**ГАЗРЫН ТОСНЫ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР. 026  
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР. 2867095/**

Хиная:

Дөрмөд аймгийн Байгаль орчин, ахуйн нөөц, ашиг зориулалтын газрын чөлөөтэй

Н. Сүх-Ялалт

Биеэлэлтийн төлөөлөгчид.

Петроматад ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн дарга:

Гүйрлэлт

Петроматад ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн орлогч  
дарга

С. Наранжаргал

## Агуулга

БҮЛЭГ I.	2024 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	5
1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
2.	2024 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА.....	6
БҮЛЭГ II.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	15
<b>БҮЛЭГ III.</b>	<b>НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>29</b>
БҮЛЭГ IV.	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	35
БҮЛЭГ VI.	ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	40
БҮЛЭГ VII.	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	41
3.	ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	50
БҮЛЭГ VIII.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	56
БҮЛЭГ IX.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....	61
БҮЛЭГ X.	АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ,.....	62
БҮЛЭГ XI.	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	67
ДҮГНЭЛТ	73	
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....</b>		<b>131</b>

## **Тайлангийн зургийн жагсаалт**

Зураг 1. Бүтээгдэхүүн хуваах гэрээт Матад ХХ талбайн байршлын зураг .....	3
Зураг 2. Матад сумын байгаль хамгаалагч талбайн зохион байгуулалтыг тогтоох үеэр.....	
Зураг 3. Өрөмдлөгийн талбайн ерөнхий төлөвлөлт .....	8
Зураг 4. “Нэг замын бодлого”-ыг чанд баримтлан нүүдэл хийгдэж байгаа нь .....	11
Зураг 5. БХГ-т XIX” талбайгаас “Мазаалай-1” төслийн талбайд хүрэх замын зураглал.....	12
Зураг 6. Тоолуурын лац болон гүйлтийг сумын байгаль хамгаалагч шалгаж баталгаажуулж буй байдал	
Зураг 7. Тоолуурын гүйлт 2024.10.20 өдөр .....	
Зураг 8. Техникийн усан хангамжийн худгийн тоолууржуулалт ба баталгаажуулалт (лац), тоолуурын гэрчилгээ	

## **ХАВСРАЛТ**

Хавсралт 1 Улсын бүртгэлийн гэрчилгээ – “Петро Матад” ХХК

Хавсралт 2 “Петро Матад” ХХК – Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

Хавсралт 3 Газар ашиглах зөвшөөрөл

Хавсралт 4 2024 оны БОМТ-ний барьцаа байршуулсан баримт Химийн бодисын тусгай зөвшөөрөл, ашиглах бодисын жагсаалт

Хавсралт 5 БОАЖЯ-аас байгаль орчныг нөхөн сэргээх дансанд байршуулсан төлбөрийн тооцоо нийлсэн тухай баримт

Хавсралт 6 Эскроу дансанд нөхөн сэргээлт, татан буулгалтын барьцаа байршуулсан баримт

Хавсралт 7 Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт

Хавсралт 8 Ус ашиглуулах дүгнэлт – 2024 он

Хавсралт 9 Ус ашиглах зөвшөөрөл

Хавсралт 10 Ус ашиглах гэрээ

Хавсралт 11 . Худгийн паспорт

Хавсралт 12. Ус ашигласны төлбөрийн баримт

Хавсралт 13: Кемпийн хатуу хог хаягдлын цэг тогтоосон захирамж

Хавсралт 14. Кемпийн ахуйн хог хаягдлыг зохицуулах гэрээ

Хавсралт 15 Ахуйн хог хаягдлын зөөвөрлөсөн бүртгэл

Хавсралт 16: Ахуйн хог хаягдлын төлбөр төлсөн баримт

Хавсралт 17: Ахуйн хог хаягдал тээвэрлэх гэрээ

Хавсралт 18: Ахуйн хог хаягдал тээвэрлэсэн хөлсийг төлсөн баримт

Хавсралт 19. Ахуйн бохир ус нийлүүлэх гэрээ

Хавсралт 20. Ахуйн бохир ус зөөвөрлөж нийлүүлсэн бүртгэл

Хавсралт 21. Ахуйн бохир усны төлбөр төлсөн баримт

Хавсралт 22. Ахуйн бохир ус тээвэрлэх гэрээ

Хавсралт 23. Ахуйн бохир ус тээвэрлэсэн төлбөрийн баримт

Хавсралт 24. “Нэг замын бодлого”

Хавсралт 25. Галын аюулгүй байдлын дүгнэлт

Хавсралт 26 Химийн бодисын агуулахын байршил тогтоосон захирамж

Хавсралт 27 Химийн бодисын агуулахын дүгнэлт

Хавсралт 28 Химийн бодисын тусгай зөвшөөрөл

Хавсралт 29 Өрөмдлөгийн гэрээтийн химийн бодисын ханган нийлүүлэгч компанитай байгуулсан Химийн бодисоор хангах, үлдэгдэл химийн бодис, уут сав шуудайг талбайг зөөвөрлөх “Турвалсан гэрээ”

Хавсралт 30 Аюултай хог хаягдал зайлуулах эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрөл

Хавсралт 31 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 2024 он – Гүйцэтгэгч “МСЗБ” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгүүлэх гэрээ

Хавсралт 32 Яаралтай үед өвчтөн шилжүүлж тээвэрлэх, дээд шатны эмнэлгийн тусламж үзүүлэх төлөвлөгөө

Хавсралт 33 Эрүүл мэндийн яаралтай нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө

Хавсралт 34 Цацрагийн эх үүсвэрт хяналт тавьж ажилласан тухай тайлан

Хавсралт 35 Тэсэлгээний гэрээт компанийн гэрчилгээ

Хавсралт 36 Тэсэлгээний гэрээт компанийн хяналтын хуудас

Хавсралт 37 Дүйцүүлэн хамгааллын хэрэгслийг хүлээлцсэн акт


## БҮЛЭГ I. 2024 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Петро Матад” ХХК нь БХГ-т Матад-XX талбайд 2007 оноос эхлэн газрын тосны хайгуул судалгааны ажил хийж байна. Энэ хугацаанд талбайн хэмжээнд хүндийн хүч, соронзон орны судалгаа, 1778 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 133.6 км<sup>2</sup> талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, хайгуулын 14 цооног өрөмдөж нийт 120 гаруй сая ам доллар зарцуулж ирсэн ба дээрх судалгааны үр дүнд түшиглэн, тус талбайн 213.92 км<sup>2</sup> талбайг сонгон авч, газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөн МУ-ын Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 7-р сарын 02-ны өдрийн А/186 дугаар тушаалаар газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийг авсан.

Орд ашиглалтын эхний үе шат (2024-2028 он)-д дан цооногоор олборлох системийг ашиглах бөгөөд олборлосон тосыг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн газрын тос экспортлох сайжруулсан замаар дамжуулан, “Тосон-уул XIX” талбайд байрлах тос цуглуулах, цэвэршүүлэх нэгдсэн байгууламжид авто тээврээр хүргэхээр төлөвлөсөн.

Хайгуулын талбайн байршлыг Зураг 1-д харуулав.



Зураг 1 Бүтээгдэхүүн хуваах гэрээт Матад XX талбайн байршил

## 2. 2024 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/ -т газрын тосны ашиглалтын Матад-XX талбайд 2024 онд газрын тосны орд ашиглалтын хүрээнд Дорнод аймгийн Матад сумын Эрдэнэбадрах багийн нутагт 213,92 км<sup>2</sup> талбайг хамарсан 3 хэмжээст чичирхийллийн хайгуул судалгааны ажил хийх, олборлолтод шилжүүлэхээр 3 цооног шинээр өрөмдөж, туршилт хийх, 2019 онд өрөмдсөн Цэн тогоруу -1 цооног болон шинээр өрөмдөх 3 цооног, нийт 4 цооногт цооногийн шингэн хагалбарын ажил, цооногийн гүйцээлт хийн, олборлолтод шилжүүлэх, цооног олборлолтод шилжүүлэхтэй холбогдсон бүтээн байгуулалтын ажлуудыг хийхээр төлөвлөсөн байсан.

2024 оны тайлант хугацаанд (тайлангийн хугацааг 2024 оны 10-р сарын 20-ны өдрөөр тасалбар болгон тайланг боловсруулав.) 3 хэмжээст чичирхийллийн хайгуулын судалгаа хийгдээгүй, 2019 онд өрөмдөж, туршилтын ажил хийгдээд байсан Цэн тогоруу -1 цооногт шингэн хагалбар, цооногийн гүйцээлтийн ажил хийгдэж, олборлолтын тоног төхөөрөмж суурилууллаа. Цэн тогоруу-2 цооног болон Мазаалай-1 цооногийг шинээр өрөмдөв. Тайлант хугацаанд БХГ-т МАТАД XX талбайгаас газрын тосны олборлолт хийгдээгүй.

Цэн тогоруу-2 (Heron-2) цооногийн өрөмдлөгийн талбайг бэлтгэх, өрөмдлөгийн тоног төхөөрөмж болон хээрийн ангийг нүүлгэн авчрах, тэдгээрийг угсарч суурилуулах ажлыг 2024 оны 8-р сарын 27-оос 2024 оны 9-р сарын 07-ны хооронд хийж гүйцэтгэсэн. 2024 оны 9-р сарын 08-ны өдрөөс эхлэн тус цооногийг өрөмдөж эхэлсэн ба нийт 24 хоногийн хугацаанд 2908 метр өрөмдөж 2024 оны 10-р сарын 02-ны өдөр дууссан. Өрөмдлөгийн ажил дуссаны дараа өрөмдлөгийн тоног төхөөрөмж болон хээрийн ангийг буулгах ажлыг 2024 оны 10-р сарын 03-аас 08-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний дагуу Цэн Тогоруу-2 цооногт хийгдэх перфораци, шингэн хагалбар, цооногийн туршилтын ажлуудыг гүйцэтгэх ажлыг баг 2024 оны 10 сарын 03-ны өдрөөс эхлэн нүүж ирэн, тоног төхөөрөмжөө угсарч суурилуулсан. 2024 оны 10-р сарын 20-ны байдлаар тус цооногт перфораци болон шингэн хагалбарын ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Цооногийн туршилтын ажлыг 2024 онд багтаан гүйцэтгэхээр үргэлжлүүлэн ажиллаж байна.

“Мазаалай - 1” (Gobi bear-1) хайгуулын цооногийн өрөмдлөгийн талбайг бэлтгэх, өрөмдлөгийн тоног төхөөрөмж болон хээрийн ангийг нүүлгэн авчрах, тэдгээрийг угсарч суурилуулах ажлыг 2024 оны 9-р сарын 6-аас 2024 оны 9-р сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Тус цооногийг 2024 оны 09 дүгээр сарын 21-ны өдрөөс эхлэн, нийт 14 хоногийн хугацаанд 1805 тууш метр өрөмдөж, 2024 оны 10 дүгээр сарын 05-ны өдөр дууссан. Өрөмдлөгийн ажил дуссаны дараа өрөмдлөгийн тоног төхөөрөмж болон хээрийн ангийг буулгах ажлыг 2024 оны 10-р сарын 05-аас 12-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Өрөмдлөгийн явцад тус цооногт хийгдсэн хэмжилт, судалгааны ажлын үр дүнг үнэлсний дараа энэхүү цооногт шингэн хагалбар, цооногийн туршилт гэх зэрэг дараа дараагийн ажлуудыг гүйцэтгэх эсэхийг шийдвэрлэхээр 2025 он хүртэл цооногийг түр хааж, талбайд харуул томилсон.

### Хүснэгт 1 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил болон гүйцэтгэсэн ажил

Ажлын хөтөлбөр	3D чичирхийллийн судалгаа	Өрөмдлөг		Цооногийн туршилт	Шингэн хагалбар болон цооног гүйцээлтийн ажил	Олборлолт	Бүтээн байгуулалт	
		Олборлолтын цооног	Ус шахалтын цооног				Дан цооногоор олборлох байгууламж	Тос цуглуулах, цэвэршүүлэх нэгдсэн байгууламж
Төлөвлөгөөт ажлын хэмжээ	200.41 км <sup>2</sup>	3	0	3	4	4	Дан цооногоор олборлох байгууламжийг 4 цооног дээр суурилуулах	-
Гүйцэтгэсэн ажлын хэмжээ	-	2	0	2	2	-	1 цооног дээр тоног төхөөрөмж суурилуулсан	-

### Хүснэгт 2 Өрөмдлөгийн цэгийн координат

Цооногийн нэр	Уртраг	Өргөрөг	Тайлбар
Цэн тогоруу -1	116° 07' 29.30" E	46° 49' 40.90" N	2019 онд өрөмдсөн.
Цэн тогоруу -2	116° 07' 26.86" E	46° 49' 15.02" N	Шинээр өрөмдсөн.
Мазаалай -1	116° 7' 38.340"	46° 49' 51.610" N	Шинээр өрөмдсөн.


Газар ашиглалтыг зохион байгуулахдаа аль болох бага зай, талбай эзлүүлэн зохистой байршуулах, нөгөө талаар байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, өрөмдлөгийн талбайн хашаанаас гадагш ямарваа нэг үйл ажиллагаа явуулахгүй байх зэрэг нөхцлийг хангаж ажиллахыг зорьсон. Өрөмдлөгийн талбайн бэлтгэл ажлыг ажил эхлэхээс өмнө өрөмдлөгийн гэрээт, өрмийн талбайн бэлтгэл ажил гүйцэтгэх гэрээт компаниудтай мөн Матад сумын байгаль хамгаалагчийн хамт өрөмдлөгийн тогтоосон цэгт урьдчилан ирж танилцан кемп байгуулах газрыг тухайн газрын газарзүйн байрлал, байгалийн нөхцөл байдалтай уялдуулан сонгож, мөн өрмийн талбайг аль болох газрын гадаргын эвдрэл бага байлгахад анхааран зохион байгуулалтыг хийж харилцан ярилцаж тохиролцсон. (Зураг 5)





**Зураг 2 Матад сумын байгаль хамгаалагч талбайн зохион байгуулалтыг тогтоох үеэр**

Өрөмдлөгийн бүх үйл ажиллагааг 3 га талбайд багтаан явуулсан. Өрөмдлөгийн талбайг зохион байгуулахдаа газар хөндөх болон хөндөхгүйгээр үйл ажиллагаа явагдах талбайг ялгаж, өрмийн шингэн хаягдлын сан, химийн бодисын агуулах, бохирын септик байрлуулсан талбай, ахуйн болон аюултай хог хаягдал цуглуулах цэгийн байршил тус бүрийг тогтоож, Матад сумын засаг дарга захирамжилсан.



**Зураг 3 Өрөмдлөгийн талбайн ерөнхий төлөвлөлт**

Тайлбар: Газрын тос, шатдаг хийн олон улсын холбооны удирдамжийг иш болгон баримталж буй өрөмдлөгийн талбайн загва

### Хүснэгт 3 Өрөмдлөгийн талбайн газар ашиглалт ба зориулалт

№	Газар ашиглалтын төрөл	Эзлэх талбайн хэмжээ, га
1	Автомашинны зогсоол	0.18
2	Ажилчдын байр, амьдрах орчин	0.54
3	Өнгөн хөрс болон жорлон, бохирын цооног (газар дор байршуулах бусад зүйлс) байрлах хэсэг	0.18
4	Өрөмдлөгийн тоног төхөөрөмжүүд (хоолой, дизель үүсгүүр, бусад) байрлах талбай	2.1
<b>Нийт</b>		<b>3.0</b>

Нэг замын зааварчилгааг зураглан боловсруулж Матад сумын засаг даргад танилцуулан төсөл хэрэгжих хугацаанд энэхүү замаар тээвэр, ложистикыг зохицуулах талаар харилцан зөвшилцөж, нэг замын маршрутыг дагаж мөрдөж байгаад хяналт тавьсан. Үүнд: гэрээт гүйцэтгэгч болох Ди Кю И ХХК-наас тухай бүр тээвэр хийгдэх төлөвлөгөөг гаргуулан авч төслийн талбай хүртэл тогтоосон маршрутын дагуу зорчиж байгаад хяналт тавьсан.



**Зураг 4 “Нэг замын бодлого”-ыг чанд баримтлан нүүдэл хийгдэж байгаа нь**

Хавсралт ххх Петро Чайна компанийн БХГ-г XIX талбайгаас “Цэн тогоруу -1” ,“Цэн тогоруу-2” болон “Мазаалай-1” талбай хүрэх “Нэг замын бодлого”



**Зураг 5 БХГ-т XIX” талбайгаас “Мазаалай-1” төслийн талбайд хүрэх замын зураглал**

2019 онд өрөмдсөн Цэн тогоруу-1 цооногийн хувьд 2024 оны 7 сарын 18 аас 8 дугаар сарны 15 ны хооронд хугацаанд шингэн хагалбар, цооногийн гүний олборлолтын тоног төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэн, 10 дугаар сард дан цооногоор олборлох системийг ашиглах үеийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулах ажил хийгдэж байна. Суурилуулсан тоног төхөөрөмжийн жагсаалтыг хүснэгт 4-т нэгтгэв.

#### Хүснэгт 4 Цэн тогоруу-1 цооногт суурилуулсан олборлолтын цооног ил болон далд төхөөрөмжүүд

Д/д	Тоног төхөөрөмж		Төрөл / Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
	Төрөл	Тоног төхөөрөмжийн нэр			
1	Сүмбэн бүлүүрт шахуурга	Дам нуруут төхөөрөмж	СҮҮ10-3-37НВ	Ширхэг	1
2		Гүний шахуурга	38ТН6.7-1.2-0.6	Ширхэг	1
3		Сүмбэ	22.23 мм, 7,62 м, НҮ	Метр	2500
4		Тос өргөгч яндан	73 мм	Метр	2500
5	Дизель генератор (Цахилгаан үүсгүүр)	Цахилгаан үүсгүүр агуулах байр	20 тоннын контейнер	Ширхэг	1
6		Цахилгаан үүсгүүр	100-200 кВт	Ширхэг	1
7	Тос хадгалах сав	Тос хадгалах сав	50-60 м <sup>3</sup>	Ширхэг	2

#### Ус ашиглалт:

Буйр нуур Мэнэнгийн талын сав газрын захиргаанаас олгосон №25 тоот “Усны дүгнэлт”, Дорнод аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас олгосон №А/07 тоот “Ус ашиглах зөвшөөрөл”, Дорнод аймгийн Матад сумын засаг даргатай 2024 оны 4-р сарын 29-ний өдөр байгуулсан “Ус ашиглах гэрээ”-ний дагуу Матад сумын нутаг дэвсгэрт 2009-10-28 өдөр “Эрдэнэдрилинг” ХХК-ий гаргасан 270 м гүнтэй, 5 л/с ундаргатай гүний худгаас технологийн ус хангамж болон хээрийн кемпийн ахуйн хэрэгцээний усыг зөөврөөр авч ашигласан. Ундны усанд савласан ус зөөврөөр ашигласан.

Гүний худагт усны тоолуур суурилуулж, хяналтын лац ломбо тавьж баталгаажуулан ашигласан. Тоолуурын заалт болон хяналтын лацанд Матад сумын байгаль хамгаалагч О. Оюунжаргал, Буйр нуур Мэнэнгийн талын Сав Газрын захиргааны дарга Ш. Хангарьд болон тус газрын холбогдох мэргэжилтнүүд, Матад сумын татварын байцаагч Х. Ганчимэг нар хяналт тавьж ажиллав. Өрөмдлөг, шингэн хагалбарын үйл ажиллагаа, тоосжилт дарах үүднээс зам талбайн услагаа хийхэд хэрэглэсэн ус болоод ахуйн хэрэгцээнд ашигласан усны хэмжээг тогтмол бүртгэлжүүлж ажиллав. 2024 оны 10 сарын 20-ны өдрийн байдлаар төслийн үйл ажиллагаанд “Цэн тогоруу-1, Цэн тогоруу- 2 болон “Мазаалай-1” талбайд нийт 1880 м3 ус ашиглаж, ус ашигласны төлбөрт 3,895,360 төгрөг төлсөн.




 СТАНДАРТ,  
 ХАМГААГАХ ГҮЙЛТ  
 ГАЗАР

**УСНЫ ТООЛУУРЫН  
 БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**  
 № ЭУ ...1611807...

(Хэрэглэгчийн нэр) .....-Д  
 ашиглаж байгаа ..... хэргийн загварын ..... №/Ц  
 хэмжээг хязгаартай ..... мм-ийн голчтой № .....-ын  
 кадуун, хүйтэн усны тоолуурыг № ..... дээр ..... ачаар битүүжилж  
 (Доогуур зурал) .....  
 2024 оны 05-р сарын 27-ны өдөр хүртэл улсын  
 баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: ..... 0 .....

Лабораторийн тэмдэг .....  
 2024 оны 05-р сарын 27-ны өдөр  
 Улсын метрологийн  
 газрын тусгай тэмдэг

Зураг 6 Тоолуурын лац болон гүйлтийг сумын байгаль хамгаалагч шалгаж баталгаажуулж буй байдал

Зураг 7 Тоолуурын гүйлт 2024.10.20 өдөр

Зураг 8 Техникийн усан хангамжийн худгийн тоолууржуулалт ба баталгаажуулалт (лац), тоолуурын гэрчилгээ

БҮЛЭГ II. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Хүснэгт 5 Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлсэн байдал
<b>Агаар орчин</b>		
<p>1.Тээврийн хэрэгсэл зорчих нэгдсэн маршрут буюу <b>НЭГ ЗАМЫН БОДЛОГО</b> баримтлах, чанд мөрдүүлэх, тэмдэглэгээ байршуулах</p>	<p>Гэрээт гүйцэтгэгч: “Мон баг” ХХК Гэрээт гүйцэтгэгч: Ди Кю И ХХК  Хяналт тавин хамтран ажиллагч: “Петроматад” ХХК</p>	<p>Нэг замын маршрутыг төслийн талбай бүрээр зураглаж, Матад сумын засаг даргад танилцуулж, төслийн турш Петроматад компани болон гэрээт, туслан гүйцэтгэгчид мөрдөж ажилласан. “Цэн тогоруу-№, Цэн тогоруу-2, Мазаалай-1 төслийн талбай тус бүрийн Нэг замын батлагдсан маршрутын зураглал”-ыг /Хавсралт -аас үзнэ үү/.</p>  <p>Маршрутын зааварчилгааг өгч, хяналт тавьж ажиллаж буй байдал</p>





		 <p data-bbox="860 884 1682 916">Нэг замын маршрутаар хээрийн ангийн нүүдэл явагдаж байгаа нь</p>
2.Хурдны тэмдэглэгээ	хязгаарлалтын	Өрөмдлөгийн талбай кемп хоорондох зам дагуу хурдны хязгаарлалтын тэмдэг байрлуулан техникийн хөдөлгөөний улмаас агаар орчинд тоосжилт үүсэх нөхцлийг бууруулах арга хэмжээ авсан.

			
<p>3.Машин тоног төхөөрөмжийн техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж, агаарт үзүүлэх нөлөөллийг бага байлгах</p>	<p>“Петроматад” ХХК</p>	<p>Хурдны хязгаарын тэмдэг байрлуулсан байдал</p>	<p>Тээврийн хэрэгслийн өдөр тутмын болон 7 хоног тутмын, 3 сар тутам болон жил бүрийн тээврийн хэрэгслийн үзлэгт машиныг бүрэн хамруулав.Агаар бохирдуулсан татварыг зохих журмын дагуу улсад төлсөн.</p>
<p>4.Агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэн тайлагнах</p>		<p>Матад ХХ талбайд ажил эхлэхээс өмнө 2024 оны 6-р сарын 06-09-ний хооронд эхний шат, өрөмдлөгийн ажил явагдаж байсан үед 2024 оны 9-р сарын 6-9-ний хооронд хоёр дахь шатны Агаар орчны хяналт шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллага болох Эм И Си Эс Зэт Би ХХК гэрээгээр хийж гүйцэтгэв. (Орчны хяналт шинжилгээний ажлын тайланг энэхүү тайланд бүрэн эхээр хавсаргав).</p>	

**Хүснэгт 6 Гадаргын ба газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлсэн байдал
<b>Гадаргын болон газрын доорх усан орчин</b>		
<p>5.Ахуйн бохир цуглуулах хар саарал усны танк, эсвэл септик системийг байгалийн нөхцөл төслийн бүтээн байгуулалттай тохируулан суурилуулна.</p>	<p>“Петроматад” ХХК</p>	<p>Ахуйн шингэн хаягдал болох хар, саарал усыг бохирын септик танк байрлуулан, цуглуулж, танкыг тогтмол суллан Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын цэвэрлэх байгууламж руу зөөж байсан. Тиймээс хөрсөнд ахуйн бохирос ямар нэгэн бохирдол төсөл хэрэгжих хугацаанд үүсээгүй. Шугам хоолойд гэмтэл гарч хөрс бохирдуулсан зөрчил гараагүй. Бохир ус зөөвөрлөлтийн бүртгэлийг <b>Хавсралт 17-оос үзнэ үү.</b></p>   

<p>6.Ахуйн болон технологийн усны үр ашиггүй алдагдлаас сэргийлэх тоолуурын ашиглалт, заалтад хяналт тавих</p>	<p>Гэрээт гүйцэтгэгч: “Ди Кю И” ХХК</p> <p>Кемпийн гэрээт гүйцэтгэгч Дорнын гүүр ХХК</p> <p>Хяналт тавин хамтран ажиллагч: “Петроматад” ХХК</p>	<p>Баталгаат, хяналтын лацтай тоолуур суурилуулж, Матад сумын байгаль хамгаалагч, Буйр нуур Мэнэнгийн талын Сав газрын захиргаа болон Матад сумын улсын татварын хяналтын байцаагч нар ус ашиглалт, тоолуурын заалт, лацанд хяналт тавьж ажилласан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>Хяналтын лацтай тоолуур Буйр нуур Мэнэнгийн талын сав газрын захиргаанаас талбайд хийгдсэн хяналт шалгалт</p>
<p>7.Усан орчны чанарын хяналт шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэн тайлагнах</p>	<p>Гэрээт гүйцэтгэгч: Эм Си Эс Зэт Би ХХК</p>	<p>Орчны хяналт шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагаар 2 удаа хийж гүйцэтгүүлсэн ба тайланг энэхүү тайланд бүрэн эхээр хавсаргасан.</p>  <p>Усан орчинд хийх хяналтын дээж авсан байдал</p>

8. Газрын тос асгаралтын үед авах хариу арга хэмжээ төлөвлөгөөтэй байх энэхүү төлөвлөгөөг хариуцан хэрэгжүүлэх инженер техникийн ажилчдыг дадлагажуулах, энэ үед ашиглагдах багаж тоног төхөөрөмжтэй харьцах ажилчдад практик сургалт зохион байгуулах, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллана



“Петроматад”  
ХХК

Газрын тосны асгартын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж, мөрдөж ажилласан. Асгаралтаас сэргийлэх иж бүрдлийг хангаж, асгаралт үүссэн үед авах арга хэмжээний сургалтыг мөн зохион байгуулсан.

Хавсралт ххх -ээс Асгаралтын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө болон сургалтын материалыг лавлана уу.



Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлсэн байдал
<b>Хөрс</b>		
<p>9.Газрын гадаргын эвдрэлийг аль болох бага хэмжээнд байлгахад тоног төхөөрөмж суурилуулалт болон түр зуурын кемп дэх төлөвлөлт зохион байгуулалтыг хийнэ</p>		<p>Цэн тогоруу-2, Мазаалай-1 цооногийн төслийн үйл ажиллагаа явагдах өрмийн талбай, хээрийн кемпийг тус бүр 3 га талбайд багтаан явуулахаар газар зохион байгуулалтыг хийсэн.</p> 
<p>10.Ил задгай ахуйн хог хаягдал хаяхаас сэргийлэн кемпэд ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байршуулах</p>	<p>“Ди Кю И” ХХК Кемпийн үйлчилгээний гэрээт гүйцэтгэгч: Дорнын гүүр ХХК Хяналт тавин хамтран ажиллагч: “Петроматад” ХХК</p>	<p>Кемпийн талбайд, гал тогоо, шаардлагатай цэгүүдэд ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байршуулан, ил задгай хог хаягдахаас урьдчилан сэргийлсэн. Хогийг цаг тухайд нь Матад сумын хогийн цэгт гэрээгээр тээвэрлэн хүргэсэн. Хавсралт: Хог ачилтын бүртгэл</p>   





<p>11.Өрөмдлөг, хаягдлын сан байгуулах талбайн шимт хөрсийг тусад нь авч хадгалан цооног хаах битүүмжлэх, хаягдлын сангийн нөхөн сэргээлтэд дахин ашиглах зориулалтаар шимт хөрсний овоолго хийнэ</p>	<p>Өрмийн талбайн бэлтгэл ажлын гүйцэтгэгч Монбаг ХХК,  Хяналт тавьж ажилласан: Ди Кю И, Петроматад</p>	<p>Өрмийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд өрмийн тоног төхөөрөмж суурилуулах талбай, өрмийн шингэн хаягдын сан байгуулах талбай, ахуйн бохир ус цуглуулах сав байрлуулах цэгүүдэд хөрс хуулалтын ажил хийгдсэн. Энэхүү хөрсийг өрөмдлөгийн талбайд стандартын дагуу шимт хөрс, шимэрхэг хөрсөөр тусад нь ялгаж, овоолго хийн, самбар байршуулан хадгалсан.</p> 
<p>12.Газрын тосны асгаралтын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх</p>	<p>Өрмийн талбайн бэлтгэл ажлын гүйцэтгэгч Монбаг ХХК,  Хяналт тавьж ажилласан: Ди Кю И, Петроматад</p>	<p>Өрөмдлөгийн талбайд шатахуун хадгалах танк, тээврийн хэрэгслийг зогсоож байрлуулах талбайд хөрсөнд шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлж геомембран дэвсэж бэлтгэсэн талбайд байрлуулж байсан.</p> 

**Хүснэгт 7 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлсэн байдал
<b>Ургамлан нөмрөг</b>		
<p>13.Өрөмдлөгийн ажлын талбай буюу түр суурингийн ургамлан бүрхэвчийн суурь судалгааг нягталж, ховор болон устаж болзошгүй зүйл байгаа эсэхийг тогтоох, нөлөөлөл аль болох бага үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх.</p>	<p>Гэрээт гүйцэтгэгч: “Ди Кю И” ХХК</p> <p>“Петроматад” ХХК</p>	<p>ОХШ-ний мэргэжлийн байгууллагын судалгаа болон төслийн талбайд өмнө хийгдсэн байгаль орчны суурь судалгаануудын дүн, нарийвчилсан үнэлгээний дүнг нягтаа. Мониторингийн судалгаагаар төслийн талбайд ховор зүйлийн “Урал чихэр өвс”, унаган ургамал болох “Цагаан хунчир”, Монголд байгаа завсрын унаган ургамал болох “Жижиг навчит харгана” зүйл ургамалыг судлан тогтоосон. Зөвшөөрөгдсөн маршрутаас бусад зам талбай ашиглахыг хориглож, хяналт тавьж ажиллалаа. Төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байлгах, байгаль хамгаалах сургалтыг зохион байгуулсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;"> <div data-bbox="638 715 981 1088"> <p style="background-color: #92d050; padding: 2px; margin-bottom: 2px;">ХОВОР УРГАМАЛ</p>  </div> <div data-bbox="996 715 1563 1088"> <p style="background-color: #92d050; padding: 2px; margin-bottom: 2px;">МОНГОЛЫН УНАГАН (ЭНДЕМИК) УРГАМАЛ</p>  </div> <div data-bbox="1579 715 2027 1088"> <p style="background-color: #92d050; padding: 2px; margin-bottom: 2px;">МОНГОЛД БАЙГАА ЗАВСРЫН УНАГАН (К)</p>  </div> </div>




<p>14.Хууль бусаар байгалийн ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг түүх, тээвэрлэх, ашиглахыг хориглох, зөрчил илэрсэн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэн, шаардлагатай арга хэмжээг авах (харьяа орон нутгийн байгаль орчны газар, байгаль орчны байцаагчид мэдэгдэх)</p>		<p>Хууль бусаар байгалийн ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг түүх, тээвэрлэх, ашиглахыг хориглох, зөрчилөөс сэргийлэх талаар төслийн талбайд хийгдсэн байгаль орчны мэдээлэл хүргэх сургалтаар зааварчилгаа өгсөн. Хууль бусаар ургамал, түүхий эд түүх, бэлтгэх, амьтан агнах зөрчил гаргаагүй.</p>  
<p>15.Ургамлан бүрхэвчийн мониторингийн судалгаа хийх</p>	<p>Мэргэжлийн байгууллага</p>	<p>Талбайд орчны хяналт шинжилгээний мониторингийн ажлыг 2024 оны 6-р сард, 2024 оны 9-сард мэргэжлийн байгууллагаар тус тус хийж гүйцэтгүүлсэн.</p>

				
				
<p>Ургамлын бичиглэл хийж буй нь</p>				

**Хүснэгт 8 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт**

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлсэн байдал
<p><b>Амьтны аймаг</b></p>		

<p>16.Ашиглалтын талбайн орчмын амьтдын судалгааг хийх</p>	<p>Орчны хяналт шинжилгээний ажил мэргэжлийн байгууллага,  Петроматад ХХК</p>	<p>Петроматад ХХК нь БХГ-т Матад ХХ талбайд нийт 7 удаагийн БОННУ, БОННУ-ний нэмэлт тодотголыг байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий байгууллагуудаар хийлгэсэн. Эдгээр БОННУ-ний ажлын хүрээнд Матад ХХ талбай дахь амьтны аймгийн талаарх судалгааг мэргэжлийн судлаачид хийж ирсэн. Матад ХХ талбайн Орд Ашиглалтын БОННУ-г 2020 онд Хатан далай ХХК, 2024 онд БОННУ-д химийн бодисын нэмэлт тодотголыг Эко Натур ХХК хийж, тайланг Дорнод аймгийн Байгаль орчны газар болон Матад сумын ЗДТГ-т хувийг хүргүүлсэн.</p>
<p>17.Ашиглалтын талбайн нутаг дэвсгэр дэх зэрлэг ан амьтдыг хамгаалах үүднээс, ховор болон ач холбогдол бүхий амьтдын талаарх мэдээлэл /фото зураг, биологийн ач холбогдол, агнах, худалдаалахыг хориглох тухай хуульчилсан байдал г. м./ өгөх, боловсрол олгох сургалт ажиллагсадад зохион байгуулах.</p>	<p>Петроматад ХХК  Гэрээт гүйцэтгэгч: “Ди Кю И” ХХК</p>	<p>Хууль бусаар байгалийн ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг түүх, тээвэрлэх, ашиглахыг хориглох, зөрчил гаргахгүй байх талаар төслийн талбайд хийгдсэн байгаль орчны мэдээлэл хүргэх сургалтаар зааварчилгаа өгсөн. Энэ төрлийн зөрчил гаргаагүй.</p> <p>Хавсралт Сургалтын бүртгэлийн хуудас болон сургалтын материал</p> <p><b>Ургамал амьтан хамгаалал</b></p> <p>Үйл ажиллагааны талбайд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ан хийх</li> <li>• Байгалийн ургамал, ховор, нэн ховор ургамал тэдгээрийн үр, эрхтнийг хууль бусаар түүх, худалдах, хадгалах, бэлтгэх, худалдан авах, тээвэрлэх, боловсруулах,</li> <li>• Тэжээвэр амьтан тэжээх, байлгахыг хориглоно</li> </ul> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">   </div> <p style="text-align: right;"><small>10</small></p>

<p>18.Хууль бусаар байгалийн ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг түүх, тээвэрлэх, ашиглахыг хориглох, зөрчил илэрсэн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэн, шаардлагатай арга хэмжээг авах (харьяа орон нутгийн байгаль орчны газар, байгаль орчны байцаагчид мэдэгдэх)</p>		<p>Зөрчил гаргаагүй.</p>
<p>19.Төсөл хэрэгжих талбайн ан амьтдын талаар мэдээлэл судалгааг орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хийх</p>		<p>Төсөл хэрэгжих талбайн орчмын амьтны ажиглалт судалгааны ажлыг өрөмдлөгийн талбайн орчимд 2024 оны 6-р сард, 9-р сард орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. ОХШ-ний тайланг бүрэн эхээр Хавсралт 30, 31, 32 үзнэ үү.</p>



Төслийн талбайд ажиглагдсан, тааралдсан зарми амьтдын зураг

### БҮЛЭГ III. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

#### Хүснэгт 9

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн арга ХЭМЖЭЭ	Хариуцах эзэн	Хэрэгжүүлсэн байдал
<b>Нөхөн сэргээлтийн ажил</b>		
<p>1.Сейсмийн хайгуулын талбай</p> <p>Хайгуулын ангийн кемпийн талбай орчимд кемп буусны дараа ахуйн бохир усны септик танк байршсан нүх зэргийг буцаан булах зэрэг тухайн орчны цэвэрлэгээ тохижилтын ажил хийж гүйцэтгэнэ.</p>	Нөхөн сэргээлтийн ажлын гэрээт компани, Петроматад ХХК	2024 онд чичирхийллийн хайгуулын судалгаа явагдаагүй тул хайгуулын судалгаа хийгдсэн талбайг нөхөн сэргээх шаардлага үүсээгүй.
<p>2.Өрөмдлөгийн талбайн нөхөн сэргээлт:</p> <p>Үүнд: өрөмдлөгийн шингэн хаягдлын сан, ахуйн шингэн хаягдлын нүх, тоног төхөөрөмж байрласан талбай, үйл ажиллагааны улмаас талхлагдсан талбай Өрөмдлөгийн талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг тухайн цооногт хийгдэх бүх туршилт, судалгаа, шингэн хагалбарын ажлууд хийгдэж дууссаны дараа гүйцэтгэнэ. Олборлолтын цооногийн талбайд олборлолтын тоног төхөөрөмжийг суурилуулсны дараа техникийн нөхөн сэргээлтийн ажил хийнэ.</p>		<p>Цэн тогоруу-2 болон Мазаалай-1 цооног өрөмдлөгийн талбайн газар ашиглалтыг газар хөндөгдөх болон үл хөндөгдөн талбайгаар ангилан үйл ажиллагаа явагдах талбайн байршил тус бүрийн координатыг тэмдэглэсэн.</p> <p>Мазаалай -1 талбайд 10-р сарын 02 ны өдөр өрөмдлөгийн ажил дуусч, 10 сарын 5-ны өдөр өрөмдлөгийн талбай дахь тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлж, Мазаалай -1 өрөмдлөгийн кемпийн талбайд байршуулсан тоног төхөөрөмж, хээрийн ангийн сууц байгууламжуудыг нүүлгэн ойр, талбайг цэвэрлэн, бохирын септик танк, шугам хоолойн хэсгүүд байрлуулсан талбайг тэгшлэн, нөхөн дүүргэх ажлуудыг хийж, биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлэн болгож үлдээсэн.</p> <p>Шаардлагатай хэсгүүдэд хөрсний хэлбэржүүлэлт тэгшилгээг хийж дуусан, өрмийн талбайг хашаатай хэвээр орон нутгаас манаач айл буулган үлдээсэн.</p>





Ахуйн шингэн хаягдлын танк суурилуулсан нүхийг эргүүлэн булж дүүргэсэн.



Танк байрласан талбайд хөрсөнд аливаа бохирдол нэвчээгүй байдал





Танк байрласан нүхийг булж тэгшилсэн байдал



Цооногийн амыг дараа жил үргэлжлүүлэн судлахаар түр хаасан.



Өрмийн талбай руу нэвтрэх хаалгыг хааж, хашааг битүүмжлэв.



Өрмийн цамхагийг буулгаж буй байдал



Ирэх онд хайгуулын ажил үргэлжлэхэд шаардлагатай зарим тоног төхөөрөмжийг талбайд хурааж, байрлуулан үлдээсэн.

2025 онд ашиглагдах зүйлсийг талбайд хурааж хадгалсан.

Цэн тогоруу-2 цооног өрөмдсөн өрөмдлөгийн талбайн техникийн нөхөн сэргээлтийг тухайн цооногт хийгдэх шаардлагатай туршилт, судалгаа, шингэн хагалбарын ажлууд хийгдэж дууссаны дараа гүйцэтгэнэ гэж төлөвлөгөөнд тусгасан ба өрөмдлөгийн дараах туршилт судалгааны ажлууд хараахан дуусаагүй, өрмийн шингэн хаягдлын сангийн техникийн нөхөн сэргээлт болон талбайн биологийн нөхөн сэргээлтийн ажил 2025 онд хийгдэхээр байна.

<p>3.Өрөмдлөгийн талбайн биологийн нөхөн сэргээлт:</p> <p>Үүнд: өрөмдлөгийн шингэн хаягдлын сан, ахуйн шингэн хаягдлын нүх, тоног төхөөрөмж байрласан талбай, үйл ажиллагааны улмаас талхлагдсан талбай г.м</p> <p>Ургамал ургалтын улирлыг харгалзан үзэж мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.</p> <p>Жич: өрөмдлөгийн талбайн биологийн нөхөн сэргээлтийн ажлыг тухайн цооногт хийгдэх бүх туршилт, судалгаа, шингэн хагалбарын ажлууд хийгдэж дуусаад техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа ургамал ургалтыг улирлыг харгалзан хийж гүйцэтгэнэ.</p> <p>Олборлолтын цооногийн талбайд олборлолтонд ашиглагдах тоног төхөөрөмжийг суурилуулсны дараа олборлолтын үйл ажиллагаатай уялдуулан хийж гүйцэтгэнэ.</p> <p>Шинээр өрөмдсөн цооногт тосны илэрц гараагүй үед биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэнэ. Биологийн нөхөн сэргээлтийг ургамлын вегетацийн үетэй уялдан дараа оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдан хийгдэж болзошгүй.</p>		<p>Биологийн нөхөн сэргээлтийг 2024 оны БОМТ-д тусгасаны дагуу ургамлын вегетацийн үетэй уялдуулан 2025 онд мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.</p>
---	--	--

БҮЛЭГ IV. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
Хүснэгт 10

№	Дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд төлөвлөсөн ажил зорилт	Хариуцах	Хэрэгжүүлсэн байдал
	1	2	3
1.	<p>Биологийн олон янз байдлыг хамгаалах түүнийг дүйцүүлэх хамгаалах арга хэмжээний хүрээнд төслийн талбай нь тал хээрийн бүсэд байрладаг хээрийн түймрийн давтамж их түймрээс шалтгаалан амьтан ургамлын төрөл зүйл аюулд өртөх, устах, орон нутгийн малчин иргэдийн эд хөрөнгө, мал түймрийн аюулд нэрвэгдэх зэрэг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллахыг зорьсон. Энэхүү зорилтын хүрээнд Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт болон Дорнод аймгийн Матад сумын Засаг Даргын Тамгын Газарт гал унтраах багаж хэрэгслийг нийлүүлнэ.</p>	Петроматад ХХК	<p>Матад ХХ талбайн олборлолтын шат руу шилжиж байгаатай холбоотойгоор дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор сум орон нутагтай харилцан зөвлөлдөж шийдвэрлэсэн. Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт гал унтраах багаж хэрэгсэл, зайнаас хяналт шалгалт, судалгаа хийх зорилгоор дрон, компютерийг хүлээлгэн өгсөн. Түүнчлэн Дорнод аймгийн Матад Сумын ЗДТГ-т гал унтраах багаж хэрэгслийг хүлээлгэн өгсөн. Хавсралт хxxx Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд галын багаж хэрэгсэл, дрон компютер хүлээлцсэн акт.</p>  <p>Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт</p>

№	Дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд төлөвлөсөн ажил зорилт	Хариуцах	Хэрэгжүүлсэн байдал
			 <p data-bbox="869 762 1444 794">Матад сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байдал.</p>
2	МУ-ын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сум эсвэл Дорнод аймагтай харилцан санал солилцож аймгийн хэмжээнд мод тарихаар төлөвлөлтөд орсон талбайнуудад мод тарих (эсвэл олборлолтын талбай орчимд боломжтой газар сонгох)	Петроматад ХХК	<p data-bbox="869 895 2168 1129">МУ-ын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дорнод аймгийн БОАЖГ болон Матад сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд, сумын байгаль хамгаалагч нартай харилцан санал солилцож Матад сумын “Сур харвааны холбооны төв талбай”-д 500 ш хайлаас, улиас моддыг тарьж, услагаа, арчилгааг хийж байна. Мод тарих, услах, арчилах ажлыг сумын иргэдтэй гэрээ байгуулан хамтран ажилласан ба ирэх оны мод тарих төлөвлөгөөнд тарьсан модны арчилгаа, услагааны зардлыг үргэлжлүүлж төлөвлөнө. Моддыг Цагаан уул ХХК мэргэжлийн цэцэрлэгжүүлэлтийн байгууллагаас худалдан авсан. Хавсралт№ Мод тарих, талбай бэлтгэх гэрээ</p>

№	Дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд төлөвлөсөн ажил зорилт	Хариуцах	Хэрэгжүүлсэн байдал
			<div data-bbox="869 306 1429 737" data-label="Image"> </div> <div data-bbox="1438 306 1975 737" data-label="Image"> </div> <p data-bbox="869 743 1482 810">Мод тарих талбай, нүх бэлдэж буй байдал Мод тарилтын өмнө услагаа хийгдэж буй байдал</p> <div data-bbox="869 817 1594 1321" data-label="Image"> </div> <div data-bbox="1639 817 2078 1321" data-label="Image"> </div> <p data-bbox="869 1327 1617 1353">Технологийн дагуу шуудуу ухаж хайлаас модыг суулгасан</p>

№	Дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд төлөвлөсөн ажил зорилт	Хариуцах	Хэрэгжүүлсэн байдал
			<div data-bbox="869 316 1294 785" data-label="Image"> </div> <div data-bbox="1303 306 2065 785" data-label="Image"> </div> <p data-bbox="869 794 1406 826">Улиас суулгаж, услагаа хийсэн буй байдал</p> <div data-bbox="869 833 1249 1343" data-label="Image"> </div> <div data-bbox="1258 826 1617 1343" data-label="Image"> </div> <p data-bbox="869 1353 1697 1385">Услагааг намрын цэнэг услагаа хүртэл үргэлжлүүлэн хийж байна.</p>

БҮЛЭГ V. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 11

Төлөвлөсөн ажил	Хариуцах	Биелэлт																																																																																																												
Өрөмдлөгийн талбайн нөлөөллийн бүсэд оршин суух иргэдийг нүүлгэн шилжүүлэх шаардлага тогтоох	Петроматад ХХК	<p>ЗГ-ын 2023 оын 7-р сарын 5-ны өдрийн 265 дугаар тогтоолоор БХГ-т Матад ХХ талбайн 21392 га газрыг улсын хэрэгцээнд авч, газар ашиглуулах гэрээ байгуулан гэрчилгээ олгох ажлыг эхлүүлсэн. БХГ-т Матад ХХ талбайн улсын тусгай хэрэгцээт газарт давхцал бүхий 11 нэгж талбарт хамаарах 10 айл өрхүүдэд нийт 176'378'000 төгрөгийн нөхөх олговор олгосон. Нүүлгэн шилжүүлэлт хийгдэх шаардлага үүсээгүй.</p> <table border="1" data-bbox="815 480 1720 847"> <thead> <tr> <th>FW/LLC</th> <th>FW/LLC</th> <th>FW/LLC</th> <th>FW/LLC</th> <th>FW/LLC</th> <th>FW/LLC</th> <th>FW/LLC</th> <th>FW/LLC</th> <th>FW/LLC</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>P240525</td> <td>2024.05.14</td> <td>Dambaatar.BH</td> <td>Compensation for overlapping land 2302001297</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240526</td> <td>2024.05.14</td> <td>Dambaatar.BH</td> <td>Compensation for overlapping land 2302001184</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240527</td> <td>2024.05.14</td> <td>Oyuunjavral.J</td> <td>Compensation for overlapping land 2302001762</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240528</td> <td>2024.05.14</td> <td>Dambaatar.T</td> <td>Compensation for overlapping land 2302001268</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240529</td> <td>2024.05.14</td> <td>Dambaatar.T</td> <td>Compensation for overlapping land 2302001715</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240530</td> <td>2024.05.14</td> <td>Serynkhov.E</td> <td>Compensation for overlapping land 2302001530</td> <td></td> <td></td> <td>48,378,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240531</td> <td>2024.05.14</td> <td>WynmooAD.M</td> <td>Compensation for overlapping land 2302001887</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240532</td> <td>2024.05.14</td> <td>Ombat.I</td> <td>Compensation for overlapping land 2302001040</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240533</td> <td>2024.05.14</td> <td>Javzantseten.B</td> <td>Compensation for overlapping land 2302001218</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td>P240534</td> <td>2024.05.14</td> <td>Unurjavral.A</td> <td>Compensation for overlapping land 2302001240</td> <td></td> <td></td> <td>12,000,000.00</td> <td>Intermet bank transfer</td> <td></td> </tr> <tr> <td colspan="6" style="text-align: right;">Total /to KHAR bank account/</td> <td>176,378,000.00</td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	P240525	2024.05.14	Dambaatar.BH	Compensation for overlapping land 2302001297			12,000,000.00	Intermet bank transfer		P240526	2024.05.14	Dambaatar.BH	Compensation for overlapping land 2302001184			12,000,000.00	Intermet bank transfer		P240527	2024.05.14	Oyuunjavral.J	Compensation for overlapping land 2302001762			12,000,000.00	Intermet bank transfer		P240528	2024.05.14	Dambaatar.T	Compensation for overlapping land 2302001268			12,000,000.00	Intermet bank transfer		P240529	2024.05.14	Dambaatar.T	Compensation for overlapping land 2302001715			12,000,000.00	Intermet bank transfer		P240530	2024.05.14	Serynkhov.E	Compensation for overlapping land 2302001530			48,378,000.00	Intermet bank transfer		P240531	2024.05.14	WynmooAD.M	Compensation for overlapping land 2302001887			12,000,000.00	Intermet bank transfer		P240532	2024.05.14	Ombat.I	Compensation for overlapping land 2302001040			12,000,000.00	Intermet bank transfer		P240533	2024.05.14	Javzantseten.B	Compensation for overlapping land 2302001218			12,000,000.00	Intermet bank transfer		P240534	2024.05.14	Unurjavral.A	Compensation for overlapping land 2302001240			12,000,000.00	Intermet bank transfer		Total /to KHAR bank account/						176,378,000.00		
FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC	FW/LLC																																																																																																						
P240525	2024.05.14	Dambaatar.BH	Compensation for overlapping land 2302001297			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240526	2024.05.14	Dambaatar.BH	Compensation for overlapping land 2302001184			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240527	2024.05.14	Oyuunjavral.J	Compensation for overlapping land 2302001762			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240528	2024.05.14	Dambaatar.T	Compensation for overlapping land 2302001268			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240529	2024.05.14	Dambaatar.T	Compensation for overlapping land 2302001715			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240530	2024.05.14	Serynkhov.E	Compensation for overlapping land 2302001530			48,378,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240531	2024.05.14	WynmooAD.M	Compensation for overlapping land 2302001887			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240532	2024.05.14	Ombat.I	Compensation for overlapping land 2302001040			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240533	2024.05.14	Javzantseten.B	Compensation for overlapping land 2302001218			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
P240534	2024.05.14	Unurjavral.A	Compensation for overlapping land 2302001240			12,000,000.00	Intermet bank transfer																																																																																																							
Total /to KHAR bank account/						176,378,000.00																																																																																																								
Шаардлагатай иргэдийг нүүлгэн шилжүүлж, нөхөн олговор олгох																																																																																																														




БҮЛЭГ VI. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Хүснэгт 12**

Төлөвлөсөн ажил	Хариуцах	Биелэлт
<p>I. Төслийн явцад түүх, соёлын дурсгалт зүйл болон археологи, угсаатан, палеонтологийн олдвор илэрвэл төслийн үйл ажиллагааг зогсоож, энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн байгууллагад болон холбогдох эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ</p>	<p>“ПетроМатад” ХХК</p>	<p>Газрын тосны хайгуулын “Матад ХХ” талбайн ашиглалтад авсан талбай түүний ойр орчмын нутаг дэвсгэрийн хэмжээнд археологи, палеонтологийн дурсгалт зүйлийн нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар 2018 онд хийлгэсэн. Уг судалгаагаар газрын тосны хайгуулын “Матад ХХ” талбайн ашиглалтын лиценз бүхий талбайд түүх соёлын дурсгал, археологи болон палеонтологийн олдвор илрээгүй. Түүнчлэн үйл ажиллагааны явцад шинээр түүх соёлын дурсгал, археологи болон палеонтологийн олдвор илрээгүй болно.</p>

БҮЛЭГ VII. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
Хүснэгт 13

Урьдчилан сэргийлэх, хамгаалахаар төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцах	Хэрэгжүүлсэн байдал
<b>Үүсэж болзошгүй байгалийн, биологийн болон технологийн гаралтай осол эрсдлээс урьдчилан сэргийлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</b>		
<p>1.Орон нутгийн иргэд болон ажиллаж буй ажиллагсдад заавар зөвлөмж өгөх, мэдээллээр хангах</p>	<p>Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч, Петроматад ХХК</p>	<p>Талбай дээр ажиллаж байсан нийт ажилчид, орон нутгийн иргэдэд төслийн талбайн бүс нутагт тохиолддог байгалийн гаралтай, технологийн гаралтай үүсэж болзошгүй осол эрсдлийн талаар танилцуулга мэдээлэл өгч, түүнээс хэрхэн сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээний талаар заавар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Үүнд галын аюулгүй байдлын сургалт, зааварчилгааг өгч, галын сургуулилт хийгдсэн, Хүхэрт хүчлийн хийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулж, сургуулилт хийгдсэн. Цооногийн даралтаас үүдэлтэй Оргилолтоос хамгаалах төхөөрөмжийн бэлэн байдлын сургуулилт, Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх сургуулилтууд төслийн байршлуудад зохион байгуулагдсан.</p> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">   </div> <p>Хүхэрт хүчлийн хийн аюулгүй байдлын сургалтын хэсгээс</p>



Хүхэрт хүчлийн хийн аюулгүй байдал сургуулилтийн хэсгээс



Төслийн талбай дээрх галын сургуулилтын явцаас

<p>2.Гал унтраах иж бүрэн хэрэгсэл</p>	<p>Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч, Петроматад ХХК</p>	<p>Төслийн талбайд шаардлагатай анхан шатны гал унтраах багаж хэрэгслээр стандартын дагуу бүрэн хангагдсан. ГАБ ханган ажилласан талаарх тайланг Дорнод аймгийн ОБА-д хүргүүлсэн. Хээрийн кемпэд Дорнод аймгийн ОБА-наас галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулж ажилласан. Хавсралт № Галын дүгнэлт</p> 
<p>3.Төсөл хэрэгжих явцад тухайн бүс нутаг болон ОУ, Монгол улсыг хамарсан өвчлөл гарч байгаа эсэхэд байнга анхаарч, гарсан тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах</p>	<p>Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч,</p>	<p>Өрөмдлөгийн ажил үргэлжлэх хугацаанд улс орон нутгийн хэмжээнд биологийн гаралтай ямар нэгэн халдварт өвчний дэгдэлт гарч, хориг хязгаар тавигдаагүй.</p>

4. Биологийн гаралтай өвчний дэгдэлт тархалтын үед ажилчдыг амраах

5. Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн ханган ажиллуулах

Петроматад ХХК

Биологийн гаралтай өвчний дэгдэлт тархалт гараагүй тул тус шалтгаанаар ажилчдыг амраах шаардлага үүсээгүй.

Талбай дээр өрөмдлөгийн ажил явагдах хугацаанд ажилчдад нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажил үүргийн хуваарьт заагдсан ажил үүрэгтэй уялдуулан олгож, НБХХ олгосон бүртгэл хөтөлж, гарын үсгээр баталгаажуулж байв.

Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Ди Кю И ХХК нь мөн өрмийн талбай дээр ажиллаж байгаа нийт инженер техникийн ажилчиддаа нэг бүрийн хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.



Code: PPM-PPH-Handover-sheet  
Version: 2.0



System owner:	<i>[Signature]</i>
Reviewed by: Sam Gidara T	<i>[Signature]</i>
Contractor:	<i>[Signature]</i>
Checked for Accuracy:	<i>[Signature]</i>
Extension:	<i>[Signature]</i>
Approved for: Sam Gidara	<i>[Signature]</i>

MSX DRILLER MGMT  
HAND-OVER SHEET  
General PPE for Block 03

Issue date: 2019.08.27

No.	Item/Description	See spec/Quantity	Need/OK
1	Safety boots	1	
2	Safety vest	1	
3	Safety glasses	1	
4	Safety helmet	1	
5	Safety harness	1	
6	Safety gloves	1	
7	Safety net	1	
8	Safety sign, (Block 03, 04, 05, 06, 07, 08, 09, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60, 61, 62, 63, 64, 65, 66, 67, 68, 69, 70, 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78, 79, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88, 89, 90, 91, 92, 93, 94, 95, 96, 97, 98, 99, 100)	1	
	<b>GRAND TOTAL</b>		

No.	Signature/Intended use	Date/Issued by	Issue date/ Issued by
1	Approved/Intended use	General PPE for Block 03	General PPE for Block 03
2	Approved/Intended use	General PPE for Block 03	General PPE for Block 03
3	Approved/Intended use	General PPE for Block 03	General PPE for Block 03
4	Approved/Intended use	General PPE for Block 03	General PPE for Block 03
5	Approved/Intended use	General PPE for Block 03	General PPE for Block 03

6.Хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан тодотгол хийж, ажиллагсдад сургалт явуулж байх

Компани ажилчдын дотоод сургалтын төлөвлөгөөг гаргаж батлуулан ажилчдыг болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай сургалтуудыг тогтмол хийдэг. Үүнд: шинээр ажилд орж байгаа ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээнд зайлшгүй шаардлагатай сургалт, нийт ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, ГАБ-ын сургалт, Анхны тусламж үзүүлэх сургалтуудыг зохион байгуулдаг. Мөн түүнчлэн өндөр эрсдэлтэй ажлын байрны сургалтууд болох H2S, аюулгүйн жолоодлого, химийн бодистой харьцах ажилтны сургалтуудад шаардлагатай ажилтнуудыг хамруулдаг

#### Галын аюулгүй байдлын сургалт



Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас дэвшүүлсэн “ Уур амьсгалын өөрчлөлтөд эрүүл аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” уриан дор 2024.04.26-ны өдөр байгууллага дээрээ нийт ажилтнуудын дунд ХАБЭА-н өдөрлөг зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр ХАБЭА-н талаарх зарим ерөнхий мэдээлэл, тэмдэг тэмдэглэгээ, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, гамшиг ослын үеийн бэлэн байдлыг хангах, галын аюулгүй байдлыг хангах, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл аюулгүй хөдөлмөр эрхлэх тухай сэдвүүдийг онцлон танилцуулга хийгдэж, мэдээлэл солилцон, асуулт хариултын тэмцээн зохион байгууллаа.

		<p>Химийн бодистой харьцах ажилчдын сургалт</p> 	
		<p>Анхны тусламж үзүүлсэн сургалт</p>	



Инженер техникийн ажилтнуудыг хүхэрт ус төрөгчийн аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан





<p>7. Яаралтай үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, ажилчдад хэрхэн ажиллах талаарх мэдээлэл, зааварчилгаа өгсөн эсэх</p>		<p>Компани төсөл хэрэгжих үеийн онцгой байдлын үед авах хариу хэмжээний төлөвлөгөөг боловсруулан удирдлага, инженер техникийн ажилчдаа хариуцсан ажил үүргийг нь тодорхойлж танилцуулсан. Гамшгийн эрсдлийн үнэлгээг Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн үүнд үндэслэн өрөмдлөгийн үйл ажиллагааны явцад авч хэрэгжүүлэх гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан Дорнод аймгийн Онцгой байдлын газарт батлуулахаар хүргүүлсэн. Ажлын талбайд “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах төлөвлөгөө” баримт бичгүүдийг нэгтгэн хавтас бүрдүүлсэн. Талбайн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” хавтаст багтсан баримт бичгүүдийг жагсаавал:</p> <p>ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД ХОЛБОО БАРИХ УТАСНЫ ЖАГСААЛТ  МАТАД ХХ ТАЛБАЙ, ГАМШГИЙН ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ  ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ  ӨВЧТӨН ЯАРАЛТАЙ ШИЛЖҮҮЛЭН ТЭЭВЭРЛЭХ, ДЭЭД ШАТНЫ ЭМНЭЛЭГТ ХҮРГЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ ОЛОН УЛСЫН СОС  ЦООНОГИЙН ОРГИЛОЛТЫН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ  ЦООНОГТОЙ ХОЛБООТОЙ ОСЛЫН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ  АСГАРАЛТЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ  ХАБЭА-Н ТӨЛӨВЛӨГӨӨ  ХАБЭА-Н ХАМТЫН БАРИМТ БИЧИГ  Агаарын зурвас тогтоосон акт  Харуул хамгаалалтын төлөвлөгөө  Аймгийн Онцгой байдлын газраас хээрийн түр кемпт галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан.  /Хавсралт 19/.</p>
--	--	---

Өрөмдлөгийн ажил эхлэх үеэс өрөмдлөгийн ажил дуусах бүхий л хугацаанд эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх амбулатори, эмч, эмнэлэгийн тэрэг кемп дээр байрлаж ажилласан.

Талбай дээр эмч ажиллах үедээ өрөмдлөгийн талбайн ойр орчимд байгаа малчин айл өрхүүдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг мөн үзүүлж ажиллаж байсан.



<p>8. Галын аюулгүй ажиллагаа, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаарх сургалтыг ажилчдад өгөх</p> <p>9. Тос хадгалах байгууламжуудыг эргэн тойронд гал-ын зурвас байгуулах</p> <p>10. Галын аюул болон бусад төрлийн анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг тоног төхөөрөмж, байгууламжуудад байрлуулах</p> <p>11.Тос асгаралтын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй /тухайн төлөвлөгөөнд тос асгаралтын үед авах арга хэмжээ, хаягдлыг хэрхэн хадгалж, устгах зэргийг нэг бүрчлэн тодорхойлсон байна/</p>	<p>ГАБ Сургалт өгсөн, галын сургуулилт, дадлага хийгдсэн. Хээрийн кемпийн гадуур галын зурвасыг 10 м өргөнтэй байгуулсан. Тос хадгалах байгууламжийг тойруулан галын зурвас татсан. Галын аюултай газар сэрэмжлүүлж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байршуулж ажиллав. Тос асгаралтын төлөвлөгөөг боловсруулж, мөрдөж ажиллав. Хавсралт:</p> <div data-bbox="887 376 2063 746"> </div>
---	---

### 3. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

#### Хүснэгт 14

Урьдчилан сэргийлэх, хамгаалахаар төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцах	Хэрэгжүүлсэн байдал
<b>Химийн бодисын эрсдлийг бууруулахаар урьдчилан сэргийлж авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</b>		
<p>Тээвэрлэх, хадгалах, хэрэглэх үед алдагдах, хүн, мал, байгальд хор хөнөөл учруулахаас бүрэн сэргийлнэ. Дараах арга хэмжээг авна:</p> <p>1. Агуулах нь үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан дүгнэлттэй байна.</p> <p>2. Химийн бодисыг ашиглах тусгай зөвшөөрөлтэй байна.</p> <p>3. Химийн аюултай бодисыг түүний онцлог шинж чанарыг нь харгалзан агуулахад журмын дагуу хадгална.</p> <p>4. Химийн бодистой харьцан ажиллах ажилтан шаардлага хангасан ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдсан байна</p> <p>5. Агуулахад аюул ослын үед хэрэглэх асгаралтын цомог, саармагжуулах бодис шаардлагатай, гал унтраах хэрэгслүүдийг ойр байлгана.</p> <p>6. Химийн бодис тээвэрлэх үед химийн бодис алдагдахад авах арга хэмжээг төлөвлөх, хоргүйжүүлэх зааварчилгааг холбогдох хүмүүст өгч ажиллах</p> <p>7. Хадгалж байгаа хорт болон аюултай бодисын сав баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг тодорхой бичсэн шошготой байна.</p>	<p>Гэрээт гүйцэтгэгч Ди Кю И ХХК, Петро Матад ХХК</p>	<p>1. Химийн бодис хадгалалт, ашиглалт, тээвэр: Химийн бодисын хадгалалт ба ашиглалтад Монгол улсын холбогдох хууль, журмууд болон олон улсын стандартад нийцсэн компанийн дотоод журам, төлөвлөгөөний дагуу хяналт тавьж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Химийн бодисыг ашиглах тухай “Химийн хорт болон аюултай бодис ашиглах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авч ажилласан.(Хавсралт ).</li> </ul> <p>Өрөмдлөгийн болон шингэн хагалбарын ажлын гэрээт гүйцэтгэгчид химийн бодис ханган нийлүүлэх байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж, уг гэрээний дагуу үйл ажиллагаандаа шаардлагатай химийн бодисыг ашиглах тусгай зөвшөөрөлтэйгээр ашигласан, “Далай үндэс ХХК”, “Тосон бодис ХХК”, эдгээр химийн бодисын гэрээтүүд нь ажиллагаа дуусахад үлдэгдэл химийн бодис, хоосон уут шуудайг талбайгаас авч явах гэрээтэй, хортой аюултай химийн бодисын хаягдал уут савыг устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага болох “Түмэн эгшиг ХХК”-тай гэрээ байгуулан ажилладаг.</p> <p>Хавсралт: Гурвалсан гэрээ, Химийн хортой аюултай бодис, хоосон сав шилжүүлэх гэрээ</p> <ul style="list-style-type: none"> <li>- Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээг БОННУ-ийн нэмэлт тодотголын хүрээнд Эко натур ХХК-иар дахин хийлгэж, БОАЖЯ-аар батлуулсан.</li> </ul> <p>Матад сумын засаг даргын Химийн бодисын агуулахын байршил тогтоосон тогтоол</p> <ul style="list-style-type: none"> <li>- Химийн бодис хадгалах агуулах нь стандартын шаардлага хангасан, дүгнэлт. /Хавсралт 3/. /Химийн бодистой харьцан ажиллах журам, асгаралтын үед мөрдөх журам, агуулахын дүрэм, хог хаягдлын менежментийн журмыг мөрдлөг болгон ажилласан/.</li> <li>- Химийн бодис хадгалж буй талбай тус бүрт хадгалагдаж буй бүтээгдэхүүнтэй холбоотой анхааруулах болон дагаж мөрдөх журмуудыг байршуулж өгсөн.</li> <li>- Химийн бодис хариуцсан ажилтан томилгоожсон ба ажлын байрны тодорхойлолтод үүрэг хариуцлагыг зааж өгсөн.</li> <li>- харуул хамгаалалтын ажилтантай, химийн бодисын бүртгэл, хаяг шошго, уут баглаа боодлын бүрэн байдлыг хянаж ажилладаг.</li> </ul>

8. Ашиглалтаас гарсан химийн бодисын сав баглаа боодлыг бүртгэлжүүлж гэрээт байгууллагад нийлүүлнэ.

9. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодисын бүртгэл хөтөлж, ХАЛМ бэлэн байлгана.

10. Химийн бодистой харьцан ажиллах сургалт зааварчилгаа өгөх



Аймаг тусгаар Урьдчилсан асаргалт шалтгаан

Үүсгэлтэй

1. Үйлдвэрлэл, барилгын тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  2. Үйлдвэрлэл, барилгын тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  3. Хөдөлгөөнтэй зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  4. Зориулалтын төмөр замын тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  5. Байгууллагад байрлах үйлдвэрлэл, барилгын тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
- Бусад зориулалт:
- тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  - тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  - тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  - тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
6. Асаргалт шалтгаан: асаргалт шалтгаан үйлдвэрлэл, барилгын тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  7. Асаргалт шалтгаан: асаргалт шалтгаан үйлдвэрлэл, барилгын тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.
  8. Төмөр замын тусгай зориулалтын төмөр замын байгууллагад байрлах.



- Асаргалт зохицуулах иж бүрдэл, саармагжуулах бодис, тосгуурыг асаргалт үүсч болзошгүй газруудад байршуулсан.

- Хээрийн түр сууринд орон тооны эмч, эмнэлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ба нийт ажилтнууд анхны тусламж үзүүлэх сургалтанд хамрагдсан.

- Ноцомхой, шатамхай шинж чанартай бодисын хадгалалтын аюулгүй байдлыг хангасны дээр гал унтраах хэрэгслүүдийг тохирох цэгүүдэд байршуулж, ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хянаж ажилласан.

- Хамт хадгалахыг хориглосон химийн бодисыг тус тусад нь, химийн хорт болон аюултай химийн бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалж байна.
- НБХХ-ээр ажилчдыг бүрэн хангаж, холбогдох сургалтуудыг зохион байгуулснаас гадна эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан.
- Химийн бодистой харьцах, түүнийг тээвэрлэх, хадгалах мэргэжлийн сургалтыг “Хэрлэн Эрдэс, Хими” ХХК-ий харьяа “Монголын Ур Чадвар Сургалт” сургалтын төв ажлын оффис дээр 2022-05-30 өдөр зохион байгуулсан. Эрсдэлтэй ажлын байрны сургалтын гэрчилгээ нь 3 жилийн хугацаатай, хүчин төгөлдөр байна.






		 <p>Цэн тогоруу- 2 болон Мазаалай-1 цооногийн өрөмдлөгийн ажилд ашиглагдсан химийн бодис, шилжүүлсэн үлдэгдэл болон хоосон сав шуудайн тайланг Хавсралт- аас үзнэ үү. Ашиглалтаас илүү гарсан химийн бодисын шуудайг Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний дагуу Түмэн эгшиг ХХК-д шилжүүлэх гэрээтэй. /Хавсралт 22/ НБХХ-ээр ажилчдыг бүрэн хангаж, холбогдох сургалтуудыг зохион байгуулснаас гадна Петроматад ХХК-ийн болон гэрээт байгууллагын ажилчид эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаж, ажил үүрэгтэй тэнцэх эмчийн бичигтэй талбайд ажилладаг.</p>
<p>2. <u>Цацрагийн үүсгүүр</u> Цацрагийн үүсгүүр тээвэрлэх, хадгалах, ашиглах үед алдагдах, хүн, мал, байгальд хор хөнөөл учруулахаас бүрэн сэргийлнэ. Үүнд: Тусгай зориулалтын хадгалах сав, агуулахтай байна. Цацрагийн үүсгүүртэй харьцах үнэмлэхтэй, томилогдсон ажилтантай байна. Цацрагийн үүсгүүр хариуцсан ажилтнуудад шаардлага хангасан</p>	<p>Цацрагийн аюулгүй ажиллагааг хариуцан ажилласан тухай ПетроМатад ХХК-ний газрын тосны хайгуулын ХХ -р талбайд өрөмдлөгийн хоёр цооногт хийгдсэн каротажийн судалгаанд ашигласан цацрагийн үүсгүүрүүдийг “ПетроМатад”ХХК “МОНКАРОТАЖ” ХХК -уудын хооронд байгуулсан гэрээний дагуу “Монкаротаж” ХХК ний Цацрагийн хяналтын ажилтан Б.Болорхүү, жолооч Б.Мөнхбаатар нар 2024 оны 09 сарын 23 нд Улаанбаатар хотоос гарч Дорнод аймгийн Халх Гол сумын нутагт байрлах “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ний 21-р талбайд байрлах Цацрагийн үүсгүүр хадгалах байрнаас 2024.09.25 ний өдөр хүлээн авч цацраг идэвхт үүсгүүрүүдийг, Цөмийн болон Цацрагийн хяналтын хэлтэс болон ТЕГ, ЦЕГ бусад байгууллагуудад мэдэгдэл хүргүүлж доорхи хүснэгтэд цөмийн цацрагийн үүсгүүрүүдийг өөрийн компаний зориулалтын дагуу бэлтгэсэн зөөврийн хадгалах контейнэрт байршуулан үүсгүүр хүлээлцэх акт үйлдэн, батлагдсан маршрутын дагуу Дорнод аймгийн Халх Гол</p>	

<p>ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах ба хувцас солих байртай байна. Цацрагийн үүсгүүрийн хөдөлгөөн хийхдээ 2-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байлцаж хөдөлгөөний тухай бүртгэлийн дэвтэрт нарийн тэмдэглэж, гарын үсэг зурж баталгаажуулж гаргана.</p>		<p>сумын 21-р талбайгаас Матад сумын 20-р талбайд цацрагийн үүсгүүрүүдийг тээвэрлэж ашигласан. Ингэхдээ тээвэрлэлтэд 2 хоног, хадгалалтад 8 хоног зарцуулсан. Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div>
<p>8. Тэсрэх бодисын хөдөлгөөн хийхдээ 2-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байлцаж орлого, зарлагын тухай акт үйлдэж, бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурж баталгаажуулж байх. Аюул ослын үед хэрэглэх шаардлагатай тоног төхөөрөмж, гал түймэр унтраах ба хувийн хамгаалалтын хэрэгслүүд, бусад шаардлагатай багаж төхөөрөмж байна.</p>		<p>Цооногт перфорацийн ажил хийхэд гэрээт гүйцэтгэгч Бластсэлэнгэ ХХК ажилласан ба 24092200450108982 дугаартай Тэсрэх материал ашиглах хяналтын хуудаст үндэслэн 24/234 дугаартай гэрчилгээний дагуу, аюулгүй байдлыг хангаж ажилласан. Хавсралт ххх Бласт Сэлэнгэ тусгай зөвшөөрөл, хяналтын хуудас</p>



БҮЛЭГ VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 15

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдал	Хариуцах эзэн	Хэрэгжүүлсэн байдал
<b>Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</b>		
<p>1. Шингэн хаягдал, ариун цэврийн байгууламж /септик танк байршуулах/, эсвэл ахуйн шингэн хаягдлын танк суурилуулна</p>	<p>Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч, “Петроматад” ХХК</p>	<p>Өрөмдлөгийн талбай дахь ажилчдын суурьшсан кемпед ахуйн шингэн хаягдал, хар саарал усыг цуглуулах зориулалттай 20 тн багтаамжтай септик танк байршуулсан. Септик танк дахь бохирыг тухай бүр бохир сорох зориулалттай машинаар соруулан тээвэрлэсэн. Петроматад ХХК нь “Хайлааст Голомт” ОНӨААТҮГ-тай бохир ус нийлүүлэх гэрээ хийсний дагуу Сүхбаатар сумын бохир цэвэрлэх байгууламжид нийлүүлж ажилласан. Төслийн тайлант хугацаанд нийт 17 удаагийн зөөвөрлөлт хийж 510 м<sup>3</sup> бохир усыг нийлүүлэ, Хайлааст Голомт ОНӨТӨҮГ-т 7.650.000₮ төгрөгийг бохир ус цэвэршүүлэх төлбөрт, бохир ус тээвэрлэх гэрээт компани болох Петротранс ХХК-д 800.002 ₮-ийн тээврийн хөлс төлсөн. Хавсралт /17/.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">    </div>
<p>2.Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлын</p>	<p>Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч,</p>	<p>Хог хаягдлын менежментэд 3R зарчмыг баримтлан, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, ашиггүй хог хаягдал үүсэхээс аль болох урьдчилан сэргийлэх, ажилчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, байгаль орчинд хандах хандлагыг эерэгээр өөрчлөх, “зөв” дадал, хэвшлийг төлөвшүүлэх тал дээр гэрээ байгуулах үе шатнаас нь эхлэн анхаарч, “Петро Матад” ХХК-ий дотоод дүрэм, журмын дагуу заавар, зөвлөмж өгч, сургалт явуулан ажиллав.</p>

<p>хэмжээг аль болох бага байлгах, дахин ашиглах болон дахин боловсруулах гэсэн 3R-ын зарчмыг баримтлах; ангилж хаях мэдээлэл сургалтаар ажилчдыг хангана</p>	<p>Петроматад ХХК</p>	<p>Хайгуулын талбай болон хээрийн ангийн ойр орчмын газрыг хоггүй, цэвэр байлгах талаар хүн бүрт өдөр тутмын ажилд гарахад сануулж, ХАБЭА-БО-ы хурлаар анхааруулга тогтмол өгч байв. Хог хаягдлуудыг ангилан тус тусын зориулалтын цэгт төвлөрүүлж, дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг орон нутаг, мэргэжлийн бусад байгууллагуудад гэрээгээр нийлүүлсэн. Хүснэгтийг харна уу.</p>												
		<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="629 341 965 395">Хог хаягдлын төрөл</th> <th data-bbox="965 341 1406 395">Гэрээт байгууллага</th> <th data-bbox="1406 341 1868 395">Эрхзүйн баримт бичиг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="629 395 965 596">Ахуйн хаягдал</td> <td data-bbox="965 395 1406 596">Матад сумын ЗД-тай байгуулсан энгийн хог хаягдлын гэрээ болон иргэн xxxxxxxxxx нартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ</td> <td data-bbox="1406 395 1868 596">Гэрээ – 2024-08 сар /Хавсралт 12/</td> </tr> <tr> <td data-bbox="629 596 965 683">Бохир ус соруулах</td> <td data-bbox="965 596 1406 683">“Хайлааст Голомт” ОНӨААТҮГ</td> <td data-bbox="1406 596 1868 683">Гэрээ - 2024 оны 08 сар /Хавсралт 12/</td> </tr> <tr> <td data-bbox="629 683 965 842">Аюултай хог хаягдал (химийн бодисын уут, хаягдал шуудай)</td> <td data-bbox="965 683 1406 842">Монголын Петролеум Инженеринг ХХК болон тус компанийн гэрээт “Түмэн эгшиг” ХХК</td> <td data-bbox="1406 683 1868 842">Гэрээ – 2024 оны 08 сар /Хавсралт 24/</td> </tr> </tbody> </table>	Хог хаягдлын төрөл	Гэрээт байгууллага	Эрхзүйн баримт бичиг	Ахуйн хаягдал	Матад сумын ЗД-тай байгуулсан энгийн хог хаягдлын гэрээ болон иргэн xxxxxxxxxx нартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ	Гэрээ – 2024-08 сар /Хавсралт 12/	Бохир ус соруулах	“Хайлааст Голомт” ОНӨААТҮГ	Гэрээ - 2024 оны 08 сар /Хавсралт 12/	Аюултай хог хаягдал (химийн бодисын уут, хаягдал шуудай)	Монголын Петролеум Инженеринг ХХК болон тус компанийн гэрээт “Түмэн эгшиг” ХХК	Гэрээ – 2024 оны 08 сар /Хавсралт 24/
Хог хаягдлын төрөл	Гэрээт байгууллага	Эрхзүйн баримт бичиг												
Ахуйн хаягдал	Матад сумын ЗД-тай байгуулсан энгийн хог хаягдлын гэрээ болон иргэн xxxxxxxxxx нартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ	Гэрээ – 2024-08 сар /Хавсралт 12/												
Бохир ус соруулах	“Хайлааст Голомт” ОНӨААТҮГ	Гэрээ - 2024 оны 08 сар /Хавсралт 12/												
Аюултай хог хаягдал (химийн бодисын уут, хаягдал шуудай)	Монголын Петролеум Инженеринг ХХК болон тус компанийн гэрээт “Түмэн эгшиг” ХХК	Гэрээ – 2024 оны 08 сар /Хавсралт 24/												
<p>3.Хог хаягдал тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт аваачих</p>	<p>Ахуйн хатуу хог хаягдлыг цуглуулахдаа кемпийн баруун хойно буюу тухайн талбайн газрын гадарга тогтоц байршил харгалзан үзэж, суваг шуудуйн дагуу түр зуурын урсац үүсэхээргүй тэгш өндөрлөг газрын сонгон авч ахуйн хог хаягдлыг түр цуглуулах цэгийг байгуулсан.</p> <p>Кемпийн талбай дээр ахуйн хог хаягдлыг цаас, шил лааз, хуванцар, хоол хүнсний, бусад хог хаягдал гэж ангилахаар төлөвлөн хогийн цэгийн зохион байгуулалтыг хийсэн. Хогийн цэгээс хөрсөнд бохирдол нэвчил үүсэх зэргээс хамгаалан хогийн цэгийн шал суурь хэсэгт геомбран хамгаалалт хийж, мөн салхинд хийсэж тухайн орчинд тархааас урьдчилан сэргийлж торон хашаа татаж хамгаалсан. Үнэр тархах, хөрсөнд нэвчих, амьтан цугларах, үүрлэх зэргээс хамгаалж хог хаягдлыг пластик сав, хүүдийд хийж, хамгаалалтын дэвсгэрийг хөрсөн дээр мөн дэвссэн.</p> <p>Хог хаягдлыг тээвэрлэхдээ Матад сумын энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий тээврийн хэрэгсэлтэй сумын иргэнтэй хог тээврийн гэрээ байгуулан, хогны ачилтыг тухай бүр бүртгэлжүүлэн, Матад сумын хогийн цэгт аваачсан эсэхийг байнга фото зургаар баримтжуулан ажилласан.</p> <p>Хог хаягдлын гэрээг Матад сумын засаг даргатай гэрээ байгуулан тухайн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 3-р сарын 28-ны өдрийн 06 дугаарын тогтоолын хавсралтын дагуу сумын хог хаягдлын үйчилгээний хураамжид тооцсоны дагуу төлбөр тооцоог шилжүүлсэн.</p>													

Ахуйн хог хаягдлын цэг




Ахуйн хог хаягдлыг цуглуулж хадгалсан байдал



Ахуйн хогийг Матад сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт ачиж буулгасан байдал



Өрөмдлөгийн ажил үргэлжлэх хугацаанд ахуйн хог хаягдлын ачилт хийгдэх бүрт хийсэн бүртгэл Тайлант хугацаанд энгийн хог хаягдлыг 2 талбай нийлээд 12 удаагийн зөөлтөөр 1.4-1.5 тн хог хаягдлын сумын төвийн хогийн цэгт төвлөрүүлсэн байна.



Матад суманд Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлсөн баримт зураг

4. Техникийн шингэн хаягдал  
Өрөмдлөгийн шингэн хаягдлын сан (зумп)-д хуримтлуулж ууршуулах, саармагжуулах, арга хэмжээ авна.

Өрөмдлөгийн шингэн хаягдлын санд хуримтлуулж, ууршуулах арга хэмжээг авч байна. Газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагааны үеийн байгаль хамгаалал, нөхөн сэргээлт. *Техникийн MNS 6200:2010* стандартын 6.6. заалт буюу “Өрөмдлөгийн шингэний хаягдлын санг цооног өрөмдлөгийн үйл ажилалгаа дууссанаас хойш 12 сар, тусгай зориулалттай шингэн хаягдлын санг тухайн технологи үйл ажиллагаа дууссанаас хойш 6 сарын дотор техникийн нөхөн сэргээлт хийнэ” – гэсэн заалтыг баримтлан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг ирэх онд хийнэ.

5.Өрмийн үйл ажиллагаанд хэрэглэсэн химийн /органик, органик биш бодис, түүний нэгдлүүд/, тэсэрч дэлбэрэх шинж бүхий бодис болон цацраг идэвхит бодис, тэдгээрийг агуулж байсан сав, ажилласан тос, масло, хаягдал дугуй гэх зэрэг орно. Тусгай зөвшөөрөлтэй гэрээт гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний дагуу шийдвэрлэнэ

Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Ди Кю И ХХК, Петроматад ХХК

Төлөвлөгөөт өрөмдлөг хугацаанаасаа хожуу эхэлсэн ч богино хугацаанд дууссан, нөгөө талаар өрөмдлөгийн талбай дээр байрлах машины тоо цөөн (4-8), тэдгээрт засвар үйлчилгээ хийх шаардлага гараагүй зэргээс шалтгаалан ашигласан тос, масло маш бага хэмжээтэй (5-10л) гарсан нь техник, тоног төхөөрөмжийн тосолгоонд бүрэн ашиглагдаж, хаягдал гараагүй.

Өрөмдлөгийн гэрээт гүйцэтгэгч Ди Кю И ХХК нь өрөмдлөгийн ажилд ашигласан химийн бодисын шуудай, ашигласан техникийн тос масло зэргийн сав баглаа боодол зэргийг эх үүсвэр дээр нь түр хадгалж, химийн бодисын ханган нийлүүлэгч Монголиан Петролеум Инженеринг ХХК-д гэрээний дагуу хүлээлгэн өгсөн ба тус компанийн хамаарах XIX талбайн химийн бодисын агуулахад хүргэж, хадгалсан. Монголиан Петролеум Инженеринг ХХК нь аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах эрх бүхий байгууллага болох Түмэн эгшиг ХХК-тай аюултай хорг хаягдлыг шилжүүлэх, устгуулах гэрээтэй ажилладаг.

**Хавсралт 22**

Петроматад компанийн Өрөмдлөгт ашиглагдах Химийн бодис нийлүүлэх болон хоосон уут сав, шуудай, аюултай хог хаягдлыг буцаан шилжүүлэх гурвалсан гэрээ болон химийн бодис ашиглалт, буцаан авсан хоосон сав шуудайн тайланг харна уу.

Хавсралт № Химийн бодис ашиглах, нийлүүлэх, үлдэгдэл сав шуудай, хэрэглэгдээгүй үлдсэн химийн бодис буцаан авах тухай гурвалсан гэрээ Петроматад ХХК, Ди Кю И ХХК болон Монголиан Петролеум Инженеринг ХХК  
Хавсралт № Аюултай хог хаягдал устгуулах, шилжүүлэх гэрээ Монголиан Петролеум Инженеринг ХХК болон Түмэн эгшиг ХХК

## БҮЛЭГ IX. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Төслийн хэрэгжилтээс байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг үнэн зөв, бодитой үнэлэх үүднээс орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг, 2024 онд 2 үе шаттай хэрэгжүүлэхээр, байгаль орчны зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага болох “Эм Эс И Зэт Би” ХХК -тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлж, тайланг хүлээн авлаа.

“Эм Эс И Зэт Би” ХХК нь хяналт-шинжилгээний үе шат бүрт хамаарах сорьц, дээжлэлт болон бусад хэмжилтүүдийг газар дээр нь хийж, үр дүнг итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлэн, холбогдох тайлангуудыг тухай бүр нь ирүүлж ажилласан /Хавсралт: Тайлангууд бүрэн эхээрээ хавсрагдав. / болно. Үүнд:

- МАТАД ХХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ 2024-I ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН – Талбайн өрөмдлөгийн үйл ажиллагаа 2024-08-25 өдрөөс эхэлсэн ба уг үйл ажиллагаа эхлэхээс өмнө хийх хяналт-шинжилгээний буюу байгалийн суурь нөхцөлийн судалгааг 2024 оны 06 дүгээр сарын 06-09-ний өдрүүдэд гүйцэтгэж, холбогдох тайланг 2024-07-15-ны өдөр өгсөн,
- МАТАД ХХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ 2024-II ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН – энэ судалгааг 2024 оны 09 дугаар сарын 06-09-ны өдрүүдэд гүйцэтгэж, хяналт-шинжилгээний тайланг 2024-10-18-ны өдөр ирүүлсэн,



**БҮЛЭГ Х. АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ,**

Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор Дорнод аймгийн засаг дарга, Матад сумын засаг дарга, Дорнод аймгийн Байгаль орчин, Аялал Жуулчлалын газар, Байгаль орчны улсын хяналтын байцаагчид болон сумын байгаль хамгаалагч нараас тусгайлан тавьсан албан шаардлага ирүүлээгүй.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**Хүснэгт 16**

№	Төлөвлөгөөт аж	Хариуцах	Хэрэгжилт
1	Сумын засаг даргын тамгын газар , Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	<p>Матад сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ-тай компанийн авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээллийг сар бүр тогтмол хүргэж ажилладаг.</p> <p>Орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Матад сумын ИТХ-ын хурлын хүсэлтээр ИТХ-н төлөөлөгчдийг Өмнөговь аймагт туршлага судлах уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үеэр төлөөлөгчдийг Өмнөговь аймгийн ЗДТГ, Даланзадгад сумын ЗДТГ-ын үйл ажиллагаатай танилцах, Өмнөговь аймгийн Уул уурхайн салбарын аж ахуй нэгжүүдтэй хамтын ажиллагааны гэрээг хэрхэн үр дүнтэй байгуулан ажиллаж байгаа талаар, танилцуулга уулзалтуудыг зохион байгуулж хийлгэсэн. Тухайлбал Монгол улсын уул уурхайн салбарын томоохон аж ахуй нэгжүүд болох Эрдэнэс таван толгой ХК, Энержи Ресурс ХХК-тай үйл ажиллагаатай танилцуулан уул уурхайн салбарын бүтээн байгуулалт, орон нутгийн хамтын ажиллагааны төслүүдийг дэлгэрэнгүй танилцуулсан. Уулзалтын төсгөлд ИТХ төлөөгчдийг компанийн оффист урьж авчран компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийсэн. Тэр үер ИТХ төлөөлөгчид тус аялалыг амжилттай сайн зохион байгуулсанд талархал илэрхийлэн цаашид Петроматад компанийг дэмжиж ажиллахаа илэрхийлсэн.</p>	
		Дорнод аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, Газрын харилцаа	



барилга хот байгуулалтын газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Гадаад иргэн харьяатын газар, Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТҮГ, Буйр нуур, Мэнэнгийн талын сав газрын захиргаатай уулзалт зохион байгуулж компанийн авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.

Матад сумын иргэд, онцгойлон Эрдэнэбадрах багийн иргэдэд мэдээлэл хүргэх уулзалтуудыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна. Төслийн үйл ажиллагаа явагдаж байгаа үед орон нутгийн иргэдийг ажилд авах, орон нутгаас мах худалдан авах ажлыг туслан гүйцэтгэгч компаниудтай хамтран зохион байгуулж байна.

Матад сумын зудын эрсдэлд өртсөн малчин өрхүүдэд компанийн хүмүүнлэгийн тусламж хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан. Тус хүмүүнлэгийн ажлын хүрээнд Дорнод аймгийн Чойбалсан суман дах Найнга уурхайгаас нүүрс ачих, тээвэрлэх ажлыг зохион байгуулж 160 тн нүүрсийг тус суманд хүргэсэн. Түүнчлэн Эрдэнэбадрах багаас өвс тээвэрлэх, Улаанбаатар хотоос хүмүүнлэгийн тусламжийн бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэн хүргэж өгсөн.

Матад сум байгуулагдсны түүхт 100 жилийн ойд зориулан компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Спортын талбайн, хүүхдийн тоглоомыг талбайг орон нутгийн



БТБО ХХК-аар гүйцэтгүүлэн тус суманд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан.



20:17



<  **Ганзориг Жео**  
20:17







Петроматд хамтаар мангд сууын түүст 300жигд хандилаж буй түүхдийн тоглоомын цогцолбор талбайг манай хамтани харуудан гуйцалгаж дуусган сууын ЗДТГазарт зүлээлтэж өглөө. Тухай ажлыг гуйцалгаад дин нутгын залуус хийж гуйцалгаж дуусгаснаараа онцлогтой,тухайн төслийг эзний сэтгэхээр хандан хамгийн сайн чанартай материаллаар гуйцалгагээ. Үг төсөлнө 139сая төгрөгөөр хийгдсэн. Одоо нутгын иргэд,хүүхдүүд тө бүрэн энэ сайхан талбайгаа ариг гэмтэй хэрэглэж хүснэ. Сэгснэ талбай бүрэн камержуулалт тавигдсаны дараа нээгдэх болно. Үг талбайг албан ёсоор нээж нээлтийн тэмцээн үздэггүй зөвлөн байгуулагдана.




 Like  Comment  Send  Share

 You, Sean Shjiree and 43 others

 Write a comment...   

БҮЛЭГ XI. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 17

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн байдал	Тайлбар
1	Байгаль хамгаалах ажлын барьцаа хөрөнгө	БОМТ хэрэгжүүлэх зардлын 50 %-тай тэнцэх барьцаа хөрөнгө болох <b>111 560 100</b> төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх дансанд төвлөрүүлсэн.	Хавсралт № -аас үзнэ үү
2	Байгаль хамгаалах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	БОМТ-ын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлсэн.	Дэлгэрэнгүй мэдээллийг тус тайлангаас лавлана уу.
3	Ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг хамгаалах талаар сургалт зохион байгуулах	Байгаль орчныг хамгаалах, төслийн талбайд байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалтыг ажилчдад болон гэрээт гүйцэтгэгчид зориулан зохион байгуулсан.	Хавсралт № Сургалтын слайд Хавсралт № Оролцогчдын бүртгэл лавлана уу.
4	Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөсөн байх.	Эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх, шаардлагатай үед дээд шатны эмнэлгийн байгууллагад өвчтөн яаралтай тээвэрлэн шилжүүлэх ажлын хүрээнд Олон улсын СОС байгууллагатай гэрээ байгуулсан. Өвчтөн тээвэрлэх үед шаардлагатай онгоц буух агаарын зурвасыг баталгаажуулж, засвар арчилгаа хийсэн.	Хавсралт № Олон улсын СОС-той хийсэн Гэрээний нүүр, Хавсралт № Онгоц буух хөөрөх нислэгийн зурвас баталгаажуулсан акт, Зурвасын координат: 46°49'21.09"N 116° 7'41.59"E  Агаарын зурвасыг тэгшилж, тэмдэглэгээ, арчилгааг хийж, онгоц буух аюулгүй байдлыг тогтмол хангасан. Нислэгийн зурваст шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ, салхины чиг тогтоогчийг байрлуулсан схем.


5 Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажиллагсдын дунд сургалт зохион байгуулах


Петро матад ХХК-ийн ажилчдад Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ОБА-ны дэслэгч Мөнгөнчимэг 2024 оны 5-р сарын 24 өдөр ГАБ-ын тухай болон Гамшгийн бэлэн байдлыг хангах тухай сургалт орсон. Компани дотооддоо ХАБЭА өдөрлөг зохион байгуулсан. Гэрээт гүйцэтгэгч нарт төслийн талбай бүрт ГАБ-ын сургалт, сургуулилт хийгдсэн.




6	<p>Ажлын байр, зам талбайд ХАБЭА-ны ба замын хөдөлгөөний дүрмийн тэмдэг, дохио, санамжуудыг хийж тавих</p>	<p>Тэмдэг, санамжуудыг байрлуулсан.</p>	
7	<p>БОМТ-нд тусгагдсан ОХШХ -ийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, үр дүнд дүгнэлт хийх,</p>	<p>ОХШХ-ийг мэргэжлийн байгууллага гүйцэтгэсэн. ОХШ-ний тайланд өгсөн зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, мөн зөвлөмжид тусгасан ажлын хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараа оны төсөв, төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.</p>	 <p>ОХШ хөтөлбөрийн хэрэгжилтийн нэг ба хоёрдугаар шатны тайланг бүрэн эхээр хавсаргав.</p>
8	<p>Петро Матад ХХК нь үндсэн захиалагчийн хувьд туслан гүйцэтгэгч, гэрээлэгч нартай байгуулах гэрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг байнга тусгаж өгнө.</p>	<p>Гэрээт гүйцэтгэгч нартай байгуулах ажил, үүргийн төлөвлөгөөнд байгаль орчин (“Петро Матад” ХХК-ий батлагдсан БОМТ-ний хүрээнд өөрсдийн үйл ажиллагаанд баримтлах БОМТ-ийг боловсруулж, хянуулах, мөрдөх), хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны (химийн бодистой харьцах албан ёсны мэргэжилтэнтэй байх,</p>	<p>Өрөмдлөгийн гэрээний салшгүй хэсэг болох ХАБЭАБО-ны хамтын гэрээний баталгаажуулалт</p>

агуулах сав нь стандартын шаардлага хангаж, албан ёсны сертификат авсан байх, г.м), эрүүл ахуйн зэрэг иж бүрэн хөтөлбөр, дотоод журамтай байхыг шаардаж, 2 талаас баталгаажуулсан баримт бичгийн дагуу, газар дээрх хяналтыг тавьж ажилласан, Дээрх хүрээнд гэрээлэн гүйцэтгэгч нар тухайн асуудлыг хариуцсан ажилтныг томилгоожуулж, тухайн чиглэлийн сургалтад хамрагдаж, сертификат авсан, “Петро Матад” ХХК-ний зүгээс, төслийн талбайд явагдаж буй өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, гарсан зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулах, холбогдох мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах зорилгоор төслийн талбайд ХАБЭАБО-ны менежерийг төслийн хугацаанд талбайд байнга байрлуулан ажиллуулсан.



9	<p>Цооног өрөмдлөгийн ажлын үеийн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, байгаль орчны хамгаалалд, туслан гүйцэтгэгч нарт хяналтыг тогтмол тавьж ажиллана.</p>	<p>Туслан гүйцэтгэгч нарт ХАБЭА-БО-ны гүйцэтгэлд дотоод хяналт тавьж, зөвлөмж өгч, шаардлагатай сургалтыг зохион байгуулан хамтран ажилласан.</p>	 <p>Дотоод хяналтууд: ХАБЭА-БО-ны хяналтын хуудсуудаар (хуучнаар МХЕГ-ын боловсруулсан хяналтын хуудсууд) болон Олон улсын стандарт шаардлагын дагуу өрмийн талбай хүлээн авах шалгах хуудсаар</p> <p>Сургалт: Анхны тусламжийн сургалт, Төслийн талбайд хэрэгжүүлэх ХАБЭА-н ерөнхий зааварчилгаа, Байгаль орчны мэдээлэл өгөх сургалт, Галын аюулгүй байдлын сургалт, Хүхэрт хүчлийн хийн аюулгүй байдлын сургалт</p> <p>Сургуулилт: Галын сургуулилт, Эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх сургуулилт, Цооногийн даралтаас шалтгаалан Оргилолт үүссэн үед авах арга хэмжээний сургуулилт, цооногоос хорт хий ялгарсан үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний сургуулилт</p>
---	---	---	--



10	<p>Петро Матад ХХК нь тухайн үйл ажиллагаа явагдах орчны баг, сум, аймгийн БО-ны газар, засаг дарга, ИТХ тэргүүлэгч, газрын даамал зэрэгтэй үйл ажиллагаа эхлэхээс өмнө уулзалт хийж, хийгдэх ажлын танилцуулга, холбогдох зөвшөөрөл, төлөвлөгөө, арга хэмжээнүүдийг танилцуулан, үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл мэдэгдлийн дагуу ажлыг эхлүүлэх ба үйл ажиллагааны явцад тогтмол мэдээ мэдээллээр хангах, хяналт шалгалт тавих нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.</p>	<p>Үйл ажиллагаа эхлэхээс өмнө, түүнчлэн гэрээт гүйцэтгэгчид талбайд очиж ажил гүйцэтгэхээс өмнө мэдэгдэл, албан бичгээр зөвшөөрлүүдийг авч байсан. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн баг, сум, аймгийн удирдлага, ИТХ-ын тэргүүлэгчид, Дорнод аймгийн Байгаль Орчин Аялал жуулчлалын газар, байгаль хамгаалагч, газрын даамал, ОБА-ны мэргэжилтнүүдтэй тус тус уулзаж, үйл ажиллагааны эхэн, дунд, дараахь үеүдийн явцын талаарх мэдээллийг цаг тухайд нь өгч мэдээлж ирсэн ба тэдний зүгээс хяналт тавих, шалгалт хийх нөхцөл боломжийг бүрдүүлж,ажилласан.</p>	 <p>Буйр нуур Мэнэнгийн талын Сав Газрын захиргаанаас хяналт шалгалтаар ирсэн төлөөлөгчдөд ажиллах нөхцлийг бүрдүүлэн хамтран ажиллав. Төслийн хэмжээнд Ус ашиглалттай холбоотой эрхзүйн шаардлагын биелэлтийг тайлагнаж, ус ашиглалт, бохир ус зайлуулж буй явцыг танилцуулан, зөвлөмж авч ажиллалаа.</p>
----	--	---	---

## ДҮГНЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний энэхүү тайлан нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментий төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг удирдамж болгон боловсруулагдсан.

Петро Матад Компани нь үйл ажиллагаандаа аюулгүй ажиллагаа, ажилчдын эрүүл мэнд болон байгаль орчныг хамгаалах ажлуудыг нэн тэргүүнд тавьж, шийдвэр гаргалт бүртээ анхааралдаа авч ажиллаж байна. 2006 оноос өнөөг хүртэл хайгуулын ажил хийж гүйцэтгэх хугацаандаа үйлдвэрлэлийн осол, ноцтой зөрчил гаргаагүй ба нөхөн сэргээлтийн ажлууд, байгаль орчны холбогдох бусад ажлуудыг хууль эрх зүйн хүрээнд бүрэн гүйцэтгэж ирсэн. Үйл ажиллагаандаа МУ-ын хууль, журам, стандартуудыг мөрдөж ажиллахаас гадна, ОУ-ын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг холбоодоос гаргасан зөвлөмж, олон улсын стандартыг баримталж, гүйцэтгэлээ жил бүр тасралтгүй сайжруулахыг зорьж байна. 2024 оны тайлант хугацаанд хайгуулын 2 цооног өрөмдөж, 2019 онд өрөмдсөн Цэн тогоруу-1 цооногт олборлолт явуулах бэлтгэл ажлыг хийн, олборлолтын ил далд төхөөрөмжүүдийг суурилууллаа.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, хор хохирлыг бодитоор, хараат бусаар үнэлж, дүгнэх, хөндлөнгийн хяналт-шинжилгээний ажлыг “Эм Си И Зэт Би” ХХК /”MCEZB” LLC/-иар 2 үе шаттай (1 ба 2-р шатны ОХШ хөтөлбөр) гүйцэтгүүлж ба авто хөсгийн шилжилт хөдөлгөөнд нэг замын бодлогыг чанд баримталж ирэв. Төслийн хэрэгжилтээс, байгаль орчинд учирч болох гол сөрөг нөлөөлөлд хог хаягдал (хуурай, шингэн ба химийн болон аюултай хог хаягдал), хөрс ба ургамал (хөрсний бохирдол, ургамлын талхлагдал), болзошгүй сөрөг нөлөөлөлд агаарын бохирдол (тоос ба дуу шуугиан), ус ашиглалт (гүний ус), гал түймэр зэрэг хүчин зүйлүүд тус тус хамаарах /1 ба 2/ нөхцөлтэй ба хог хаягдлуудыг тусгаарлагч бүхий зориулалтын сав, агуулах талбайд тусад нь ангилан ялгаж, цаг тухайн үед гэрээний дагуу ачуулах буюу хүргэхээс гадна агаарын бохирдол, хөрс, ургамлын талхлагдлаас сэргийлэн нэг замаар зорчих, зам талбайг тэмдэгжүүлэх, сул явалтыг зогсоох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь дээрх төрлийн бохирдлыг хязгаарлах хүчин зүйл болсон. Ажилчдын ундны усыг зөөврөөр буюу савласан усаар хангаж байсан ба технологийн хэрэгцээний гүний худагт усны тоолуур суурилуулж, сумын байгаль хамгаалагчаар хяналт тавиулан (хяналтын лац, тоолуурын гүйлт шалгах гм) ашигласан нь усны нөөцийг арви гамтай зарцуулах нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Усны төлбөрийг тоолуурын заалтаар төлж ирсэн ба ахуйн хэрэглээний бохир усыг “Хайлааст Голомт ОНӨААТУУГ-ын үйлчилгээгээр зайлуулуулж байсан нь усны нөөц, хөрсийг бохирдлоос сэргийлсэн чухал арга хэмжээ болсон юм.

Мазаалай 1 цооногийн өрөмдлөгийн үйл ажиллагаа дуусч, төслийн дараагийн үе шат буюу ашиглалтад шилжих бэлтгэл ажлыг хангаж байна. Галын болон бусад болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгааллын дүрмийг чанд сахих, холбогдох сургалтуудыг үе шаттай хийх зэрэг хууль тогтоомж, стандарт шаардлагуудыг бүрэн хэрэгжүүлж, сахин мөрдсөнөөр дээрх сөрөг нөлөөллүүд бага буюу зөвшөөрөгдөх дээд хэмжээний хүрээнд байлаа.

Газрын тосны хайгуулын “Матад ХХ” талбайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан Байгаль орчныг хамгаалах ажилд зориулан 223,120.2 сая төгрөг төлөвлөснөөс нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн дансанд 111, 560.1 төгрөг байршуулж, төлөвлөгөөт арга хэмжээний хүрээнд 358,418.0 сая төгрөг тус тус зарцуулж, 100% гүйцэтгэлтэй ажиллав.

Мөн, ажилчдын эрүүл мэндийн үзлэг, хяналтыг тогтмол хийж ирсэн ба “БОМТ-2024”-д тусгасан нийт 10 бүлгийн 77 ажлыг энэхүү тайлант хугацаанд амжилттай хийж гүйцэтгэв.

## Хүснэгт 18

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ХУРААНГУЙ					
№	Дэд төлөвлөгөө	БОМТ тусгагдсан ажлуудын тоо	биелсэн	Нэмэлт тайлбар	Гүйцэтгэл /%
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19	19	-	100
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3	2	*2024 оны БОМТ-д үйл ажиллагаа болон вегетацийн үетэй уялдаж хийгдэхийг тусгайлан тэмдэглэсэн.	100*
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2	2		100
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөх олговор олгох төлөвлөгөө	2	2		100
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	1	1		100
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө, Химийн бодисын эрсдлийн менежмент	27	27		100
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	5	5		100
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	5	5		100
9	Төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	3	3		100
10	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	10	10		100
	<b>Нийт</b>	77	76	1	

**2024 оны БОМТ хэрэгжүүлсэн зардлын хураангуй**

**Хүснэгт 19 БОМТ -ний зардлын хураангуй**

№	Арга хэмжээ	БОМТ зардал мян.төг төсөв	Төсвийн гүйцэтгэл	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16,300.0	16,300.0	Гэрээт гүйцэтгэгч “Ди Кью И” ХХК, “Монбаг” ХХК тус тус гүйцэтгэж, “Петро Матад” ХХК байнгын хяналт тавьж, хамтран ажиллав.
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	45,000.0	-	Энэ онд хийгдэхгүй
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	71,080.2	75.000.	
4	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	9,500.0	9,500.0	Гэрээт гүйцэтгэгч “Ди Кью И” ХХК-иас химийн бодис, цацрагын эх үүсвэрийн хяналтад зарцуулсан зардал
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	45,500.0	45,500.0	Хог хаягдлын гэрээ, холбогдох зардлууд
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4,340.0	4,340.0	2024 оны орон нутгийн уулзалтын зардал
7	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	3,000.0	3,000.0	Нөлөөллийн бүсийн дагуух малчин айл өрхөд ажилласан зардал
8	Химийн бодисын эрсдлийн менежмент	9,000.0	9,000.0	
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	19,400.0	19,400.0	Орчны хяналт-шинжилгээг нийт 2 удаа хийлгэнэ. Гэрээт гүйцэтгэгч “Эм Эс И Зэт Би” ХХК
10	Нүүлгэн шилжүүлэх, нөхөх олговор олгох	-	176'378.0	
<b>Нийт зардал</b>		<b>223,120.2</b>	<b>358,418,0</b>	

\*2024 оны Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын барьцааны дүн 111 560 100 төгрөг БОУАӨЯ-ны тусгай дансанд байршуулсан.

## **ХАБСРАЛТ**



Хавсралт 2 : Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл– “Петро Матад” ХХК

МОНГОЛ УЛС  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

20 21 оны 07 сарын 05 өдөр Дугаар 696 Уламбалтар хит

<i>Эрхлэх үйл ажиллагааны төрөл</i>	Газрын тос ашиглах
<i>Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр</i>	"Петроматад" ХХК
<i>Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг</i>	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг Энхтайвны өргөн чөлөө 17, Блок ская тауэр, 506 тоот
<i>Регистрийн дугаар</i>	2867095
<i>Тусгай зөвшөөрлийн хугацаа</i>	2046 оны 07 сарын 01 өдөр хүртэл
<i>Тусгай нөхцөл, шийрдлага</i>	

Холбогдох хууль, дүрэм, журмын керэгжилтийг хангаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээ биелүүлж ажиглах.

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдан 2025. оны 07. сарын 05 өдрийн 696 дугаар тушаалыг үндэслэн илгээ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮГ,  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

  
Г.БЕНДОН

## Хавсралт 1. Газар ашиглах зөвшөөрөл



### ДӨРНОД АЙМАГ МАТАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

№ 284 05 04

А/16

Улаанбаатар

#### Газар ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 44 дүгээр зүйлийн 44.8 дахь хэсэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 06 дугаар тогтоолоор батлагдсан сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Матад сумын Эрдэнэбадрах 6-р багийн нутаг дэвсгэр дэх газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт 20 дугаар талбайд үйл ажиллагаа явуулж байгаа "Петроматад" ХХК /РД:2867095/-д 3 нэгж талбарын нийт 399.016 га /3990161 м<sup>2</sup>/ талбай бүхий газрыг хавсралтад дурьдсанаар 5 жилийн хугацаатайгаар ашиглуулсугай.

2. Газар ашиглагч "Петроматад" ХХК-д газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудсыг өгч, газар ашиглах гэрээ болон гэрчилгээг цахимваар үүсгэж, улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг сумын газрын даамалд үүрэг болгосугай.

3. Холбогдох хууль тогтоомж, газар ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрын төлбөрийн хуулийн хугацаанд бүрэн барьцдуулж, газрын зориулалтын дагуу ашиглахыг "Петроматад" ХХК-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д. БАТТУЛГА





Хавсралт 4 2024 оны БОМТ-ний барьцаа байршуулсан баримт

**ХААН БАНК** Огноо/Date: 2021.10.19 15:53:54

**Шилжүүлгийн мэдээлэл / Transaction information**  
Журналын/Journal No: 20625684

Системийн огноо/System Date: 2021.10.18

Дү	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханца/Rate
Дү	5031 104 021	ПЕТРО МАТАД ХХК	15,826,000.00 MNT	1.00
/ арван таван сая найман зуун хорин зургаан мянган төгрөг /				
Кү	Банкны дугаар/Branch No: 90 Дансны/Картын дугаар Account/Card Number: 100900013406	Банкны нэр/Bank Name: Төрийн Сан Нэр/Name: БО нөхөн сэргээх банклага	15,826,000.00 MNT	1.00

Гүйцэтгэлийн утга/Transaction description:  
ББ-Петро Матад ХХК - БО нөхөн сэргээх барьцаа

**ХААН БАНК** Огноо/Date: 2021.12.16 16:01:59

**Шилжүүлгийн мэдээлэл / Transaction information**  
Журналын/Journal No: 14130397

Системийн огноо/System Date: 2021.12.16

Дү	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханца/Rate
Дү	5031 104 021	ПЕТРО МАТАД ХХК	98,134,100.00 MNT	1.00
/ ерэн найман сая нэг зуун гучин дөрвөн мянга нэг зуун төгрөг /				
Кү	Банкны дугаар/Branch No: 90 Дансны/Картын дугаар Account/Card Number: 100900013406	Банкны нэр/Bank Name: - Төрийн Сан Нэр/Name: БО нөхөн сэргээх банклага	98,134,100.00 MNT	1.00

Гүйцэтгэлийн утга/Transaction description:  
ББ-Р211220-Петро Матад ХХК 2867095 БО нөхөн с

**ХААН БАНК** Огноо/Date: 2024.02.11 17:16:04

**Шилжүүлгийн мэдээлэл / Transaction information**  
Журналын/Journal No: 00980238740

Системийн огноо/System Date: 2024.02.11 17:16:04

Дү/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханца/Rate
	5031104025	ПЕТРОМАТАД	42,780,810.00 MNT	1.00
(Дөрвөн хоёр сая дөнгөж зуун найр өсөн мянган найман зуун арван төгрөг)				
Кү/To	Банкны дугаар/Branch No: 90 Дансны/Картын дугаар Account/Card Number: 100900013406	Банкны нэр Bank Name: Төрийн Сан Нэр/Name: БО нөхөн сэргээх Банклага	42,780,810.00 MNT	1.00

Гүйцэтгэлийн утга/Transaction description:  
ББ-2827095 Петро Матад ХХК БО-ны нөхөн сэргээх барьцаа

Харгивалч танд байрлалаа./Thank you to our customers

**Хавсралт 5. БОАЖЯ-аас байгаль орчныг нөхөн сэргээх дансанд байршуулсан төлбөрийн тооцоо нийлсэн тухай баримт**

НХМийгт Т-3

Санхүү, хэийн засгийн сайд,  
Үндэсний статистикийн газрын  
даргын 2002 оны тоот  
тушаалын хэвсгалт

**ТООЦООНЫ ҮЛДЭГДЛИЙН БАТАЛГАА №**

Нэхэмжлэгч:

Байгууллагын нэр: Байгаль Орчин Ажлаа  
Жууамчлалын Яам

Төлөгч:

Байгууллагын нэр: Петро Матад ХХК

Хаяг: Улаанбаатар 15160, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэслэл гудамж 5/2, Засгийн  
газрын II байр

Хаяг: Улаанбаатар 15000, Сүхбаатар  
дүүрэг I-р хороо, Бяло скай тауэр, 508

Утас, факс: (976-51) 261966

Э-нууцагч:

Банкны нэр: БО нөхөн сэргээх баталгаа  
Банкны дансны дугаар: 100900013406

Утас, факс: 70141099

Э-нууцагч:

Банкны нэр: Петро Матад ХХК  
Банкны дансны дугаар: 5031 104 021

**ТООЦОО НИЙЛЭСЭН ДАНСНЫ №**

Нэхэмжлэгчийн нэрийн өмнөөс нэгтгэн бодогч амхитай С овогтой Лхам нь төлөгчийн нэрийн өмнөөс нэгтгэн бодогч амхитай Ширадорж овогтой Монхмарсэтай тус хоёр байгууллага хооронд 2013 оны 09 сарын 30 өдрөөс 2021 оны 10 сарын 25 өдрийг дуусгал зугаашид нэг амхидсан зүйлээ хоёр байгууллагад хэлэгдэж буй нэгтгэн бодох бүртгэлийн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэлийн бичигтэр нэг бүрчлэн нийлж үзэхэд Петро Матад ХХК нь БО нөхөн сэргээх баталгааны 100900013406 тоот дансанд 80,920,000 төгрөг (нэг сая арав зуун хорин мянган төгрөг 00 мөнгө) тусж байршуулсан нь үзэн болохыг харилцан батал.

(Тэмдэг)

Нэхэмжлэгч байгууллагын нэгтгэн бодогч, *Лхам*

(Тэмдэг)

Төлөгч байгууллагын нэгтгэн бодогч, *Петро Матад*

**Хавсралт 6 Эскроу дансанд нөхөн сэргээлт, татан буулгалтын барьцаа байршуулсан баримт**

ТӨЛБӨРЧҮЙН ДАЛГААВАР / TRANSFER SLIP № P210524  
 Огноо / Date 2021 оны Зургадугаар сар 25

Төлөгч / Payer's name /		Петро Матад ХХК		Дансны / Account / №	Дүн / Amount /
Код / Code				Дэвсгэл / Detail	12,000.00
Төлөгчийн / Payer's name /	Голомт	банк	нхл	8145 101 029	
Хүлээн авагч / Beneficiary's name /	ЭСКРОУ ДАНСНЫ ӨГЛӨГ			Кредит / Credit	
Нийд / Code					
Хүлээн авагчийн / Beneficiary's name /	Голомт	банк	нхл	8140224100006	
Мөнгөний дүн / Amount / үсгээр, тоогоор / in letters				12,000.00 \$	
Арван хоёр мянган ам.доллар 00 цент					
Baraa khatan wesa bуюу ажил үйлчилгээ гүйцэтгэсэн өдөр / Date					
Төлбөрийн зорилго / Purpose's detail / (Баримт болон ажил үйлчилгээний нэр дэглэх баримтын №)					Гүйцэтгэлийн
Эскроу дансруу нилгүүлэг					уриа
					төлбөрийн
					зориулалт
					төлөх
					түгээр
					төлбөрийн
					хэлтэ

Тамга / Stamp



Төрийн үсэг 1 / Signature 1

Төрийн үсэг 2 / Signature 2



Bankind гүйлгээ хийсэн / If for bank use only

2021 он 06 сар 25 өдөр

Гарын үсэг / Signature



## Хавсралт 7 Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт



"ХАТАН ДАЛАЙ" ХХК-Д

МОНГОЛ УСНЫ ЗАСГИЙН ГАРЫН ХЭРСЭЖЭЭРЭГЧИЙН АГСЭСАГ

### УСНЫ ГАЗАР

10000 Төв аймгийн нутаг, Баянтал дунд, 7 дугаар хороо,  
Төв аймгийн үндэс, Утас/Факс: (970-01) 25 44 47,  
И-мэйл: info@mwsc.mn

2024.09.16 № 216/1  
Тангай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт хүргүүлэх тухай

Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь "Матад ХХ" талбайд "Петро Матад" ХХК газрын тосны ашиглалт явуулах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын зарийвчилсан үнэлгээний тайланг "Усны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.10 дахь заалтын дагуу хянаж үзэхэд:

1. "Петро Матад" ХХК нь 2021-2024 онд газрын тос ашиглалтын "Матад ХХ" талбайд 3 хэмжээст чигирхийллийн судалгаа хийж, ашиглалтын 30 цонгог оролдож, олборлолт явуулахаар төлөвлөсөн байна.

2. Төслийн технологийн усны хэрэгцээг БОНХАЖ-ийн Сайдны 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ажил гүйцэтгэл, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцож 2021 онд 9685 м<sup>3</sup>/жил, 2022 онд 15825 м<sup>3</sup>/жил, 2023 онд 15050 м<sup>3</sup>/жил, 2024 онд 18060 м<sup>3</sup>/жил, төсөл хэрэгжих 4 жилийн хугацаанд 58620 м<sup>3</sup>/жил ус ашиглах бөгөөд тус хэрэгцээг өөрийн эзэмшлийн гүний хурдаас ашиглана (Хүдгийн ундарга 5 л/с буюу 157680 м<sup>3</sup>/жил).

3. Унд ахуйн усны хэрэгцээ 2021 онд 1395.5 м<sup>3</sup>/жил, 2022 онд 867 м<sup>3</sup>/жил, 2023 онд 1017 м<sup>3</sup>/жил, 2024 онд 1090 м<sup>3</sup>/жил, нийт 4369.5 м<sup>3</sup>/жил бөгөөд стандартын шаардлага хангасан шаваршуулсан усыг гэрээт байгууллагаас зөөвөрөөр ашиглангана.

Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь "Матад ХХ" талбайд "Петро Матад" ХХК газрын тосны ашиглалт явуулахад усны ашиглах боломжит нөөц хүрэлцээтэй гэж үзэж байна.

Уг төсөл хэрэгжих талбай, ашиглалтын хугацаа нь газрын доорх усны нөөц тогтосон ордын хилтэй давхцалгүй болно.

ДАРГА  ДАРГА МЯГМАР





БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
БУЙР НУУР-МЭНЭНГИЙН ТАЛЫН  
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21063  
Утас/Факс: 7058-3461

2024.03.01 № 25

ТӨСВИЙ 2024.02.22-ны № 023/024 -г

Г "ПЕТРО МАТАД" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ А.ГЭРЭЛТ-ОД ТАНАА

Дорнод аймгийн Матад сум, Мэнэнгийн талын сав газарт орших газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт "Матад ХХ" талбайд 2024 онд явуулах үйл ажиллагааны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хүргүүлж байна.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь зүйлд заасны дагуу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зөвшөөрөл авч, гэрээ байгуулж ажиллахыг мэдэгдье.

Хавсралт...<sup>4</sup>...хуудастай.

ДАРГА



Ш.ХАНГАРЬД

## УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны ᠑᠒ дугаар сарын ᠒1 ны өдөр

Дугаар ᠒1

Чойбалсан хот

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:  
"Петро матад" ХХК, Гуйцэтгэх захирал А.Гэрэлт-Од, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайванд өргөн чөлөө 17, Блюской Таур 508 тоот, Утас: 94575252, улсын бүртгэлийн дугаар: 9019017097, регистрийн дугаар: 2867095

2. Төслийн нэр, байршил:

Дорнод аймгийн Матад сумын нутагт орших газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт "Матад ХХ" талбай 216 км<sup>2</sup> талбайг эзлэн оршино.

3. Төсөл хэрэгжүүлэгч

Петро матад ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат

	Уртраг	Өргөрөг
1.	115° 59' 4.000"	46° 50' 0.000"
2.	116° 16' 42.000"	46° 50' 0.000"
3.	116° 16' 42.000"	46° 48' 58.500"
4.	116° 14' 52.000"	46° 48' 58.500"
5.	116° 14' 52.000"	46° 47' 37.000"
6.	116° 11' 44.000"	46° 47' 37.000"
7.	116° 11' 44.000"	46° 47' 0.000"
8.	116° 11' 6.000"	46° 47' 0.000"
9.	116° 11' 6.000"	46° 46' 35.000"
10.	116° 8' 48.000"	46° 46' 35.000"
11.	116° 8' 48.000"	46° 46' 18.500"
12.	116° 8' 11.000"	46° 46' 18.500"
13.	116° 8' 11.000"	46° 45' 45.500"
14.	116° 7' 38.000"	46° 45' 45.500"
15.	116° 7' 38.000"	46° 45' 13.000"
16.	116° 8' 58.000"	46° 45' 13.000"
17.	116° 8' 58.000"	46° 44' 38.000"
18.	116° 6' 21.000"	46° 44' 38.000"
19.	116° 6' 21.000"	46° 43' 30.000"
20.	115° 55' 32.500"	46° 43' 30.000"
21.	115° 55' 32.500"	46° 46' 34.000"
22.	115° 56' 30.000"	46° 46' 34.000"
23.	115° 56' 30.000"	46° 47' 27.000"
24.	115° 57' 24.000"	46° 47' 27.000"
25.	115° 57' 24.000"	46° 48' 14.000"
26.	115° 58' 15.000"	46° 48' 14.000"
27.	115° 58' 15.000"	46° 49' 3.000"
28.	115° 59' 4.000"	46° 49' 3.000"

5. Үйлдвэрлэл үйлчилгээний нэр, төрөл зориулалт:

Газрын тосны хайгуул, олборлолт хийх.

6. Үйлдвэрийн техник, технологи лажиллах горим, хүчин чадал:

Хонот 2 ээлжээр, нийт 250 хүн 190 хонот ажиллана.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

2024 онд Газрын тос олборлолтын өрөмдлөг хийнэ. Цэн тогоруу 2-4 дүгээр ценогийн өрөмдлөг хийхээр төлөвлөсөн. Байршлын координат.

Цэн тогоруу - 2	116° 07' 26.88"	46° 49' 15.02"
Цэн тогоруу - 3	116° 07' 26.00"	46° 49' 30.00"
Цэн тогоруу - 4	116° 07' 38.40"	46° 49' 51.610"

**8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо метрээр/:**

Дорнод аймгийн Матад сумын нутаг Матад ХХ талбайд 2024 онд хийсэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрс, ус, агаар, дуу чимээ, амьтдын ажиглалт хийсэн цэгүүдийн байршлыг доорх зурагт үзүүлэв.

Зураг 5. БОХШХ дээжлэлт, ажиглалтын цэгийн байршил



## 2.4 АГААР ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024 -Н ГҮЙЦЭТГЭЛ

### 2.4.1 Агаарын чанарын хэмжилт, арга, ажиглалтын дүн


Матад ХХ талбайн агаарын чанарын мониторинг судалгааны хүрээнд түгээмэл бохирдуулагчид болох хүхэрлэг хий ( $SO_2$ ), азотын давхар исэл ( $NO_2$ ), нийт тоосонцор (TPS), дуу чимээг шууд хэмжлийн багажаар төлөвийг тодорхойлсон үр дүнг энэ хэсэгт орууллаа.

*Хүснэгт 3. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгийн байршил*

№	Хэмжилтийн цэгийн дугаар	Байршил	Өргөрөг	Уртраг
1	20M-A-01	Цэн тогоруу-1	46° 49' 52.7"	116° 08' 35.73"
2	20M-A-02	Warehouse	46° 48' 54.38"	116° 10' 04.38"
3	20M-A-03	Цагаан зээр-1	46° 49' 28.42"	116° 06' 43.4"
4	20M-A-04	Замын уулзвар	46° 49' 06.29"	116° 06' 24.31"
5	20M-A-05	Ашиглалт явагдаагүй талбай	46° 44' 52.7"	116° 08' 35.73"

а.

Зураг 6. Талбайн агаарын чанарын хэмжилтийн цэг



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Зураг 7. Агаарын чанарын хэмжилт 20М-А-01 /Цэн тогоруу-1/*



*Хүснэгт 4. 20М-А-01 цэгийн хэмжилтийн дүн (нэгж: мкг/м<sup>3</sup>)*

№	Цэгийн дугаар	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос	Дуу чимээ
1	20М-А-01	10	26	12	42
	<b>Агаарын чанарын стандарт MNS4585:2016</b>	<b>450</b>	<b>200</b>	<b>500</b>	<b>60</b>

Агаарын чанарын хэмжилтийн 20М-А-01 цэг нь Цэн тогоруу-1 цооног өрөмдсөн талбай бөгөөд тухайн талбайн өнгөн хөрсийг хуулж зассан байна. Агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээс харахад Хүхэрлэг хийн хэмжээ 10 мкг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн хэмжээ 26 мкг/м<sup>3</sup>, нийт тоосны агууламж 12 мкг/м<sup>3</sup>, дуу чимээ 42 дБа буюу Агаарын чанарын стандарт MNS4585:2016-аас давсан үзүүлэлт байхгүй байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Зураг 8. Агаарын чанарын хэмжилт 20M-A-02 /Warehouse /*



*Хүснэгт 5. 20M-A-02 цэгийн хэмжилтийн дүн (нэгж: мкг/м<sup>3</sup>)*

№	Цэгийн дугаар	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос	Дуу чимээ
1	20M-A-02	13	22	60	38
<b>Агаарын чанарын стандарт MNS4585:2016</b>		<b>450</b>	<b>200</b>	<b>500</b>	<b>60</b>

Агаарын чанарын хэмжилтийн 20M-A-02 цэг нь төслийн агуулах байрлаж байгаа талбай бөгөөд тухайн агуулахыг хашаалсан, цоожтой байсан тул хашааны гадна талаас авсан болно. Агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээс харахад Хүхэрлэг хийн хэмжээ 13 мкг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн хэмжээ 22 мкг/м<sup>3</sup>, нийт тоосны агууламж 60 мкг/м<sup>3</sup>, дуу чимээ 38 дБа буюу Агаарын чанарын стандарт MNS4585:2016-аас давсан үзүүлэлт байхгүй байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Зураг 9. Агаарын чанарын хэмжилт 20М-А-03 /Цагаан зээр-1/*



*Хүснэгт 6. 20М-А-03 цэгийн хэмжилтийн дүн (нэгж: мкг/м<sup>3</sup>)*

№	Цэгийн дугаар	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос	Дуу чимээ
1	20М-А-03	11	33	94	48
<b>Агаарын чанарын стандарт MNS4585:2016</b>		<b>450</b>	<b>200</b>	<b>500</b>	<b>60</b>

Агаарын чанарын хэмжилтийн 20М-А-03 цэг нь Цагаан зээр-1 цооног өрөмдөхөөр төлөвлөсөн талбай бөгөөд тухайн талбайд одоогийн байдлаар цооног өрөмдөөгүй онгон зэлүүд хэвээр байна. Агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээс харахад Хүхэрлэг хийн хэмжээ 11 мкг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн хэмжээ 33 мкг/м<sup>3</sup>, нийт тоосны агууламж 94 мкг/м<sup>3</sup>, дуу чимээ 48 дБа буюу Агаарын чанарын стандарт MNS4585:2016-аас давсан үзүүлэлт байхгүй байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Зураг 10. Агаарын чанарын хэмжилт 20М-А-04 /Замын уулзвар/*



*Зураг 11. Замын уулзвар*





**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Хүснэгт 7. 20М-А-04 цэгийн хэмжилтийн дүн (нэгж: мкг/м<sup>3</sup>)*

№	Цэгийн дугаар	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос	Дуу чимээ
1	20М-А-04	11	28	12	50
<b>Агаарын чанарын стандарт MNS4585:2016</b>		<b>450</b>	<b>200</b>	<b>500</b>	<b>60</b>

Агаарын чанарын хэмжилтийн 20М-А-04 цэг нь Цэн тогоруу 1 талбайгаас-“Петро Чайна Дачин Тамсаг” ХХК-ий газрын тос экспортлох сайжруулсан зам дайрсан уулзвар юм. Агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээс харахад Хүхэрлэг хийн хэмжээ 11 мкг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн хэмжээ 28 мкг/м<sup>3</sup>, нийт тоосны агууламж 12 мкг/м<sup>3</sup>, дуу чимээ 50 дБа буюу Агаарын чанарын стандарт MNS4585:2016-аас давсан үзүүлэлт байхгүй байна.

*Зураг 12. Агаарын чанарын хэмжилт 20М-А-05 /Ашиглалт төлөвлөгдөөгүй талбай/*



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Хүснэгт 8. 20М-А-05 цэгийн хэмжилтийн дүн (нэгж: мкг/м<sup>3</sup>)*

№	Цэгийн дугаар	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос	Дуу чимээ
1	20М-А-05	12	31	85	40
<b>Агаарын чанарын стандарт MNS4585:2016</b>		<b>450</b>	<b>200</b>	<b>500</b>	<b>60</b>

Агаарын чанарын хэмжилтийн 20М-А-05 цэг нь ашиглалт явагдаагүй цаашид ямар нэгэн ашиглалт төлөвлөөгүй онгон зэлүүдээрээ байгаа талбай бөгөөд төслийн талбайн урд хэсэгт Бүрдний гол нэртэй газрын хойд талд хужир мараа бүхий талбай юм. Агаарын чанарын хэмжилтийн үр дүнгээс харахад Хүхэрлэг хийн хэмжээ 12 мкг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн хэмжээ 31 мкг/м<sup>3</sup>, нийт тоосны агууламж 85 мкг/м<sup>3</sup>, дуу чимээ 40 дБа буюу Агаарын чанарын стандарт MNS4585:2016-аас давсан үзүүлэлт байхгүй байна.

### 2.4.2 Агаарын чанарын хэмжилтийн үр дүн

Цэн тогоруу-1, Цагаан зээр-1, төслийн талбай дахь агуулахын хашааны гадна, төслийн талбайн урд хэсэг, замын уулзвараас болон ашиглалт төлөвлөгдөөгүй талбай гэсэн нийт 5 цэгт агаарын чанарын хэмжилтийг хийж үр дүнг MNS4585:2016 агаарын чанарын орчны стандартын хоногийн зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй (ЗДХ) харьцуулав (Хүснэгт 9-д үзүүлэв).

*Хүснэгт 9. Төслийн талбай хэмжилтийн дүн (нэгж: мкг/м<sup>3</sup>)*

№	Цэгийн дугаар	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос	Дуу чимээ
1	20М-А-01	10	26	12	42
2	20М-А-02	13	22	60	38
3	20М-А-03	11	33	94	48
4	20М-А-04	11	28	12	50
5	20М-А-05	12	31	85	40
<b>Агаарын чанарын стандарт MNS4585:2016</b>		<b>450</b>	<b>200</b>	<b>500</b>	<b>60</b>

*Эх сурвалж: Сүхбаатар, Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль Орчин Шинжилгээний Лабораторийн шинжилгээний дүнгээр*


*Хүснэгт 10. Азотын давхар исэлийн хэмжилт*

№	Цэгийн дугаар	Азотын давхар исэл	Агаарын чанарын стандарт MNS4585:2016
1	20М-А-01	22	200
2	20М-А-02	33	
3	20М-А-03	28	
4	20М-А-04	31	
5	20М-А-05	26	

b.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

График 1. Азотын давхар исэл




Хүснэгт 11. Хүхэрлэг хийн хэмжилт

№	Цэгийн дугаар	Хүхэрлэг хий	Агаарын чанарын стандарт MNS4585:2016
1	20M-A-01	10	450
2	20M-A-02	13	
3	20M-A-03	11	
4	20M-A-04	11	
5	20M-A-05	12	

с.

График 2. Хүхэрлэг хий




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 12. Нийт тоос

№	Цэгийн дугаар	Нийт тоос	Агаарын чанарын стандарт MNS4585:2016
1	20М-А-01	12	500
2	20М-А-02	60	
3	20М-А-03	94	
4	20М-А-04	12	
5	20М-А-05	85	

d.

График 3. Нийт тоос




Хүснэгт 13. Дуу чимээ

№	Цэгийн дугаар	Дуу чимээ	Агаарын чанарын стандарт MNS4585:2016
1	20М-А-01	42	60
2	20М-А-02	38	
3	20М-А-03	48	
4	20М-А-04	50	
5	20М-А-05	40	

e.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

График 4. Дуу чимээ



f. Хүснэгт 11. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Утга	Батлагдсан БОХШХ төлөвлөгөө	Ажил эхлэхээс өмнөх БОХШХ-ийн гүйцэтгэл	Тайлбар
ААН	Үйл ажиллагаа хариуцагч байгууллага: Петро Матад ХХК	БОХШХ гүйцэтгэгч: Эм И Си Эс Зэт Би ХХК	Гэрээ байгуулагдсан.
БОХШХ-Ш1: Агаарын чанар	<p>- Нийт тархсан тоосонцор (TSP), Тоос (PM<sub>2.5</sub>, PM<sub>10</sub>) - 3 хэмжээст чичирхийллийн судалгааны талбай, өрөмдлөгийн талбай болон талбайгаас 1 км зайд хяналтын 10 цэгт - Жилд 2 удаа хавар болон намар,</p> <p>- SO<sub>2</sub>, NO<sub>2</sub> - Өрөмдлөгийн талбай болон талбайгаас 1 км зайд хяналтын 10 цэгт - эхлэхийн өмнө болон дараа</p> <p>- Дуу чимээ – 10 цэгт жилд 2 удаа</p>	<p>Нийт 5 цэгээс агаар дах тоосны хэмжилтийг хийхэд стандартын зөвшөөрөгдөх түвшинд байна.</p> <p>Бохирдлын үзүүлэлтийг тодорхойлох дээжлэлтийг шууд хэмжлийн багажаар тодорхойлсон. Хэмжилтийн дундаж утга Хүхэрлэг хийн хэмжээ 10-13 мкг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн хэмжээ 22-33 мкг/м<sup>3</sup>, нийт тоосны агууламж 12-94 мкг/м<sup>3</sup>, дуу чимээ 38-50 дБа буюу Агаарын чанарын стандарт MNS4585:2016-аас давсан үзүүлэлт байхгүй байна.</p>	<p>Үйл ажиллагаа явагдаагүй байгаа тул хэмжилтийн дүнгүүд стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд буюу бохирдолгүй байна, мөн цаг агаарын хувьд салхитай эхний өдөр буюу 20M-S-01, 20M-S-05 цэгүүдэд хэмжилт хийхэд шиврээ бороотой байв.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

<p>Дүгнэлт:</p>	<p>Цэн тогоруу -1 талбай нь үйл ажиллагаа явагдаагүй орчны тоосжилт, түгээмэл бохирдуулагчийн хэмжилтийн дүн агаарын чанарын түгээмэл бохирдуулагчийн агууламж техникийн ерөнхий шаардлага MNS4585:2007-ийн хэмжээнд тодорхойлогдсон. Хот сууринаас алслагдсан бүс нутагт агаарын түгээмэл бохирдуулагч маш бага байдаг. Хүхэрлэг хий нь хүхэр агуулсан шатах материалын шаталтаас үүсдэг бол азотын давхар исэл нь өндөр температурт шаталтаас үүсэх бохирдуулагчид тул хөдөө хээр газар, хүн ам бага суурьшсан бүсүүдэд бага байдаг. Тоос, тоосонцрын агууламж хавар намрын улиралд хүчтэй шороон шуурганы үер стандарт хэмжээнээс давах тохиолдолд байдаг ч цөөн тохиолддог.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Агаар дах хүнд металл тодорхойлохгүйгээр орчны хөрсний дээжид хүнд металл тодорхойлуулахаар дээжлэлт хийсэн.</li> <li>- Орчны агаараас үнс, цацрагийн дээжлэлт авах боломжгүй байсан ба дараагийн удаагийн хөрсний дээжлэлтэд тус дээжлэлтийг авч, шинжлүүлэхээр төлөвлөв.</li> </ul>		
<p>Утга</p>	<p><b>Батлагдсан БОХШХ төлөвлөгөө</b></p>	<p><b>Ажил эхлэхээс өмнөх БОХШХ-ийн гүйцэтгэл</b></p>	<p><b>Тайлбар</b></p>
<p>Зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйл ажиллагаа явагдахад машин техник хэрэгслийн нөлөөгөөр орчинд тоосжилт, агаар бохирдуулах бодисууд ялгарна, тухайн үед талбарт ажиллахад хэмжилт, дээжлэлтийг төлөвлөгөөний дагууд хийж гүйцэтгэнэ.</li> <li>- Тоосжилт үүсэх нөхцөлүүдийг тухай бүр БОННУ болон БОМТ тусгагдсан арга хэмжээ авах орчны айл өрх, мал амьтанд бохирдол үүсэхээс сэргийлэх шаардлагатай.</li> <li>- Үйл ажиллагааны хүрээнд агаар орчны бохирдол үүсгэх аваас экологи эдийн засгийн хохирлын үнэлгээний өртгөөр БОМТ барьцаа хөрөнгө байршуулсан ба тухайн гүйцэтгэлийг үнэлэх ажиллах, төлбөр тооцоог тооцох.</li> <li>- Техник хэрэгслийн аюулгүй ажиллагаа, үзлэг оношилгоо, агаар бохирдлын төлбөр тооцоог цаг тухайд нь барагдуулсан байх.</li> <li>- Аливаа үйл ажиллагаа эхлэхэд зам ашиглалт, тоосжилт үүсэхээс сэргийлж, 1 зам, маршрутын бодлого баримтлах. Замын тэмдэг тэмдэглэгээг тодорхой байршуулах.</li> </ul>		

## 2.5 УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

### 2.5.1 Усны мониторинг


Талбайд усны талаарх хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон биелэлтийг энэ хэсэгт авч үзэв. Матад ХХ талбай нь сав газрын ангиллаар Буйр нуур Мэнэнгийн голын ай сав газарт хамаарна. Усгүй жижиг, хужир мараа бүхий хонхор хотос газар төслийн талбай дотор нэлээд олон байна. Талбай болон түүний орчмын нутгийн хүн амын ундны усан хангамжид энгийн болон гүний худгуудыг түлхүү ашиглана.

Гадаргын усыг төлөөлүүлэн төслийн талбайгаас хойд талд талбайн хамгийн хойд захаас шулуунаар 4.5 км зайд орших Хөвөө нуурын усанд, газрын доорх усыг төлөөлүүлэн Петро Матад ХХК-ийн гүний худаг, Малчны худаг гэсэн 3 цэгээс усны ерөнхий химийн шинжилгээ, хүнд металлын шинжилгээ, төслийн худаг болон малчны худгийн уснаас цацраг идэвхийн шинжилгээг хийлгэсэн.

Хүснэгт 14. Дээжлэлтийн худгийн мэдээлэл

№	Уст цэгийн байршил	Нэр
1	46° 47' 58.96" 116° 12' 59.1"	Петро матад ХХК-ийн гүний худаг
2	46° 52' 39.24" 116° 13' 07.17"	Хөвөө нуур
3	46° 41' 48.4" 116° 06' 56.11"	Малчны гүний худаг

Зураг 13. усны дээж авсан цэгийн байршил





## 2.5.2 Усны химийн найрлага

### 20M-W-01

20M-W-01 буюу Петро Матад ХХК-ийн гүний худаг төслийн талбай дотор төслийн агуулахын хашааны ар талд,  $46^{\circ} 47' 58.96''$   $116^{\circ} 12' 59.1''$  цэгт байрлаж байна.

Зураг 14. Петро матад ХХК-ийн худгийн уснаас дээж авалт,  $46^{\circ} 47' 58.96''$   $116^{\circ} 12' 59.1''$



20M-W-01 төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшиж буй худгийн усны цахилгаан дамжуулах чанар  $4070 \mu\text{s}/\text{cm}$ , нийт ууссан уусмал  $2239 \text{ ppm}$  байсан ба химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, хлор, сульфат, натри, магнийн ионууд нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарт MNS0900:2018” стандарт заасан хэмжээнээс их байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Хүснэгт 14. 20М-W-01 мониторингийн цэгийн усны химийн найрлага, 2024-I*

Хэмжсэн үзүүлэлтүүд	1дм <sup>3</sup> -д байгаа		
	мг/л	мг-экв/л	мг-экв%
<b>Na<sup>+</sup>+ K<sup>+</sup></b>	789.9	34.34	77.5
<b>Ca<sup>2+</sup></b>	68.1	3.40	7.7
<b>Mg<sup>2+</sup></b>	79.9	6.57	14.8
<b>NH<sub>4</sub><sup>+</sup></b>	0.1	0.01	0.0
<b>Fe<sup>2+</sup></b>	0.0	0.0	0.0
<b>Fe<sup>3+</sup></b>	0.0	0.0	0.0
<b>Нийт катион</b>	938.0	44.32	100.0
<b>Cl<sup>-</sup></b>	739.5	20.83	47.0
<b>SO<sub>4</sub><sup>-</sup></b>	750.0	15.63	35.3
<b>NO<sub>2</sub><sup>-</sup></b>	2.1	0.05	0.1
<b>NO<sub>3</sub><sup>-</sup></b>	26.0	0.42	0.9
<b>CO<sub>3</sub><sup>-</sup></b>	0.0	0.0	0.0
<b>HCO<sub>3</sub><sup>-</sup></b>	451.4	7.40	16.7
<b>Нийт анион</b>	1969.0	44.32	100.0

HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр 2681.3 мг/дм<sup>3</sup>, анион катионуудын нийлбэр 2907.0 мг/дм<sup>3</sup>, ерөнхий хатуулаг 9.97 мг-экв/дм<sup>3</sup>, усны цахилгаан дамжуулах чанар 4070 μs/cm, нийт ууссан уусмал 2239 ppm, исэлдэх чанар 4.00 мг/дм<sup>3</sup> байна. Физик шинж чанарын хувьд тунгалаг нь 30 см, үнэргүй, өнгөгүй, үл мэдэг тунадастай.

**20М-W-02**

20М-W-02 буюу төслийн талбайгаас хойд талд талбайн хамгийн хойд захаас шулуунаар 4.5 км зайд орших Хөвөө нуураас 46° 52' 39.24" 116° 13' 07.17" цэгээс усны дээжийг авав. Усны дээжийг авах үед буюу 2024 оны 6-р сарын 10-д нуурын ус захаараа ширгэж нуурын доод шавар ёроол гарсан байсан ба цаашаа явж ус авах боломжгүй доошоо шигдэж байсан тул нуурын зах руу 20 м орчим орж шаварт тогтсон уснаас авав.

*Зураг 15. Хөвөө нуураас дээж авалт, 46° 52' 39.24" 116° 13' 07.17"*

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



Зураг 16. Хөвөө нуур



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Зураг 17. Хөвөө нуурын шал (ус ширгэсэн байв)*



20M-W-02 Хөвөө нуурын усны цахилгаан дамжуулах чанар 746000  $\mu\text{s}/\text{cm}$ , нийт ууссан уусмал 447600 ppm байсан ба химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, магнийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд шорвог, маш хатуу, хүчтэй шүлтлэг орчинттой, органик болон органик бус бохирдолтой, маш их булингартай ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс сульфат, хлорын агууламж нь “Усан орчны чанарын үзүүлэлт MNS4586:1998” стандарт заасан хэмжээнээс их байна.

*Хүснэгт 15. 20M-W-02 мониторингийн цэгийн усны химийн найрлага, 2024-I*


Хэмжсэн үзүүлэлтүүд	1дм <sup>3</sup> -д байгаа		
	мг/л	мг-экв/л	мг-экв%
<b>Na<sup>+</sup>+ K<sup>+</sup></b>	39505.1	1717.61	19.7
Ca <sup>2+</sup>	1801.6	89.90	1.0
<b>Mg<sup>2+</sup></b>	83052.8	6830.00	78.5
<b>NH<sub>4</sub><sup>+</sup></b>	197628.5	5567.00	64.0
<b>Fe<sup>2+</sup></b>	150000.0	3125.00	35.9
<b>Fe<sup>3+</sup></b>	1238.0	66.49	0.8
<b>Нийт катион</b>	125.597.5	8704.00	100.0
<b>Cl<sup>-</sup></b>	197628.5	5567.00	64.0
<b>SO<sub>4</sub><sup>-</sup></b>	150000.0	3125.00	35.9
<b>NO<sub>2</sub><sup>-</sup></b>	0.1	0.00	0.00

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

<b>NO<sub>3</sub><sup>-</sup></b>	0.00	0.00	0.00
<b>CO<sub>3</sub><sup>-</sup></b>	180.0	6.00	0.1
<b>HCO<sub>3</sub><sup>-</sup></b>	366.0	6.00	0.1
<b>Нийт анион</b>	348174.6	8704.00	100.0

HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр 473589.1 мг/дм<sup>3</sup>, анион катионуудын нийлбэр 473772.1 мг/дм<sup>3</sup>, ерөнхий хатуулаг 6919.90 мг-экв/дм<sup>3</sup>, усны цахилгаан дамжуулах чанар 746000 μs/cm, нийт ууссан уусмал 447600 ppm, исэлдэх чанар 352.00 мг/дм<sup>3</sup> байна. Физик шинж чанарын хувьд тунгалаг нь 0 см, үнэргүй, өнгө хар бор, давстай амттай, шороон тунадастай.

График 5. 20M-W-02 цэгийн усны химийн найрлага



Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

**20M-W-03**

20M-W-03 буюу малчны гүний худаг нь төслийн талбайгаас урагш 3 км зайд , 46° 41' 48.4'' 116° 06' 56.11'' цэгт байрлаж байна.

Зураг 18. Малчны худгийн уснаас дээж авалт, 46° 41' 48.4'' 116° 06' 56.11''



20M-W-02 төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшиж буй худгийн усны цахилгаан дамжуулах чанар 5548  $\mu\text{s}/\text{cm}$ , нийт ууссан уусмал 3329 ppm байсан ба химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд давстай, хатуувтар ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, хлор, сульфат, натри, магнийн ионууд нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарт MNS0900:2018” стандарт заасан хэмжээнээс их байна.

Хүснэгт 16. 20M-W-03 мониторингийн цэгийн усны химийн найрлага, 2024-I


Хэмжсэн үзүүлэлтүүд	1дм <sup>3</sup> -д байгаа		
	мг/л	мг-экв/л	мг-экв%
Na <sup>+</sup> K <sup>+</sup>	1179.0	51.26	88.2
Ca <sup>2+</sup>	37.3	1.86	3.2

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

<b>Mg<sup>2+</sup></b>	60.8	5.00	8.6
<b>NH<sub>4</sub><sup>+</sup></b>	0.1	0.01	0.0
<b>Fe<sup>2+</sup></b>	0.0	0.0	0.0
<b>Fe<sup>3+</sup></b>	0.0	0.0	0.0
<b>Нийт катион</b>	1277.2	58.13	100.0
<b>Cl<sup>-</sup></b>	976.6	27.51	47.3
<b>SO<sub>4</sub><sup>-</sup></b>	980.0	20.42	35.1
<b>NO<sub>2</sub><sup>-</sup></b>	0.0	0.0	0.0
<b>NO<sub>3</sub><sup>-</sup></b>	0.0	0.0	0.0
<b>CO<sub>3</sub><sup>-</sup></b>	0.0	0.0	0.0
<b>HCO<sub>3</sub><sup>-</sup></b>	622.2	10.20	17.5
<b>Нийт анион</b>	2578.8	58.13	100.0

HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр 3544.9 мг/дм<sup>3</sup>, анион катионуудын нийлбэр 3856.0 мг/дм<sup>3</sup>, ерөнхий хатуулаг 6.86 мг-экв/дм<sup>3</sup>, усны цахилгаан дамжуулах чанар 5548 μs/cm, нийт ууссан уусмал 3329 ppm, исэлдэх чанар 4.64 мг/дм<sup>3</sup> байна. Физик шинж чанарын хувьд тунгалаг нь 22 см, үнэргүй, сул шаргал өнгөтэй, бага зэрэг тунадастай.

*График 6. 20M-W-01, 20M-W-03 цэгүүдийн усны химийн найрлага*



### 2.5.3 Усанд агуулагдах хүнд металлын агууламж

Төслийн талбайгаас хойд талд талбайн хамгийн хойд захаас шулуунаар 4.5 км зайд орших Хөвөө нуур, Петро Матад ХХК-ийн гүний худаг, Малчны худаг гэсэн 3 цэгээс усны хүнд металлын шинжилгээг хийлгэсэн усанд тодорхойлсон элементүүдийн агуулгыг ихээс бага руу жагсаан 17,18-д нэгтгэн харуулав.

Худгийн усны дээжид тодорхойлсон нийт элементүүдийн ихэнх нь дээрх усны дээжид илэрсэн бөгөөд зарим нэг нийтлэг элементүүд хэмжилт хийсэн багажийн илрүүлэх хязгаараас бага гарсан байна (Fe, Al, Ba, Cu, Cr, Ti, V, Be, Ag, In, Sn, Sb, Te, La, Ce, Sm, Tb, Ho, Tm, Lu, Hg, Pb, Bi).

Дээрх усны дээжид агуулагдаж буй микро элементүүдийн агуулгыг Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартад заасантай харьцуулахад Mg, Mn, Na, Mo, As, Se, U-ийн агуулга өндөр байна.

*Хүснэгт 17. Газрын доорх усны тодорхойлсон микро элементүүдийн агуулга. Усны чанарын үзүүлэлт болох MNS 4586: 1998 стандарт.*

Д/д	Элемент үүд	нэгж	Detection limit	Дээжний нэр, код		MNS0900:2018 стандарт
				Компаний худаг 20M-W-01	Малчны худаг 20M-W-03	
1.	Al	µг/л	10	<10	<10	0.5
2.	Ba	µг/л	10	<10	<10	0.7
3.	Ca	µг/л	0.05	84.9	38.7	100
4.	Cr	µг/л	10	<10	<10	0.05
5.	Cu	µг/л	5	<5	<5	2.0
6.	Fe	µг/л	50	<50	<50	0.3
7.	K	µг/л	0.1	4.5	3.9	
8.	Mg	µг/л	0.05	88.6	56.1	30.0
9.	Mn	µг/л	5	28	169	0.1
10.	Na	µг/л	0.05	840	1130	200.0
11.	P	µг/л	50	145	128	
12.	Sr	µг/л	1	1875	1164	
13.	Ti	µг/л	10	<10	<10	
14.	V	µг/л	10	<10	<10	
15.	Zn	µг/л	5	<5	<5	5.0
16.	Be	µг/л	0.1	<0.1	<0.1	
17.	Sc	µг/л	1	4	5	
18.	Co	µг/л	0.06	0.67	0.26	
19.	Ni	µг/л	0.3	1.3	<0.3	
20.	Ga	µг/л	0.02	0.04	0.06	
21.	Mo	µг/л	0.1	16	30.4	0.07
22.	As	µг/л	0.03	11	10.5	0.01
23.	Se	µг/л	0.2	71.5	17.6	0.04
24.	Rb	µг/л	0.01	2.81	4.9	
25.	Y	µг/л	0.005	0.041	0.032	
26.	Zr	µг/л	0.05	0.29	0.37	
27.	Nb	µг/л	0.005	0.503	0.46	
28.	Ag	µг/л	0.2	<0.2	<0.2	0.1



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

29.	Cd	µг/л	0.01	0.01	0.02	
30.	In	µг/л	0.001	<0.001	<0.001	
31.	Sn	µг/л	0.1	<0.1	<0.1	
32.	Sb	µг/л	0.2	<0.2	<0.2	
33.	Te	µг/л	0.1	<0.1	<0.1	
34.	Cs	µг/л	0.001	0.015	0.092	
35.	La	µг/л	0.01	<0.01	0.04	
36.	Ce	µг/л	0.05	<0.05	<0.05	
37.	Pr	µг/л	0.006	<0.006	0.01	
38.	Nd	µг/л	0.01	<0.01	0.01	
39.	Sm	µг/л	0.002	<0.002	<0.002	
40.	Eu	µг/л	0.001	0.001	0.001	
41.	Gd	µг/л	0.003	<0.003	0.006	
42.	Tb	µг/л	0.002	<0.002	<0.002	
43.	Dy	µг/л	0.001	0.001	0.004	
44.	Ho	µг/л	0.001	<0.001	<0.001	
45.	Er	µг/л	0.001	0.001	0.001	
46.	Tm	µг/л	0.001	<0.001	<0.001	
47.	Yb	µг/л	0.001	0.001	0.004	
48.	Lu	µг/л	0.002	<0.002	<0.002	
49.	Hf	µг/л	0.004	0.185	0.081	
50.	Ta	µг/л	0.001	0.357	0.38	
51.	W	µг/л	0.05	1.41	1.43	
52.	Hg	µг/л	0.5	<0.5	<0.5	0.001
53.	Tl	µг/л	0.007	0.059	<0.007	
54.	Pb	µг/л	0.5	<0.5	<0.5	0.01
55.	Bi	µг/л	0.01	<0.01	<0.01	
56.	Th	µг/л	0.002	0.068	0.067	
57.	U	µг/л	0.004	97.3	64	0.03

Хөвөө нуурын уснаас авсан усны дээжид агуулагдаж буй микро элементүүдийн агуулгыг MNS4586:1998 стандартад заасантай харьцуулахад P, Mn, Se, Rb, Co, Ni-ийн агуулга өндөр байна. Үүнээс гадна Al, Mg, Na, Sr элементүүдийн агууламж маш өндөр байгаа нь дээжийг авах үед нуурын ус ширгэсэн байсан тул нуурын лаг шавар дээр мал, амьтны хөлд тогтож, шүүрч гарч ирсэн уснаас авсантай холбоотой байна.

*Хүснэгт 18. Гадаргын усны тодорхойлсон микро элементүүдийн агуулга. Усны чанарын үзүүлэлт болох MNS 4586: 1998 стандарт.*

Д/д	Элемент үүд	нэгж	Detection limit	Дээжний нэр, код	MNS4586:1998 стандарт
				Хөвөө нуурын ус 20M-W-02	
1.	Al	µг/л	10	6995	
2.	Ba	µг/л	10	37	
3.	Ca	µг/л	0.05	89.9	100
4.	Cr	µг/л	10	<10	100
5.	Cu	µг/л	5	<5	250
6.	Fe	µг/л	50	1238	
7.	K	µг/л	0.1	588	
8.	Mg	µг/л	0.05	6830	
9.	Mn	µг/л	5	612	10

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

10.	Na	µг/л	0.05	26700	
11.	P	µг/л	50	2883	10
12.	Sr	µг/л	1	7442	
13.	Ti	µг/л	10	152	
14.	V	µг/л	10	<10	
15.	Zn	µг/л	5	11	
16.	Be	µг/л	0.1	0.8	10
17.	Sc	µг/л	1	3	
18.	Co	µг/л	0.06	183	10
19.	Ni	µг/л	0.3	186	10
20.	Ga	µг/л	0.02	1.92	
21.	Mo	µг/л	0.1	110	
22.	As	µг/л	0.03	415	
23.	Se	µг/л	0.2	1690	10
24.	Rb	µг/л	0.01	86.5	5
25.	Y	µг/л	0.005	1.44	
26.	Zr	µг/л	0.05	4.49	
27.	Nb	µг/л	0.005	1.01	
28.	Ag	µг/л	0.2	<0.2	5
29.	Cd	µг/л	0.01	0.22	
30.	In	µг/л	0.001	0.096	
31.	Sn	µг/л	0.1	0.3	
32.	Sb	µг/л	0.2	2.5	
33.	Te	µг/л	0.1	0.9	
34.	Cs	µг/л	0.001	2.37	
35.	La	µг/л	0.01	4.02	
36.	Ce	µг/л	0.05	7.11	
37.	Pr	µг/л	0.006	1.16	
38.	Nd	µг/л	0.01	2.98	
39.	Sm	µг/л	0.002	0.807	
40.	Eu	µг/л	0.001	0.172	
41.	Gd	µг/л	0.003	1.01	
42.	Tb	µг/л	0.002	0.131	
43.	Dy	µг/л	0.001	0.607	
44.	Ho	µг/л	0.001	0.129	
45.	Er	µг/л	0.001	0.429	
46.	Tm	µг/л	0.001	0.077	50
47.	Yb	µг/л	0.001	0.326	
48.	Lu	µг/л	0.002	0.044	
49.	Hf	µг/л	0.004	0.552	100
50.	Ta	µг/л	0.001	0.606	
51.	W	µг/л	0.05	2.02	
52.	Hg	µг/л	0.5	<0.5	
53.	Tl	µг/л	0.007	0.21	
54.	Pb	µг/л	0.5	19.1	
55.	Bi	µг/л	0.01	0.15	
56.	Th	µг/л	0.002	2.36	
57.	U	µг/л	0.004	1300	

## 2.5.4. Усны цацрагийн дэвсгэр түвшин

Төслийн талбайг төлөөлүүлэн Петро Матад ХХК-ийн гүний худаг болон малчны худгаас 2024 оны 6-р сарын 9-ний өдөр усны дээжийг авав. Усны дээж авсан цэгүүдийн байрлалыг 18-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 19. Цацрагийн дээж авсан уст цэгийн байршил

Дээжний дугаар	Дээжний нэр	Уртраг	Өргөрөг	ДТД өндөр, м	Тайлбар
20M-W-01	Петро матад ХХК-ийн гүний худаг	116° 12' 59.1''	46° 47' 58.96''	674	Мотороор усаа шахдаг гүний худаг
20M-W-03	Малчны гүний худаг	116° 06' 56.11''	46° 41' 48.4''	709	Мотороор усаа шахдаг гүний худаг

Ураны байгалийн цацраг идэвхт бүлд үүсэх радоны задралын богино наст бүтээгдэхүүнүүд  $^{214}\text{Pb}$ ,  $^{214}\text{Bi}$ -ээс гарах гамма квантуудыг хагас дамжуулагч детектороор бүртгэж, анализаторын спектрийн хамгийн их эрчимтэй гамма шугамуудыг 351.9кэВ, 609.3кэВ-ийн бүрэн шингээлтийн пикийн талбай буюу импульсийн тоогоор задралын богино наст бүтээгдэхүүнүүдтэйгээ цацраг идэвхийн тэнцвэрт орших радоны эзлэхүүнт идэвхийг тодорхойлно. Усны дээжүүдэд радоны эзлэхүүнт идэвхийг дараах томъёогоор тооцоолов.

$$A = \frac{S(E_i) - S_{\phi}(E_i)}{K \cdot \varepsilon_0(E) \cdot k_{\gamma} \cdot V \cdot t_{\text{хэм}}}$$

Үүнд: A – эзлэхүүнт идэвх, Бк/л

$S(E_i)$  – бүрэн шингээлтийн пикийн талбай (анализаторын заалтаар авна), импульс

$S_{\phi}(E_i)$  – тухайн нөхцөл дэх гамма спектрометрийн фон

V – усны эзэлхүүн (л)

$K = e^{-\lambda t}$

$\lambda = 2.098 \cdot 10^{-6} \text{ c}^{-1}$  – радоны задралын тогтмол

t – дээж авснаас хэмжих хүртэлх хүлээсэн хугацаа

$\varepsilon_0(E_i)$  – усны хувьд детекторын үнэмлэхүй бүртгэх чадвар

$t_{\text{хэм}}$  – хэмжих хугацаа, сө

$k_{\gamma}$  – цацраг идэвхт изотопын  $E_i$  энергитэй гамма квантын гаралт

Энэ хэмжилтэд өндөр ялгах чадвартай цэвэр хагас дамжуулагч германи детектор бүхий 4096 сувагтай анализатор бүхий гамма спектрометр ашиглан MNS 5632:2006 (Усан дахь радоны хэмжээг тодорхойлох гамма спектрометрийн арга) стандартын дагуу тооцоог хийж гүйцэтгэв. Усны дээжийг 1 литр эзлэхүүнтэй дээжийг детекторт углаж ордог цилиндр маринелл саванд хийж, түүнээс гарах гамма цацрагийг 3600 секунд хэмжиж тодорхойлсон үр дүнг 9-т харуулав.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 20. Усны дээжийн цацраг идэвхийн судалгааны дүн

Д/д	Дээжний нэр	Изотопын эзлэхүүний идэвх Бк/л				
		<sup>214</sup> Pb	<sup>214</sup> Bi	<sup>222</sup> Rn	<sup>226</sup> Ra	<sup>238</sup> U
1	Петро матад ХХК-ийн гүний худаг	4	10	7	<0.6	<0.6
2	Малчны гүний худаг	47	57	52	<0.6	<0.6
Илрүүлэх доод хязгаар (1л эзлэхүүнтэй 1 цаг хэмжих үед)		1.3	1.5	1.4	0.6	0.6
Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ (MNS0900:2018)		-	-	100	-	-

Худгийн усны дээжүүдэд агуулагдах <sup>226</sup>Ra, <sup>238</sup>U-ийн хувийн идэвхийн хэмжээ гамма спектрометрийн эдгээр изотопуудыг илрүүлэх хязгаар 0,6 Бк/л-ээс бага байна. Худгийн усны дээж дахь <sup>222</sup>Rn-ын эзлэхүүнт идэвх харгалзан 7, 52 Бк/л байгаа нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага”, түүнд тавих хяналт (MNS 900:2018) улсын стандартын зөвшөөрөгдөх хэмжээ (100 Бк/л)-ээс бага байна.

Хүснэгт 21. Усны хяналт шинжилгээний үр дүн

Утга	Батлагдсан БОХШХ төлөвлөгөө	Ажил эхлэхээс өмнөх БОХШХ-ийн гүйцэтгэл	Тайлбар
ААН	Үйл ажиллагаа хариуцагч байгууллага: Петро Матад ХХК	<b>БОХШХ гүйцэтгэгч:</b> Эм И Эс Зэт Би ХХК	Гэрээ байгуулагдсан.
БОХШХ-Ш1: Ус	<ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий химийн үзүүлэлт – Техникийн худгаас – жилд 2 удаа</li> <li>- Бичил элементийн агууламж – жилд 2 удаа</li> <li>- Цацрагийн үүсгүүрээс – Cs137, Am241/Be, U2388, Ra226, K40, Sr90 Унд ахуйн усны микробиологийн шинжилгээ. Үүнд ахуйн усны эх үүсвэрээс Усны чанар, рН, уусан нийт давс, нийт хатуулаг (CaCO<sub>3</sub>, Ca, Mg, Na, K, SO<sub>4</sub>, NO<sub>2</sub>, NO<sub>3</sub>, NH<sub>4</sub>, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni) үнэр, өнгө, нүүрс ус устөрөгчид болон унд ахуйн усанд химийн шинжилгээг мэргэжлийн</li> </ul>	<p>Хөвөө нуурын шаварлагаас өнөөгийн төлөв байдлын ажиглалтыг Дроны нислэгээр үйлдэн баримтжуулалт хийв. Компанийн худгаас болон малчны гүний худгаас дээж авч Геоэкологийн хүрээлэнд лабораторит чанарын үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийлгэсэн. Хүний ундны усанд хэрэглэхэд стандарт хэмжээнээс давсан байна. Мөн дээрх уснуудаас хүнд металл болон цацрагийн дээж авч шинжлүүлэхэд Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын</p>	<p>Мониторингийн ажлын хүрээнд ундны усны 2, гадаргын усны 1 дээж авсан.</p> <p>Дахин талбайд ажиллахад төлөвлөгөөний дагууд шаардлагатай үзүүлэлтүүдийн дээжлэлтийг авч, шинжлүүлнэ.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	байгууллагаар жилд 2 удаа шинжлүүлэх	үнэлгээ MNS 0900:2018 стандартад заасантай харьцуулахад Mg, Mn, Na, Mo, As, Se, U-ийн агуулга өндөр байна. Худгийн усны дээжүүдэд агуулагдах <sup>226</sup> Ra, <sup>238</sup> U-ийн хувийн идэвхийн хэмжээ гамма спектрометрийн эдгээр изотопуудыг илрүүлэх хязгаар 0,6 Бк/л-ээс бага, <sup>222</sup> Rn-ын эзлэхүүнт идэвх харгалзан 7, 52 Бк/л байгаа нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага”, түүнд тавих хяналт (MNS 900:2018) улсын стандартын зөвшөөрөгдөх хэмжээ (100 Бк/л)-ээс бага байна.	
Дүгнэлт:	Хөвөө нуур нь Матад ХХ талбайд хамгийн ойр байрлах гадаргын усны эх үүсвэр талбар ба экосистемийн хувьд ач холбогдолтой газар ба хэмжилт мониторингийн үед нуур ус ширгэсэн, энэ тэнд алаг цоог тогтоол ус маш бага хэмжээгээр байв.		
Зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:	<ul style="list-style-type: none"> <li>- Усны чанарын хяналт шинжилгээг төлөвлөгөөний дагууд хийж гүйцэтгэх.</li> <li>- Усны дүгнэлтийн дагууд тооцсон норм журмыг баримтлах, ашигласан усны төлбөрийг цаг тухайд нь төлж барагдуулах.</li> <li>- Уст цэгүүдийн орчныг хүн техник явахад тухайн орчны газрыг нөхөн сэргээж, таатай болгох. Хэт шаварлаг орчинд хүн, мал унаж бэртэхээс сэргийлэх. Ус түгээх цэг байрны стандарт MNS5775:015 мөрдлөг болгон ажиллах.</li> </ul>		


## **2.6 ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024-Н ГҮЙЦЭТГЭЛ**

### **2.6.1 Хөрсний төлөв байдал**

Матад ХХ талбай нь ухаа гүвээт тал болон хужир мараа бүхий хотос хонхруудыг багтаасан 213.92км<sup>2</sup> талбай эзлэн байршина. Цаашид газрын тосны олборлолтын үйл ажиллагаа, ажилчдын сууц болон хаягдлын сан, өрмийн зумп зэргийг байгуулах зэргээс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, хайгуулын талбайн хөрсөн бүрхэвчийн шинж чанар, зонхилох хэв шинжийн хөрсний тархалтыг илрүүлэх зорилгоор хөрсөн бүрхэвчийн суурь судалгааг мониторингийн хамтад нь гүйцэтгэв.

Дорнод аймгийн Матад сумд байрлах “Петро Матад” ХХК-ийн Матад ХХ талбай нь байгалийн мужлалаар Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их мужийн , Монголын дорнод хэсгийн давхаргат болон суурьт өндөрлөг тал, тэгшдүү хотгор, сул сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уулс бүхий хотгор гүдгэрийн хэв шинж бүхий Тамсагийн давхаргат өндөрлөг тал, тэгшдүү хотгор бүхий хуурай хээрийн дэд мужид багтана. Матад ХХ-р талбайн гадарга нь Монгол орны хувьд Дорнодын нам дор бүхий газар бөгөөд гадаргын үнэмлэхүй өндөр нь 600-800 м хооронд хэлбэлзэх тэгш тал бүхий талбайд байрлана.

Зураг 19. Талбайн өндөржилтийн зураг




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Дорнод аймгийн Матад сумын нутаг нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар хотгорын бүсчлэлийн Хангайн их мужийн Монголын дорнод мужийн Мэнэн-Матадын 19-р тойрогт хамрагдана (Үндэсний атлас, 2009). Тус тойрогт үлдмэл шинжтэй нам уул болон ухаа толгодоор сайр чулуурхаг шинжтэй нимгэн ялзмагт давхарга бүхий хар хүрэн хөрс, үлдмэл зоо болон тэгш талархаг нутгаар хүрэн шороон хөрс, үерийн ус хуримтлагддаг хотос, хонхор болон ухаа толгодын дунд үүссэн дэрс бүхий хотгор, жалга судгаар нугархаг болон мараалаг хөрсний хэв шинж давсархаг хөрсний хэв шинж зонхилон тархана.

Матад ХХ талбай нь Далайн нуруу 699м орчим үлдмэл шинжтэй зоо, Овоот уул 720м, Давст уул 730м орчим нам уулс, ухаа толгод болон түүний хажуугаар урсах Бүрдний голын давсархаг хөрс, Улаан хонхор, хөвөө нуур орчмын давст ширгэдэг нуур бүхий хотгоруудын орчимд байрлана. Иймд өндөрлөг тэгш талархаг газруудаар хар хүрэн болон хүрэн шороон хөрсний хэв шинж зонхилох бол нам дор хотос газруудаар давсархаг болон үлдмэл нугархаг хөрсний хэв шинжүүд тархана.

Судалгааны талбайд зонхилон тархсан хүрэн шороон хөрс нь 30-40 см хүртэл зузаан хүрэн өнгийн ялзмаг хуримтлалын давхаргатай, саармаг болон сул шүлтлэг урвалын орчинтой, ихэнх тохиолдолд карбонатгүй, чулуугүй зөвхөн нунтаг шороон хэсгээс бүрддэг нь энэ нутгийн хөрсний үндсэн гол онцлог шинжийг илэрхийлдэг.

Зураг 1. Хөрсний судалгаа, морфологи бичиглэлийн цэг



ы

Матад ХХ талбайн хөрсний өнөөгийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдолтыг тодорхойлох зорилгоор хөрсний 10 мониторингийн цэгийг сонгосон ба үүнээс 9 цэгт хөрсний зүсэлт хийж хөрсний морфологи бичиглэл, хяналт шинжилгээ ажиглалт хийн хөрсний үржил шимийн ерөнхий үзүүлэлт, механик бүрэлдэхүүнийг тодорхойлсон, 5 цэгт хүнд металл, эрүүл ахуйн өнөөгийн агууламж тодруулах




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

зорилготойгоор хөрсний шинжилгээний дээжийг ерөнхий шаардлага (MNS3298:1991) стандартын дагуу авч, магадлан итгэмжлэгдсэн Ланд Овнер ХХК-ийн Грийн лаб лабораторид шинжлүүлсэн. Цэн тогоруу-1, Цагаан зээр-1, Замын уулзвар гэсэн 3 цэгээс хөрсний нефт бүтээгдэхүүний шинжилгээг авч Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид, Цэн тогоруу-1, Цагаан зээр-1, Замын уулзвар, Хогийн цэг гэсэн 4 цэгээс цацраг идэвхийн дээжийг авч Цөмийн физикийн судалгааны төвийн итгэмжлэгдсэн лабораторид тус тус шинжлүүлсэн.

*Хүснэгт 22. Хөрсний дээж авч, бичиглэл хийсэн цэгүүд*


Цэгийн дугаар	Талбай	Хөрсний төрөл	Газарзүйн байршил		Хийсэн шинжилгээний үзүүлэлт
			Өргөрөг	Уртраг	
20M-S-01	Цэн тогоруу-1	Хар хүрэн хөрс	46° 49' 52.7"	116° 08' 35.73"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй, Нефт бүтээгдэхүүн, Цацраг
20M-S-02	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Мараалаг хүрэн хөрс	46° 47' 35.29"	115° 58' 03.79"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-03	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Хар хүрэн хөрс	46° 47' 30.57"	116° 07' 24.48"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-04	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Нугархаг хүрэн хөрс	46° 45' 25.45"	116° 05' 05.03"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-05	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Хужир мараа	46° 44' 52.7"	116° 08' 35.73"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй,
20M-S-06	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Мараалаг хүрэн хөрс	46° 49' 37.89"	116° 03' 05.8"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-07	Цагаан зээр-1	Хүрэн шороон хөрс	46° 49' 28.42"	116° 06' 43.4"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй,
20M-S-08	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Хүрэн шороон хөрс	46° 49' 09.01"	116° 14' 38.47"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-09	Замын уулзвар	Хар хүрэн хөрс	46° 49' 06.29"	116° 06' 24.31"	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй, Нефт бүтээгдэхүүн, Цацраг
20M-S-10	Хогийн цэг	Хар хүрэн хөрс	46° 49' 52.71"	116° 08' 37.52"	Хөрсний хүнд металл, Эрүүл ахуй, Цацраг

Зураг 20. Хөрсний дээж авсан цэг



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

**2.6.2 Хөрсний морфологи бичиглэл**

<b>Хэмжилтийн цэг: 20M-S-01</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний нэр:</b> Хар хүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 49'40.86" E: 116° 07'27.75"		
<b>Өндөр д.т.д:</b> 688		
<b>Газар ашиглалт:</b> Газрын тосны худгийн цэг		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> Тэгш талархаг		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> хайгуулын өрөмдлөг, дамжуулах худаг		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Хүчтэй Өрөмдлөгийн үйл ажиллагааны нөлөөгөөр талбай талхагдалд өртсөн шинжтэй.		
	<b>А үе</b> 0-11см	Цайвар өнгөтэй, хуурай, сийрэг нийцтэй, ургамлын нарийн үндэстэй, чулуугүй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой бүтэц илрэхгүй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц.
	<b>AB үе</b> 11-23см	Чийгтэй, бараавтар өнгөтэй, улаан туяатай, шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Дарагдаж нягтарсан шинжтэй. Чулуугүй, ургамлын нарийн ганц нэг үндэстэй. Шилжилт нягтаар мэдэгдэхүйц.
	<b>В үе</b> 23- доош гүнд	Хөрс үүсгэгч эх чулуулгийн давхарга. Том ширхэгтэй элсэнцэр бүхий механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой нийцэл ажиглагдахгүй.
<b>Хөрсний бохирдол:</b>		Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй
<b>Ландшафт:</b>		Тал хээрийн ландшафт
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>		пролювийн хурдаст тэгш тал

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

<b>Хэмжилтийн цэг: 20M-S-02</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Мараалаг хүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 47'35.29" E: 115° 58'03.79"		
<b>Өндөр д.т.д:</b> 672		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> Тэгш талархаг		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	<b>A үе</b> 0-17см	Цайвар өнгөтэй, хуурай, сийрэг нийцтэй, ургамлын нарийн үндэстэй, ганц нэг бутлаг ургамлын бүдүүн үндэс нэвтэрсэн. Чулуугүй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой бүтэц илрэхгүй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц.
	<b>AB үе</b> 17-36см	Чийгтэй, бараавтар өнгөтэй, улаан туяатай, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Дарагдаж нягтарсан шинжтэй. Чулуугүй, ургамлын нарийн ганц нэг үндэстэй. Шилжилт нягтаар мэдэгдэхүйц.
<b>Хөрсний бохирдол:</b>		Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй
<b>Ландшафт:</b>		Тал хээрийн ландшафт
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>		пролювийн хурдаст тэгш тал


<b>Хэмжилтийн цэг: 20M-S-03</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хархүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 47'30.57" E: 116° 07' 24.48"		
<b>Өндөр д.т.д:</b> 719		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> Тэгш талархаг		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	A үе 0-17см	Бараавтар өнгөтэй, өлөн чийгтэй, сийрэг нийцтэй, ургамлын нарийн үндэстэй. Чулуугүй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой бүтэц илрэхгүй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц.
	AB үе 17-28см	Чийгтэй, цайвар өнгөтэй, Карбонат хуримтлалын давхарга. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Дарагдаж нягтарсан шинжтэй. Чулуугүй, ургамлын нарийн ганц нэг үндэстэй. Шилжилт нягтаар мэдэгдхүйц.
<b>Хөрсний бохирдол:</b>	Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй	
<b>Ландшафт:</b>	Тал хээрийн ландшафт	
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>	Пролювийн хурдаст тэгш тал	
<b>Хэмжилтийн цэг: 20M-S-04</b>	Төсөл: МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай	

<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Үлдмэл нугархаг хүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай	<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>	
<b>Координат:</b> N: 46° 45' 24.45" E: 116° 05' 5.03"		
<b>Өндөр д.т.д:</b> 719		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> Тэгш талархаг		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	A үе 0-18см	Элсэн хучаас. Цайвар өнгөтэй, хуурай . Өвслөг ургамлын бөөгнөрсөн үндэстэй. Тодорхой бүтэц ялгарахгүй, чулуугүй. Бутлаг ургамлын ганц нэг үндэстэй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Шилжилт өнгөөр болон нягтаар тод.
	AB үе 18-33см	Хуурай, цайвар өнгөтэй. Нягтарч дарагдсан шинжтэй. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Чулуугүй, ургамлын үндэсгүй.
<b>Хөрсний бохирдол:</b>	Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй	
<b>Ландшафт:</b>	Тал хээрийн ландшафт	
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>	Пролювийн хурдаст тэгш тал	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

<b>Хэмжилтийн цэг: 20M-S-05</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хужир мараалаг хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай	<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>	
<b>Координат:</b> N: 46° 44' 03.9" E: 116° 00' 20.01"		
<b>Өндөр д.т.д:</b> 677		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> нугархаг хотгор		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	A үе 0-20см	Хар бараан болон улаавтар толботой. Босоо болон хөндлөн давхарга ялгарсан. Ургамлын нарийн үндэс ихтэй. Хөрсний гадаргад цайвар өнгөтэй давсны хучмал үүснэ. Өнгөн хөрсний дээд үе давхаргад органик хуримтлалын бараан толбо ялгарна
	B үе 20-40см	Хар бараан өнгөтэй. Чийгтэй. Хүнд шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Чулуугүй, ургамлын үндэсгүй. Тодорхой бүтэцгүй. Шилжилт механик бүрэлдэхүүнээр болон нягтаар мэдэгдэхүйц.
	BC үе 40-60см	Чийгтэй, том ширхэгтэй элсэн үе. Плювиал үйл ажиллагааны нөлөөгөөр хуримтлагдсан үе. Ургамлын үндэсгүй, чулуугүй. Тодорхой бүтэц ялгарахгүй.
<b>Хөрсний бохирдол:</b>	Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй	
<b>Ландшафт:</b>	Тал хээрийн ландшафт	
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>	Пролувийн хурдаст тэгш тал	

<b>Хэмжилтийн цэг: 20M-S-06</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Мараалаг хүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай. Цагаан зээр кемп	<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>	
<b>Координат:</b> N: 46° 49' 37.89" E: 116° 03' 05.80"		
<b>Өндөр д.т.д:</b> 656		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> нугархаг хотгор		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>A үе 0-18см</p>	<p>Цайвар өнгөтэй. Хуурай, сийрэг нийцтэй. Чулуугүй, ургамлын нарийн үндсээр торлогдсон шинжтэй. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Шилжилт нягтаар болон механик бүрэлдэхүүнээр мэдэгдэхүйц.</p>
	<p>AB үе 19-60см</p>	<p>Бараан өнгөтэй, чийгтэй. Чулуугүй, Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Ганц ургамлын нарийн үндэстэй. Чулуугүй, бага зэрэг дарагдаж нягтарсан шинжтэй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц</p>
<p><b>Хөрсний бохирдол:</b></p>	<p>Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй</p>	
<p><b>Ландшафт:</b></p>	<p>Тал хээрийн ландшафт</p>	
<p><b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b></p>	<p>Пролювийн хурдаст тэгш тал</p>	



<p><b>Хэмжилтийн цэг: 20M-S-07</b></p>	<p><b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай</p>	
<p><b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хүрэншороон хөрс</p>		
<p><b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай. Цагаан зээр кемп</p>	<p><b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b></p>	
<p><b>Координат:</b> N: 46° 49' 28.42" E: 116° 06' 43.40"</p>		
<p><b>Өндөр д.т.д:</b> 683</p>		
<p><b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай</p>		
<p><b>Талбайн ерөнхий төрх:</b> нугархаг хотгор</p>		
<p><b>Чулуужилт:</b> Бага</p>		
<p><b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй</p>		
<p><b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.</p>		
	<p>A үе 0-14см</p>	<p>Цайвар өнгөтэй. Хуурай, сийрэг нийцтэй. Чулуугүй, ургамлын нарийн үндсээр торлогдсон шинжтэй. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Шилжилт нягтаар болон механик бүрэлдэхүүнээр мэдэгдэхүйц.</p>
	<p>AB үе 14-30см</p>	<p>Бараан өнгөтэй, чийгтэй. Чулуугүй, Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Ганц ургамлын нарийн үндэстэй. Чулуугүй, бага зэрэг дарагдаж нягтарсан шинжтэй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц</p>
	<p>B үе 30-70см</p>	<p>Цайвар өнгөтэй, карбонат хуримтлалын давхарга, өлөн чийгтэй. Чулуугүй. Ганц нэг ургамлын нарийн үндэстэй. Шавранцар механик бүрэлдэхүүнтэй.</p>
<p><b>Хөрсний бохирдол:</b></p>	<p>Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй</p>	
<p><b>Ландшафт:</b></p>	<p>Тал хээрийн ландшафт</p>	
<p><b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b></p>	<p>Пролювийн хурдаст тэгш тал</p>	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

<b>Хэмжилтийн цэг: 20M-S-08</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хүрэншороон хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай. Цагаан зээр кемп		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 49' 09.01" E: 116° 14' 38.47"		
<b>Өндөр д.т.д:</b> 672		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> нугархаг тал		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	A үе 0-21см	Бараан өнгөтэй. Чийгтэй, сийрэг нийцтэй. Чулуугүй, ургамлын нарийн үндэстэй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Шилжилт нягтаар болон механик бүрэлдэхүүнээр мэдэгдэхүйц.
	AB үе 21-49см	Бараан өнгөтэй, чийгтэй. Чулуугүй, Хөнгөн шавранцар, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Ганц ургамлын нарийн үндэстэй. Чулуугүй, бага зэрэг дарагдаж нягтарсан шинжтэй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц
<b>Хөрсний бохирдол:</b>	Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй	
<b>Ландшафт:</b>	Тал хээрийн ландшафт	
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>	Пролювийн хурдаст тэгш тал	



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

<b>Хэмжилтийн цэг: 20М-S-09</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хархүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 49'06.29" E: 116° 09' 24.31"		
<b>Өндөр д.т.д:</b> 656		
<b>Газар ашиглалт:</b> Сайжруулсан шороон замын дэргэд		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> тэгш тал		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	<b>A үе</b> 0-11см	Хучаас үе. Цайвар өнгөтэй. Хуурай, сийрэг нийцтэй. Чулуугүй, Ургамлын нарийн үндэстэй. Хөрсний өнгөн хэсэг ерөмтсөн шинжтэй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Хэврэг бөөмөрхөг бүтэцтэй. Шилжилт нягтаар болон механик бүрэлдэхүүнээр мэдэгдэхүйц.
	<b>AB үе</b> 11-34см	Цайвар өнгөтэй, чийгтэй. Чулуугүй, ургамлын үндэсгүй. Давсны цайвар нэчвмэл толботой. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Чулуугүй, бага зэрэг дарагдаж нягтарсан шинжтэй.
	<b>BC үе</b> 35-50см	Бараан өнгөтэй, чийгтэй, дарагдмал шинжтэй. Чулуугүй, ургамлын үндэсгүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой бүтэц ялгарахгүй.
<b>Хөрсний бохирдол:</b>		Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй
<b>Ландшафт:</b>		Тал хээрийн ландшафт
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>		Пролювийн хурдаст тэгш тал

### 2.6.3 Хөрсний хяналт шинжилгээний үр дүн

Матад ХХ талбайд зонхилон хөрсний хэв шинжүүдийг урьдчилан тодорхойлж, хээрийн судалгааны ажлын хүрээнд хөрсний морфологи бүтэц болон үе давхаргаас лабораторийн задлан шинжилгээнд зориулан хөрсний дээж цуглуулсан. Одоогийн байдлаар судалгааны талбайд газрын тосны хайгуулын өрмийн цэг, тос дамжуулах худаг, тээврийн шороон зам зэрэг газрын доройтлын хэлбэрүүд илэрнэ.

Зонхилох хэв шинжийн хөрсний хими, физик шинж чанарыг дараах үзүүлэлтээр авч үзэв. Үүнд:

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**


*Хүснэгт 23. Хөрсний химийн үндсэн шинж*

Хөрс	Дээж	гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dSm	CaCO <sub>3</sub> %	Ялзма г, %	Шингээгдсэн		Хөдөлгөөнт	
								Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Хархүрэн хөрс	20M-S-01	0-11	8.81	0.04	0.067	2.64	0.75	12.9	9.5	0.9	19
		12-22	8.62	0.05	0.099	5.93	0.6	11.5	5.2	1.4	24
		23-доош	8.13	0.04	0.063	0	1.5	11.1	2.9	0.8	18
	20M-S-03	0-17	7.91	0.02	0.039	0	1.5	11.4	5.6	1.9	31
		18-28	8.08	0.02	0.041	0	1.5	14.2	1.6	1.8	25
	20M-S-09	0-11	8.06	0.04	0.05	0	1.76	11.1	2.3	1.5	26
		12-34	7.87	0.02	0.048	0	1.41	10.8	1.2	1.3	19
35-50		8.38	0.03	0.062	0	1.42	9.4	3.2	1.6	15	
Хүрэншороон хөрс	20M-S-07	0-14	7.97	0.05	0.103	0	1.31	12.6	2.6	3.1	34
		15-30	8.33	0.04	0.086	0.49	1.12	13.7	5.2	2.5	39
		31-70	8.84	0.04	0.079	4.94	1.06	9.9	5.2	0.6	11
	20M-S-08	0-21	7.39	0.04	0.081	0	1.72	12.2	1.2	1.5	29
		21-49	8.04	0.04	0.077	0	1.43	13.2	4.2	2.1	24
Мараалаг хүрэн	20M-S-02	0-17	7.84	0.03	0.065	0	1.41	15.3	1.2	1.6	31
		18-36	8.55	0.05	0.094	0	1.47	19.2	2.4	2.1	29
	20M-S-06	0-18	9.57	0.03	0.054	0	1.53	9.7	3.5	2.5	29
		19-60	7.97	0.01	0.027	0	1.48	10.2	4	1.4	33
Нугархаг хүрэн хөрс	20M-S-04	0-18	7.17	0.03	0.054	0	1.84	13.6	1.2	2.9	35
		19-33	7.1	0.02	0.042	0	2.09	16.2	7.2	2.5	34
Хужир мараа	20M-S-05	0-20	9.52	0.18	0.356	2.31	1.12	6.6	3.7	1.5	16
		21- 40	9.9	0.62	1.236	3.62	1.16	13	2	1.6	18
		40-60	9.47	0.33	0.667	0.99	0.26	7.3	0.8	0.4	7


**Хөрсний урвалын орчин:** Хөрсний уусмалын орчин нь хөрсний үе давхаргад агуулагдах уусмалын хүчиллэг болон шүтлэг шинжийг тодорхойлох голлох үзүүлэлт болдог. Хөрсний урвалын орчинг 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.0-6.7 бол сул хүчиллэг, 6.7.-7.3 бол саармаг, 7.4-7.8 орчим сул шүтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүтлэг, 8.5-9.0 хүчтэй шүтлэг гэж ангилсан байдаг (Soil Survey Manual, 2006).

Матад ХХ талбайн ухаа толгод болон тэгш талархаг газраар тархсан хархүрэн хөрсний урвалын орчин 8.5 очрим сул шүтлэг шинжтэй байгаа бөгөөд хөрсний гадаргад үүссэн элсэнцэр хучаас үеийн хөгжилтэй холбоотойгоор хөрсний өнгөн хэсэгт урвалын орчин саармаг шинжтэй болсон байна (*график.1*).


**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**




*График 7. Хархүрэн хөрсний урвалын орчин*



*График 8. Хүрэншороон хөрсний урвалын орчин*



*График 9. Мараалаг хүрэн хөрсний урвалын орчин*



*График 10. Нугархаг хүрэн хөрсний урвалын орчин*

*График 11. Хужирлаг хөрсний урвалын орчин*

Хархүрэн хөрсний морфологи бүтэцтэй холбоотойгоор хуримтлалын В давхаргад голлох шүлтлэг утга илэрч байгаа бол сийрэг болон элсэнцэр хуримтлал бүхий үе давхаргуудад урвалын орчин саармагжиж байна.

Хүрэншороон хөрсний хувьд хөрсний өнгөн үе илүү саармаг 7.0 орчим утгатай байгаа бол шилжилтийн В давхарга болон гүний үе давхаргуудад 8.0 болж сул шүлтлэг шинжтэй болж


## Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

байна. Хүрэн шороон хөрсний угаагдлын горим болон механик бүрэлдэхүүний тархалттай холбоотойгоор доод үе давхаргуудад илүү шүлтлэг шинж илэрнэ (график.2). Хүрэн шороон хөрсний морфологи бүтцийн хөгжилтэй холбоотойгоор шавар үүсэх үйл явц зонхилдог шилжилтийн В давхаргад давс, эрдсийн хуримтлал голчлон хуримтлагддаг байна.

Мараалаг хөрсний урвалын орчин сул шүлтлэг шинжтэй боловч зарим хэв шинжийн хөрсний өнгөн хэсэг нь өрөмтсөн шинжтэй байгаа бөгөөд урвалын орчин 9.0 шүлтлэг шинжтэй болсон байна. Угаагдлаар хуримтлагдах нэмэлт чийгжилтийн нөлөөгөөр хөрсний морфологи бүтэц бүрэлдэн тогтох учир угаагдал хуримтлалын нөлөө тод ялгардаг шинжтэй (график.3). Нугархаг хөрсний хувьд угаагдлын эрчим өндөртэй учир урвалын орчин 7.1 орчим саармаг шинжтэй бөгөөд хөрсний доод үеүүдэд илүү буурах хандлагатай байна (график.4). Давсархаг хөрсний хувьд урвалын орчинд 9.0 дээш буюу хүчтэй шүлтлэг шинжтэй болох бөгөөд хүнд шавранцар механик бүрэлдэхүүнтэй, чийгээр ханасан шинжтэй, исэлдэн ангижрах урвалын нөхцөлтэй холбоотойгоор хөрсний үе давхарга бүхэлдээ шүлтлэг шинжтэй болсон байна.

Судалгааны талбайн хөрсний урвалын орчны тархалтыг авч үзэхэд Бүрдний гол болон давст худаг орчмын давсархаг хотгоруудад шүлтлэг утга голчлон тархах бол Давст ухаа, Далайн нуруу орчмын тэгш зоо маягын газруудад илүү саармаг утга тархсан байна (зураг.21).

Зураг 21. Матад ХХ газрын тосны хайгуулын талбайн урвалын орчин- pH утга




**Хөрсний карбонат ( $\text{CaCO}_3$ ):** Хөрсний карбонатын агууламж нь pH буюу хөрсний урвалын орчинтой нягт холбоотой үүсдэг ба хөрсний үе давхаргад агуулагдах карбонатын давсны агууламж, тархалт нь хөрсний үржил шимийн түвшинд нөлөөлөхөөс гадна элэгдэл, эвдрэлд тэсвэртэй байдал, чийгийн агууламж зэрэг шинж чанартай уялддаг. Хөрсний карбонатын агууламжаас илрэх гүн болон агууламжаар ангилан үздэг бөгөөд 0-2% агууламжтай бол сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% хүчтэй карбонатжсан гэж үнэлнэ (Guideline for soil description. 2006).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Матад ХХ газрын тосны хайгуулын талбай нь дорнод монголын хээрийн экосистемийн нөлөөнд бүрэлдэн тогтсон, элсэнцэр голлосон механик бүрэлдэхүүнтэй, сийрэг нийцтэй, ургамлын нарийн үндэс ихтэй зуны хур борооны усаар үе үе нэвт угаагддаг шинжтэй учир карбонатын агууламж төдийлөн илрэхгүй байна. Хэмжилтийн талбайд Хархүрэн хөрсний 20M-S-01, хүрэн шороон хөрсний 20M-S-07, хужир мараалаг хөрсний 20M-S-05 цэгүүдэд карбонатын агууламж илрэх боловч өнгөн хөрс болон гүний үе давхаргуудад ихээхэн ялгаатай илэрнэ. Хөрсний өнгөн А үед 0.5-2.0% орчим илрэх бол гүний үе давхаргуудад 5.0% орчим утга хүрнэ (*график.6*). Карбонатын агууламж нь голчлон шилжилтийн В давхаргад шавар үүсэх үйл явц болон угаагдлын хуримтлалын нөлөөгөөр голчлох хуримтлагдах үйл явц ажиглагдаж байна.

График 12. Матад ХХ талбайн хөрсний карбонатын агууламж



**Хөрсний цахилгаан дамжуулалт (EC(dS/m)):** Хялбар уусах давс нь ургамлын ургалт, үндэсний хөгжилт, агаар, ус нэвчих, исэлдэн ангижрах чанартай уялдан хөрсний үржил шимт бодисын хөдөлгөөн, бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Хөрсний гадарга өрөмтөх, давсны цайвар өнгө үүсэх зэрэг нь хөрсний доройтлын индикатор үзүүлэлт болдог. Хөрсний хялбар уусах давсны агууламж 0.0-0.75dS/m бол давсжаагүй, 0.75-2.0dS/m бол сул давсжилттай, 2.0-4.0dS/m бол давсны агууламж дунд зэрэг, 4.0-8.0dS/m бол давсны агууламж их, 8.0-15.0dS/m бол давсны агууламж өндөр, >15.0dS/m хэт их давсархаг гэж ангилж үздэг (Guideline for soil description. 2006).

Матад ХХ талбайн хар хүрэн хөрсний хялбар уусах давсны агууламж 0.06-0.09dS/m орчим хэлбэлзэх бөгөөд хэмжилтийн цэгүүдэд хөрсний морфологи бүтцээс шалтгаалсан өөрчлөлт багатай байгаа бөгөөд хар хүрэн хөрсний хувьд морфологи бүтцийн ялгаа сул учир ялгаа төдийлөн үүсэхгүй байна (*график.7*). Хүрэн шорооны хөрсний хялбар уусах давсны агууламжийн хувьд 0.07-0.10dS/m орчим хэлбэлзэх бөгөөд хөрсний шилжилтийн үед шаварлаг фракцын хуримтлалтай холбоотой учир давсны агууламж нэмэгдсэн шинжтэй байна. Нөгөө талаар газар ашиглалт болон бүс нутгийн уур амьсгалын онцлогтой

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

холбоотойгоор хэмжилтийн цэгүүдэд хөрсний гадарга өрөмтсөн шинжтэй учир давсжилтад тодорхой нөлөө үзүүлж байна (график.8). Хүрэн шороон хөрсний хэв шинжийн хувьд шилжилтийн В давхаргад давсны агууламж бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна. Мараалаг хүрэн хөрсний хувьд угаагдал, чийгийн горимын онцлогтой холбоотойгоор давсны агууламж 0.04-0.09dS/m орчим хэлбэлзэх бөгөөд шилжилтийн В давхаргад бага зэрэг нэмэгдэх хандлагатай байна (график.9). Нугархаг хүрэн хөрсний хувьд гадаргын угаагдлын нөлөөгөөр нэмж хуримтлагдах шинжтэй учир хөрсний үе давхарга бүхэлдээ үе үе усаар угаагддаг шинжтэй учир хөрсний үе давхаргад агуулагдах хялбар уусах давсны агууламж 0.05dS/m орчим утгатай хэлбэлзэж байгаа бөгөөд хөрсний морфологи бүтцээс шалтгаалсан өөрчлөлт багатай байна (график.10). Бүрдний голын хөндийд хийсэн давсархаг хөрсний дүнгээс үзэхэд өнгөн үед 0.35dS/m орчим хэлбэлзэх бол шилжилтийн В давхаргад 1.23dS/m орчим өндөр агууламжтай байгаа бол эх чулуулгийн С давхаргад 0.66dS/m орчим байна (график.11).




График 13. Хархүрэн хөрсний цахилгаан дамжуулах чанар




График 14. Хүрэншороон хөрсний цахилгаан дамжуулах чанар






График 15. Мараалаг хүрэн хөрсний цахилгаан дамжуулах чанар

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



Хялбар уусах давсны тархалтын хувьд Бүрдний голын хөндий дагуух хэмжилтийн цэгт 1.23dS/m орчим утга илэрч байгаа бол үлдмэл зоо болон сайргархаг хүрэн хөрсний хэв шинжүүдэд бага утга 0.03dS/m хүртэл бага агууламжтай байна. Талбайн тархалтын хувьд баруун болон баруун урд хэсгийн нам дор хотос газруудад голчлон давсны агууламж давамгайлж байгаа бол зүүн болон хойд хэсгийн хэмжилтийн цэгүүдэд 0.03dS/m орчим бага утга тархсан шинжтэй байна (зураг.4).

Зураг 22. Матад ХХ газрын тосны хайгуулын талбайн хөрсний хялбар уусах давсны агууламж



**Хөрсний ялзмаг:** хөрсний үржил шимийн гол үзүүлэлт бөгөөд хөрсөнд үлдсэн ургамал, амьтны үлдэгдэл бактерийн үйл ажиллагаагаар задарч, хөрсний үе давхаргад хуримтлагдан, ургамлын өсөлт, хөгжилтөнд зарцуулагддаг. Ялзмагийн агууламж нь ургамлын өсөлт хөгжилтөөс гадна хөрсний жижиг хэсгүүдийг хооронд барьцалдуулан, тогтвортой агрегат бүтэц үүсгэх, гадны нөлөөллийг тэсвэрлэх, биологийн идэвхийг нэмэгдүүлэх, агаар-ус солилцоог эрчимжүүлэх, химийн урвалуудад зохицуулагч үүргээр оролцох зэрэг олон үүргийг хавсарч гүйцэтгэдэг онцлогтой. Хөрсний ялзмагийн агууламжийг Олон улсын практикт хөрсний ялзмагийн агууламжаар нь маш бага буюу <1%, бага буюу 1-2%, дунд буюу 2-5%, их буюу >5% гэж хуваан авч үздэг (<https://njaes.rutgers.edu/soil-testing-lab/organic-matter-levels.php>).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Матад ХХ талбайн хархүрэн хөрсний ялзмагийн агууламж 1.5% орчим хэлбэлзэх бөгөөд ургамлын нарийн үндэсний бөөгнөрөл бүхий өнгөн үе давхаргуудад үл ялиг нэмэгдэж 1.7% хүрсэн байна. Хархүрэн хөрсний морфологи бүтцээс шалтгаалсан өөрчлөлт сул ажиглагдаж байна (*график.12*). Хүрэншороон хөрсний хувьд ялзмагийн хэмжээ 1.12-1.72% хүртэл хэлбэлзэх шинжтэй бөгөөд морфологи бүтцийн шинж чанараас шалтгаалсан өөрчлөлт илрэхгүй шинжтэй байна (*график.13*). Хүрэншороон хөрсний хувьд нэг өвслөг ургамлын үндэсний хөгжилтэй холбоотой өнгөн үеүүдэд голчлох ялзмагийн агууламж илэрнэ.

Мараалаг хүрэн хөрсний хувьд ялзмагийн агууламж 1.4% орчим хэлбэлзэх бөгөөд чийгийн горимын хангамжтай холбоотой ургамал бүрхэвчийн нягтшил өндөртэй тул хөрсний өнгөн хэсгийн ялзмагийн агууламж, органик бодисын нөөц баялаг шинжтэй. Иймд мараалаг хүрэн хөрсний ялзмагийн агууламж үе давхаргаас шалтгаалсан өөрчлөлт багатай, тогтмол шинжтэй байна (*график.14*). Давсархаг хужирлаг хөрсний Бүрдний голын татмын системтэй холбоотой чийгсэг ургамал болон давссаг ургамлын бүрхэцтэй холбоотой ялзмагийн агууламж 1.1% орчим тогтмол шинжтэй байгаа бөгөөд доод үе давхаргууд руу буурсан шинжтэй байна (*график.15*).




График 18. Хархүрэн хөрсний ялзмагийн агуудамж




График 19. Хүрэншороон хөрсний ялзмагийн агуудамж



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**




График 20. Мараалаг хүрэн хөрсний ялзмагийн агуудамж





График 21. Нугархаг хүрэн хөрсний ялзмагийн агуудамж

График 22. Хужирлаг хөрсний ялзмагийн агуудамж

Матад ХХ талбайн хөрсний ялзмагийн агууламжийн тархалтын байдлаас үзэхэд голлох өндөр утга нь ухаа гүвээт тал, толгодын бүсийн хар хүрэн хөрсөнд 2.0% орчим хүрэх бол тэгш талархаг газруудаар тархах хүрэн шороон хөрсний хувьд 1.5% утга зонхилсон шинжтэй байна. Бүрдний гол болон давсархаг нуур бүхий хотгоруудад ялзмагийн хэмжээ 1.1% орчим болж буурж байна (зураг.5).

Зураг 2. Матад ХХ газрын тосны хайгуулын талбайн хөрсний ялзмагийн агууламж



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

**Хөрсний хөдөлгөөнт суурийн нийлбэр** ( $K_2O+P_2O_5$ ): ургамлын өсөлт, хөгжилтөнд шаардлагатай азот, фосфор, кали зэрэг макро элементүүд байгалийн болон ургамлын задралын үйл явцаас хөрсний үе давхаргад хуримтлагддаг. Эдгээрээс калийн исэл ( $K_2O$ ) фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) ургамлын хэрэгцээт макро элементүүдэд авч үзэх бөгөөд хөдөлгөөнт суурийн нэгдэлд хамааруулдаг. Хөрсний фосфорын пентоксидын агууламж  $<2\text{мг}/100\text{гр}$  хэмжээтэй бол бага хангамжтай,  $2-4\text{мг}/100\text{гр}$  хэмжээтэй бол сайн хангамжтай гэж үнэлдэг бол калийн ионы агууламжын хувьд  $<10\text{мг-экв}/100\text{гр}$  бол бага хангамжтай,  $10-20\text{мг-экв}/100\text{гр}$  бол сайн хангамжтай гэж үнэлдэг (Guideline for soil description. 2006).

Матад ХХ хайгуулын талбайн хархүрэн хөрсний фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж хэмжилтийн цэгүүдэд дунджаар  $1.0\text{мг}/\text{кг}$  хэмжээтэй байгаа бөгөөд хөрсний хэмжилтийн цэгүүдэд ихээхэн хэлбэлзэлтэй буюу  $0.9-1.8\text{мг}/\text{кг}$  хэмжээтэй байна. Хархүрэн хөрсний калийн исэл ( $K_2O$ ) агууламж  $18-31\text{мг}/\text{кг}$  хүртэл хэлбэлзэх бөгөөд морфологи бүтцийн тархалтын утгаас үзэхэд шилжилтийн В давхаргад голчлох өндөр утга тархах бол зарим хэмжилтийн цэгүүдэд эх чулуулгийн үед хуримтлал үүссэн шинжтэй байна (график.17). Хүрэн шороон хөрсний хувьд хөрсний өнгөн А давхаргад фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж  $3.0\text{мг}/\text{кг}$  хүртэл байгаа бол доод үе давхаргуудад буураж  $0.6\text{мг}/\text{кг}$  хүрсэн байна. Калийн исэл ( $K_2O$ ) агууламж  $29-39\text{мг}/\text{кг}$  орчим хэлбэлзэх бөгөөд хөрсний шилжилтийн В давхаргад илүү хуримтлагдсан угаагдсан шинжтэй байна (график.18). Мараалаг хүрэн хөрсний хувьд фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж  $1.4-2.5\text{мг}/\text{кг}$  орчим хэлбэлзэх бөгөөд ургамлын үндэсний тархалттай холбоотойгоор шим тэжээлийн бодисын хуримтлал ажиглагдаж байна. Калийн исэл ( $K_2O$ ) агууламж  $29-33\text{мг}/\text{кг}$  орчим хэлбэлзэх бөгөөд өнгөн үед илүү өндөр агууламжтай байна (график.19). Нугархаг хөрсний хувьд чийгжилтийн нөлөөгөөр фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж  $2.9\text{мг}/\text{кг}$  орчим байгаа бол калийн исэл ( $K_2O$ ) агууламж  $35\text{мг}/\text{кг}$  агууламжтай байна (график.20). Давсархаг хөрсний хувьд фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж  $1.5\text{мг}/\text{кг}$  орчим байгаа бол калийн исэл ( $K_2O$ ) агууламж  $16\text{мг}/\text{кг}$  тус тус агууламжтай байна. Давсархаг болон нугархаг хөрсний хувьд ургамлын нарийн үндэс бүхий өнгөн 5см орчим үед голчлох шим тэжээлийн бодис хуримтлагдсан шинжтэй байна (график.21).




График 23. Хархүрэн хөрсний хөдөлгөөнт суурь

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**




График 24. Хүрэншироон хөрсний хөдөлгөөнт суурь




График 25. Мараалаг хүрэн хөрсний хөдөлгөөнт суурь




График 26. Нугархаг хүрэн хөрсний хөдөлгөөнт суурь






График 27. Хужирлаг хөрсний хөдөлгөөнт суурь


**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**




*График 28. Хархүрэн хөрсний шингээгдсэн суурь*



*График 29. Хүрэншороон хөрсний шингээгдсэн суурь*



*График 30. Мараалаг хүрэн хөрсний шингээгдсэн суурь*



*График 31. Нугархаг хүрэн хөрсний шингээгдсэн суурь*

*График 32. Хужирлаг хөрсний шингээгдсэн суурь*

Матад ХХ талбайн хөрсний шингээгдсэн суурийн хувьд хархүрэн хөрсний хувьд кальцийн агууламж 11мг-экв/100гр орчим хэмжээтэй байгаа бол магнийн агууламж 4мг-экв/100гр

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

хэмжээтэй хэлбэлзэх бөгөөд өнгөн А үед 9.5мг-экв/100гр хүрэх бол эх чулуулгийн С үед 1.6мг-экв/100гр болж буурсан шинжтэй байна (*график.22*). Хүрэншороон хөрсний хувьд калцийн агууламж 12мг-экв/100гр орчим хэлбэлзэх бөгөөд морфологи бүтцээс шалтгаалсан өөрчлөлт багатай, тогтмол утгатай байгаа бол кальцийн агууламж ургамалын үндэс бүхий өнгөн үед 2.0мг-экв/100гр орчим бага утгатай байгаа бол шилжилтийн ургамлын үндэс бүхий доод үе давхаргуудад 5.0мг-экв/100гр орчим болж нэмэгдэж байна (*график.23*). Мараалаг хөрсний кальцийн агууламж өнгөн хэсгээс доод үе давхарга руу 1-3.5мг-экв/100гр болж нэмэгдэж байгаа бол магнийн агууламж 2.5мг-экв/100гр орчим дундаж агууламжтай байна (*график.24*). Нугархаг хүрэн хөрсний кальцийн агууламж 14мг-экв/100гр байгаа бол магнийн агууламж 1.2мг-экв/100гр тус тус агууламжтай байгаа бөгөөд шилжилтийн В давхаргад 7.2мг-экв/100гр тус тус агууламжтай байна (*график.25*). Давсархаг хөрсний 7.0мг-экв/100гр орчим хэмжээтэй байгаа боловч хар бараан органик бодисын хуримтлал бүхий АВ давхаргад 13мг-экв/100гр хүрч огцом нэмэгдсэн шинжтэй байна (*график.26*).

**Хөрсний механик бүрэлдэхүүн:** хөрс үүсгэгч эх чулуулгаас өгөршлийн нөлөөгөөр жижиг үйрмэг чулуулаг болон бутардаг. Хөрсний үе давхаргад агуулагдах жижиг ширхэгч фракцуудыг хэмжээгээр ангилдаг бөгөөд олон улсын хэмжээнд элс 2.0-0.05мм, тоос 0.05-0.002мм, шавар <0.002мм тус тус ангилдаг. Хөрсний механик бүрэлдэхүүний ангиллыг Качинскийн боловсруулсан аргазүйгээр үнэлдэг бөгөөд үүнд голлох фракцаар нь бус хөрсний тогтвортой бүтэц үүсгэгч нарийн ширхэгт тоосны фракцын агууламжаар ангилдаг. Нарийн ширхэгт шаврын агууламж 10%-аас бага агууламжтай үед хөнгөн шавранцар ангилалд авч үзэж бол >10% дээш агууламжтай үед шавранцар ангилалд багтаан үздэг (Ө.Бэхтөр, 1964).

*Хүснэгт 24. Хөрсний механик бүрэлдэхүүн*

Дд	Дээж	гүн, см	Механик бүрэлдэхүүн, %, ширхэгийн хэмжээ-мм						
			1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Хархүрэн хөрс	20M-S-01	0-11	26.8	43.1	11.3	3.3	10.6	5.0	18.8
		12-22	24.1	44.2	12.4	4.0	8.4	6.8	19.3
		23-доош	28.6	49.9	12.6	1.0	5.9	2.0	9.0
	20M-S-03	0-17	17.9	60.6	7.8	3.1	8.1	2.5	13.7
		18-28	19.2	53.4	9.7	2.9	5.0	9.8	17.7
	20M-S-09	0-11	44.6	40.7	6.7	0.2	6.7	1.1	8.0
12-34		25.3	52.9	7.3	2.7	8.0	3.8	14.5	
35-50		28.2	50.3	4.6	5.3	6.3	5.3	16.9	
Хүрэншороон хөрс	20M-S-07	0-14	28.4	49.2	11.8	2.3	3.3	5.0	10.5
		15-30	24.6	46.0	10.8	2.9	9.6	5.6	18.1
		31-70	15.7	47.7	17.0	4.3	9.8	5.5	19.6
	20M-S-08	0-21	22.0	55.9	6.6	2.9	6.9	5.7	15.5
		21-49	33.8	36.0	8.8	3.7	9.6	8.1	21.4
Мараалаг хүрэн	20M-S-01	0-17	27.5	43.7	14.3	3.2	7.0	4.3	14.6
		18-36	26.4	42.8	12.2	3.8	10.1	4.8	18.6
	20M-S-06	0-18	32.5	48.9	6.5	4.2	6.7	1.2	12.1
Нугархаг хүрэн хөрс	20M-S-04	0-18	28.5	47.5	9.3	2.7	8.4	3.6	14.7
		19-33	35.6	35.2	9.9	4.3	8.4	6.6	19.3
Хужир мараа	20M-S-	0-20	53.2	14.2	4.4	5.0	17.3	5.9	28.2
			6.2	51.7	12.3	2.6	19.1	8.2	29.8

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	05	21-40	20.7	37.3	10.1	3.4	21.1	7.4	31.9
		40-60	39.6	46.2	3.9	1.3	6.1	2.9	10.3

Лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд хархүрэн хөрсний үе давхарга дахь том ширхэгт элсэн фракц (2.0-0.005мм) агууламж 78% орчим хэлбэлзэх бөгөөд зарим тохиолдолд элсэн хучаастай хэмжилтийн цэгүүдэд 80% дасан байна. Тоос (0.005-0.002мм) агууламж 13% орчим хэлбэлзэх боловч өнгөн үед 6% хүртэл буурах бол шилжилтийн давхаргад 16% хүртэл хэлбэлзэж байна. Шавар (>0.002мм) агууламж 10% давсан шинжтэй байна (график.28). Хүрэн шороон хөрсний хувьд элсэн фракц (2.0-0.005мм) агууламж хөрсний үе давхаргад 70% орчим хэлбэлзэх бол тоос (0.005-0.002мм) агууламж 10-20% ихээхэн хэлбэлзэлтэй байна. Хүрэн хөрсний үе давхаргын тогтоц, хөрсөнд явагдах хими, биологийн үйл явцтай холбоотойгоор хүрэн хөрсөнд шавар үүсэх үйл явц идэвхтэй явагддаг байна (график.29). Мараалаг хүрэн хөрсний хувьд элсэн фракц (2.0-0.005мм) агууламж 80% хүртэл хэлбэлзэх бөгөөд дунджаар 70% орчим агууламжтай байгаа бол бол тоос (0.005-0.002мм) агууламж 15% орчим хэлбэлзэнэ. Шавар (2.0-0.005мм) агууламж 10% орчим агууламжтай байна (график.30). Нугархаг хөрсний хувьд элсэн фракц (2.0-0.005мм) агууламж 70% хүртэл хэлбэлзэх бөгөөд дунджаар 70% орчим агууламжтай байгаа бол бол тоос (0.005-0.002мм) агууламж 15% орчим хэлбэлзэнэ. Шавар (2.0-0.005мм) агууламж 20% орчим агууламжтай байна (график.31). Давсархаг хөрсний хувьд элсэн фракц (2.0-0.005мм) агууламж өнгөн үед 60% орчим байх бол гүний элсэнцэр үед 85% хүрнэ. Тоос (0.005-0.002мм) агууламж 14% орчим байгаа боловч гүний үе давхаргуудад 5% буюу шавар үүсэх, хуримтлагдах үйл явц илрэхгүй байна. Шавар (2.0-0.005мм) агууламж 28% хүртэл өндөр агууламжтай байна (график.32).



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**




График 34. Хүрэншороон хөрсний механик бүрэлдэхүүн




График 35. Мараалаг хүрэн хөрсний механик бүрэлдэхүүн




График 36. Нугархаг хүрэн хөрсний механик бүрэлдэхүүн

График 37. Хужирлаг хөрсний механик бүрэлдэхүүн

**2.6.4. Хөрсөн дэх хүнд металлын агууламж**

Газрын тосны хайгуул, олборлолтын Матад ХХ талбайгаас цуглуулсан өнгөн хөрсний дээжид өргөн тархалттай хүнд элементүүд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr) агууламжийг тодорхойлуулав. Хөрсний хүнд металлын бохирдлыг үнэлэхдээ бохирдлын индекс ашиглан, MNS5850:2019 стандартад заасан хүлцэх агууламжтай харьцуулан тодорхойллоо.

Хөрсний хүнд элементийн агууламжаас үзэхэд кадми (Cd) агууламж багажийн мэдрэг бүртгэгдэхгүй бага агууламжтай байгаа бол никель (Ni) агууламж 24-33мг/кг, дунджаар 29.4мг/кг орчим, хар тугалга (Pb) 21-28мг/кг хэлбэлзэх ба дундаж агууламж 24.9мг/кг орчим, зэс (Cu) агууламж 21-30мг/кг орчим, дундаж агууламж 25мг/кг, хром (Cr) 29-56мг/кг орчим дундаж агууламж 37.8мг/кг тус тус хэмжээтэй байна. Матад ХХ талбайд MNS5850:2019 стандартад заасан хүлцэх агууламжаас хэтэрсэн буюу бохирдол илрээгүй шинжтэй байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**


Хүснэгт 25. Хүнд металлын агууламж

Дд	Дээж	гүн, см	Хүнд металл, мг/кг					
			Никель	Кадми	Хар тугалга	Зэс	Цайр	Хром
1	20M-S-01	0-11	29.7	0	21.6	21.5	64.6	33.4
2	20M-S-05	0-20	24.2	0	24.2	24.3	70.8	38.7
3	20M-S-07	0-14	28.7	0	24.8	22.8	73.2	30.1
4	20M-S-09	0-11	30.4	0	26.1	26.8	62.1	29.7
5	20M-S-10	0-5	30.2	0	24.3	27.7	68.7	56.9
6	Цэн тогоруу-1	0-5	33.4	0	28.4	30.5	71.7	38.2
<b>MNS5850:2019</b>			150	3	100	100	300	150
<b>Шаварлаг</b>			150	1.5	100	100	300	150
<b>Шавранцар</b>			100	1	70	80	150	100
<b>Элсэрхэг</b>			60	3	50	60	100	60

Хөрсний бохирдлын зэргийн индекс ашиглан хэмжилтийн цэгүүдэд бохирдлын коэффициент буюу хүлцэх агууламжаас хэтэрсэн буюу бохирдолтой цэгийг илрүүлэх тооцооллыг гүйцэтгэсэн. Хөрсний бохирдлын индексээс үзэхэд Матад ХХ талбайн хүрээнд хүнд металлын бохирдлын индексийн утга нийт элементийн утга 2 буюу хүлцэх агууламжаас давсан утга илрээгүй буюу бохирдолгүй байна.

Хүснэгт 26. Бохирдлын индекс

Гүн, см	Хүнд металл мг/кг					
	Ni	Cd	Pb	Cu	Zn	Cr
<b>20M-S-01</b>	1.2	1.0	1.2	1.2	1.2	1.2
<b>20M-S-05</b>	1.2	1.0	1.2	1.2	1.2	1.3
<b>20M-S-07</b>	1.2	1.0	1.2	1.2	1.2	1.2
<b>20M-S-09</b>	1.2	1.0	1.3	1.3	1.2	1.2
<b>20M-S-10</b>	1.2	1.0	1.2	1.3	1.2	1.4
<b>Цэн тогоруу-1</b>	1.2	1.0	1.3	1.3	1.2	1.3





**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



**2.6.5. Хөрсөн дэх микробиологийн агууламж**

Хөрсний нянгийн бохирдлын түвшинг үнэлэхэд хүн болон амьтны гаралтай гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бактери (*Salmonella*) болон савханцрууд (*E.Coli*), агааргүй орчинд үрждэг (*Cl. perfringens*) анаэроб бактери гэсэн гурван үзүүлэлтүүдийг нянгийн бохирдлын ерөнхий үнэлгээний үзүүлэлт болгон ашигладаг. Хөрс өвчин үүсгэгч бактериар бохирдох нөхцөл, эх сурвалж нь тухайн өвчнөөр өвчилсөн амьтны ялгадас болон сэг зэм, өвчин тээгч хүний ялгадас зэргээр шууд болон усаар дамжин хөрсөнд ордог. Матад ХХ талбайн хувьд цаашид ажилчид оршин суух учир хөрсний нянгийн суурь түвшинг үнэлэх зорилгоор өнгөн хөрсний дээжид нянгийн агууламжийг тооцоолсон. Судалгааны талбайн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор төслийн нөлөөлөлд өртөх талбайн хүрээнд хэмжилтийн цэгээс өнгөн хөрсний дээж цуглуулан, нянгийн шинжилгээнд хамруулсан. Лабораторийн шинжилгээний дүнгээс үзэхэд хэмжилтийн цэгүүдэд нийт нянгийн тоо  $2.7-4.4 \cdot 10^4$ , *E. Coli* гэдэсний савханцар, *Cl. Perfingers* анаэробын титр 1.0 орчим агууламжтай буюу бохирдлын түвшин цэвэр буюу бохирдолгүй байгаа бол Хогийн цэг 20M-S-10 хэмжилтийн цэгт нийт нянгийн тоо  $6.4 \cdot 10^5$ , *E. Coli* гэдэсний савханцар 1.0 хэмжээтэй илэрсэн буюу өвчин үүсгэгч савханцраар бага зэрэг бохирдсон байгааг илтгэж байна. Энэ нь хогийн цэг мал амьтан үхсэн сэг зэмийг хаясан байгаатай холбоотой гэж таамаглаж

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

байна. Тухайн хогийн цэг нь Петроматад ХХК-ийн хогийн цэг биш малчин иргэдийн үнс болон үхсэн малын сэгийг зөөж хаяж үүсгэсэн хогийн цэг байна.

Агааргүй орчинд үрждэг *Cl. Perfringens* бактери төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй талбайд <0.1 хэмжээтэй буюу цэвэр түвшинд байна. Төсөл хэрэгжих талбайд агааргүйтэн болон гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нянгийн илрэл үүсэхгүй тохиолдолд эрүүл гэж үзэх учир хогийн цэг орчимд тодорхой агууламж илэрсэн байна. Иймд цаашид аж ахуйн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажил явуулахын тулд бохирдсон цэгийг тодорхойлон, бага бохирдолтой цэгийн хөрсийг цэвэршүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зохимжтой юм (хүснэгт 27).

Хүснэгт 27. Хөрсөн дэх гэдэсний өвчин үүсгэгч нян, бактери

ID	Дээж	Нянгийн тоо		Гэдэсний савханцарын титр (E.Coli)		Анаэробын титр (Cl.Perfringens)	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	
1	20M-S-01	4.4*10 <sup>4</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
2	20M-S-05	2.7*10 <sup>5</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
3	20M-S-07	3.2*10 <sup>5</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
4	20M-S-09	2.8*10 <sup>5</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
5	20M-S-10	6.4*10 <sup>5</sup>	1.0	Бага зэрэг бохирдолтой	0.1<	Цэвэр	

### 2.6.6. Хөрсөн дэх нефт бүтээгдэхүүн

Матад ХХ талбайн Цэн тогоруу-1, Цагаан зээр-1, Замын уулзвар гэсэн 3 цэгээс хөрсний нефт бүтээгдэхүүний шинжилгээг авч Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид шинжлүүлсэн.

Хүснэгт 28. Нефт бүтээгдэхүүний дээж авсан хөрсний цэгийн байршил

Цэгийн дугаар	Талбай	Хөрсний төрөл	Газарзүйн байршил	
			Өргөрөг	Уртраг
20M-S-01	Цэн тогоруу-1	Хар хүрэн хөрс	46° 49' 52.7''	116° 08' 35.73''
20M-S-07	Цагаан зээр-1	Хүрэн шороон хөрс	46° 49' 28.42''	116° 06' 43.4''
20M-S-09	Замын уулзвар	Хар хүрэн хөрс	46° 49' 06.29''	116° 06' 24.31''

Хөрсний шинжилгээний хариунаас харахад хөрсөнд агуулагдах нефт бүтээгдэхүүний агууламж 20M-S-01 цэгт 0.7 гр/кг, 20M-S-07 цэгт 0.2 гр/кг, 20M-S-09 цэгт 0.2 гр/кг байгаа нь MNS5850:2019 стандартад заасан хөрсөнд агуулагдах газрын тосны бүтээгдэхүүний хүлцэх агууламж 2 гр/кг-аас хэтрээгүй байна.

Хүснэгт 29. Хөрсөн агуулагдах газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээ

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Цэгийн дугаар	Талбай	Нефт гр/кг	МНС5850:2019 стандарт	
			Хүлцэх агууламж	Хортой агууламж
20M-S-01	Цэн тогоруу-1	0.7	2.0	8.0
20M-S-07	Цагаан зээр-1	0.2		
20M-S-09	Замын уулзвар	0.2		

### 2.6.7. Хөрсний цацраг идэвх

Матад ХХ талбайн цацрагийн дэвсгэр түвшин тогтоох зорилгоор сонгосон цэгүүдээс авсан хөрсний дээж дэх байгалийн ба үүсмэл цацраг идэвхт изотопуудын бүрэлдэхүүн, тэдгээрийн хувийн идэвхийг гамма спектрометрээр тодорхойлов. Тухайн төслийн талбайгаас авсан хөрсний дээжид цацраг идэвхт элементүүдийн хувийн идэвхийг тодорхойлох хэмжилтэд өндөр ялгах чадвартай цэвэр хагас дамжуулагч германи детектор, 4096 сувагтай анализатор бүхий гамма спектрометр ашигласан.

Талбайн хөрсний 3 цэгээс хөрсний 5 см гүн, 15 см x15 см талбайгаас хөрсний дээж авав. Дээжээ детекторт углаж ордог 700 см<sup>3</sup> эзлэхүүнтэй Маринеллийн саванд хийж, түүнийг 1 цаг хэмжив. Гамма спектрометр гаргаж авсан гамма спектрээс хөрсөн дэх цацраг идэвхт изотопуудын хувийн идэвхийг бүрэн шингээлтийн пикийн талбайгаар олохдоо дараах томъёог ашигласан. (Норов Н, Даваа С, Шагжамба Д, МУИС Эрдэм шинжилгээний бичиг №5 138 х.19-26, 1998)

$$A = \frac{N(E_i)}{k \cdot \varepsilon_0(E) \cdot k_\gamma \cdot m \cdot t}$$

Үүнд: А- изотопын хувийн идэвх (Бк/кг);

N(E)- гамма квантын бүрэн шингээлтийн пикийн талбай;

k<sub>γ</sub>- гамма квантын гаралт

ε<sub>0</sub>(E)- усны хувьд (ρ=1г/см<sup>3</sup>) олсон детекторын үнэмлэхүй бүртгэх чадвар;

k- дээжид гамма квантын сулралтыг тооцсон тогтмол (туршлагаар тодорхойлсон)

m - дээжний жин (кг)

t - хэмжсэн хугацаа (с).

Цөмийн зэвсгийн ил туршилт хийж байсан үед агаар мандалд хаягдаж, улмаар газрын хөрсөнд бууж хуримтлагдсан <sup>137</sup>Cs-ийн хувийн идэвхийг тодорхойлов. Хөрсөн дэх <sup>226</sup>Ra-ийн хувийн идэвхийг байгалийн цацраг идэвхт <sup>238</sup>U-ын бүлийн изотопуудын үүсгэх шугамуудаас хамгийн эрчимтэй 609.31кэВ (<sup>214</sup>Pb) шугамаар нэлээд нарийн тодорхойлогдоно.

<sup>232</sup>Th-ийн хувийн идэвхийг тодорхойлохдоо 583,19 кэВ (<sup>208</sup>Tl), 911,16 кэВ (<sup>228</sup>Ac) энергитэй гамма туяаг бүртгэсэн. <sup>40</sup>K, <sup>137</sup>Cs изотопуудын хувийн идэвхийг тэдгээрийн 1460.75 кэВ, 661.66 кэВ энергитэй гамма цацрагийн шугамуудаар тодорхойлов.

Байгалийн цацрагийн дэвсгэр түвшин дараах 3 хүчин зүйлсээс бий болно. (Белозерский Н.Г. , 2008) Үүнд:

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

1. Сансрын туяа
2. Дэлхийн царцдас, хөрс, агаар, ус болон байгалийн бусад зүйлд агуулагдах цацраг идэвхт нуклидуудаас цацрах төрөл бүрийн цацраг.
3. Дэлхийн гадарга дээр ил цөмийн зэвсгийн туршилт хийх үед болон цөмийн түлшний циклийн ослын үед гадаад орчинд хаягдах үүсмэл цацраг идэвхт нуклидаас цацрах цацраг зэрэг болно.

*Хүснэгт 30. Цацрагийн дээж авсан хөрсний цэгийн байршил*

Цэгийн дугаар	Талбай	Хөрсний төрөл	Газарзүйн байршил	
			Өргөрөг	Уртраг
20M-S-01	Цэн тогоруу-1	Хар хүрэн хөрс	46° 49' 52.7"	116° 08' 35.73"
20M-S-07	Цагаан зээр-1	Хүрэн шороон хөрс	46° 49' 28.42"	116° 06' 43.4"
20M-S-09	Замын уулзвар	Хар хүрэн хөрс	46° 49' 06.29"	116° 06' 24.31"
20M-S-10	Хогийн цэг	Хар хүрэн хөрс	46° 49' 52.71"	116° 08' 37.52"

Тус тусгай зөвшөөрлийн талбайгаас авсан хөрсний дээжид байгалийн болон үүсмэл цацраг идэвхт изотопуудын хувийн идэвхийг гамма спектрометрийн аргаар тодорхойлсон дүнг 10-р хүснэгтэд үзүүлэв. Төслийн талбайн хөрсөн дэх үүсмэл цацраг идэвхт <sup>137</sup>Cs-ийн хувийн идэвх, байгалийн цацраг идэвхт элементүүдийн агуулалт, хөрсөнд агуулагдах байгалийн цацраг идэвхт элементүүдийн хувийн идэвхийн хэмжээг ашиглан газрын хөрснөөс 1 м өндөрт агаарт шингэсэн цацрагийн тунгийн чадлыг дараах томъёогоор тооцно. (Норов Н, Даваа С, Шагжжамба Д, МУИС Эрдэм шинжилгээний бичиг №5 138 х.19-26, 1998)

$$P=0,427A_U +0,662 A_{Th}+0.043 \cdot A_K$$

Үүнд: P – шингэсэн цацрагийн тунгийн чадал (нГр/цаг);

$A_U, A_{Th}, A_K$  – <sup>238</sup>U, <sup>232</sup>Th, <sup>40</sup>K-ийн хувийн идэвх (Бк/кг).

*Хүснэгт 31. Талбайн хөрсний дээжийн цацраг идэвхт изотопуудын хувийн идэвх, элементийн агуулалт, агаарт шингэсэн цацрагийн тунгийн чадал*

№	Дээжийн дугаар	Изотопын идэвх, Бк/кг				Элементийн агуулалт			Радийн эквивалент, Бк/кг
		<sup>226</sup> Ra	<sup>232</sup> Th	<sup>40</sup> K	<sup>137</sup> Cs	U, г/т	Th, г/т	K, %	
1	20M-S-01	17	14	804	6	1.4	3.5	2.7	50
2	20M-S-07	15	11	787	2	1.2	2.7	2.6	46
3	20M-S-09	15	12	768	<1.1	1.2	3.0	2.6	46
4	20M-S-10	24	11	678	5	1.9	2.7	2.3	46
		17.75	12	759.25	4.33	1.42 5	2.975	2.55	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Дундаж	30	35	934	3.8	2.4	5.8	3.0	
Дэлхийн дундаж	25[1]	25[1]	370[1]	7.9[2]	2.0	5.2	1.2	

(United Nations Scientific Committee on the Effects of the Atomic Radiation Report, 1993)

Эдгээр хөрсний дээж дэх байгалийн цацраг идэвхт элемент ураны дундаж агуулалт 1.2-1.9 г/т байгаа нь, торын дундаж агуулалт 2.9 г/т байгаа нь дэлхийн дунджаас бага, калийн дундаж агуулалт 2.5% байгаа нь дэлхийн дунджаас 2 дахин их байна.

**Хүснэгт 23. хөрсний хяналт шинжилгээний үр дүн**

Утга	Батлагдсан БОХШХ төлөвлөгөө	Ажил эхлэхээс өмнөх БОХШХийн гүйцэтгэл	Тайлбар
ААН	Үйл ажиллагаа хариуцагч байгууллага: Петро Матад ХХК	<b>БОХШХ гүйцэтгэгч:</b> Эм И Си Эс Зэт Би ХХК	Гэрээ байгуулагдсан.
БОХШХ-Ш1: Газрын гадарга, хөрс	<ul style="list-style-type: none"> <li>- Хүнд металл, агро химийн шинж чанар – 3 хэмжээст чичирхийллийн талбай, өрөмдлөгийн талбай орчим – 4 цэгээс</li> <li>- Хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүн /ТРН/ - 10 цэгээс – 2 удаа</li> </ul> <p>Хог хаягдлын төлөв байдал ажиглалт Хөрсний хүнд метал, ТРН, ВТЕХ, Toluene, Methylbenzene, Xylene-volatile, aromatic compounds</p>	Хөрсний 10 мониторингийн цэгийг сонгосон ба үүнээс 9 цэгт хөрсний зүсэлт хийж хөрсний морфологи бичиглэл, хяналт шинжилгээ ажиглалт хийн хөрсний үржил шимийн ерөнхий үзүүлэлт, механик бүрэлдэхүүнийг тодорхойлсон, 5 цэгт хүнд металл, эрүүл ахуйн өнөөгийн агууламж тодруулах зорилготойгоор хөрсний шинжилгээний дээжийг авч, магадлан итгэмжлэгдсэн Ланд Овнер ХХК-ийн Грийн лаб лабораторид шинжлүүлсэн. Цэн тогоруу-1, Цагаан зээр-1, Замын уулзвар гэсэн 3 цэгээс хөрсний нефт бүтээгдэхүүний шинжилгээг авч Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид, 4 цэгээс цацраг идэвхийн дээжийг авч Цөмийн физикийн судалгааны төвийн итгэмжлэгдсэн лабораторид тус тус шинжлүүлсэн.	Матад ХХ талбайн 213 км.кв талбайд тархсан хөрсний тархалтын хэв шинжийг төлүүлэх цэг болгонд хөрсний зүсэлт хийж морфологи бичиглэл хийсэн болно.
Дүгнэлт:	<p>Газрын тосны хайгуул, олборлолтын Матад ХХ талбайн хөрсний мониторингийн хүрээнд хээрийн судалгаа болон зураглалын судалгааны үр дүнд газрын гадаргын хэлбэр дүрс, геологийн хурдас чулуулгийн тархалт, зүй тогтолтой уялдан хар хүрэн, хүрэн шороон, нугархаг болон мараалаг хүрэн хөрсний хэв шинжүүдийг ялган тодорхойлж, давсархаг нуур тойром болон дэрс бүхий хотгоруудад үлдмэл мараалаг болон давсархаг хөрсний хэв шинжүүдийг тус тус ялган тодорхойлов.</p> <p>Матад ХХ хайгуулын талбайн хөрсний суурь судалгааны анхдагч дүнгийн боловсруулалтаас үзэхэд хөрсний урвалын орчин сул шүлтлэг болон шүлтлэг шинжтэй, карбонатын агууламж бага, ихэнх хэмжилтийн цэгүүдэд илрэхгүй бөгөөд зөвхөн мараалаг</p>		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>болон давсархаг хөрсний хэв шинжүүдэд илэрсэн байгаа шинжтэй бол давсны агууламж ядуулаг шинжтэй байна. Хөрсний ялзмагийн агууламж 1.5% орчим тогтмол шинжтэй боловч ургамлын үндэсний тархалтын бүсүүдэд илүү хуримтлагдсан шинжтэй байна. хөрсний үржил шимийн хөдөлгөөнт болон шингээгдсэн суурийн нийлбэр хангамжтай сайн түвшинд байх бөгөөд хөдөлгөөнт суурийн нийлбэрт калийн исэл давамгайлах бол шингээгдсэн суурийн нийлбэрт кальцийн ион давамгайлна.</p> <p>Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн өргөн тархалттай хүнд металлын агууламжаас үзэхэд MNS5850:2019 стандартад заасан хүлцэх агууламжаас хэтэрсэн буюу бохирдол илрэхгүй байна.</p> <p>Төсөл хэрэгжих талбайд агааргүйтэн болон гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нянгийн илрэл үүсэхгүй тохиолдолд эрүүл гэж үзэх учир хогийн цэг орчимд тодорхой агууламж илэрсэн байна. Иймд цаашид аж ахуйн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын ажил явуулахын тулд бохирдсон цэгийг тодорхойлон, бага бохирдолтой цэгийн хөрсийг цэвэршүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зохимжтой юм</p>
--	--

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1

## 2.7 АМЬТНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024 -Н ГҮЙЦЭТГЭЛ


### 2.7.1. Газарзүйн байршил

Дорнод аймгийн Матад сумын төв нь Улаанбаатар хотоос зүүн тийш 720 километр, Дорнод аймгийн төв Чойбалсангаас урд зүгт 150 километр далайн төвшнөөс дээш 698 м өндөрт хээрийн бүсэд байрлана.

*Зураг 23. Мониторингийн талбайн ерөнхий байдал*



Зураг 24. Амьтан ажиглагдаж тэмдэглэл хийсэн цэгүүдийн байршил





### 2.7.2. Шавж

Шавж байгаль дээр экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул олон янзын экологийн онцлогтой.

Бидний судалгаа хийсэн нутгийн шавжийн анги нь хуурай хээрийн бүлгэмдэлд хамаарах бөгөөд нийт шавжийн тоо нэн олон боловч тархалт нь жигд биш байдгаараа онцлог ажээ. Хавар ба зуны эхэн үед зүйлийн бүрэлдэхүүн хамгийн олон янз болдог байна. Энэхүү бүлгэмдэлд хөдөө аж ахуйн хортон шавжаас *Chrysops ricordoce*, *Haematopota turkestanica turkestanica*, *H. desertorum* зэрэг 12 зүйл хөх түрүү түгээмэл тархалттай бол шөвгөн хушуут эрээн царцаа (*Aeropedellatus variegatus*), дорнын шөвгөн сахалт (*Myrmeleotettix palpalis*), модлог идэшт шавжаас сибирийн хүр (*Dendrolimus superans sibiricus*) зэрэг бэлчээрийн хортон зонхилдог. Иксод хачиг *Dermacentor nuttalli*, *Ixodes crenulatus* газар сайгүй тархдаг ажээ (БНМАУ-ын атлас).








Бидний судалгааны явцад Матад сумын нутагт орших мониторингийн талбайд дараах 10 гаруй зүйлийн шавжууд тааралдсан юм (Зураг 25).

*Зураг 25. Хайгуулын талбайд тааралдсан шавж*









Хужир мараат чийглэг хотгорт

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1

	
Шоргоолжны үүр	
	
Хар цох	Аалз
	
Харгана дээрх эрвээхэйн авгалдай	Цагаан зээрийн сэг дээрх авгалдай
	
Мелябрийн буглаа цох	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	
<p>Барабений таршаа</p>	<p>Эмэгчин ба эрэгчин шоргоолжуудад хос далавч хөгжсөн байна. Сарьсан далавчтаны нэг юм.</p>
	
<p>Хэдгэнэ</p>	<p>Бясаа</p>
	
<p>Шүр цох</p>	<p>Эрвээхэй</p>

**2.7.3. Хоёр нутагтан, мөлхөгчид**

Монгол оронд 2 баг, 4 овог, 4 төрөлд багтах 6-8 зүйлийн хоёр нутагтан тэмдэглэгджээ [8, 9, 10, 11]. Манай оронд 3 овог, 7 төрөл, 9 зүйлийн могой тэмдэглэгджээ. Монгол орны мөлхөгчдийн зүйлүүдийн ихэнх нь өмнөд нутгийн гандуу, хуурай бүс нутагт амьдардаг.

Матад ХХ талбайн нутаг дэвсгэр нь Монгол орны амьтдын тархцын зургаас үзвэл Дорнод Монголын тойрогт хамаарах бөгөөд тухайн нутагт тархсан мөлхөгчдийн тархац, байршлын талаар Х.Мөнхбаяр, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар (1991, 2001, 2005, 2010) нарын бүтээлд дурдсан байна. Тэдгээр судлаачдын бүтээлээс үзэхэд монгол бах (*Bufo raddei*), монгол гүрвэл (*Eremias argus*), рашааны могой (*Elaphe dione*), бамбай хоншоорт могой (*Gloydus halys*) зэрэг хоёр нутагтан, мөлхөгчид тархсан хэмээн тэмдэглэжээ. Харин энэ

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

удаагийн бидний судалгааны явцад монгол гүрвэл (*Eremias argus*) хэмээх нэг зүйлийн мөлхөгч уг бүс нутагт тархан амьдарч байна.

Монгол гүрвэл (*Eremias argus*) нь хайгуулын талбайн судалгааны 4 цэгт тааралдав. Тэдгээрийн орогнон орших нүх нь мэрэгчийн орхигдсон нүх, үхсэн амьтны сэг болон байгалийн хөрсөнд өөрсдийн ухсан нүх зэрэг байв (зураг 26).



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



*Зураг 26. Монгол гүрвэл (Eremias argus), түүний орогнох орчин. Зургийг Н. Цэгмид 2024.06.09*

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгч амьтдын хувьд амьдрах орчны хомсдол, бохирдол нь ховордуулах үндсэн гол шалтгаан болж байна. Ихэнх тохиолдолд байгалийн нөөцийн олборлолт, ашиглалтын улмаас орчны хомсдол, доройтол нүүрлэж байна. Уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын хөрс эвдэрснээс болж тархац тоо толгой хомсдох магадлалтай.

**2.7.4. Хайгуулын талбай дах шувуудын зүйлийн бүрдэл**

Бидний судалгаанд хамрагдсан нутаг нь Монгол орны шувууны газарзүйн мужлалаар Евразийн хээрийн дэд муж, Монгол-Дагуурын провинцийн хуваарилалд хамаарагдана. Энд бүртгэгдсэн шувууд хээр тал, ус намаг, барилга байгууламж зэрэг экологийн янз бүрийн орчинд оршин амьдардаг шувууд байгаа нь тус нутагт олон янзын ландшафтийн хэв шинжтэй болохыг илтгэн харуулна.

Биднээс өмнө энэ нутаг болон Дорнод Монголын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хамгийн анхны шувууны судалгааг Оросын Холбооны Улсын шувуу судлаач эрдэмтэн А.Я. Тугаринов (1932), Монгол-Зөвлөлтийн биологийн экспедиции В.А. Остапенко ба бусад (1976-1977), В.Е. Фомин., А. Болд (1975), Н. Цэвээнмядаг (2001) нар хийж өөрсдийн тайлан, бүтээлдээ нийтлүүлжээ (хүснэгт 2).

*Хүснэгт 32. Дорнод Монголын шувуудын зүйлийн тоо*

№	Судлагдсан газрын нэр	Зохиогч	Судлагдсан он	Зүйлийн тоо	
				Бүгд	Ялалт баг
1.	Налайх, Чойр, Батхан, Бойр, Халхын гол	Тугаринов А.Я.	1932	185	21
2.	Ховд, Их нууруудын хотгор, Буйр нуур, Халхын гол, Бөөн цагаан нуур, Таацын цагаан нуур, Улаан нуур	Остапенко В.А., Гаврилов В.М., Фомин В.Е., Болд А., Цэвээнмядаг Н.	1980	36	18
3.	Монголын бүх бүс, бүслүүр	Фомин В.Е., Болд А.	1991	415	118
4.	Дорнод аймаг	Цэвээнмядаг Н.	2001	330	-

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

А.Я. Тугариновын «Птицы Восточной Монголии по наблюдениям экспедиции 1928 г.» бүтээлд 21 зүйлийн шувууд Халхын гол, Буйр нуур орчимд бүртгэгдсэнээс 4 зүйл (шилийн сар, монгол болжмор, адууч чогчиго, бүжимч чогчиго) шувууд адил байв.

В.А. Остапенко ба бусад «Характер пребывания, территориальное размещение и некоторые черты экологии куликов Монголии» бүтээлд хиазатынхан овгийн шувуудын тархалтыг Ховд хотоос Халхын гол хүртэлх уудам нутагт хийгдсэнээрээ онцлог ба нийт 36 зүйлийн шувууг судлан тэмдэглэсэнээс Халхын гол, Буйр нуур орчимд 18 зүйлийн шувууны үржил, экологийн онцлогийн тухай бичиглэл хийжээ. Бидний судалгааны явцад уг нутагт 3 зүйлийн хиазатынхан овгийн шувуудын оршин амьдардаг болох нь тогтоогдов.

В.Е. Фомин, А. Болд нарын «Каталог птиц Монгольской народной Республики » бүтээлд Монгол орны бүх нутаг дэвсгэрт оршин амьдрах 415 зүйлийн шувуудын тархалтыг багтаасан манай орны шувуу судлалын шинжлэх ухааны тулгуур судалгааны материал нэг юм. Судалгаа хийгдсэн нутагт 118 зүйлийн шувууд бүртгэгдсэнээс бид 24 зүйлийн шувуудтай тааралдсан болно.

Бидний судалгаагаар хайгуулын талбай, түүний орчмын тал хээрт хийгдсэн экологийн олон янзын орчинд амьдардаг (хээр, барилга байгууламж, ус намаг, говь цөл, хад асга, мод бутны) нийт 8 баг, 14 овог, 21 төрөлд хамаарах 24 зүйл шувуу бүртгэв. Эдгээр шувуудын 12 зүйл (50 %) нь бор шувуутан юм. Амьдрах орчноор нь ангилвал хээр талын-10 (42%), ус намгийн-5 (21%), хад асганы-4 (17%), мод бутны-2 (8%), барилга байгууламжийн-2 (8%), говь цөлийн-1 (4%) зүйл шувууд тус тус байна. Энэ нутаг дахь шувуудын 10 зүйл (42%) нь хээр талын орчныг шүтэн амьдардаг байна (хүснэгт 33).

Хүснэгт 33. Хайгуулын талбай орчимд зуны улиралд тааралдах шувууд

№	Зүйлийн нэр		Оршин амьдрах хэлбэр	Амьдрах орчин	Гарал үүсэл Штегман, 1938	2024 он				Бүгд
						Талбай	Матад төв	Талбай руу явах замд	Талбай	
1	Хондон ангир	<i>Tadorna ferruginea</i>	өн	УН	Мон			2		2
2	Анхидал ангир	<i>Tadorna tadorna</i>	өн	УН	Мон			2		2
3	Шилийн сар	<i>Buteo hemilasius</i>	с	ХТ	Мон	1			1	2
4	Нөмрөг тас	<i>Aegyptus monachus</i>	с	ХА	Мон			4		4
5	Өвгөт тогоруу	<i>Grus virgo</i>	өз	ХТ	Мон	2				2
6	Нарийн хиазат	<i>Charadrius dubius</i>	өз	УН	ПА	1				1
7	Дорнын хиазат	<i>Charadrius veredus</i>	өз	УН	ГдТ	6				6
8	Эгэл хараалай	<i>Sterna hirundo</i>	өз	УН	ПА	2				2
9	Говийн ногтруу	<i>Syrhaptes paradoxus</i>	с	ГЦ	Мон			2	6	8
10	Хөхвөр тагтаа	<i>Columba livia</i>	с	ББ	ГдТ		46			46

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

11	Хурын ураацай	<i>Apus apus</i>	өз	ХА	ЕВ		30			30	
12	Хондлойцагаан ураацай	<i>Apus pacificus</i>	өз	ХА	ХЯТ		12			12	
13	Алаг шаазгай	<i>Pica pica</i>	с	МБ	ЕВ		2			2	
14	Улаанхушуут жунгаа	<i>Pyrrhocorax pyrrhocorax</i>	с	МБ	Мон		4			4	
15	Асрын алтанхараацай	<i>Hirundo rustica</i>	өн	ББ	ПА	6				1	
16	Боролзой богширго	<i>Alauda arvensis</i>	өз	ХТ	ПА	14+1juv			2	17	
17	Шооронэвэрт болжмор	<i>Eremophila alpestris</i>	с	ХТ	Арк	34			4	38	
18	Монгол болжмор	<i>Melanocorypha mongolica</i>	с	ХТ	Мон	38			18	56	
19	Адууч чогчиго	<i>Oenanthe oenanthe</i>	өз	ХТ	ПА	2				2	
20	Бүжимч чогчиго	<i>Oenanthe isabellina</i>	өз	ХТ	Мон	2	4			6	
21	Хээрийн боршувуу	<i>Passer montanus</i>	с	ХТ	ПА	8	12			20	
22	Хадны боршуу	<i>Petronia petronia</i>	с	ХА	ГдТ		4			4	
23	Монгол божирог	<i>Pyrgilauda davidiana</i>	с	ХТ	Мон	12			10	22	
24	Годлевскийн шийхнүүхэй	<i>Anthus godlewskii</i>	өн	ХТ	Мон	2				2	
<b>Нийт</b>							<b>116</b>	<b>114</b>	<b>10</b>	<b>41</b>	<b>291</b>

Тоо толгойн хувьд элбэг буюу олон тоогоор байнга тааралдаж байсан шувууд бол хээрт монгол болжмор (*Melanocorypha mongolica*), шооронэвэрт болжмор (*Eremophila alpestris*) болон боролзой богширго (*Alauda arvensis*) байна.

Дорнод Монголын тал хээрт хиазатынхан овгийн шувуудаас 3 зүйл бүртгэгдсний нэг зүйл нь дорнын хиазат (*Charadrius veredus*) юм. Хайгуулын талбайн судалгааны 3 цэгт тааралдав (зураг 27).

Зураг 27. Дорнын хиазат (*Charadrius veredus*)



Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1

Зураг 28. Нарийн хиазат (*Charadrius dubius*)-ын амьдрах орчин



Нарийн хиазат (*Charadrius dubius*)-ын мөр

Зуны улиралд оршин амьдрах зарим зүйл шувууны нэр, өнгөт зураг (судалгааны хугацаанд өөрсдийн авсан зураг), биеийн хэмжээ, идэш тэжээл, байршлын талаарх тайлбар бүхий жагсаалыг оруулав (Хүснэгт ). Шувуу нэг бүрийн зүйлийн нэрийг монгол болон шинжлэх ухааны гэсэн дараалалтай байрлуулав. Шувууны биеийн уртыг миллиметрээр, биеийн жинг том шувуудыг килограмм, жижгийг граммаар тус тус үзүүллээ. Биеийн уртыг **L**, биеийн жинг **P** үсгээр тус тус тэмдэглэв.



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Хүснэгт 34. Матад, түүний сав газарт тохиолдох зарим шувууд*

	<p><b>Анхидал ангир- <i>Tadorna tadorna</i></b>  <b>L 550-650 мм. P 0.8-1.65 кг.</b>                  Хужиртай нуур, тойром дагаж тархана. Гүехэн усны ёроолын амьтан, ургамлаар хооллоно.                  Багавтар устай нууранд хооллож байв.</p>
	
<p><b>Өвгөт тогируу- <i>Antropoides virgo</i></b> <b>L 950-985 мм. P 2.0-3.0 кг.</b>                  Үүрээ газар дээр ямарч дэвсгэргүй засч, 2 өндөг гаргана. Хорхой, шавж, зөөлөн биетэн, үр, ургамлын найлзуур үндсээр хооллоно. Хялганат хээрт хооллож байв.</p>	
	<p><b>Шилийн сар- <i>Buteo hemilasius</i></b>  <b>L 610-720 мм. P 1-1.3 кг.</b>                  Уулын хээр, хээр, хээржсэн цөлөөр амьдарна.                  Замын хажуугийн овоолсон шороон дээр сууж байв. Монгол чичүүлийн нүх замын хажуугаар элбэг тааралдана.</p>
	<p><b>Нөмрөг тас - <i>Aegyptius monachus</i></b>  <b>L 1000-1200 мм. P 7.5-12.0 кг.</b> Нэг удаад 1-2.5 кг цул мах иднэ. Нэг өндөг гаргана.  <b>Идэш тэжээл:</b>                  Сэг зэмээр хооллоно.</p>
	

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1

	<p><b>Асрын алтанхараацай-<i>Hirundo rustica</i></b></p> <p><b>L</b> 170-210 мм. <b>P</b> 11-23 г. Голцуу суурин газрыг бараадана. Их төлөв чийглэг орчинд нутаглана. Нисдэг шавжаар хооллоно.</p>
	<p><b>Монгол болжмор-<i>Melanocorypha mongolica</i></b></p> <p><b>L</b> 180-212 мм. <b>P</b> 41-67 г. Хээржсэн цөл, тал хээрт амьдардаг. Ургамлын үр, шавжаар хооллоно.</p>

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

	<p><b>Шоорон эвэртболжмор-<i>Eremophila alpestris</i></b></p> <p>L 160-190 мм. P 30-45 г. Говь, хээр, уулын хээр, модгүй уулсаар амьдардаг. Шавж, үрээр хооллоно.</p>
	<p><b>Боролзой богширго - <i>Alauda arvensis</i></b></p> <p>L 170-200 мм. P 29-50 г. Говь, хээр, уулын хээр, модгүй уулсаар амьдарна. Шавж, үрээр хооллоно.</p> <p>Доорх зураг боролзой богширгоны дэгдээхэй</p>

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



*Годлевскийн шийхнүүхэй- Anthus godlewskii*

L 155-170 мм. P 23-28 г. Чийглэг нугаар амьдарна. Шавж, үрээр хооллоно.

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

	<p><b>Адууч чогчиго - <i>Oenanthe oenanthe</i></b></p> <p>L 140-165 мм. P 19-35 г. Хээр, уулын хээрээр амьдарна. Янз бүрийн үет хөлтнөөр хооллоно.</p>
	<p><b>Хээрийн бор шувуу - <i>Passer montanus</i></b></p> <p>L 125-150 мм. P 19-29 г. Бут сөөгт бүх нутгаар амьдарна. Янз бүрийн үет хөлтөн, ургамлын үрээр хооллоно.</p>

### 2.7.5. Хөхтөн амьтад

Дэлхийн бөмбөрцөг дээр одоо 4500 гаруй зүйл хөхтөн амьтан тархсанаас 140 гаруй зүйл зэрлэг хөхтөн амьтад манай оронд тархан амьдарч байгааг судлаачид тогтоосон байна [1, 2, 3]. Монгол орны уугуул 128 зүйл хөхтөн амьтныг үнэлснээс 16 хувь нь бүс нутгийн хэмжээнд ховордлын ангилалд орсны 2 хувь нь **устаж байгаа**, 11 хувь нь **устаж болзошгүй**, 3 хувь нь **эмзэг** ангилалд хамрагдсан болохыг тогтоожээ.

Дорнод аймгийн Матад сумын нутгийн хөхтөн амьтдын судалгаа Монгол орны хөхтөн, амьтдын судалгааны хүрээнд багтаж иржээ. Тухайлбал, А.Г.Банников (1950), В.Е.Соколов, В.Н.Орлов (1980), С.Дуламцэрэн (1970, 2005) зэрэг эрдэмтдийн Монгол орны хөхтөн амьтдын талаарх тулгуур бүтээлүүдэд тус нутгийн хөхтөн амьтдын талаарх мэдээлэл багтжээ. Эдгээр бүтээлд хөхтөн амьтдын тархцын мужлалаар Дорнод Монголын тойрогт хамаарагдана (зураг 6).

Матад сумын нутаг буюу Дорнод Монголын хээрт 26 зүйлийн хөхтөн амьтад оршин амьдардаг болохыг судлан тогтоожээ.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хэвлэлийн мэдээнээс үзэхэд тус нутагт тархан амьдрах хөхтөн амьтдад дагуур зараа, бэсрэг атаахай, өөдсөн атаахай, азийн малтаахай, бор туулай, дагуур огдой, монгол тарвага, дагуур зурам, мэрэгчтнээс хэргэлзий огтоно, үлий цагаан огтоно, хөх шишүүхэй, орог зусаг, монгол чичүүл, гэрийн хулгана, сибирь алагдаага, махан идэшт амьтдаас нохой элбэнх, хярс, шар үнэг, саарал чоно, халздай дорго, өмхий хүрнэ, хотны үен, цагаан үен, хээрийн солонго, мануул зэрлэг туруутнаас цагаан зээр зэрэг хээрийн иж бүрдлийг бүрдүүлэн сэргээн зохицуулагчид нутагладаг тухай (Цэвэгмид, Цэнджав, 1989; Дуламцэрэн, 2006; Батсайхан нарын, 2014) хэвлэлийн мэдээ байна.

Бид хайгуулын талбайн орчимд цагаан зээр, бор туулай, халздай дорго зэргийг бүртгэсэн болно. Энэ нутаг бол цагаан зээрийн хувьд түүний өвөлждөг гол нутаг болохыг тэнд газар бүр алхам тутамд тааралдах сэг илтгэн харуулна (зураг 7).

*Зураг 29. Цагаан зээрийн сэг. Зургийг Н. Цэгмид 2024.06.8-9 өдрүүд*



Энэхүү олон цагаан зээрийн сэг нь 2023-2024 оны өвөл цас ихтэй байснаас тал нутагт хоол тэжээлгүй их хүйтний улмаас үхсэн байна. Зарим нь хаврын түймэрт шатаж үхсэн байна. Нэг цагаан зээрийг саарал чоно барьж идсэн ул мөр илрэв (зураг 8).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



*Зураг 30. Цагаан зээрийн сэг. Зургийг Н. Цэгмид 2024.06.8*

Ус мараа бүхий орчинд цагаан зээрийн мөр тааралдав (зураг 31). Цагаан зээр нь намхан уул толгод, гүвээ бүхий хялганат хээрт байршин амьдардаг. Ус болон бэлчээрийн хомсдолоос шалтгаалан байршлаа сэлгэнэ. Иймд хайгуулын талбайд орших энэхүү ус мараа бүхий орчин бол цагаан зээрийн хувьд маш чухал газар юм. Энэ газрыг хамгаалан авч үлдэхэд анхаарах зайлшгүй шаардлага байна. Учир нь цагаан зээр ч биш биологийн олон янз байдал хамгаалагдана.

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



Зураг 31. Ус мараа бүхий хотгорын ерөнхий байдал. Зургийг Н. Цэгмид 2024.06.8 өдөр Хайгуулын талбайд амьдарч буй цагаан зээрийн зургийг оруулав (зураг 32).







Зураг 32. Хөвөө нуурын урд. 2024.06.08. 20:38 цаг.

### **Бор туулай - *Lepus tolai***

Манай орны ойгоос бусад бүх нутагт түгээмэл тархсан амьтны нэг. Бүрэнхий шөнөөр гүйж бут, харгана, өвслөг ургамал, дэрсээр хооллоно. Түүнчлэн бор туулай ойт хээр, хээр, говь цөлд өргөн дэлгэр тархацтай, голын хөндий, хээрийн ургамалтай задгай газар болон гол горхи, баян бүрд дагаж амьдрах бөгөөд үетэн, хунчир, тарваган шийр, шаваг, таана зэрэг шүүст өвслөг ургамлаар хооллоно. Хавар зонхилон дэрсний үндэс ухаж идэх дуртай гэж судлаачид (Цэнджав нар, 1989) тэмдэглэсэн байна. Ороо нийллэг 3-р сарын дунд үед болж, эм туулай 42 орчим хоног хээлээ тээдэг. Жилд 2 удаа төллөх ба нэг удаа дунджаар 2-6 бүжин төрүүлнэ. Нэг настай үржилд ордог. Байгалийн нөхцөлд 7 хүртэл жил насална. Бор туулай агнуурын ач холбогдолтой (Зураг 11).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



*Зураг 33. Бор туулайн ялгадас*

**Хярс (*Vulpes corsak*)**

Монголд өргөн тархацтай, элбэг мах идэштэн. Биеийн урт 50-60 см, сүүлний урт 25-36 см, чихний урт 6-9 см, биеийн жин 2-3 кг. Биеийн өнгө төрхөөрөө үнэгтэй төстэй боловч биеэр илэрхий жижиг. Биеийн өнгө хул-шаргалдуу саарал. Сор үсний үзүүр цагаан тул мөнгөлөг туяатай харагдана. Нуруун тал нь хүрэвтэр. Цээж болон хэвлий шаргал туяа бүхий цайвар. Сүүл богино, үзүүр нь хар. Өвлийн үс тод улаан шаргал, зуны үс улбар цайвар. Хярс үнэг нь Хэнтий, Хөвсгөлийн тайга, Алтай Хангайн өндөр уулс, Их Хянганы салбар уулс, Алтайн өвөр говийн хамгийн цөлөрхөг хэсэг зэрэг нутгаас бусад хээр, ойт хээр, уулын хээрийн ихэнх нутагт түгээмэл тархсан (Дуламсүрэн, 1970). Жинхэнэ тал хээрийн амьтан (зураг 12). Шөнө гөрөөлнө, өдөр нүхэнд орж, орой бүрэнхий болмогц идэш тэжээл эрж үүр цайтал гөрөөлнө. Зун, намар, хавар зонхилон жижиг мэрэгч, шувуу түүний өндөг, ангаахай, дэгдээхэй, заримдаа царцаа дэвхрэг, өвсний үр, амьтны сэг иднэ. Гээгдсэн суран чөдөр, хазаар, ногт, уургын хуйв зэргийг ч иддэг амьтан. Гэвч аль ч улиралд тэжээлийн 70-90%-ийг бэлчээрийн хортон үлийн цагаан оготно эзэлдэг. Ороо хөөцөө 2-р сард болж, 5 сард 2-5, заримдаа түүнээс ч олон гавар гаргадаг. Гавар хоёр долоо хоногийн дараа нүдээ нээж, сар шахам эхийгээ хөхнө. Сарын дараа бор хоолонд дасгадаг. Хавар гарсан зулзагууд зуны дунд сараас бие даан нэг нэгээрээ явж гөрөөлөх боловч төрсөн нүх болон бие биеэсээ нэн их холдохгүй.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Зураг 34. Хялгана дээрх хярсны ялгадас*



Саарал чоно, түүний ялгадас нь нохдын овгийн бусад махчин амьтдынхаас хэмжээгээр том, бараан, бүдүүн, үс ноос, хялгас, ясны хэлтэрхий ихтэй байдгаараа амархан ялгагдана (Зураг 13).

*Зураг 35. Чонын ялгадас. Цэн тогоруу 1 талбайд*



Төслийн талбайд тарвага амьдарч байжээ. Бидний олсон хавх бол он удаан жил хаягдаж хавхны тал нь шороонд дарагдсан байв. Хавх гар хийцийнх бөгөөд гинжээр аргамжсан байв.

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1

Зураг 36. Хавх



Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1




Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

## 2.8 УРГАМЛАН НӨМРӨГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024 -Н ГҮЙЦЭТГЭЛ

### 2.8.1. Судалгааны материал

Бид хээрийн судалгааг 2024 оны 6 -р сарын дунд 10 хоногт багтаан нийт 13 цэгт ургамлын мониторинг цэгүүдэд бичиглэл хийж, материал цуглуулав.

Зураг 37. Ургамлын хээрийн судалгааны мониторинг цэг



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

**2.8.2. Судалгааны арга зүй**

Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын зааврын дагуу ургамлын судалгаанд дараах аргуудыг хэрэглэсэн.

- Ургамлын буюу геоботаникийн бичиглэлийг 100 м<sup>2</sup> талбайд хийж,
- Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхойлох,
- Ургамлын бүрхэц тодорхойлох /халцгай, хад чулууны бүрхэц/
- Ургац тодорхойлох

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн фото зургийг авахдаа 1м<sup>2</sup>-ын тор тавьж, эгц дээрээс нь авах бөгөөд фото зургийг тайланд оруулахдаа дараах мэдээллийн хамт бичсэн.

- Аймгийн/нийслэлийн нэр
- Сумын/ дүүргийн нэр
- Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар
- Солбицол
- Он сар өдөр

Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тогтоох арга: Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо 100 ам метр /10м x 10м/ газрын дөрвөн өнцөгт нь ялгах тэмдэг тавьж, нэг өнцгөөс нөгөө өнцгийг чиглэн диагалдан явж тохиолдох бүх ургамлыг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн нэршлийг Монгол орны гуурст дээд ургамлын бүртгэл бичигт (И.А.Губанов, 1996) болон ургамал таних бичигт (В.И.Грубов, 2008) зааснаар нэрлэж, олон улсын СИ системийн нэршлээр филогенетик системийн дагуу жагсаан бичсэн.

Зүйл ургамлын арвийг өгөхдөө харьцуулах үндсэн мэдээнд аль аргыг хэрэглэсэнээс хамааран 2.1, 2.2-р хүснэгтэд үзүүлсэн шатлалыг хэрэглэн ургамал тус бүрийн арвийг талбайгаа 100 % гэж үзэн нүдэн баримжаагаар тооцоолон хувилж өгсөн.

Зүйлийн жагсаалт хийх үед танихгүй юмуу эргэлзээтэй ургамал тааралдвал цуглуулгад авч дугаар, болзолт нэр, хугацаа, ургамал цуглуулсан газар ба бэлчээрийн хэв шинжийн нэрийг жижиг цаасан дээр бичиж хавсаргав.

**Хүснэгт 35. Друдегийн үнэлгээ**

Бүрхэцийн хэмжээ		Зүйлийн баялгийн онцлог	Хоорондын зай, см
Кодоор	Хувь		
Сop <sup>2-3</sup>	30 дээш	Нэн арвин	<20
Сop <sup>1</sup>	10-25	Арвин	20-40
Sp	5-10	Тармагдуу	40-100
Sol	1-5	Дунд зэрэг	100-150
R	1	Нэн ховор	>150

**2. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц, халцгай газар, хагд, хад чулууны хэмжээг тодорхойлох:** Газрын гадарга дээрх ургамлан нөмрөгийн бүрхэц, халцгай газар, хайрга чулуу, хагдны хэмжээг тодорхойлохдоо: Л.Г.Раменскийн 1м<sup>2</sup> -ийн трансектын тороор ургамлан нөмрөгийн бүрхэц тодорхойлох уламжлалт аргыг хэрэглэсэн.

## **Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Ажиглалтын талбай дотроо дурын цэгийг сонгон трансектын торыг ашиглан тодорхойлсон. Торны 1 нүд 1%-тай тэнцэнэ.

Торны эгц дээрээс нь харж, зогсоо байдлаас хөрсний гадаргын бүрхцийг торны 1 нүдийг 1 хувь гэж тооцон нүд болгоноор тоолон ургамлын бүрхэц, халцгай газрын хэмжээ, хад чулууны хэмжээ, хагдны бүрхцийг хувилж гарган доорх нүдэнд бичсэн.

**3. Ургац тодорхойлох арга.** Ургацын дээжийг бүрхэц тодорхойлсон цэгээс (1 м<sup>2</sup> талбай) ургамлыг газрын хөрснөөс 0 см-ийн түвшинд хагд, ногоог аж ахуйн бүлгээр ялган, хайчлан авч сүүдэр газар тавьж хатаан 0,01 нарийвчлалтай жингээр хуурай жинг жигнэж тогтоов. 5 давталтын тоог дундажлан талбайн ургацын тон мэдээг гаргасан. Хэмжилтийг хүснэгтэд нэгтгэн давталтын дундаж гр-аар хэмжигдсэн ургацыг ц/га гэсэн нэгжид шилжүүлэн тооцож тэмдэглэв.

### **4. Бэлчээрийн талхагдал**

Бэлчээрийн талхлагдалыг ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт ба ургамлын тусгац бүрхэц болон ургацаар тодорхойлсон. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлтийг Друдегийн аргаар, ургамлын тусгац бүрхэвчийг Л.Г.Раменскийн аргаар тус тус тодорхойлсон.

Бэлчээрийн талхлагдалыг дараах 3 зэрэглэлд хуваасан. Үүнд:

- Сул талхлагдсан
- Дунд талхлагдсан
- Хүчтэй талхлагдсан

Сул талхлагдсан бэлчээр: Үндсэн бүлгэмдлийн зохилогч, дэд зохилогч нь ценоз /бүлгэмдэл/ үүсгэх үүрэг өөрчлөгдөхгүй. Сул талхагдалд орсон бол бэлчээрийн зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт бага зэрэг орж, үетний тоо буурч, алаг өвсний тоо ихсэх хандлагатай.

Дунд зэрэг талхлагдсан бэлчээр: Зонхилогч ургамлын ариг багасаж, агь, ишгүй гичгэнэ /навтуул/, арзгар согсоолж, нэг наст шарилжууд ариг ихтэй ургана. Дунд талхагдалд орсон бол зүйлийн бүрэлдэхүүний тоо мэдэгдэхүйц цөөрч, ургамлын бүрхэц багасаж, бүрхцэд талхагдлын заагуур ургамлын арви ихэссэн.

Их талхлагдсан бэлчээр: Үндсэн бүлгэмдэл зохилогч ургамлууд цөөрөн ганц нэг болон сийрэгжиж оронд нь агь, адамсийн шарилж, ширэг улалж, амманы сэдэргэнэ зэрэг мал иддэггүй хог ургамлын ариг нэмэгдэнэ. Их талхагдалд орсон бол зүйлийн бүрэлдэхүүний тоо эрс цөөрч, тухайн бэлчээрт 2-3 талхагдлын заагуур ургамал давамгайлсан зонхилогч болсон.

### **2.8.3 Ургамалжлын мониторинг судалгааны үр дүн**

#### **Ургамлан нөмрөгийн төлөв байдал**

Ургамалжлын бичиглэл: Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд ургамалжлын 10 бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Х-хээрийн Хялгана-улалж-хазаарт (106 /X-I-2-5), Хялганат (110 /X-I-2-9), Хялгана-хиагт (105 / X-I-2-4), Хялгана-биелэгт (108/ X-I-2-7), Хялгана-жигжиг дэгнүүлт үетэнт (126 / X-II-2-5), Үетэнт- жигжиг улалжит (120 / X-I-4-1), Хялгана-харганат (129 / X-II-2-8) бүлгэмдэл байна.

Н-Нам хотосын Улалж-дэрст (228 / Н-III-5-1), Үетэн-жигжиг улалж-бударганат (219/ Н-III-2-3), Дэрс -өлөнгөт (222 / Н-III-3-3) бүлгэмдэл байна.

Мониторингийн талбай нь газрын гадаргын төрх байдлын хувьд ландшафтын ялгарлаар хээрийн цэвэр өвслөг ургамалтай 168.72 га, бүс дундын нугын 45.2 га талбай байна.

Мониторингийн ургамлан нөмрөгийн 100 м<sup>2</sup> талбайд 7-18 зүйл, 1м<sup>2</sup> талбайд 3 -10 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын тусгаг бүрхэц хээрээр 53.0-75.0%, дэрст нугадаа 64.4-87.4%, га –ийн ургац хээрээр 3.644-6.396 центнер, нугадаа 2.55-4.828 центнер байна.

*Хүснэгт 36. Ургамалжлын бичиглэл*

№	Бэлчээрийн төрөл	Бэлчээрийн ургамалжлын шалгуур үзүүлэлт							
		Зүйлийн тоо (100м <sup>2</sup> талбайд)	Зүйлийн тоо (1м <sup>2</sup> талбайд)	Ургамлын бүрхэц, %	Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хад, хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац, ц/га
1	Хялгана-улалж-хазаарт (106 /X-I-2-5))	12	4-6	53.0	5.2	19.8	0.0	27.2	3.838
2	Хялганат (110 /X-I-2-9)	14	4-6	75.0	3.2	19.6	-	5.4	6.396
3	Хялгана-хиагт (105 / X-I-2-4)	9	3-5	53.8	16.6	29.4	2.4	14.4	3.828
4	Улалж-дэрст (228 / Н-III-5-1)	7	6-7	87.4	1.0	7.4	0.0	5.2	4.828
5	Үетэн-жигжиг улалж-бударганат (219/ Н-III-2-3)	10	3-5	64.4	11.8	28.4	0	7.2	2.55
6	Дэрс -өлөнгөт (222 / Н-III-3-3)	18	5-10	74.6	12.0	15.2	2.2	8.0	4.312
7	Хялгана-биелэгт (108/ X-I-2-7)	11	5-6	60.4	2.8	12.0	0.0	27.6	5.37
8	Хялгана-жигжиг дэгнүүлт үетэнт (126 / X-II-2-5)	9	5-6	55.6	23.4	32.6	1.4	10.4	3.644
9	Үетэнт- жигжиг улалжит (120 / X-I-4-1)	7	4-5	66.6	5.0	19.6	0.0	13.8	3.864
10	Хялгана-харганат (129 / X-II-2-8)	29	5-10	54.6	32.0	35.2	2.2	8.0	4.312

1. Хялгана-улалж-хазаарт (106 /X-I-2-5) хээрийн бүлгэмдлийн (20M-FL -1 –р цэг) 100м<sup>2</sup>-д Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), зонхилж, үетнээс Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* С.А.Мей.), алаг өвснөөс: Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Цуулбар багваахай

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

(*Taraxacum dissectum* (Ldb.) Ldb.), буурцагтнаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.) DC.), Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), талхагдлын заагуур ургамлаас Бөөн цэцэгт цангуу (*Lepidium densiflorum* Schrad.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.) ургасан, нийт 6 овог, 12 төрөл, 12 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 53.0%, түүнээс талхагдлын заагуур ургамал 5.2% эзэлж, нийт бүрхцэд хад чулуу гүй, хагд 27.2%, халцгай газар 19.8% байна (Зураг 39, Хүснэгт 37).



*Зураг 38. Ургамлын бичиглэл 1.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
Хялгана-улалж-хазаарт бүлгэмдэл  
N 46°45'18.72''; E 115°57'28.99''; h 663;  
2024.06.08.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хялгана-улалж-хазаарт бүлгэмдлийн га –ийн ургац 3.88 цн, үүнээс, хялгана, хиаг, хазаар өвс зэрэг үетэн 2.062 цн, хагд 1.082 цн, алаг өвс 0.572 цн, улалж 0.152 цн байна (хүснэгт 38).

*Хүснэгт 37. Хялгана-улалж-хазаарт бүлгэмдлийн ургацын бичиглэл*

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	20.9	20.5	21.2	20.1	20.4	103.1	20.62	2.062
Улалж	2.0	1.0	1.0	1.5	2.1	7.6	1.52	0.152
Алаг өвс	6.0	5.5	5.4	5.6	6.1	28.6	5.72	0.572
Хагд	10.0	11.2	12.1	10.3	10.5	54.1	10.82	1.082
Нийт	38.9	38.2	39.7	37.5	39.1	193.4	38.38	3.838

2. Хялганат (110 /X-I-2-9) хээрийн бүлгэмдлийн (20M-FL -2 –р цэг) 100м<sup>2</sup>-д Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Том хялгана (*Stipa grandis* P.Smirn.) зонхилж, үетнээс Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), алаг өвснөөс: Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Дагуур хатны цэцэг (*Cymbaria dahurica* L.), Хигмэл гичгэнэ (*Potentilla multifida* L.), буурцагтнаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.) DC.), Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), талхагдлын заагуур ургамлаас Цагаан лууль (*Chenopodium album* L), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Бөөн цэцэгт цангуу (*Lepidium densiflorum* Schrad.), Цэх галуун таваг (*Chiazospermum erectum* L.) ургасан, нийт 8 овог, 12 төрөл, 14 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 4-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 75.0%, түүнээс талхагдлын заагуур ургамал 3.2% эзэлж, нийт бүрхцэд хад чулуугүй, хагд 5.4%, халцгай газар 19.6% байна (Зураг 6, 7, Хүснэгт 6).



*Зураг 39. Ургамлын бичиглэл 2.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа

Хялганат бүлгэмдэл

N 46°47'33.25"; E 115°58'08.98"; h 674;

2024.06.08.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 38. Хялганат ургамлан нөмрөгийн төлөв байдал

Бэлчээрийн төрөл	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	Ургац/га
Хялганат	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1	75	6	14	3	23	-	2	6.75
Давталт 2	70	6	14	2	25	-	5	6.57
Давталт 3	68	4	14	2	24	-	8	5.96
Давталт 4	78	85	14	5	19	-	3	6.03
Давталт 5	84	6	14	4	7	-	9	6.67
Дундаж	75.0	4-6	14	3.2	19.6	-	5.4	6.396

Хялганат бүлгэмдлийн га –ийн ургац 6.396 цн, үүнээс, хялгана зэрэг үетэн 5.026 цн, харгана 1.37 цн байна (хүснэгт 39).

Хүснэгт 39. Хялганат бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Хялгана	55.0	55.2	51.1	46.8	43.2	251.3	50.26	5.026
Харгана	12.5	10.5	8.5	13.5	23.5	68.5	13.7	1.37
Нийт	67.5	65.7	59.6	60.3	66.7	319.8	63.96	6.396

3. Хялгана-хиагт (105 / Х-I-2-4) хээрийн бүлгэмдэлд (20M-FL -3 –р цэг) Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.) зонхилж, улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), алаг өвснөөс: Бүхэл навчит багдай (*Dontostemon integrifolius* (L.) C.A.Mey.), Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), сөөг, сөөгөнцрөөс Жижиг навчит харгана (*Caragana microphylla* (Pall) Lam.), Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) G. Don.), буурцагтнаас Дагуур хошоон бут (*Lespedeza dahurica* (Laxm.) Schingdl.), зэрэг нийт 100м<sup>2</sup> талбайд 6 овог, 9 төрөл, 9 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 3-5 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 53.8%, түүнээс талхагдлын заагуур ургамал 16.6%, нийт гадаргын бүрхцэд хайрга чулуу 2.4%, хагд 14.4%, халцгай газар 29.4% байна (Зураг 41, хүснэгт 41).

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



*Зураг 40. Ургамлын бичиглэл 3.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
Хялгана-хиагт бүлгэмдэл  
N 46°47'30.57"; E 115°07'24.48": h 719;  
2024 06 20

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



*Зураг 41. Ургамлын бичиглэл 4.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
Улалж-дэрст бүлгэмдэл  
N 46°47'30.57"; E 115°07'24.48": h 719;  
2024.06.09.

*Хүснэгт 40. Улалж-дэрст ургамлан нөмрөгийн төлөв байдал*

Бэлчээрийн төрөл	Үзүүлэлт							Ургац/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагчийн заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хэгдны хэмжээ, %	
Улалж-дэрст	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1	90	6	7	1	5	0	5	5.55
Давталт 2	91	7	7	1	3	0	6	1.61
Давталт 3	88	6	7	1	8	0	4	7.92
Давталт 4	82	6	7	0	13	0	5	2.01
Давталт 5	86	7	7	2	8	0	6	7.05
Дундаж	87.4	6-7	7	1.0	7.4	0.0	5.2	4.828


Улалж-дэрст бүлгэмдлийн га –ийн ургац 4.828 цн, үүнээс улалж 1.814 цн, дэрс 3.014 цн байна (хүснэгт 44).

*Хүснэгт 41. Улалж-дэрст бүлгэмдлийн ургацын бичиглэл*

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Улалж	15.5	16.1	18.6	20.1	20.4	90.7	18.14	1.814
Дэрс	40.0	0.0	60.6	0.0	50.1	150.7	30.14	3.014
Нийт	55.5	16.1	79.2	20.1	70.5	241.4	48.28	4.828

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

5. Үетэн-жижиг улалж-бударганат (219/ Н-III-2-3) бүлгэмдэлд (20М-FL -5 –р цэг) Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Нангиад түнгэ (*Leymus chinensis* (Trin.) Tzvel.), Турьхан цэцэгт зурман сүүл (*Puccineillia tenuiflora* (Griseb.) Scribn.et Merr.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.) зонхилж, улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* С.А.Мей.), үндэслэг иштэн Цагаалин цахилдаг (*Iris lactea* Pall.), бударганаас Гоолиг шар бударгана (*Kalidium gracile* Fenzl.), шарилжаас Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.) зэрэг нийт 100м<sup>2</sup> талбайд 5 овог, 8 төрөл, 9 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 3-5 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 64.4%, түүнээс талхагдлын заагуур ургамал 11.8% эзэлж, сул доройтсон, нийт бүрхцэд чулуугүй, хагд 7.8%, ургамалгүй халцгай газар 28.4% байна (Зураг 43, Хүснэгт 45).



*Зураг 42. Ургамлын бичиглэл 5.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
Үетэн-жижиг улалж-бударганат бүлгэмдэл  
N 46°44'04.14"; E 116°00'20.63"; h 679;  
2024.06.09.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 42. Үетэн-жижиг улалж-бударганат ургамлан нөмрөгийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж	Үзүүлэлт							Ургац/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	
Үетэн-жижиг улалж-бударганат	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1	68	4	10	15	24	0	8	2.74
Давталт 2	70	3	10	8	21	0	9	2.35
Давталт 3	61	5	10	9	35	0	4	2.41
Давталт 4	58	5	10	10	34	0	8	2.81
Давталт 5	65	4	10	17	28	0	7	2.44
Дундаж	64.4	3-5	10	11.8	28.4	0	7.2	2.55

Үетэн-жижиг улалж-бударганат бүлгэмдлийн га –ийн ургац 2.55 цн, үүнээс хиаг, түнгэ зэрэг үетэн 1.78 цн, бударгана шарилж 0,524 цн, хагд 0,246 цн байна (хүснэгт 46).

Хүснэгт 43. Үетэн-жижиг улалж-бударганат бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн, улалж	18.5	15.8	17.8	20.1	16.8	89.0	17.8	1.78
Бударгана, шарилж	5.1	5.2	5.1	5.5	5.3	26.2	5.24	0.524
Хагд	3.8	2.5	1.2	2.5	2.3	12.3	2.46	0.246
Нийт	27.4	23.5	24.1	28.1	24.4	127.5	25.5	2.55

6. Дэрс -өлөнгөт (222 / Н-III-3-3) хээрийн бүлгэмдэлд (20М-FL-6 –р цэг) .), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.) зонхилж, үетэнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Дэврвэн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Ахарсорт арвай (*Hordeum brevisubulatum* (Trin.) link.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), алаг өвснөөс: Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Бүхэл навчит багдай (*Dontostemon integrifolius* (L.) C.A.Mey.), сөөг, сөөгөнцрөөс Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) буурцагтанаас Юлдэн тарваган шийр (*Thermopsis lanceolata* R.Br.), Нумраа хунчир (*Astragalus adsurgens* Pall.), талхлагдлын заагуур ургамлаас Шоргор лууль (*Chenopodium acuminatum* Willd.), Агь (*Artemisia frigida* Willd.), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), Адамсын шарилж (*Artemisia Adamsii* Bess.), Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), зэрэг нийт 100м<sup>2</sup> талбайд 7 овог, 14 төрөл, 18 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>–д 5-10 орчим зүйл тааралдаж байв. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 54.6%, түүнээс талхагдлын заагуур ургамал 32.0%, нийт гадаргын бүрхцэд хайрга чулуу 2.2%, хагд 8.0%, халцгай газар 35.2% байна (Зураг 16, 17, хүснэгт 14).



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



*Зураг 43. Ургамлын бичиглэл 6.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
 Дэрс -өлөнгөт бүлгэмдэл  
 N 46°49'37.89"; E 116°03'05.8"; h 656;  
 2024.06.09

*Хүснэгт 44. Дэрс -өлөнгөт ургамлан нөмрөгийн төлөв байдал*

Бэлчээрийн хэв шинж	Үзүүлэлт							Урга ц/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	
Дэрс -өлөнгөт	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1	70	5	18	10	21	3	6	4.33
Давталт 2	65	7	18	5	22	5	8	4.01
Давталт 3	88	8	18	18	3	0	9	4.63
Давталт 4	73	10	18	12	18	2	7	4.12
Давталт 5	77	7	18	15	12	1	10	4.47
Дундаж	74.6	5-10	18	12.0	15.2	2.2	8.0	4.312

Дэрс -өлөнгөт бүлгэмдлийн га –ийн ургац 4.312 цн, үүнээс хиаг, хялгана зэрэг үетэн 0.91 цн, алаг өвс 0.418 цн, хагд 0.442, хог ургамал ба шарилж 2.542 цн байна (хүснэгт 15).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 45. Дэрс -өлөнгөт бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	9.1	8.3	8.5	9.1	10.5	45.5	9.1	0.91
Алаг өвс	4.6	3.5	4.5	4.1	4.2	20.9	4.18	0.418
Хагд	4.5	5.1	5.2	3.5	3.8	22.1	4.42	0.442
Хог ургамал ба шарилж	25.1	23.2	28.1	24.5	26.2	127.1	25.42	2.542
Нийт	43.3	40.1	46.3	41.2	44.7	215.6	43.12	4.312

7. Хялгана-биелэгт (108/ X-I-2-7) бүлгэмдэлд (7 –р цэг) Сибирь биелэг (*Poa sibirica* Roshev.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.) зонхилж, улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), алаг өвснөөс: Имт гичгэнэ (*Potentilla bifurca* L.), Дагуур хатны цэцэг (*Cymbaria dahurica* L.), Бүхэл навчит багдай (*Dontostemon integrifolius* (L.) C.A.Mey.), буурцагтанаас Тарваган харгана (*Caragana pugnata* (L.) DC.), талхагдлын заагуур ургамлаас Сортой лууль (*Chenopodium aristatum* L.), Ишгэн шарилж (*Artemisia dracuncululus* L.) ургасан, нийт 8 овог, 10 төрөл, 11 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>–д 5-6 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 53.0%, түүнээс талхагдлын заагуур ургамал 1.6% эзэлж, нийт бүрхцэд хад чулуу гүй, хагд 27.2%, халцгай газар 19.8% байна Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 60.4%, түүнээс талхагдлын заагуур ургамал 2.8% эзэлж, , нийт бүрхцэд чулуугүй, хагд 27.6%, халцгай газар 12.0% байна (Зураг 45, Хүснэгт 49).



Зураг 44. Ургамлын бичиглэл 7.

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
Хялгана-биелэгт бүлгэмдэл  
N 46°49'05.21"; E 116°04'32.18"; h 668;  
2024 06 09

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Хүснэгт 46. Хялгана-биелэгт ургамлан нэмрөгийн төлөв байдал*

Бэлчээрийн хэв шинж	Үзүүлэлт							Ургац/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	
Хялгана-биелэгт	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1	65	5	11	2	11	0	24	5.54
Давталт 2	61	5	11	3	13	0	26	4.65
Давталт 3	58	6	11	5	12	0	30	5.39
Давталт 4	63	6	11	1	11	0	26	6461
Давталт 5	55	6	11	3	13	0	32	5.66
Дундаж	60.4	5-6	11	2.8	12.0	0.0	27.6	5.37

Хялгана-биелэгт бүлгэмдлийн га –ийн ургац 5.37 цн, үүнээс биелэг, хялгана, дааган сүүл зэрэг үетэн 3.46 цн, алаг өвс 0.924 цн, хагд 0.986 цн байна (хүснэгт1 7).

*Хүснэгт 47. Хялгана-биелэгт бүлгэмдлийн ургацын бичиглэл*

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	45.5	46.8	43.8	40.1	46.8	173.0	34.6	3.46
Алаг өвс	10.1	11.2	8.9	8.5	7.5	46.2	9.24	0.924
Хагд	9.8	8.5	11.2	7.5	12.3	49.3	9.86	0.986
Нийт	55.4	46.5	53.9	46.1	56.6	268.5	53.7	5.37

8. Хялгана-жигж дэгнүүлт үетэнт (126 / X-II-2-5) хээрийн бүлгэмдлийн (8, 11, 12, 13 –р цэг) 100м<sup>2</sup>-д Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), зонхилж, үетнээс Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), алаг өвснөөс Марал навчит гичгэнэ (*Potentilla tanacetifolia* Willd.ex Schlecht.), Сибирь зүр өвс (*Filifolium sibiricum* (L.) Kitam.) буурцагтнаас Жижиг навчит харгана (*Caragana microphylla* (Pall) Lam.), шарилжаас Агь (*Artemisia frigida* Willd.), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai.), ургасан, нийт 6 овог, 8 төрөл, 9 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 6-8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 55.6%, түүнээс талхагдлын заагуур ургамал 23.4% эзэлж, дунд зэргийн доройтсон төрхтэй, нийт бүрхцэд хад чулуу 1.4%, хагд 10.4%, халцгай газар 32.6% байна (Зураг 46, Хүснэгт 51).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



*Зураг 45. Ургамлын бичиглэл 8.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
Хялгана-харганат бүлгэмдэл  
N 46°49'28.42"; E 116°06'43.4"; h 683;  
2024.06.08.

*Хүснэгт 48. Хялгана-жигж дэгнүүлт үетэнт ургамлан нөмрөгийн төлөв байдал*

Бэлчээрийн хэв шинж	Үзүүлэлт							Урга ц/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	
Хялгана-жигж дэгнүүлт үетэнт	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1	55	5	9	25	33	1	11	3.68
Давталт 2	51	5	9	20	38	2	9	3.64
Давталт 3	60	6	9	28	28	2	10	3.71
Давталт 4	53	6	9	21	34	1	12	3.46
Давталт 5	59	6	9	23	30	1	10	3.71
Дундаж	55.6	5-6	9	23.4	32.6	1.4	10.4	3.644

Хялгана-жигж дэгнүүлт үетэнт бүлгэмдлийн га –ийн ургац 3.644 цн, үүнээс үетэн ургамал 1.004 цн, алаг өвс 0.738 цн, улалж 0.476 цн, хадг 0.206 цн, хог ургамал 1.22 цн байна (хүснэгт 52).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

*Хүснэгт 49. Хялгана-жигж дэгнүүлт үетэнт бүлгэмдлийн ургацын бичиглэл*

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	9.2	9.5	9.8	10.5	11.2	50.2	10.04	1.004
Алаг өвс	8.5	7.5	7.6	6.8	6.5	36.9	7.38	0.738
Улалж	4.5	4.8	3.8	6.1	4.6	23.8	4.76	0.476
Хагд	2.1	1.1	3.1	2.5	1.5	10.3	2.06	0.206
харгана	12.5	13.5	12.8	11.4	10.8	61.0	12.2	1.22
Нийт	36.8	36.4	37.1	37.3	34.6	182.2	36.44	3.644

9. Үетэнт- жигж улалжит (120 / X-I-4-1) хээрийн бүлгэмдлийн (9 –р цэг) 100м<sup>2</sup>-д улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* С.А.Мей.), үетнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), буурцагнаас Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai.) ургасан, нийт 4 овог, 7 төрөл, 7 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 3-5 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 66.6%, түүнээс талхагдлын заагуур ургамал 5.0% эзэлж бага зэрэг доройтсон төрхтэй, нийт бүрхцэд хад чулуугүй, хагд 13.8%, халцгай газар 19.6% байна (Зураг 47, Хүснэгт 53).



*Зураг 46. Ургамлын бичиглэл 9.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
 Үетэнт- жигж улалжит бүлгэмдэл  
 N 46°47'48.01"; E 116°13'05.17"; h 675;  
 2024.06.21.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 50. Үетэнт- жижиг улалжит ургамлан нөмрөгийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж	Үзүүлэлт							Урга ц/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	
Үетэнт- жижиг улалжит	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1	68	5	7	4	18	0	14	3.97
Давталт 2	69	5	7	3	17	0	14	3.97
Давталт 3	65	7	7	5	22	0	13	3.91
Давталт 4	68	5	7	7	19	0	1	4.16
Давталт 5	63	6	7	6	22	0	15	3.31
Дундаж	66.6	4-5	7	5.0	19.6	0.0	13.8	3.864

Үетэнт- жижиг улалжит бүлгэмдлийн га –ийн ургац 3.864 цн, үүнээс зүр өвс 1.684 цн, үетэн ургамал 1.518 цн, алаг өвс 0.534 цн, хагд 0.128 цн, байна (хүснэгт 54).

Хүснэгт 51. Үетэнт- жижиг улалжит бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	18.2	19.5	18.5	17.5	10.5	84.2	16.84	1.684
Улалж	15.5	15.0	15.1	15.2	15.1	75.9	15.18	1.518
Буурцагтан	4.5	4.0	4.2	7.5	6.5	26.7	5.34	0.534
Хагд	1.5	1.2	1.3	1.4	1.0	6.4	1.28	0.128
Нийт	39.7	39.7	39.1	41.6	33.1	193.2	38.64	3.864

10. Хялгана-харганат (129 / X-II-2-8) хээрийн бүлгэмдлийн (10 –р цэг) 100м<sup>2</sup>-д Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Жижиг навчит харгана (*Caragana microphylla* (Pall) Lam.) зонхилж, алаг өвснөөс Марал навчит гичгэнэ (*Potentilla tanacetifolia* Willd.ex Schlecht.), Сибирь зүр өвс (*Filifolium sibiricum* (L.) Kitam.) буурцагтнаас Шар царгас (*Medicago falcata* L.), Үнэрт хошоон (*Melilotus suaveolens* Ldb.), шарилжаас Агь (*Artemisia frigida* Willd.), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai.), Өнхрүүш хамхуул (*Corispermum declinatum* Steph.) ургасан, нийт 5 овог, 8 төрөл, 8 зүйл ургамал ургасан, 1м<sup>2</sup>-д 5-8 орчим зүйл тааралдаж байв. Ургамлын тусгаг бүрхэц 60.2%, түүнээс талхагдлын заагуур ургамал 2.2% эзэлж, нийт бүрхцэд хад чулуу 9.6%, хагд 10.4%, халцгай газар 19.8% байна (Зураг 48, Хүснэгт 55).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



*Зураг 47. Ургамлын бичиглэл 10.*

Дорнод аймаг, Матад сум, Матад ХХ талбайн ургамлын мониторинг судалгаа  
Хялгана-харганат бүлгэмдэл  
N 46°49'09.01"; E 116°14'38.47": h 1072;  
2024.06.09.

*Хүснэгт 52. Хялгана-харганат ургамлан нөмрөгийн төлөв байдал*

Бэлчээрийн хэв шинж	Үзүүлэлт							Ургац/га
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	
Хялгана-харганат	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1	60	8	15	2	20	10	10	2.5
Давталт 2	61	6	15	3	21	9	9	2.5
Давталт 3	58	7	15	3	25	8	9	5.57
Давталт 4	66	5	15	2	11	11	12	2.67
Давталт 5	56	5	15	1	22	10	12	2.41
Дундаж	60.2	5-8	15	2.2	19.8	9.6	10.4	3.13

Хялгана-харганат бүлгэмдлийн га –ийн ургац 3.13 цн, үүнээс үетэн ургамал 0.966 цн, алаг өвс 0.682 цн, агь 0,442 цн, хагд 0.138 цн, харгана 0.902 цн байна (хүснэгт 56).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 53. Хялгана-харганат бүлгэмдлийн ургацын бичиглэл

Ургамлын бүлэг	Давталт					Бүгд	Дундаж	Ургац, ц/га
	1	2	3	4	5			
Үетэн	10.2	10.5	5.5	11.5	10.6	48.3	9.66	0.966
Алаг өвс, зүр өвс	7.5	8.0	4.0	7.5	7.1	34.1	6.82	0.682
Агь шарилж	5.5	5.0	0.0	6.5	5.1	22.1	4.42	0.442
Хагд	1.8	1.5	1.1	1.2	1.3	6.9	1.38	0.138
Харгана	0.0	0.0	45.1	0.0	0.0	45.1	9.02	0.902
Нийт	25.0	25.0	55.7	26.7	24.1	156.5	31.3	3.13

### 2.8.4. “Матад ХХ” талбайн ургамлын аймгийн судалгаа

Зүйлийн бүтэц бүрэлдэхүүний баялаг. Бид судалгааны талбайд нийт 12 овог, 33 төрөл, 47 зүйл бүртгэв (хүснэгт 57).

Хүснэгт 54. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайн ургамлын зүйлийн бүрдлийн бичиглэл

№	Овог, төрөл, зүйлийн шинжлэх ухааны нэр	Зүйлийн арви (Друдегийн үнэлгээгээр)	Судалгааны цэг
1	<i>Gramineae</i> Juss. -Үетэний овог		
1	<i>Achnatherum</i> P. B.		
1	<i>Achnatherum splendens</i> (Trin.) Nevski-Гялгар дэрс	Cop <sup>1</sup>	1, 6
2	<i>Stipa</i> L.		
2	<i>Stipa Krylovii</i> Roshev.-Крыловын хялгана	Cop <sup>3</sup>	1, 2, 3, 4, 5, 7, 8, 9
3	<i>Stipa grandis</i> P.Smirm.-Том хялгана	Cop <sup>3</sup>	2
4	<i>Stipa sibirica</i> Roshev.- Сибирь хялгана	Cop <sup>3</sup>	7
3	<i>Cleistogenes</i> Keng.		
5	<i>Cleistogenes squarrosa</i> (Trin.)Keng.-Дэрвээн хазаар өвс	Cop <sup>1</sup>	1, 2, 3, 9
4	<i>Koeleria</i> Pers.		
6	<i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schult.-Том цэцэгт дааган сүүл	Cop <sup>1</sup>	7
5	<i>Poa</i> L.		
7	<i>Poa pratensis</i> L.-Нугын биелэг өвс	Sol	5
8	<i>Poa botryoides</i> Trin.-Цацаглаг биелэг өвс	Cop <sup>2</sup>	7
6	<i>Puccineillia</i> Parl.		
9	<i>Puccineillia tenuiflora</i> (Griseb.) Scribn.et Merr.-Турьхан цэцэгт зурман сүүл	Cop <sup>2</sup>	5
7	<i>Agropyron</i> Gaertn.		



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

10	<i>Agropyron cristatum</i> (L.) P.B.-Саман ерхөг	Cop 1	6
8	<i>Hordeum</i> L.		
11	<i>Hordeum brevisubulatum</i> (Trin.) link.-Ахарсорт арвай	Sol	9
9	<i>Elytrigia</i> Desv.		
12	<i>Elytrigia repens</i> (L.) Desv. ex Nevski.-Мөлхөө хиаг	Cop 1	1, 2, 3, 4, 5,
10	<i>Leymus</i> Hochat.)		
13	<i>Leymus chinensis</i> (Trin.) Tzvel.- Нангиад түнгэ	Cop 1	5
2	<i>Superaceae</i> Juss. - Улалжийн овог		
11	<i>Carex</i> L.		
14	<i>Carex duriuscula</i> C.A.Меу.-Ширэг улалж	Cop 2	1, 2, 3, 4, 5,
3	<i>Iridaceae</i> Juss.-Цахилдагны овог		
12	<i>Iris</i> L.		
15	<i>Iris lactea</i> Pall.- Цагаалин цахилдаг	Sol	5
4	<i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог		
13	<i>Chenopodium</i> L.		
16	<i>Chenopodium aristatum</i> L. - Сортой лууль	Cop 2	7
17	<i>Chenopodium album</i> L-Цагаан лууль	Cop 2	2
18	<i>Chenopodium acuminatum</i> Willd.- Шоргор лууль	Cop 1	6
14	<i>Corispermum</i> L.		
19	<i>Corispermum declinatum</i> Steph.-Өнхрүүш хамхуул	Cop 2	10
15	<i>Kalidium</i> Moq.		
20	<i>Kalidium gracile</i> Fenzl.- Гоолиг шарбударгана	Cop 1	5
16	<i>Salsola</i> L.		
21	<i>Salsola collina</i> Pall.-Толгодын бударгана	Cop 1	2
5	<i>Toonoлжин цэцэгтэний овог (Cruciferae</i> Juss.)		
17	<i>Lepidium</i> L.		
22	<i>Lepidium densiflorum</i> Schrad.-Бөөн цэцэгт цангуу	Cop 1	1
18	<i>Dontostemon</i> Andrz.		
23	<i>Dontostemon integrifolius</i> (L.) C.A.Меу -Бүхэл навчит багдай	Sol	3
6	<i>Papaveraceae</i> Juss. -Намуугийн овог		
19	<i>Chiazospermum</i> Bernh.		
24	<i>Chiazospermum erectum</i> L.-Цэх галуун таваг	Sol	2
7	<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог		
20	<i>Potentilla</i> L.		
25	<i>Potentilla bifurca</i> L.-Имт гичгэнэ	Cop 1	1, 3, 5,
26	<i>Potentilla tanacetifolia</i> Willd.ex Schlecht.-Марал навчит гичгэнэ	Cop 1	10
27	<i>Potentilla multifida</i> L.- Хигмэл гичгэнэ	Sol	2
8	<i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

21	<i>Thermopsis</i> R.Br.		
28	<i>Thermopsis lanceolata</i> R.Br.-Юлдэн тарваган шийр	Sol	6
22	<i>Medicago</i> L.		
29	<i>Medicago falcata</i> L.- Шар царгас	Cop <sup>1</sup>	10
23	<i>Melilotus</i> Mill.		
30	<i>Melilotus suaveolens</i> Ldb.-Үнэрт хошоон	Sol	10
24	<i>Caragana</i> Lam.		
31	<i>Caragana pygmaea</i> (L.) DC.-Тарваган харгана	Sol	1, 2
32	<i>Caragana microphylla</i> (Pall) Lam.- Жижиг навчит харгана	Sol	4, 10
25	<i>Astragalus</i> L.		
33	<i>Astragalus galactites</i> Pall.-Цагаан хунчир	Sol	1
34	<i>Astragalus adsurgens</i> Pall.-Нумраа хунчир	Sol	6
26	<i>Glycyrrhiza</i> L.		
35	<i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.-Урал чихэр өвс	Sol	1, 2
27	<i>Lespedeza</i> Michx.		
36	<i>Lespedeza dahurica</i> (Laxm.) Schingdl.-Дагуур хошоонбут	Sol	3
9	<i>Rutaceae</i> Juss. -Сүлүүгийн овог		
28	<i>Haplophyllum</i> Juss.		
37	<i>Haplophyllum dahuricum</i> (L.) G. Don – Дагуур хүж өвс	Sol	3
10	<i>Boraginaceae</i> Juss. - Ноцоргонын овог		
29	<i>Lappula</i> Fabr.		
38	<i>Lappula intermedia</i> (Ldb.) M.Pop.- Завсрын ноцгоно	Cop <sup>1</sup>	4, 10
11	<i>Scrophulariaceae</i> Juss. -Иршимбийн овог		
30	<i>Cymbaria</i> L.		
39	<i>Cymbaria dahurica</i> L.- Дагуур хатны цэцэг	Sol	2
12	<i>Asteraceae</i> Dumort. -Гол гэсэртэний овог		
31	<i>Filifolium</i> Kitam.		
40	<i>Filifolium sibiricum</i> (L.) Kitam.- Сибирь зүр өвс	Cop <sup>2</sup>	10
32	<i>Artemisia</i> L.		
41	<i>Artemisia mongolica</i> Fisch. ex Nakai -Монгол шарилж	Sol	5, 7, 8, 10
42	<i>Artemisia frigida</i> Willd.-Агь	Cop <sup>3</sup>	6
43	<i>Artemisia Sieversiana</i> Willd.-Сиверсийн шарилж	Cop <sup>1</sup>	4
44	<i>Artemisia Adamsii</i> Bess.-Адамсын шарилж	Cop <sup>1</sup>	6
45	<i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.-Ямаан шарилж	Cop <sup>1</sup>	1, 5, 6
46	<i>Artemisia dracunculus</i> L.-Ишгэн шарилж	Cop <sup>1</sup>	9
33	<i>Taraxacum</i>		
47	<i>Taraxacum dissectum</i> (Ldb.) Ldb.- Цуулбар багваахай	Cop <sup>1</sup>	1
	12 овог, 33 төрөл, 47 зүйл		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Ургамлын ангиллын үндсэн бүлгийн бүтэц. Уг талбайд бүртгэгдсэн зүйл ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд ойм, шивэрсэн, шивлээ, нүцгэн үртэний хүрээний хүрээний зүйл ургамалгүй, далд үртэний хүрээний 47 зүйл (үүнээс нэг талтан 15 зүйл, хос талтан 32 зүйл) байна (хүснэгт 58) [10].

*Хүснэгт 55. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайн ургамлуудын ангиллын үндсэн бүлгийн бүтэц*

Ангиллын үндсэн бүлгүүдийн нэр	Овгийн тоо	Төрлийн тоо	Зүйлийн	
			тоо	эзлэх хувь (%)
Далд үртний хүрээ	12	33	47	100.0
Үүнээс:				
а. Нэг талт үрт ургамлын анги	3	12	15	31.91
б. Хос талт үрт ургамлын анги	9	21	32	68.09

Энд бүртгэгдсэн ургамлаас үетэн, буурцагтан, голгэсэртэн, лууль, сарнай, тонолжин цэцэгтэний овгууд нь төрөл, зүйлийн тоогоор эхний 6 –д жагсаж байгаа [9, 10] бөгөөд бусад овгууд ганц зүйлтэй байна. Эхний 6 овогт багтах зүйл ургамлууд судалгааны талбай орчмын бүх зүйлийн ихэнхийг буюу 87.24% -ийг бүрдүүлж байна (Хүснэгт 59).


*Хүснэгт 56. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд бүртгэсэн ургамлын ангиллын бүтэц*

№	Овог	Төрлийн тоо	Зүйлийн тоо	Эзлэх хувь, %
1	<i>Gramineae</i> Juss.-Үетэний овог	10	13	27.66
2	<i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог	7	9	19.15
3	<i>Asteraceae</i> Dumort. -Гол гэсэртэний овог	3	8	17.02
4	<i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог	4	6	12.77
5	<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог	1	3	6.38
6	<i>Тонолжин цэцэгтэний овог (Cruciferae</i> Juss.)	1	2	4.26
	Нийт зүйлийн	26	41	87.24

Ургамлын амьдралын хэлбэр. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд ургаж байгаа 47 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 10 зүйл нэг наст өвслөг ургамал (21.28%), 32 зүйл олон наст өвслөг ургамал (68.09%), 5 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (10.64%) байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

График 38. Ургамлын амьдралын хэлбэр



Ургамлын ач холбогдол ба хор холбогдол. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбай дахь бүх зүйл ургамлаас 11 овгийн 32 төрлийн 45 зүйл бэлчээрийн (95.74%), 8 овгийн 10 төрлийн 13 зүйл эмийн ашигт ургамал (27.66%), 10 овгийн 15 төрлийн 20 зүйл хөл газрын ургамал (42.55%) бүртгэгдсэн [4, 5, 10, 12] байна (хүснэгт 60).

Хүснэгт 57. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбай дахь зүйлийн бүрдлийн онцлог

Ач холбогдол ба хор холбогдол	Ангилал зүйн нэгж			Эзлэх хувь
	овог	төрөл	зүйл	
Бэлчээр тэжээлийн ургамал	11	32	45	95.74%
Эмийн ашигт ургамал	8	10	13	27.66%
Хөл газрын ургамал	10	15	20	42.55%

Бэлчээрийн ургамлаас малд онц сайн идэмжтэй Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Нангиад түнгэ (*Leymus chinensis* (Trin.) Tzvel.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.), Ахарсорт арвай (*Hordeum brevisubulatum* (Trin.) link.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Shult.), Агь (*Artemisia frigida* Willd.), Жижиг навчит харгана (*Caragana microphylla* (Pall) Lam.), Нумраа хунчир (*Astragalus adsurgens* Pall.), зэрэг ургамлууд байна .

Ургамал хамгаалал. Ургамал судлаач У.Лигаа, Ш.Дариймаа, П.Цэрэннадмид, төслийн багийн гишүүд Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Б.Бат-Энэрэл нарын хамт (2008 онд) Монгол орны нэн ховор ургамлын зурагт лавлахад 53 овог, 99 төрлийн 133 зүйл ургамал бүртгэсэн байдаг. 2009 онд У.Лигаа ахлагчтай эрдэмтэн судлаач Ш.Дариймаа, Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Х.Жамъяндорж, Б.Бат-Энэрэл нар Монгол орны ховор ургамлын зурагт

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

лавлахад 355 зүйл ховор ургамлын ангилал зүй, таних шинж, тархац, ургах орчин, үржил, нөөц хомсдох шалтгаан, хамгаалах арга хэмжээ зэргийг бичсэн байна [6, 7, 8].

Дээрх судлаачдын бүтээлийн дагуу Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбай дотор ургаж байгаа нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын бүртгэлийг гаргахад нэн ховор ургамал бүртгэгдээгүй, ховор ургамал Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), Монголын унаган ургамал Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.) 1 зүйл, Монголд байгаа завсрын унаган ургамал Жижиг навчит харгана (*Caraganamicrophylla* (Pall) Lam.), эртний цөлийн үлдэц Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) бүртгэгдсэн байгаа нь бүх ургамлын 8.52% нь хамгаалалтад авах шаардлагатай ургамалд багтаж байна (хүснэгт 61).

Хүснэгт 58. “Матад ХХ” талбай дахь зүйлийн бүрдлийн онцлог




Ургамал хамгааллын статус	Ангилал зүй			Эзлэх хувь
	Овог	Төрөл	Зүйл	
Нэн ховор ургамал	0	0	0	0.0%
Ховор ургамал	1	1	1	2.13%
Монголын унаган ургамал	1	1	1	2.13%
Монголд байгаа завсрын унаган ургамал	1	1	1	2.13%
Үлдвэр ургамал	1	1	1	2.13%
Бүгд				8.52%

Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд ургаж байгаа элбэг ургамлууд. Уг талбайд ургаж байгаа ургамлын фото зураг, ангилал зүй, статус, биологийн таних шинж, тархац, ургах орчны талаарх мэдээллийг доорх хүснэгтээр харуулав (Хүснэгт 62).

Хүснэгт 59. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайн ургамлын таних шинж

ХОВОР УРГАМАЛ	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Чихэр-өвсний төрөл (<i>Glycyrrhiza</i> L.)  Зүйл: <i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.-Урал чихэр өвс  Статус: Ховор ургамал  Биологийн онцлог: Иш эгц босоо мөчирлөг бус, 40-100 см өндөр, навчис 4-8 хос, өндгөрхүү зуувгар, цавуулаг булчирхайтай, цэцэг том, цайвар нил, богинохон цацаг үүсгэнэ, буурцаг том хавчгар, мушгирч тахийсан. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт. өвөр., Алаш., Өмнөговь дахь тархалт: Цагаан хад, Булан Сухайт, Наранбулаг, Улаан нуурын хөндий, Номгон сумын дэнгийн худаг, Ургах орчин: Чийглэг марцлаг нуга, марц, хужиртай элс, элсэрхэг хээр, нуур, голын хөндийд ургана. Ашигт чанар: Ногоон үед нь тэмээ сайн, хонь, ямаа дунд зэрэг иддэг. Эмийн гоц ашигт ургамал.</p>
МОНГОЛЫН УНАГАН (ЭНДЕМИК) УРГАМАЛ	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  <i>Astragalus galactites</i> Pall.-Цагаан Хунчир  Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал  Биологийн онцлог: Навчинцар 6-8 хос, сондгой өдөлсөн нийлмэл. Цэцэг бойтгорхуу хэлбэртэй, цагаан өнгөтэй, олон цэцэг газарт шигдэж ургасан харагддаг. Дэгнүүл үүсгэдэг олон наст өвслөг ургамал. Мал идвэл хорддог.. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд, Монг.-Алт, Дунд.Халх, Дорн.-Монг., Дунд. Халх., Говь-Алт. Алаш.</p>
<p><b>МОНГОЛД БАЙГАА ЗАВСРЫН УНАГАН (СУБЭНДЕМИК) УРГАМАЛ</b></p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Харганын төрөл (<i>Caragana</i> Lam.)  Жижиг навчит харгана (<i>Caraganamicrophylla</i> (Pall) Lam.  Биологийн онцлог: Шаравтар саарал холтостой эгц босоо найлзууруудтай 40-60 см өндөр сөөгөн ургамал. Үндэслэг ишээр үржиж сийрэгдүү сондуулархуу бут үүсгэнэ. Дагавар навчис нь моджиж доошоо нугарсан өргөс үүсгэнэ. Жижигхэн саарлавтар ногоон өнгийн зууван бөгөөд бараг нүцгэн 5-10 хос навч хан бүхий хос бус өдлөг навчнуудтай .Тархалт: Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Дунд. Халх, Дор. Монг. Ургах орчин: Элсэрхэг хээр, хээрийн хайргархаг, чулуурхаг хажуу, товцог, сэвхүүл элс, хад, нуранганд ургана.</p>
<p><b>ҮЛДЭЦ УРГАМАЛ</b></p>	
<p><i>Rutaceae</i> Juss. -Сүлүүгийн овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Rutaceae</i> Juss. -Сүлүүгийн овог  Хүж өвсний төрөл (<i>Haplophyllum</i> Juss.)  Зүйл: <i>Haplophyllum dahuricum</i> (L.) G. Don - Дагуур хүж өвс  Статус: Ховор, үлдэц ургамал  Биологийн онцлог: Доод хэсэгтээ модожсон, оло, нарийхан, саваархуу иштэй, 10-20 см өндөр ургадаг, эгц шулуун салаархаг, навчис 7-15 мм урт, нарийн зуувгар, булчирхайлаг, цэцэг шар, 5 гишүүнт, бамбай баг цэцэгт нэгдэг, хонхорцог таван мооо салбанлаг, нүцгэн.  Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг. –Даг., Хянг., Ховд., Дунд. Халх., Дорн. -Монг., Олон н., Говь –Алт. Цөлөрхөг хээрийн үйрмэг чулуут ба чулуурхаг хажуу, бэл хормой, хад асганд ургана. Ашигт чанар: Тэмээ хавраас намар хүртэл дунд зэрэг иддэг.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



Эмийн ашигт ургамал	
Rosaceae Juss. -Сарнайн овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  Rosaceae Juss. -Сарнайн овог  Гичгэнийн төрөл (<i>Potentilla</i> L.)  Зүйл: <i>Potentilla bifurca</i> L.-Имт гичгэнэ  Статус: Элбэг  Биологийн онцлог: Үндэслэг иштэй, ёзоороосоо эхлэн салаалсан 5-25 см өндөр иштэй, навчис сондгой өдлөг нийлмэл, навчинцарууд үзүүртээ им адил онтой ухагдсан байдаг, өтгөн налчгар үслэгтэй ургамал. Цэцэг тод шар. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дор. Говь., Говь –Алт., Зүүнгар. Ургах орчин: Марцлаг нуга, үйрмэг чулуурхаг хажуу, голын эргээрд ургана. Ашигт чанар: Бог мал ногоон үед нь сайн, үхэр, адуу тааруу, тэмээ дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  Rosaceae Juss. -Сарнайн овог  Гичгэнийн төрөл (<i>Potentilla</i> L.)  <i>Potentilla tanacetifolia</i> Willd.ex Schlecht.-Марал навчит Гичгэнэ  Биологийн онцлог: Салаалсан үндэстэй, 20-80 см өндөр иштэй, навчис сондгой өдөлсөн нийлмэл, налчгар ширүүн үсэрхэг. Том тод шар, хүрдэрхүү цэцэгтэй, цөөн цэцэгт баг цэцэг үүсгэдэг. Самранцар жимстэй.  Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг, Оүйä., Äóíä.Õàëö., Дорн.-Монг. Ургах орчин: Хээрийн нуга, уулын хайрга чулуутай хажуу, хээрийн сөөгөн ширэнгэн дунд ургана.</p>
Leguminosae Juss. - Буурцагтаны овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  Leguminosae Juss. - Буурцагтаны овог  Харганын төрөл (<i>Caragana</i> Lam.)  Жижиг навчит харгана (<i>Caraganamicrophylla</i> (Pall) Lam.  Биологийн онцлог: Шаравтар саарал холтостой эгц босоо найлзууруудтай 40-60 см өндөр сөөгөн ургамал. Үндэслэг ишээр үржиж сийрэгдүү сондуулархуу бут үүсгэнэ. Дагавар навчис нь моджиж доошоо нугарсан өргөсүүсгэнэ. Жижигхэн саарлавтар ногоон өнгийн зуван бөгөөд бараг нүцгэн 5-10 хос навч хан бүхий хос бус өдлөг навчнуудтай .Тархалт: Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Дунд. Халх, Дор. Монг. Ургах орчин: Элсэрхэг хээр, хээрийн хайргархаг, чулуурхаг хажуу, товцог, сэвхүүл элс, хад, нуранганд ургана.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  <i>Medicago falcata</i> L.- Шар Царгас  Үндсэн шинж: Бутаар ургадаг олон наст ургамал. Иш 40-60 см өндөр, олон нумраа, эсвэл өндиймөл. Гурвалсан нийлмэл навчтай. Навчинцар үсэрхэг, 10-20 мм урт, нарийн шаантгархуу, уртавтар, дундаас дээш юмуу орой тус газраа шүдэрхэг. 20-30 тод шар цэцгүүд нь толгойрхуу нягт багцагт нэгдэнэ. Буурцаг 7-12 мм урт, 3 мм өргөн, гонзгойвтор, ихэвчлэн хадуур лугаа адил махир, хааяа шулуун, нүцгэн, эсвэл үсэрхэг. Цэцэглэж үрлэх хугацаа: VII -VIII сар. Тархалт: Хэнт., Монг. -Даг., Дорн. -Монг., Хянг., Дунд. Халх., Олон н., Дорн. Говь. Ургах газар, орчин нөхцөл: Хээржүү нуга ба хажуу, хуурай ойн цоорхойн элсэрхэг болоод шаварлаг хөрс, эргийн хайр ба элс, тариа ногооны талбайд ургана. Эмийн ач холбогдол: Газар дээрх биеийг бөөр ба уушигны өвчинд ууна.</p>
	<p>Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Хошооны төрөл (<i>Melilotus</i> Mill.)  Зүйл: <i>Melilotus suaveolens</i> Ldb.-Үнэрт хошоон  Статус: Элбэг  Биологийн онцлог: Голлосон үндэстэй, 20-50 см өндөр ургадаг, гурвалсан нийлмэл навчтай, навчинцар гонзгойдуу тонгоруу өндгөрхүү, хоёр хажуугаараа 6-11 жижигхэн жигд бус шүдлэгтэй, шар өнгийн бойтгорхуу цэцэгтэй, цацаг баг цэцэгт нэгддэг, буурцаг өндгөрхүү, торлог, ганц үртэй. Амьдралын хэлбэр: Хоёр наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ханг., Монг. -Даг., Хянг., Монг.-Алт., Дунд Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь. –Алт., Ургах орчин: Голын эргийн марзлаг нуга, элстэй газар, элсэрхэг хээр, уулын нугат хажууд ургана. Ашигт чанар: Үхэр адуу иддэг. Тарималжуулах боломжтой.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Тарваганшийрийн төрөл (<i>Thermopsis</i> R. Br.)  Зүйл: <i>Thermopsis lanceolata</i> R.Br.-Юлдэн тарваган шийр  Статус: Элбэг ургамал.  Биологийн онцлог: Мөлхөө үндэслэг иштэй, 10-40 см өндөр ургадаг, богино налчгр сэрэвгэр үсэрхэг, гурвалсан нийлмэл гонзгой юлдэрхүү навчтай, шар өнгийн бойтгорхуу цэцэгтэй, 2-3 –аараа тойруулгаар байрладаг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. -Монг., Олон н., Дорн. говь. Ургах орчин: Хайргархаг чулуурхаг хээржүү хажуу, бэл хормойд ургана. Ашигт чанар: Газар дээрх бие, үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
<p><b>Asteraceae Dumort. -Гол гэсэртэний овог</b></p>	



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Зүр өвсний төрөл (<i>Filifolium Kitam.</i>)          Зүйл: <i>Filifolium sibiricum</i> (L.) Kitam.- Сибирь Зүр өвс          Статус: Элбэг          Биологийн онцлог: Иш 20-60 см өндөр ургадаг. Бүдүүн ташуу үндэслэг иштэй, урт бариултай хар ногоон, хошоод өдлөг цуулбар навчтай, навчны үзүүрийн салбан утсархуу. Цэцэг шар, сагснуулд нийлмэл бамбайд нэгддэг. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Дорн.-Монг. Ургах орчин: Хуурай хээр, уулын чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Бог мал, адуу, үхэр хавар зундаа дунд зэрэг иддэг.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Төрөл: Шарилж (<i>Artemisia L.</i>)          Зүйл: <i>Artemisia frigida</i> Willd.-Агь          Статус: Элбэг          Биологийн онцлог: Богино үндэслэг иштэй, өтгөн бутар ургадаг, 10-40 см өндөр цайвар саарал хуурайсаг ургамал. Навчис налчгар торгомсог цайвар үслэгээр өвс хучигдмал, өдлөөг цуулбар, сагснууд нийлж унжгардуу цацаг баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Сөөгөнцөр. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Дорн. говь. Ургах орчин: Уул толгодын чулуурхаг ба хайргархаг хажуу, бэл хормой, хадархаг газар ургана. Ашигт чанар: Аль ч улиралд мал сайн иддэг, шимт чанар өндөр ургамал. Газар дээрх бие, үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Цуулбар багваахай (<i>Taraxacum dissectum</i> (Ldb.) Ldb.)          Үндсэн шинж: Сум иштэй, 5-20 ургадаг, сум иштэй. Навч гүнзний гол судалдаа хүртэл өдлөг цуулбар юмуу өдлөг хагалбар, юлдэрхүү юмуу шугаман юлдэрхүү хэлбэртэй. Цэцэг нь шар өнгөтэй, сагс баг цэцэгтэй, ороолтын гадаад навчинцар сэртэнгүй, захаараа цэцэглэх үедээ ороолцолдсон үстэй байснаа сүүлдээ гууждаг. Цэцэглэж үрлэх хугацаа: VI –VII сар.          Тархалт: Хөвс., Ханг., Хэнт., Монг-Даг., Дорн. Монг., Ховд., Монг. Алт. Ургах орчин: Голын эргийн хайргатай газар</p>
<p><b>Бэлчээрийн ургамал</b></p>	




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p><i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог  Түнгийн төрөл (<i>Leymus</i> Hochat.)  Зүйл: <i>Elytrigia repens</i> (L.) Desv. ex Nevski.-Мөлхөө хиаг  Статус: Элбэг  Биологийн онцлог: Урт мөлхөө найлзууртай, 20-100 см өндөр ургадаг, навчис тэнэгэр хавтгай, өргөн шугамархуу, түрүүхэйн хайрс хөх ногоон, 3-7 тод судалтай, түрүү бортгорхуу, түрүүхэйнүүд жид цувраа байрлалтай. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.  Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар, Алт. –өвөр. Ургах орчин: Нугархаг хауу хээрээр ургана. Ашигт чанар: Үхэр хавар маш сайн, өвөл дунд зэрэг, адуу, бог мал, тэмээ аль ч улиралд сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог  Биелэгийн төрөл (<i>Poa</i> L.)  Зүйл: <i>Poa botryoides</i> Trin.-Цацаглаг биелэг өвс  Биологийн онцлог: Газар доор мөлхөө найлзуургүй, нягт дэгнүүл үүсгэдэг, иш 25-55 см өндөр ургадаг, 3 хүртэл цөөн үетэй, ишний 1/2-1/4 хүртэл навчтай, навч нарийн шугаман, хумираа, навчны хэлхэн 1-2 мм урт, давхар шүдлэг, залаа урт нарийн, шигүү, хүрэн ягаан туяатай ногоон, цэцгийн доод хайрс 5 бүдэг судалтай, хянга 1/2, захын судал 1/3 хүртэл богино зөөлөн үслэгтэй, каллус цөөн урт багц үстэй, амуу жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар. Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажууд ургана. Ашигт чанар: Бог мал хавар сайн, зун дунд зэрэг, адуу, үхэр зун сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог  Биелэгийн төрөл (<i>Poa</i> L.)  Зүйл: <i>Poa pratensis</i> L.-Нугын биелэг өвс  Биологийн онцлог: Газар доор мөлхөө найлзууртай, зарим нь сийрэг дэгнүүл үүсгэдэг, иш 25-90 см өндөр ургадаг, 3-4 үетэй, ишний 2/3 навчтай, навч 4 мм өргөн, шугаман, хавтгай, навчны хэлхэн 0,5-2,0 мм урт, дугуйдуу бүтэн, залаа пирамид хэлбэртэй, ногоон өнгөтэй, цэцгийн доод хайрс 5 тод судалтай, хянга 1/2, захын судал 1/3 хүртэл богино зөөлөн үслэгтэй, судал хооронд үслэггүй, каллус өтгөн орооцолдсон бөөн багц үстэй, амуу жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их.н., Говь-Алт., Зүүнгар. Ургах орчин: Голын эргийн чийглэг нугад ургана. Ашигт чанар: Тэмээнээс бусад мал өвлөөс бусад улиралд сайн иддэг.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)          Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог          Хазаар өвсний төрөл (<i>Cleistogenes</i> Keng.)          Зүйл: <i>Cleistogenes squarrosa</i> (Trin.)Keng.-Дэрвээн хазаар өвс          Статус: Элбэг          Биологийн онцлог: Элсэн дугтуй бүхий сахлаг үндэстэй, жижиг сийрэг бутуар ургадаг, иш 5-10 үетэй, 15-30 см өндөр, навч хавтгай шугаман, юлдэрхүү, ширүүн, залаа баг цэцэг нь 5-7 см, 3-10 мм өргөн, түрүүхэй 2-4 цэцэгтэй, бор ногоон өнгөтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт. Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажуу, хээр талаар ургана. Ашигт чанар: Тэмээнээс бусад мал зундаа сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)          Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)  <i>Gramineae</i> Juss. –Үетэний овог          Хялганын төрөл (<i>Stipa</i> L.)          Зүйл: <i>Stipa Krylovii</i> Roshev.-Крыловын хялгана          Статус: Элбэг          Биологийн онцлог: 30-70 см өндөр 3 үетэй иштэй, сахлаг үндэстэй, нягт бутуар ургадаг, хуурайсаг ургамал. Навчны илтэсний дотогшоо хумираа, нарийн шугаман, залаа 10-20 см урт, түрүүхэйдээ нэг цэцэгтэй, шивээний сор 10-15 см урт, хошоод нугархай, нүцгэн. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Олон н., Дорн. говь., Говь-Алт.. Ургах орчин: Чулуурхаг хууяа хээр, элсэрхэг хайргархаг хуурай хажууд ургана. Ашигт чанар: Жилийн аль чулралд тэмээнээс бусад мал сайн иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)          Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог          Дааган сүүлийн төрөл (<i>Koeleria</i> Pers.)          Зүйл: <i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schult.-Том цэцэгт дааган сүүл          Биологийн онцлог: Найлзуурын угийг хучиж буй хагдарсан навчны угларга тууш ширхэглэгээр салбарч цуурдаггүй, навчны илтэс үсэрхэг юмуу нүцгэн, залаа ногоовтор юмуу нил ягаавтар туяатай, түрүүхэй 3.5-5.5 мм урт, цэцгийн доод хайрс нүцгэн юмуу тачир үсэрхэг, тоосовч 1.5-2.3 мм урт. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Дорн.-Монг., Ховд., Монг. Алт., Хянг., Дунд. Халх., Дорн.Монг., Олон н., Говь-Алт. Ургах орчин: Уулын чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Адуу, бог мал хавар сайн, үхэр дунд зэрэг, тэмээнээс бусад мал өвөл, хавартаа муу иднэ.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Gramineae</i> Juss. -Үетний овог  Түнгийн төрөл (<i>Leymus</i> Hochat.)  Зүйл: <i>Leymus chinensis</i> (Trin.) Tzvel.- Нангиад түнгэ  Статус: Элбэг  Биологийн онцлог: Үндэслэг иштэй,сийрэг дэгнүүл үүсгэдэг, шугамархуу шулуун навчтай, 15 см хүртэл урттай түрүү баг цэцэгтэй, түрүүхэй 1-2 (3), цэцгийн доод хайрс үсгүй юмуу богино өргөсөнцөртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Олон.н., Дорн говь., Говь-Алт. Өмнөговь дахь тархалт: Ханбогд сумын бага мод. Ургах орчин: Нуга, цайдам, элс хайргатай тойромд ургана. Ашигт чанар: Бүх төрлийн мал өвөл дунд зэрэг, адуу, үхэр хавар, зун маш сайн, тэмээ, бог мал сайн иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог  Арвайн төрөл (<i>Hordeum</i> L.)  Зүйл: <i>Hordeum brevisubulatum</i> (Trin.) link.-Ахарсорт арвай  Биологийн онцлог: Богино үндэслэг иштэй, 40-80 см өндөр ургадаг, 2-3 үетэй, навчны илтэс хавтгай шулуун, түрүү 3-9 см урт, цэцгийн доод хайрсны дээд бие богино өргөсөнцөртэй, доод бие гөлгөр, үзүүртээ 3-5 мм хүртэл урт сортой. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.  Тархалт: Хөвс., Өүйд., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Говь Алт., Дорн. говь, Зүүнгар. Ургах газар, орчин нөхцөл: Голын хөндий, тойром, цайдамын хужирлаг нугад ургана. Ашигт чанар: Хавраас намар бүх төрлийн мал сайн иддэг. Тэжээлийн чанараар өндөр ургамал.</p>
<p><i>Iridaceae</i> Juss.-Цахилдагны овог</p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Iridaceae</i> Juss.-Цахилдагны овог  Цахилдагны төрөл (<i>Iris</i> L.)  Зүйл: <i>Iris lactea</i> Pall.- Цагаалин цахилдаг  Статус: Элбэг  Биологийн онцлог: 20-50 см өндөр ургадаг, нягт дэгнүүлтэй, навчис 4-8 мм өргөн, сэлмэрхүү зузаан, цэцэг хөх ягаан, хучаас навч түнтгэр биш. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Алаш. Ургах орчин: Уулын гол, булгийн марзлаг эргээр ургана. Ашигт чанар: Хатсаны дараа үхэр дунд зэрэг, бог мал, тэмээ сайн иддэг, хадаж тэжээлд хэрэглэдэг. Үндэс, цэцэг, үрийг эмэнд хэрэглэнэ.</p>
<p><i>Cyperaceae</i> Juss. - Улалжийн овог</p>	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Суперасеае Juss.</i> – Улалжийн овог овог          Улалжийн төрөл (<i>Carex L.</i>)  <i>Зүйл: Carex duriuscula C.A.Mey.</i>-Ширэг улалж          Статус: Элбэг          Биологийн онцлог: Урт нарийхан үндэслэг иштэй, өтгөн багц найлзуур үсгэдэг, түрүүнцэр нарийн, уутанцар өргөн өндгөрхүү, шадар хайрс цайвар хүрэн.          Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт, Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн.говь., Говь –Алт. Ургах орчин: Элсэрхэг газар, хээржүү хажууд ургана. Ашигт чанар: Зун, намар адуу, бог мал маш сайн, үхэр сайн, тэмээ дунд зэрэг иддэг. Хөрс хучигч ургамал.</p>
<p><b>ХӨЛ ГАЗРЫН УРГАМАЛ</b></p>	
<p><i>Asteraceae Dumort.</i> -Гол гэсэртэний овог</p>	
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i>  <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i>  <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i>  <i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i>  <i>Artemisia mongolica Fisch. ex Nakai</i> -Монгол шарилж          Үндсэн шинж: Навч гонзгойгоом өргөн өндгөрхүү хэлбэртэй, дээд тал нь нүцгэн, доод тал нь цагаан орооцолдсон үслэгтэй.          Цэцэглэж үрлэх хугацаа: VI –VII сар.          Тархалт: Хөвс., Ханг., Хэнт., Монг.-Даг., Хянг., Дорн. Монг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт. Ургах орчин: Эрэг орчмын ба уулын нуга, хээр, голын эргийн сөөгөн ширэнгэ, чулуурхаг хавцал, элсэн уурхай, сайрын хажууд, байшин, булаг, худаг, шуудуу, тариалан, орхигдсон газарт ургадаг.</p>
	<p><i>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (Angiospermae)</i>  <i>Анги: Хос талт үрт ургамлын (Dicotyledonae)</i>  <i>Овог: Голгэсэртэний (Asteraceae Dumort.)</i>  <i>Төрөл: Шарилж (Artemisia L.)</i>  <i>Зүйл: Artemisia Sieversiana Willd.</i>-Сиверсийн шарилж          Статус: Элбэг          Биологийн онцлог: Иш 20-100 см өндөр, навчис өргөн гурвалжин, анхдагч сегмент өдлөг, үзүүрийн салбанцар гонзгой өндгөрхүү, сагс 4-7 мм өргөн, сийрэг залаа үүсгээг. Амьдралын хэлбэр: Нэг наст өвлөг ургамал.          Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Дорн. говь., Говь-Алт. Ургах орчин: Чулуурхаг хажуу, хээр хөндийгөөр ургана. Ашигт чанар: Ногоон үед нь мал иддэггүй.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгээсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Төрөл: (<i>Artemisia L.</i>)  <i>Artemisia Adamsii</i> Bess.-Адамсын шарилж          Үндсэн шинж: Сийрэгдүү саарал ногоону үмхий үнэртэй ургамал Навчис 1.5-6 см урт, 0,8-3,5 см өргөн, хошоод шурвантаа өдлөг цуулбар. Илтэс нь үзүүр хэсэг рүүгээ заримдаа цөөвөр жижгэрсэн сегментүүдтэй, сагс шар том.          Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг.-Алт, Дунд.Халх, Дорн.-Монг., Олон н., Говь-Алт.          Ургах газар, орчин нөхцөл: Уулын чулуурхаг, хайргархаг хажуу, голын эрэг, хээр тал, хөндийгөөр</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгээсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Төрөл: Шарилж (<i>Artemisia L.</i>)  <i>Зүйл: Artemisia dracunculus L.</i>-Ишгэн шарилж          Статус: Элбэг          Биологийн онцлог: Үндэслэг иш модожсон, 20-150 см өндөр сүрлэн шар иштэй, навчис шугаман юлдэрхүү, шовх, суурь орчимдоо хааяа үзүүр хэсэгтээ 3 салбантай, сагс унжуу шилбэтэй, өтгөн дэрэвгэр залаа баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Алт. өвөр., Зүүнгар., Дорн. говь.          Ургах орчин: Уулын чулуурхаг хажуу, бэл, асга нураг, голын хайр, элсэнд ургана. Ашигт чанар: Тэмээ сайн, үхэр дунд, бог мал, адуу арай дутмаг иддэг. Навч, найлзуурыг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
<p><b><i>Chenopodiaceae Vent.</i> - Луулийн овог</b></p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)          Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Chenopodiaceae Vent.</i> - Луулийн овог          Хамхуулын төрөл (<i>Corispermum L.</i>)  <i>Зүйл: Corispermum declinatum Steph.</i>-Өнхрүүш хамхуул          Статус: Монголын завсрын унаган ургамал          Биологийн онцлог: Дээшээ дэрэвгэр мөчиртэй, хамхуул үүсгэдэг, навчис өргөн, нарийн тонгоруу өндгөрхүү юмуу зуувгар, үзүүрээдээ хурц, цэцгийн дагавар навчис шугаман юлдэрхүү, жимс гонзгойвтор тонгоруу өндгөрхүү, өвөр тал нь гүдгэр, дундуураа хөндлөн нугалаастай. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Монг.-Даг., Дунд. Халх., Ургах орчин: Суурин газар хог хэлбэртэй ургахаас гадна, элсэрхэг хээр, жалга гуу дагаж ургана. Ашигт чанар:Тэмээ зундаа тааруу, намар, өвөл сайн иддэг. Бог мал муу иддэг.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог  Луулийн төрөл (<i>Chenopodium</i> L.)  Зүйл: <i>Chenopodium aristatum</i> L. - Сортой лууль  Статус: Элбэг  Биологийн онцлог: 5-30 см өндөр, ёзоороосоо эхлэн салаалж бөмбөгөр бут үүсгэдэг, намар улаавтар өнгөтэй болдог, навчис юлдэрхүү, бүтэн захтай, мухар оройтой, баг цэцгийн мөчрөнцөрийн үзүүр сортой. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.  Тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх, Дорн.-Монг., Их н., Дорн. Говь., Говь Алт., Алт. Өвөр., Алаш. Ургах орчин: Чулуурхаг хайргархаг хажууд ургана.  Ашигт чанар: Ногоон байхад нь тэмээ дунд зэрэг иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог  Луулийн төрөл (<i>Chenopodium</i> L.)  Зүйл: <i>Chenopodium album</i> L-Цагаан лууль  Статус: Элбэг  Биологийн онцлог: 15-100 см өндөр, салаалсан эгц иштэй, навчис 2-6 см урт, 2-3.5 см өргөн, гурвалжин өндгөрхүү юмуу гонзгойвтор хэлбэртэй, цэцгүүд нийлж түрүүхүү баг цэцэг болж, тэдгээр нь нийлж залаа баг цэцэг үүсгэдэг, цэцгийн шадар эрхтэн өнгөрлөг хучаастай, жимс нь цэцгийн шадар эрхтэнтэйгээ цуг байх бөгөөд ерөнхийдөө эрхэрхүү байдалтай, нуруун талаасаа бөмбөгөрдүү, нөгөө тал нь хотгор, цайвар саарал өнгөтэй. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Хөвс., Ханг., Монг. –Даг., Хянг., Ховд, Монг.-Алт., Дунд. Халх, Дорн.- Монг., Говь-Алт. Ургах орчин: Суурин газар болон талхлагдсан дортойосн газар ургана. Ашигт чанар: Ногоон ба хатсан үед нь тэмээ дуртай, хонь, үхэр дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг эмэнд хэрэглэнэ.</p>
<p><b><i>Boraginaceae</i> Juss. - Ноцоргонын овог</b></p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Boraginaceae</i> Juss. - Ноцоргонын овог  Ноцгонын төрөл (<i>Lappula</i> Fabr.)  Зүйл: <i>Lappula intermedia</i> (Ldb.) M.Pop.- Завсрын ноцгоно  Статус: Элбэг  Биологийн онцлог: Зөвхөн дээд хэсэгтээ салаархаг, ширүүн урт үсэрхэг, 5-15 см өндөр ургамал. Навч гонзгой, иш, навч үсэрхэг, цэцэг цэнхэр, мушгиа баг цэцэгтэй, самранцар гурвалжин, нуруун тавцан хянгагүй, товруулаг эмжээртэй, дээрээ нарийхан өргөстэй.  Амьдралын хэлбэр: Нэг наст ургамал  Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь-Алт., Дорн. говь. Ургах орчин: Уул толгодын чулуурхаг энгэр хажуу, нуур, голын эргийн хайрганд, сайрын оёорт талд ургана. Ашигт чанар: Тэмээ зундаа дунд зэрэг иддэг.</p>

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

## 2.9 НИЙГМИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024 -Н ГҮЙЦЭТГЭЛ

Матад ХХ талбай нь 213.92 км.кв буюу өргөн уудам газар нутгийг хамарч байна. Одоогийн байдлаар Цэн тогоруу-1 цооногийг өрөмдсөн ба манаачаар тухайн нутгийн иргэн (айл) ажиллаж байна. Мониторингийн ажлын үед гэрийн эзэн, охин, ач охинтойгоо байсан хэдий ч гэрийн эзэн бүрэг зан төлөвтэй аман асуултад хариулахаас зайлсхийж охин нь асуумжид товч хариултыг өгч гэрийн эзэгтэй мэдэх ба одоогоор эзгүй эмнэлэгт хэвтэхээр төв явсан гэсэн тул санал асуулгыг хуудсыг бөглөж чадаагүй болно.

*Зураг 48. Манаач айл (Цэн тогоруу-1)*



Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээллэснээр талбай дээр нийт 10 айл (өвөлжөө, зуслан эсэх тодорхойгүй) байна. Координатыг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 60. Төслийн талбайд байх айл, өрхүүд*

№	Нэр/эзэмшигч	Уртраг	Өргөрөг
1	Гантулга	116° 3' 42.265" E	46° 49' 58.594" N
2	Ганбаатар	116° 2' 50.284" E	46° 49' 45.792" N
3	Гантулга	116° 2' 16.704" E	46° 49' 17.180" N
4	Өнөржаргал	116° 1' 57.856" E	46° 48' 58.118" N




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

5	Саранхүү	116° 1' 42.862" E	46° 48' 44.203" N
6	Жаргалсайхан	115° 56' 41.131" E	46° 45' 32.015" N
7	Энхболд	115° 56' 49.279" E	46° 45' 20.018" N
8	Буянжаргал	116° 0' 24.349" E	46° 49' 54.537" N
9	Ганбат	115° 56' 23.018" E	46° 43' 47.294" N
10	Ганзориг	116° 4' 59.909" E	46° 46' 24.911" N

Эдгээр 10 айлын байршлыг дараах зурагт гаргав.

*Зураг 49. Талбай дээр тоологдсон айл өрхүүд*



Дээрх зургийн дагуу төслийн талбай баруун хойд зэрэгцээ байршиж буй 6 айлуудын байршил дээр бүгд нүүсэн хоосон гэрийн буурь байсан ба 4 гэрийн буурь шатсан байна. 1 гэрийн буурийг тойроод 5 үхэр 1 цагаан зээр үхсэн ба тодорхой хэмжээгээр шатсан байна. Тухайн айл нүүхэд зудад муудсан үхэр босож чадахгүй буурин дээр үлдэж үхсэний дараа хээрийн түймэрт өртсөн гэж таамаглаж байна.

Зураг 50. Айлын буурь



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Дараах гэрийн буурийг тойроод 5 үхэр 1 цагаан зээр үхсэн ба тодорхой хэмжээгээр шатсан байна. Тухайн айл нүүхэд зудад муудсан үхэр босож чадахгүй буурин дээр үлдэж үхсэний дараа хээрийн түймэрт өртсөн гэж таамаглаж байна.

*Зураг 51. Гэрийн буурь дээр үхсэн мал*



Төслийн талбай дээгүүр зам дагаж үхсэн мал (үхэр, адуу) нэлээд олон таарсан ба мөн цагаан зээр нэлээн их үхсэн байна. Үүнийг тухайн жилийн цаг уур, уур амьсгалын нөхцөл байдалтайгаар цас ихээр орж идэш тэжээл хомсодсоноос буюу зудад өртсөн гэж үзэж байна.

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1

Зураг 52. Зудад өртөж үхсэн мал, амьтан



Мөнтүүнчлэн төслийн талбайн зүүн урд 4 сарын сүүл 5 сарын эхээр хэсгээр хээрийн түймэр гарсан байна.

Зураг 53. Шатсан талбай



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**



Шатсан талбайн хуучин хагд өвс шатаж, шинэ өвс ургасан байгаа тул тод ногоон өнгөөр ялгарч харагдаж байна.

Мониторингийн ажлын хээрийн судалгаанд явж байхад тоологдсон айл өрхүүдийг доорх зурагт үзүүлэв.

Зураг 54. Хээрийн судалгаанд тоологдсон айл өрхүүд



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Төслийн талбай дотор, талбайн зүүн урд хэсэгт модон байшин, малын төмөр хашаа, морины зүчээ бүхий айл байна. Тухайн айл нь цоожтой байсан санал асуулга авч чадаагүй болно.

*Зураг 55. Төслийн талбай дотор талбайн зүүн урд хэсэгт байрлах айл*



Төслийн талбай дотор компанийн агуулахын баруун хойд талд 2 монгол гэртэй айл зусаж байна. Тухайн айл нь Эзэннайрамдал гэх хүний малчин өрх байна. Малчин өрхийн гэрийн эзэн Батчөдөр, гэргий Ууганцэцэг нар нь 2 хүүхэдтэй. Ойролцоогоор 150 орчим үхэр, 200 орчим адууг маллаж байна.

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1

Зураг 56. Петро Матадын агуулахын баруун хойд талын айл



Зураг 57. Санал асуулга авч буй явц



Төслийн талбай дотор талбайн урд хэсэгт Цайдам хэмээх газрын зүүн талд дугуйтай чирдэг контейнер бүхий айл байна. Тухайн айл мөн эзгүй цоожтой байгаа ба харин түүний малчин Баяраа хэмээх хүнтэй малаа усалж буйтай таарч санал асуулга авав. Тухайн



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

айлын эзний гэрийг Өнөржаргал, эзэгтэйг Ариунаа гэх ба тэднийх 400 орчим үхэр, 10 хэдэн азарга адуутай. Өвлийн улиралд гэрээ барьж өвөлждөг<sup>3</sup>.

*Зураг 58. Контейнер бүхий айл*



Тухайн худгаас нутгийн иргэд унданд хэрэглэдэггүй зөвхөн мал усалгаанд хэрэглэдэг байна.

---

<sup>3</sup> Малчин Баяраагийн өгсөн санал асуулгаар

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

Зураг 59. Мал усалгааны худаг,  $116^{\circ} 5' 54.24'' E$   $46^{\circ} 44' 31.77'' N$



Зураг 60. Малчин иргэнээс санал асуулга авч буй байдал



### **III. НЭГДСЭН ДҮГНЭЛТ ЦААШИД ХИЙГДЭХ АЖИЛ**

Матад ХХ талбайд 2024 оны 6 сарын байдлаар хуучин Цэн тогоруу-1 цооног, манаач айл, дотоод зам, агуулах бүхий хашаа, хуучин өрмийн цооног, төслийн худаг байрлана, талбайн 90-95% хувь ургамлан бүрхэвчтэй, 5% нь бүрхэцгүй байна. Талбайд хэмжилт судалгаа хийхэд ямар нэг үйл ажиллагаа эхлээгүй байна. Талбайд үйл ажиллагаа, өрөмдлөг хийхээс өмнө байгаль орчны хяналт шинжилгээний хээрийн судалгааг газрын гадарга, дуу, чимээ, ус, хөрс, ургамал, амьтны аймаг гэсэн чиглэлүүдээр хийж гүйцэтгэж байгаа ба энэхүү тайлан нь урьдчилсан ноорог тайлан болно. Ус, хөрс, агаарын чанарын хэмжилт дээжлэлтийг хийж, холбогдох итгэмжлэгдсэн лабораториудад дээжийг шинжлүүлж байна, цаашид давтан судалгаа хийгдэх тул энэхүү тайлангийн үр дүнг нэгдсэн дүгнэлт гэж үзэхгүй.

Газрын тосны хайгуул, олборлолтын Матад ХХ талбайн хөрсний мониторингийн хүрээнд хээрийн судалгаа болон лабораторийн задлан шинжилгээ, үр дүнгийн анхдагч боловсруулалт гүйцэтгэв. Хээрийн судалгаа болон зураглалын судалгааны үр дүнд Матад ХХ газрын тосны хайгуулын талбайд газрын гадаргын хэлбэр дүрс, геологийн хурдас чулуулгийн тархалт, зүй тогтолтой уялдан хар хүрэн, хүрэн шороон, нугархаг болон мараалаг хүрэн хөрсний хэв шинжүүдийг ялган тодорхойлж, давсархаг нуур тойром болон дэрс бүхий хотгоруудад үлдмэл мараалаг болон давсархаг хөрсний хэв шинжүүдийг тус тус ялган тодорхойлов.

Матад ХХ хайгуулын талбайн хөрсний суурь судалгааны анхдагч дүнгийн боловсруулалтаас үзэхэд хөрсний урвалын орчин сул шүлтлэг болон шүлтлэг шинжтэй, карбонатын агууламж бага, ихэнх хэмжилтийн цэгүүдэд илрэхгүй бөгөөд зөвхөн мараалаг болон давсархаг хөрсний хэв шинжүүдэд илэрсэн байгаа шинжтэй бол давсны агууламж ядуулаг шинжтэй байна. Хөрсний ялзмагийн агууламж 1.5% орчим тогтмол шинжтэй боловч ургамлын үндэсний тархалтын бүсүүдэд илүү хуримтлагдсан шинжтэй байна. хөрсний үржил шимийн хөдөлгөөнт болон шингээгдсэн суурийн нийлбэр хангамжтай сайн түвшинд байх бөгөөд хөдөлгөөнт суурийн нийлбэрт калийн исэл давамгайлах бол шингээгдсэн суурийн нийлбэрт кальцийн ион давамгайлна.

Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн өргөн тархалттай хүнд металлын агууламжаас үзэхэд MNS5850:2019 стандартад заасан хүлцэх агууламжаас хэтэрсэн буюу бохирдол илрэхгүй байна.

“Матад ХХ” талбайд ургамалжлын 10 бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь хээрийн Хялгана-улалж-хазаарт (106 /X-I-2-5), Хялганат (110 /X-I-2-9), Хялгана-хиагт (105 / X-I-2-4), Хялгана-биелэгт (108/ X-I-2-7), Хялгана-жигиг дэгнүүлт үетэнт (126 / X-II-2-5), Үетэнт-жигиг улалжит (120 / X-I-4-1), Хялгана-харганат (129 / X-II-2-8), нам хотосын Улалж-дэрст (228 / H-III-5-1), Үетэн-жигиг улалж-бударганат (219/ H-III-2-3), Дэрс -өлөнгөт (222 / H-III-3-3) бүлгэмдэл байна.

Судалгааны талбайн ургамлан нөмрөгийн 100 м<sup>2</sup> талбайд 7-18 зүйл, 1м<sup>2</sup> талбайд 3 -10 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын тусгаг бүрхэц хээрээр 53.0-75.0%, дэрст нугадаа 64.4-87.4%, га –ийн ургац хээрээр 3.644-6.396 центнер, нугадаа 2.55-4.828 центнер байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

“Матад ХХ” талбай дотор 12 овог, 33 төрөл, 47 зүйл ургаж байгаагаас 45 зүйл бэлчээрийн (95.74%), 8 овгийн 10 төрлийн 13 зүйл эмийн ашигт ургамал (27.66%), 10 овгийн 15 төрлийн 20 зүйл хөл газрын ургамал (42.55%) бүртгэгдэж байгаагаас харахад хүн ба малын хөлөөр олшрогч хөл газрын ургамал нэмэгдэх хандлагатай байна.

Тус талбай дотор 10 зүйл нэг наст өвслөг ургамал (21.28%), 32 зүйл олон наст өвслөг ургамал (68.09%), 5 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (10.64%) ургаж байгаагийн дотор нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын бүртгэлийг гаргахад нэн ховор ургамал бүртгэгдээгүй, ховор ургамал Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), Монголын унаган ургамал Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.) 1 зүйл, Монголд байгаа завсрын унаган ургамал Жижиг навчит харгана (*Caraganamicrophylla* (Pall) Lam.), эртний цөлийн үлдэц Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) бүртгэгдсэн байгаа нь бүх ургамлын 8.52% нь хамгаалалтад авах шаардлагатай ургамалд багтаж байна

Төслийн БОННУ-ний нэмэлт тодотголын тайлан 2024 онд БОАЖЯ-аар батлагдсан ба 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдсан, ба газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны ажил хийгдэж Газрын харилцаа геодези зураг зүйн газраар батлагдсан, техникийн ус хангамжийн худгийн ус ашиглах дүгнэлт гаргуулсан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэлийг хөндлөнгийн байгууллагаар 2022 онд хийлгэсэн одоо дахин хийлгэж байгаа.

Хөвөө нуур усгүй, давс хужир ихтэй байгаа ба цагаан зээрийн сэг зэм их тохиолдсон, цаашид үйл ажиллагааны хүрээнд тогтоол ус, нүүдлийн амьтад ундаалах цэг байгуулах ажлыг төсөл хэрэгжүүлэх анхаарах шаардлагатай байна.

Аж ахуй нэгж нь нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй ажлын тайлан болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон бусад байгаль орчны тайлан өгөгдөл, мэдээ мэдээллийг өөрсдийн вэбсайтад байршуулан онлайн хэлбэрт оруулах.

Энэхүү урьдчилсан тайлангийн үр дүнтэй танилцан, тухайн жилийн БОМТ – ийн биелэлтийн тайланг төсөл хэрэгжүүлэгч А-618 дугаар тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” дагууд боловсруулан, хавсралтаар БОХШХ үр дүнг оруулан, орон нутагт тайлагнаж, танилцуулан, цаашид өрөмдлөгийн талбар тогтоон ажиллахад баримтлах зүйлсийг тодорхой болгон, биелүүлж ажиллах нь зүйтэй.

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

#### IV. ЛАБОРАТОРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН



"GREEN LAB" LLC  
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ



СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2024.06.10-27

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "ЭМ И СИ ЭС ЗЭТ БИ" ХХК

Холбоо барих дугаар: 98113183

Дээж авсан газар: Дорнод аймаг Матад сум "Матад" ХК

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн /MNS3310:1991/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	pH	Давс, %	ЦДЧ	CaCO <sub>3</sub> , %	Ялзмаг, %	Шингээгдсэн суурьд, мг/кг/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	24/2946	20M-S-01	0-11	8.81	0.04	0.087	2.64	0.75	12.9	9.5	0.9	1.9
2	24/2947		12-22	8.62	0.05	0.099	5.93	0.60	11.5	5.2	1.4	2.4
3	24/2848		23-с	8.13	0.04	0.083	0.00	1.50	11.1	2.9	0.8	1.8

Хөрсний механик бүрэлдэхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширээгүүд, % ширээгийн хэмжээ, мм						
				1.0-0.25	0.25-0.08	0.08-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	24/2946	20M-S-01	0-11	26.8	43.1	11.3	3.3	10.6	5.0	18.8
2	24/2947		12-22	24.1	44.2	12.4	4.0	8.4	6.8	19.3
3	24/2848		23-с	28.6	49.9	12.6	1.0	5.9	2.0	9.0

Хөрсний хүнд металл /MNS ISO 11466:2007/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	24/2946	20M-S-01	0-11	29.7	-	21.6	21.6	64.6	33.4
Шаврандэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
Элсэндэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

Жич: Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэлийн дээжэнд хамаарах ба хувиар олцуулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦАТГАЭСЭН:

Шинжээч:



/С. Мягмардаш/

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Лабораторийн эрхлэгч

Г.Ганчимэг /M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 6-р хороо, Ням Кашитал байр 10 давхар 02 тоот  
Утас/Факс : 72702020, 88950626 E-mail: landownermongolia@gmail.com

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



"GREEN LAB" LLC  
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ



СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2024.06.10-27

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "ЭМ И СИ ЭС ЗЭТ БИ" ХХК

Холбоо барих дугаар: 98113163

Дээж авсан газар: Дорнод аймаг Матад сум "Матад" ХК

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн /MNS3310:1991/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	pH	Давс, %	ЦДЧ	CaCO <sub>3</sub> , %	Ялзмаг, %	Шингээгдсэн сууриуд, мг-экв/100 гр		Шингээгдээгүй элементүүд, мг/100 гр	
									Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	24/2949	20M-S-02	0-17	7.84	0.03	0.065	0.00	1.41	15.3	1.2	1.8	3.1
2	24/2950		18-36	8.55	0.06	0.094	0.00	1.47	19.2	2.4	2.1	2.9

Хөрсний механик бүрэлдэхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	24/2949	20M-S-02	0-17	27.5	43.7	14.3	3.2	7.0	4.3	14.6
2	24/2950		18-36	26.4	42.8	12.2	3.8	10.1	4.8	18.6

Жгш: Шинжилгээний харму нь зөвхөн тухайн цэгийн дээжэнд хамаарах ба хувилан олшруулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжээч:



/С. Мянгардаш/

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Лабораторийн эрхлэгч

Г.Ганчимэг /M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5-р хороо, Нөгм Капитал байр 10 давхар 02 тоот  
Утас/Факс : 72702020, 88950626  
E-mail: landownermongolia@gmail.com

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



"GREEN LAB" LLC  
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ



СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2024.06.10-27

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "ЭМ И СИ ЭС ЗЭТ БИ" ХХК

Холбоо барих дугаар: 98113163

Дээж авсан газар: Дорнод аймаг Матад сум "Матад" ХК

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн /MNS3310:1991/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	pH	Давс, %	ЦДЧ	СаСО <sub>3</sub> , %	Ялзмаг, %	Шингээгдсэн сууринд, мг-экв/100 гр		Шингээгдсэн элементүүд, мг/100 гр	
									Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	24/2951	20M-S-03	0-17	7.91	0.02	0.039	0.00	1.50	11.4	5.6	1.9	31
2	24/2952		18-28	8.08	0.02	0.041	0.00	1.50	14.2	1.6	1.8	25

Хөрсний механик бүрэлдэхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1.0-0.25	0.25-0.08	0.08-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
1	24/2951	20M-S-03	0-17	17.9	60.6	7.8	3.1	8.1	2.5	13.7
2	24/2952		18-28	19.2	53.4	9.7	2.9	5.0	9.8	17.7

Жич: Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжэнд хамаарах ба хувилан олцуулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжээч:

У.С. Мянгардаш

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Лабораторийн эрхлэгч

Г.Ганчимэг /M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Чинэлтэд дүүрэг 6-р хороо, Нөт Капитал байр 10 давхар 02 тоот  
Утас/Факс : 72702020, 88950626 E-mail: landownermongolia@gmail.com

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



"GREEN LAB" LLC  
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ



СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2024.06.10-27

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "ЭМ И СИ ЭС ЗЭТ БИ" ХХК

Холбоо барих дугаар: 98113163

Дээж авсан газар: Дорнод аймаг Матад сум "Матад" ХК

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн / MNS3310:1991/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	рН	Давс, %	ЦДЧ	СаСО <sub>3</sub> , %	Ялзмаг, %	Шингээгдсэн сууринуд, мг-экв/100 гр		Шингээгдэлийн элементүүд, мг/100 гр	
									Са	Мg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	24/2953	20M-S-04	0-18	7.17	0.03	0.054	0.00	1.84	13.6	1.2	2.9	35
2	24/2954		19-33	7.10	0.02	0.042	0.00	2.09	16.2	7.2	2.5	34

Хөрсний механик бүрэлдэхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1.0-0.25	0.25-0.06	0.06-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	24/2953	20M-S-04	0-18	35.6	35.2	9.9	4.3	8.4	6.6	19.3
2	24/2954		19-33	53.2	14.2	4.4	5.0	17.3	5.9	28.2

Жич: Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжэнд хамаарах ба хувиран олшруулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжээч:

/С. Мягмардаш/

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Лабораторийн эрхлэгч

Г.Ганчимэг /M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Чинээлтэй дүүрэг 6-р хороо, Нөт Капитал байр 10 давхар 02 тоот  
Утас/Факс: 72702020, 88950626 E-mail: landownermongolia@gmail.com



Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



"GREEN LAB" LLC  
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ



СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2024.06.10-27  
Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "ЭМ И СИ ЭС ЗЭТ БИ" ХХК  
Холбоо барих дугаар: 98113163  
Дээж авсан газар: Дорнод аймаг Матад сум "Матад" ХК

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн / MNS3310:1991/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	pH	Давс, %	ЦДЧ	CaCO <sub>3</sub> , %	Ялзмаг, %	Шингээгдсэн суурьгууд, мг-жв/100 гр		Шим тэжээлийн элементүүд, мг/100 гр	
									Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	24/2955	20M-S-05	0-20	9.52	0.18	0.356	2.31	1.12	6.6	3.7	1.5	16
2	24/2956		21-40	9.90	0.62	1.236	3.62	1.16	13.0	2.0	1.6	18
3	24/2857		41-60	9.47	0.33	0.957	0.99	0.26	7.3	0.8	0.4	7

Хөрсний механик бүрэлдэхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	24/2955	20M-S-05	0-20	6.2	51.7	12.3	2.6	19.1	8.2	29.8
2	24/2956		21-40	20.7	37.3	10.1	3.4	21.1	7.4	31.9
3	24/2857		41-60	39.6	46.2	3.9	1.3	6.1	2.9	10.3

Хөрсний хүнд металл /MNS ISO 11466:2007/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	24/2955	20M-S-05	0-20	24.2	-	24.2	24.3	70.8	38.7
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
Элсэнд хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

Жеж Шинжилгээний харму нь зөвхөн тухайн цагийн дээжэнд хамаарах ба хувиран олшруулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжлэгч:

ХЯНАЖ БАТАЛГААЖУУДСАН:

Лабораторийн эрхлэгч

Г.Ганчимэг /M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 6-р хороо, Нөм Капитал байр 10 давхар 02 тоот  
Утас/Факс : 72702020, 88950626 E-mail: landownermongolia@gmail.com

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I



"GREEN LAB" LLC  
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ



СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Дээж ирсэн огноо: 2024.06.10-27  
Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: "ЭМ И СИ ЭС ЗЭТ БИ" ХХК  
Холбоо барих дугаар: 98113163  
Дээж авсан газар: Дорнод аймаг Матад сум "Матад" ХК

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн / MNS3310:1991/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	рН	Давс, %	ЦДЦ	СаСО <sub>3</sub> , %	Ялзмаг, %	Шингээгдсэн суурьд, мг-экв/100 гр		Шингээгдсэн элементүүд, мг/100 гр	
									Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Сайрын нэр	Янз бүрийн хангамшил , м <sup>3</sup> /с				
	1%	2%	3%	5%	10%
Бүрдийн гол	101.6	84.3	75.25	66.05	55.9

Үерийн их өнгөрөлтийг 1, 2, 3, 5, болон 10 хувийн хангамшилтай буюу 100, 50, 30, 20 болон 10 жилд тохиох утгуудаар гаргав. Энэ нь бусад хангамшилтай их өнгөрөлтийн мэдээнд үндэслэн хөвийн болон үерээс хамгаалах барилга байгууламжуудыг төлөвлөн хэрэгжүүлэхэд шаардагдах тоон утга юм.

Талбайд усны талаарх хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон биелэлтийг энэ хэсэгт авч үзэв. Матад ХХ талбай нь сав газрын ангиллаар Буйр нуур Мэнэнгийн голын ай сав газарт хамаарна. Усгүй жижиг, хужир мараа бүхий хонхор хотос газар төслийн талбай дотор нэлээд олон байна. Талбай болон ойр орчмын нутгийн хүн амын ундны усны гол эх үүсвэрт энгийн болон гүний худгуудыг түлхүү ашигладаг байна.

## 2.5.2 Усны мониторинг


Талбайд усны талаарх хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэлийг энэ хэсэгт авч үзэв. Матад ХХ талбай нь сав газрын ангиллаар Буйр нуур Мэнэнгийн голын ай сав газарт хамаарна. Усгүй жижиг, хужир мараа бүхий хонхор хотос газар төслийн талбай дотор нэлээд олон байна. Талбай болон түүний орчмын нутгийн хүн амын ундны усан хангамжид энгийн болон гүний худгуудыг түлхүү ашиглана.

Гадаргын усыг төлөөлүүлэн төслийн талбайгаас хойд талд талбайн хамгийн хойд захаас шулуунаар 4.5 км зайд орших Хөвөө нуурын усанд, газрын доорх усыг төлөөлүүлэн Петро Матад ХХК-ийн гүний худаг, Малчны худаг гэсэн 3 цэгээс усны ерөнхий химийн шинжилгээ, хүнд металлын шинжилгээ, төслийн худаг болон малчны худгийн уснаас цацраг идэвхийн шинжилгээг хийлгэсэн.

Хүснэгт 14. Дээжлэлтийн худгийн мэдээлэл

№	Уст цэгийн байршил	Нэр
1	46° 47' 58.96'' 116° 12' 59.1''	Петро матад ХХК-ийн гүний худаг
2	46° 52' 39.24'' 116° 13' 07.17''	Хөвөө нуур
3	46° 41' 48.4'' 116° 06' 56.11''	Малчны гүний худаг

Зураг 20. усны дээж авсан цэгийн байршил



### 2.5.3 Усны химийн найрлага

#### 20M-W-01

20M-W-01 буюу Петро Матад ХХК-ийн гүний худаг төслийн талбай дотор төслийн агуулахын хашааны ар талд, 46° 47' 58.96" 116° 12' 59.1" цэгт байрлах бөгөөд сул шүлтлэг орчинтой (рН 7.85-8.07), цахилгаан дамжуулах чанар болон нийт ууссан эрдэс (ЕС 4070-7160  $\mu\text{S}/\text{cm}$ , TDS 2239-4296 ppm).

Зураг 21. Петро матад ХХК-ийн худгийн уснаас дээж авалт, 46° 47' 58.96" 116° 12' 59.1"



20M-W-01 төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшиж буй худгийн усны цахилгаан дамжуулах чанар 4070  $\mu\text{S}/\text{cm}$ , нийт ууссан уусмал 2239 ppm байсан ба химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, хлор, сульфат, натри, магнийн ионууд нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарт MNS0900:2018” стандарт заасан хэмжээнээс их байна.

Хүснэгт 18. 20M-W-01 мониторингийн цэгийн усны химийн найрлага, 2024-I

Хэмжсэн үзүүлэлтүүд	1дм <sup>3</sup> -д байгаа					
	мг/л		мг-экв/л		мг-экв%	
	2024.6	2024.9	2024.6	2024.9	2024.6	2024.9
Na <sup>+</sup> + K <sup>+</sup>	789.9	1378.3	34.34	59.93	77.5	84.0
Ca <sup>2+</sup>	68.1	61.1	3.40	3.05	7.7	4.3
Mg <sup>2+</sup>	79.9	95.1	6.57	7.82	14.8	11.0
NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.1	0.5	0.01	0.03	0.0	0.0
Fe <sup>2+</sup>	0.0	0.0	0.0	0.00	0.0	0.0
Fe <sup>3+</sup>	0.0	9.0	0.0	0.48	0.0	0.7
<b>Нийт катион</b>	938.0	1544.0	44.32	71.31	100.0	100.0
Cl <sup>-</sup>	739.5	1417.5	20.83	39.93	47.0	56.0

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

<b>SO<sub>4</sub><sup>-</sup></b>	750.0	1050.0	15.63	21.88	35.3	30.7
<b>NO<sub>2</sub><sup>-</sup></b>	2.1	0.0	0.05	0.00	0.1	0.0
<b>NO<sub>3</sub><sup>-</sup></b>	26.0	0.2	0.42	0.00	0.9	0.0
<b>CO<sub>3</sub><sup>-</sup></b>	0.0	12.0	0.0	0.40	0.0	0.6
<b>HCO<sub>3</sub><sup>-</sup></b>	451.4	555.1	7.40	9.10	16.7	12.8
<b>Нийт анион</b>	1969.0	3034.8	44.32	71.31	100.0	100.0

20M-W-01 усны 6 сард авсны дээжний үр дүнгээр HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр 2681.3 мг/дм<sup>3</sup> байсан бол 9 сард 4301.3 мг/дм<sup>3</sup> болж өссөн, 6 сард анион катионуудын нийлбэр 2907.0 мг/дм<sup>3</sup> байсан бол 9 сард 4578.9 мг/дм<sup>3</sup> болж өссөн, ерөнхий хатуулаг 6 сард 9.97 мг-экв/дм<sup>3</sup> хэмжигдсэн бол 9 сард 10.87 мг/дм<sup>3</sup> болж тус тус нэмэгдсэн, усны цахилгаан дамжуулах чанар 4070-аас 7160 µS/cm, нийт ууссан уусмал 2239-4296 ppm, исэлдэх чанар 4.00-7.20 мг/дм<sup>3</sup> болж 6 сараас хойш 9 сар хүртэлх 3 сарын хугацаанд өөрчлөлтөд орсон байна. 6 болон 9 сарын дээжүүдийн физик шинж чанарын хувьд тунгалаг нь 30-20 см болж буурсан, үнэргүй, өнгөгүй байсан бол цайвар бор шар өнгөтэй, үл мэдэг тунадастайгаас бор шар тунадастай болсон байна.

**20M-W-02**

20M-W-02 буюу төслийн талбайгаас хойд талд талбайн хамгийн хойд захаас шулуунаар 4.5 км зайд орших Хөвөө нуураас 46° 52' 39.24" 116° 13' 07.17" цэгээс усны дээжийг авав. Усны дээжийг авах үед буюу 2024 оны 6-р сарын 10-д нуурын ус захаараа ширгэж нуурын доод шавар ёроол гарсан байсан ба цаашаа явж ус авах боломжгүй доошоо шигдэж байсан тул нуурын зах руу 20 м орчим орж шаварт тогтсон уснаас авсан байсан бол 2024 оны 9 сард нуур нь усаар дүүрсэн дээж авахад ямар нэгэн саад байгаагүй болно. Нуурын ус нь сул шүлтлэгээс шүлтлэг орчинтой (pH 7.93-13.00), цахилгаан дамжуулах чанар болон нийт ууссан эрдэс (EC 154200-746000 µS/cm, TDS 92520-447600 ppm) байна.

Зураг 22. Хөвөө нуураас дээж авалт, 46° 52' 39.24" 116° 13' 07.17"



Зураг 23. Хөвөө нуур



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



20M-W-02 Хөвөө нуурын усны цахилгаан дамжуулах чанар 746000  $\mu\text{s}/\text{cm}$ , нийт ууссан уусмал 447600 ррт байсан ба химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, магнийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд шорвог, маш хатуу, хүчтэй шүлтлэг орчинттой, органик болон органик бус бохирдолтой, маш их булингартай ус байна. Шинжилсэн үзүүлэлт 2024.09 сульфат, хлорын агууламж нь “Усан орчны чанарын үзүүлэлт MNS4586:1998” стандарт заасан хэмжээнээс их байна.

*Хүснэгт 19. 20M-W-02 мониторингийн цэгийн усны химийн найрлага, 2024-I*

Хэмжсэн үзүүлэлтүүд	1дм <sup>3</sup> -д байгаа					
	мг/л 1дм <sup>3</sup> -д байгаа		мг-экв/л		мг-экв%	
	2024/6	2024/9	2024/6	2024/9	2024/6	2024/9
<b>Na<sup>+</sup>+ K<sup>+</sup></b>	39505.1	33818.1	1717.61	1470.35	19.7	75.5
<b>Ca<sup>2+</sup></b>	1801.6	6976.9	89.90	348.2	1.0	17.9
<b>Mg<sup>2+</sup></b>	83052.8	1570.5	6830.00	129.2	78.5	6.6
<b>NH<sub>4</sub><sup>+</sup></b>	197628.5	0.1	5567.00	0.01	64.0	0.0
<b>Fe<sup>2+</sup></b>	150000.0	0.0	3125.00	0.00	35.9	0.0
<b>Fe<sup>3+</sup></b>	1238.0	0.0	66.49	0.00	0.8	0.0
<b>Нийт катион</b>	125.597.5	42365.6	8704.00	1947.66	100.0	100.0
<b>Cl<sup>-</sup></b>	197628.5	68.586	5567.00	1932.00	64.0	99.2
<b>SO<sub>4</sub><sup>-</sup></b>	150000.0	550	3125.00	11.46	35.9	0.6
<b>NO<sub>2</sub><sup>-</sup></b>	0.1	0.0	0.00	0.00	0.00	0.0
<b>NO<sub>3</sub><sup>-</sup></b>	0.00	0.0	0.00	0.00	0.00	0.0
<b>CO<sub>3</sub><sup>-</sup></b>	180.0	12.0	6.00	0.40	0.1	0.0
<b>HCO<sub>3</sub><sup>-</sup></b>	366.0	231.8	6.00	3.80	0.1	0.2
<b>Нийт анион</b>	348174.6	1947.66	8704.00	1947.66	100.0	100.0

20M-W-01 усны 6 сард авсны дээжний үр дүнгээр HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр 473589.1 мг/дм<sup>3</sup> байсан бол 9 сард 111629 мг/дм<sup>3</sup> болж буурсан, 6 сард анион катионуудын нийлбэр 473772.1 мг/дм<sup>3</sup> байсан бол 9 сард 111745.4 мг/дм<sup>3</sup> болж буурсан, ерөнхий хатуулаг 6 сард 6919.90 мг-экв/дм<sup>3</sup> хэмжигдсэн бол 9 сард 477.3 мг/дм<sup>3</sup> болж тус тус буурсан, усны цахилгаан дамжуулах чанар 746000-аас 154200  $\mu\text{s}/\text{cm}$ , нийт ууссан уусмал 447600-92520 ррт, исэлдэх чанар 352.00-62.72 мг/дм<sup>3</sup> болж 6 сараас хойш 9 сар хүртэлх 3 сарын хугацаанд өөрчлөлтөд орсон байна. 6 болон 9 сарын дээжүүдийн физик шинж чанарын хувьд тунгалаг нь 0-26 см болсон, үнэргүй, өнгө хар бор байсан бол

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

цайвардуу өнгөтэй, шороон тунадастайгаас тунадасгүй болсон байна. Энэхүү огцом өөрчлөлт нь 6 сард дээж авахад нуурын ус ширгэсэн лаг шаварт тогтсон уснаас дээж авсан бол 9 сард нуурын ус их, дээж авахад саадгүй байсантай холбоотой.

**20M-W-03**

20M-W-03 буюу малчны гүний худаг нь төслийн талбайгаас урагш 3 км зайд , 46° 41' 48.4'' 116° 06' 56.11'' цэгт байрлах бөгөөд сул шүлтлэг орчинтой (pH 7.90-8.38), цахилгаан дамжуулах чанар болон нийт ууссан эрдэс (EC 5548-7580  $\mu\text{S}/\text{cm}$ , TDS 3329-4548 ppm).

Зураг 24. Малчны худгийн уснаас дээж авалт, 46° 41' 48.4'' 116° 06' 56.11''



20M-W-02 төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшиж буй худгийн усны цахилгаан дамжуулах чанар 5548  $\mu\text{S}/\text{cm}$ , нийт ууссан уусмал 3329 ppm байсан ба химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд давстай, хатуувтар ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, хлор, сульфат, натри, магнийн ионууд нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарт MNS0900:2018” стандарт заасан хэмжээнээс их байна.

Хүснэгт 20. 20M-W-03 мониторингийн цэгийн усны химийн найрлага, 2024-I

Хэмжсэн үзүүлэлтүүд	1дм <sup>3</sup> -д байгаа					
	мг/л		мг-экв/л		мг-экв%	
	2024/6	2024/9	2024/6	2024/9	2024/6	2024/9
Na <sup>+</sup> K <sup>+</sup>	1179.0	1343.2	51.26	58.40	88.2	75.9
Ca <sup>2+</sup>	37.3	155.3	1.86	7.75	3.2	10.1
Mg <sup>2+</sup>	60.8	130.4	5.00	10.72	8.6	13.9
NH <sub>4</sub> <sup>+</sup>	0.1	0.15	0.01	0.01	0.0	0.0
Fe <sup>2+</sup>	0.0	0.0	0.0	0.00	0.0	0.0
Fe <sup>3+</sup>	0.0	0.75	0.0	0.04	0.0	0.1
<b>Нийт катион</b>	<b>1277.2</b>	<b>1629.7</b>	<b>58.13</b>	<b>76.92</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Cl <sup>-</sup>	976.6	1485.0	27.51	41.83	47.3	54.4
SO <sub>4</sub> <sup>-</sup>	980.0	1230.0	20.42	25.63	35.1	33.3
NO <sub>2</sub> <sup>-</sup>	0.0	0.05	0.0	0.00	0.0	0.0
NO <sub>3</sub> <sup>-</sup>	0.0	10.0	0.0	0.16	0.0	0.2







**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

<b>CO<sub>3</sub><sup>-</sup></b>	0.0	24.0	0.0	0.80	0.0	1.0
<b>HCO<sub>3</sub><sup>-</sup></b>	622.2	518.5	10.20	8.50	17.5	11.1
<b>Нийт анион</b>	2578.8	3267.5	58.13	76.92	100.0	76.92

20M-W-01 усны 6 сард авсны дээжний үр дүнгээр HCO<sub>3</sub><sup>-</sup> ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр 3544.9 мг/дм<sup>3</sup> байсан бол 9 сард 4638.0 мг/дм<sup>3</sup> болж өссөн, 6 сард анион катионуудын нийлбэр 3856.0 мг/дм<sup>3</sup> байсан бол 9 сард 4897.3 мг/дм<sup>3</sup> болж өссөн, ерөнхий хатуулаг 6 сард 6.86 мг-экв/дм<sup>3</sup> хэмжигдсэн бол 9 сард 18.47 мг/дм<sup>3</sup> болж тус тус нэмэгдсэн, усны цахилгаан дамжуулах чанар 5548-аас 7580 µs/cm, нийт ууссан уусмал 3329-4548 ррт, исэлдэх чанар 4.64-7.84 мг/дм<sup>3</sup> болж 6 сараас хойш 9 сар хүртэлх 3 сарын хугацаанд өөрчлөлтөд орсон байна. 6 болон 9 сарын дээжүүдийн физик шинж чанарын хувьд тунгалаг нь 22-25 см болсон, үнэргүй, сул шаргал өнгөтэй байсан бол цайвардуу өнгөтэй, бага зэрэг тунадастайгаас үл мэдэг тунадастай болсон байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Хүснэгт 21. Сорьцын физик үзүүлэлтүүд*

№	Сорьц авсан газрын нэр, солбицол	Фото зураг		Физик-химийн үзүүлэлтүүд	
		2024.06 сар	2024.09 сар	2024.06 сар	2024.09 сар
1	Гүний худаг 20М-W-01  N-46°47'58.96" E-116°12'59.1"			pH: 7.85 EC: 4070 $\mu\text{S}/\text{cm}$ TDS: 2239 ppm	pH: 8.07 EC: 7160 $\mu\text{S}/\text{cm}$ TDS: 4296 ppm
2	Хөвөө нуур 20М-W-02  N-40°52'39.24" E-116°13'07.17"			pH: 13.00 EC: 746000 $\mu\text{S}/\text{cm}$ TDS: 447600 ppm	pH: 7.93 EC: 154200 $\mu\text{S}/\text{cm}$ TDS: 92520 ppm
3	Малчны худаг худаг 20М-W-03  N-46°41'48.4" E-116°06'56.11"			pH: 7.90 EC: 5548 $\mu\text{S}/\text{cm}$ TDS: 3329 ppm	pH: 8.38 EC: 7580 $\mu\text{S}/\text{cm}$ TDS: 4548 ppm


## 2.5.4 Макро элементүүдийн агууламж

20M-W-01 буюу Гүний худгийн ус нь химийн бүрэлдэхүүний хувьд хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрөл, анионы харьцаа  $Cl^- > SO_4^{2-} > HCO_3^-$ , катионы харьцаа  $Na^+ + K^+ > Mg^{2+}$ , чанарын хувьд давсархаас давстай (эрдэсжилт нь 2907-4578.9 мг/л), маш хатуу (хатуулаг нь 9.97-10.87 мг-экв/л) устай байна.

20M-W-03 буюу Малчдын худгийн ус нь химийн бүрэлдэхүүний хувьд хлорын ангийн, натрийн бүлгийн, 1, 2-р төрөл, анионы харьцаа  $Cl^- > SO_4^{2-} > HCO_3^-$ , катионы харьцаа  $Na^+ + K^+ > Mg^{2+} > Ca^{2+}$ , чанарын хувьд давстай (эрдэсжилт нь 3856-4897.3 мг/л), хатуувтраас маш хатуу (хатуулаг нь 6.86-18.47 мг-экв/л) устай байна.

20M-W-02 буюу Хөвөө нуурын ус нь химийн бүрэлдэхүүний хувьд хлорын ангийн, натрийн бүлгийн, 3-р төрөл, анионы харьцаа  $Cl^- > SO_4^{2-}$ , катионы харьцаа  $Mg^{2+} > Na^+ + K^+$ ,  $Na^+ + K^+ > Ca^{2+}$ , чанарын хувьд шорвог (эрдэсжилт нь 111745.4-473772.1 мг/л), маш хатуу (хатуулаг нь 477.30-6919.90 мг-экв/л) устай байна.

График 5. Гурвалжны диаграмм 2024 оны 6 сар



### 2024 оны 6-р сард гурвалжны диаграммын үр дүн:

Зүүн гурвалжин (катион график): 20M-W-01 дээжийг баруун доод талд ойртуулсан байгаа нь кальцийн агууламж өндөртэй гэсэн үг. 20M-W-02 нь гурвалжны төв хэсэгт байрласан


**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

бөгөөд энэ нь кальци, магни, натрийн илүү тэнцвэртэй харьцааг харуулж байна. 20M-W-03 дээд хэсэг рүү чиглэж байгаа нь натри, калийн агууламж өндөр байгааг харуулж байна.

Зөв гурвалжин (анион график): 20M-W-01 дээжийг зүүн доод талд байрлуулсан нь бикарбонатын агууламж давамгайлж байгааг харуулж байна. 20M-W-02 ба 20M-W-03 гурвалжны төв рүү чиглэж байгаа нь бикарбонат ба хлорид/сульфатын харьцаа ижил байгааг харуулж байна.

Усны ерөнхий төрөл: 20M-W-01 нь зүүн доод талд байрлах бөгөөд энэ нь кальцийн бикарбонат төрлийн ус гэдгийг харуулж байна. 20M-W-02 ба 20M-W-03 нь төвийн ойролцоо харагдах боловч натри, хлоридын тал руу бага зэрэг шилжсэн. Энэ нь эдгээр усны сорьцод натри, хлорид эсвэл сульфатын агууламж өндөр байгааг харуулж байгаа нь илүү их эрдэсжилт, ууршилтад орсон усыг илтгэнэ.

График 6. Гурвалжны диаграмм 2024 оны 9 сар



**2024 оны 9-р сард гурвалжны диаграммын үр дүн:**

Катион гурвалжин (Зүүн): 20M-W-01 дээжийг баруун доод талд байгаа нь кальцийн ионы давамгайллыг харуулж байна. 20M-W-02 нь гурвалжны голд илүү байрлалтай байгаа нь кальци, магни, натри + калийн илүү тэнцвэртэй байгааг илтгэнэ. 20M-W-03 гурвалжны оройд ойрхон байгаа нь бусад хоёр катион дээр натри, кали давамгайлж байгааг харуулсан.

## Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

Анион гурвалжин (баруун): 20M-W-01 зүүн доод талд байрладаг нь бикарбонатын агууламж өндөр байгааг харуулж байна. 20M-W-02 ба 20M-W-03 дээжийг доод төв рүү ойртуулсан нь эдгээр хоёр дээж нь бас их хэмжээний бикарбонаттай боловч хлорид ба сульфатын агууламжаараа бие биеэсээ бага зэрэг ялгаатай болохыг харуулсан.

Төв хэсэг: 20M-W-01-ийн зүүн доод талд байрлах байрлал нь кальцийн бикарбонат төрлийн ус болохыг харуулж байна. 20M-W-02 ба 20M-W-03 дээжүүд нь бикарбонат ба сульфат эсвэл хлоридын хольцтой байгаа нь натрийн бикарбонат эсвэл натрийн хлорид/сульфатын төрөл рүү шилжсэн байна.

20M-W-01: Энэ усны дээжинд кальци, бикарбонат давамгайлж байгаа нь кальцийн баялаг чулуулгаар тэжээгддэг нуур, горхи зэрэг цэнгэг усны эх үүсвэрээс гаралтай байж магадгүй юм. 20M-W-02 ба 20M-W-03: Эдгээр хоёр дээж нь натрийн давамгайлал, сульфат эсвэл хлоридын агууламж руу шилжиж байгааг харуулж байна. Энэ нь давсжилт ихэссэн эсвэл илүү эрдэсэжсэн эх үүсвэрийн нөлөөг илтгэж магадгүй бөгөөд энэ нь гүний ус, ууршилт, антропоген нөлөөг илтгэнэ.

### 2.5.3 Усанд агуулагдах микро элементүүдийн агууламж

Микро элементүүдийн агууламжийг дээрх 3 цэг болох “Петро Матад” ХХК-ны гүний худаг, малчны худаг, Хөвөө нуураас цуглуулсан сорьцод хийж гүйцэтгэлээ. Усны сорьцод 2024 оны 6-р сард “SGS” лабораторид 53 үзүүлэлтүүдийг тодорхойлсон бол 2024 оны 9-р сард “Хан Лаб” лабораторид 2 сорьцод 6 үзүүлэлтүүдийг тодорхойлсон. 2024 оны 6-р сард худгийн усанд нийт тодорхойлсон үзүүлэлтүүдээс Al, Ba, Cr, Cu, Fe, Ti, V, Zn, Be, Ag, In, Sn, Sb, Te, Ce, Pr, Nd, Sm, Eu, Gd, Tb, Dy, Ho, Er, Tm, Yb, Lu, Hg, Pb, Bi зэрэг элементүүд нь мэдрэх хязгаараас бага буюу үл мэдэг илэрсэн байна. Харин Sc, Co, Ni, Ga, Rb, Y, Zr, Nb, Cd, Cs, La, Hf, Ta, W, Tl, Th зэрэг элементүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартад зааснаас бага зарим үзүүлэлтүүд нь стандартад заагаагүй боловч агууламж нь бага илэрсэн байв. Иймээс харьцангуй өндөр илрэлтэй болон стандартад заасан утгаас их үзүүлэлтүүд болох P, Sr, Mo, As, Se, U агууламжуудыг тодотгон авч үзэв.

Микро элементийн агууламж (мкг/л)

Үзүүлэлтүүд мкг/л	As (Хүнцэл)	Sr (Стронци)	P (Фосфор)	Se (Селен)	Mo (Анзан)	U (Уран)	
MNS 0900:2018	10	2000	1142	40	70	30	
20M-W-01	2024.06	11	1875	145	71.5	16	97.3
	2024.09	<0.01					
20M-W-03	2024.06	10.5	1164	128	17.6	30.4	64
	2024.09	<0.01					

Төслийн талбайн гүний худагт агуулагдах уран, хүнцэл, селены агууламж нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартад зааснаас 3.24, 1.1, 1.8 дахин тус тус их тодорхойлогдсон байна. Харин малчны худгийн хувьд хүнцэл болон ураны агууламж нь мөн адил дээрх стандартад зааснаас 1.05, 2.13 дахин харгалзан их байв.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Хөвөө нуурын усанд мөн адил микро элементийн 53 үзүүлэлт тодорхойлсон. Үүнд: Al, Ba, Cr, Cu, Fe, Mn, P, Sr, Ti, V, Zn, Be, Sc, Co, Ni, Ga, Mo, As, Se, Rb, Y, Zr, Nb, Ag, Cd, In, Sn, Sb, Te, Cs, La, Ce, Pr, Nd, Sm, Eu, Gd, Tb, Dy, Ho, Er, Tm, Yb, Lu, Hf, Ta, W, Hg, Tl, Pb, Bi, Th, U. Эдгээрээс хөнгөн цагаан Al-6995 мкг/л, нийт фосфор P- 2883 мкг/л, нийт төмөр Fe-1238 мкг/л, стронци Sr-7442 мкг/л, титан Ti-152 мкг/л, селен Se-1690 мкг/л, рубиди Rb-86.5 мкг/л, уран U-1300 мкг/л илэрсэн нь гадаргын усны стандартад заагаагүй боловч маш өндөр агууламжтай байна

Нуурын усны микро элементийн агууламж мкг/л

Үзүүлэлтүүд мкг/л		Mn (Манган)	Zn (Цайр)	Co (Кобальт)	Ni (Диц)	Mo (Анзан)	As (Хүнцэл)	Cd (Зөөлөн цагаан)	Pb (Хар тугалга)
MNS 4586:1998		100	10	10	10	250	10	5	10
20M-W-02	2024.06	<b>612</b>	<b>11</b>	<b>183</b>	<b>186</b>	110	<b>415</b>	0.22	<b>19.1</b>

Дээрх үзүүлэлтүүдийг “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:4998” стандарттай харьцуулахад манганы агууламж 6.12 дахин, цайрын агууламж 1.1 дахин, кобальтын агууламж 18.3 дахин, хүнцлийн агууламж 41.5 дахин, хар тугалганы агууламж 1.9 дахин тус тус их дүн гарсан байна.

Гүний худаг болон гар худгийн гүний усан дахь уран, хүнцэл, селенийн түвшин нэмэгдэх нь геологийн болон хүний хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалдаг.

Геологийн тогтцоос шалтгаалах : Усан дахь ураны агууламж нэмэгдэхэд тодорхой чулуулгийн тогтоц, ялангуяа боржин чулуу, занар зэрэг байгальд оршдог чулуулгууд нөлөөлөх ба ялангуяа ашигт малтмалын орд газруудад цаг хугацааны явцад гүний усанд ууссанаар нөлөөлдөг. Хүнцлийн хувьд ихэнхдээ тунамал чулуулаг, галт уулын чулуулаг, хүнцэл агуулсан эрдэс бодис агуулсан хөрсөнд байдаг. Эдгээр чулуулгийн өгөршил, элэгдэл нь хүнцлийг агууламжийг гүний усанд нэмэгдүүлэх боломжтой. Селен нь хүнцэлтэй адил чулуулаг, хөрсөнд үүсэж, өгөршлийн болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас гүний усанд уусдаг. Ашигт малтмалаар баялаг уст үеүд дэх газрын доорх усны хөдөлгөөн нь уран, хүнцэл, селен зэрэг микро элементүүдийг уусгаж, зөөвөрлөж боломжтой байдаг ба гүний худгууд нь ихэвчлэн ашигт малтмал агуулсан чулуулагтай харилцан үйлчлэлтэй уст давхаргад оршдог.

Хүний үйл ажиллагаанаас шалтгаалах: Хөдөө аж ахуйн үйл ажиллагааны улмаас бордоо, пестицид, амьтны хог хаягдлыг ашиглах нь урсац эсвэл уусгах замаар хүнцэл эсвэл ураныг гүний усанд оруулах боломжтой байдаг. Уул уурхай, аж үйлдвэрийн үйл ажиллагааны хувьд тухайн бүс нутагт олборлолт явуулж байгаа тохиолдолд геологийн тогтцыг алдагдуулж, эдгээр элементүүдийн гүний усанд ялгарах хэмжээг нэмэгдүүлдэг.

**Гүний ус дахь эдгээр элементүүдийн агууламжийг бууруулах аргууд**

Ион солилцоо: Ураны ионыг натри гэх мэт илүү хоргүй ионуудтай солилцох замаар ундны уснаас ураныг үр дүнтэй арилгаж болно.



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Урвуу осмос (RO): Уран, хүнцэл, селенийг молекулын түвшинд шүүж тодорхой хэсгийг зайлуулдаг өргөн хэрэглэгддэг арга юм.

Шингээх арга: Идэвхжүүлсэн хөнгөн цагааны исэл эсвэл мөхлөгт төмрийн исэл шүүлтүүр нь хүнцлийг зайлуулахад тустай байдаг.

Мөн өндөр агууламжтай усыг бага бохирдсон эх үүсвэртэй холих нь эдгээр элементүүдийн нийт түвшинг бууруулж болох ч аюулгүй байдлыг хангахын тулд үүнийг сайтар хянаж байх ёстой. Хэрэв уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь бохирдлыг үүсгэж байгаа бол урсац болон хог хаягдлыг арилгах шаардлагатай. Харин хөдөө аж ахуйн үйл ажиллагааны улмаас бохирдож байгаа бол химийн хорт бодис, бордооны хэрэглээг багасгах хэрэгтэй. Цаашид эдгээр элементүүдийн агууламжийг тогтмол хянаж, шинжилгээнд хамруулах нь зүйтэй.

#### 2.5.4. Усны цацрагийн дэвсгэр түвшин

Төслийн талбайг төлөөлүүлэн Петро Матад ХХК-ийн гүний худаг болон малчны худгаас 2024 оны 6 болон 9 сард усны дээжийг авав. Усны дээж авсан цэгүүдийн байрлалыг 18-р хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 22. Цацрагийн дээж авсан уст цэгийн байршил*

Дээжний дугаар	Дээжний нэр	Уртраг	Өргөрөг	ДТД өндөр, м	Тайлбар
20M-W-01	Петро матад ХХК-ийн гүний худаг	116° 12' 59.1"	46° 47' 58.96"	674	Мотороор усаа шахдаг гүний худаг
20M-W-03	Малчны гүний худаг	116° 06' 56.11"	46° 41' 48.4"	709	Мотороор усаа шахдаг гүний худаг

Ураны байгалийн цацраг идэвхт бүлд үүсэх радоны задралын богино наст бүтээгдэхүүнүүд <sup>214</sup>Pb, <sup>214</sup>Bi-ээс гарах гамма квантуудыг хагас дамжуулагч детектороор бүртгэж, анализаторын спектрийн хамгийн их эрчимтэй гамма шугамуудыг 351.9кэВ, 609.3кэВ-ийн бүрэн шингээлтийн пикийн талбай буюу импульсийн тоогоор задралын богино наст бүтээгдэхүүнүүдтэйгээ цацраг идэвхийн тэнцвэрт орших радоны эзлэхүүнт идэвхийг тодорхойлно. Усны дээжүүдэд радоны эзлэхүүнт идэвхийг дараах томъёогоор тооцоолов.

$$A = \frac{S(E_i) - S_{\phi}(E_i)}{K \cdot \varepsilon_0(E) \cdot k_{\gamma} \cdot V \cdot t_{xэм}}$$

Үүнд: A – эзлэхүүнт идэвх, Бк/л

S(E<sub>i</sub>) – бүрэн шингээлтийн пикийн талбай (анализаторын заалтаар авна), импульс

S<sub>φ</sub>(E<sub>i</sub>) – тухайн нөхцөл дэх гамма спектрометрийн фон

V – усны эзэлхүүн (л)

K=e<sup>-λt</sup>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

$\lambda - 2.098 \cdot 10^{-6} \text{ c}^{-1}$  – радоны задралын тогтмол

$t$  – дээж авснаас хэмжих хүртэлх хүлээсэн хугацаа

$\epsilon_0(E_i)$  – усны хувьд детекторын үнэмлэхүй бүртгэх чадвар

$t_{\text{хэм}}$  – хэмжих хугацаа, се

$k_{\gamma}$  – цацраг идэвхт изотопын  $E_i$  энергитэй гамма квантын гаралт

Энэ хэмжилтэд өндөр ялгах чадвартай цэвэр хагас дамжуулагч германи детектор бүхий 4096 сувагтай анализатор бүхий гамма спектрометр ашиглан MNS 5632:2006 (Усан дахь радоны хэмжээг тодорхойлох гамма спектрометрийн арга ) стандартын дагуу тооцоог хийж гүйцэтгэв. Усны дээжийг 1 литр эзлэхүүнтэй дээжийг детекторт углаж ордог цилиндр маринелл саванд хийж, түүнээс гарах гамма цацрагийг 3600 секунд хэмжиж тодорхойлсон үр дүнг 9-т харуулав.

*Хүснэгт 23. Усны дээжийн цацраг идэвхийн судалгааны дүн*

Д/д	Дээжний нэр	Изотопын эзлэхүүний идэвх Бк/л									
		<sup>214</sup> Pb		<sup>214</sup> Bi		<sup>222</sup> Rn		<sup>226</sup> Ra		<sup>238</sup> U	
		6 сар	9 сар	6 сар	9 сар	6 сар	9 сар	6 сар	9 сар	6 сар	9 сар
1	20M-W-01	4	6	10	13	7	10	<0.6	<0.6	<0.6	<0.6
2	20M-W-03	47	11	57	12	52	11	<0.6	<0.6	<0.6	<0.6
Илрүүлэх доод хязгаар (1л эзлэхүүнтэй 1 цаг хэмжих үед)		1.3		1.5		1.4		0.6		0.6	
Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ (MNS0900:2018)		-		-		100		-		-	

Худгийн усны дээжүүдэд агуулагдах <sup>226</sup>Ra, <sup>238</sup>U-ийн хувийн идэвхийн хэмжээ гамма спектрометрийн эдгээр изотопуудыг илрүүлэх хязгаар 0,6 Бк/л-ээс бага байна. Худгийн усны дээж дахь <sup>222</sup>Rn-ын эзлэхүүнт идэвх харгалзан 6 сард 20M-W-01 нь 7 Бк/л, 20M-W-01 нь 52 Бк/л байсан бол 9 сард 20M-W-03 нь 10 Бк/л, 20M-W-03 нь 11 Бк/л байгаа нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага”, түүнд тавих хяналт (MNS 900:2018) улсын стандартын зөвшөөрөгдөх хэмжээ (100 Бк/л)-ээс бага байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Хүснэгт 24. Усны хяналт шинжилгээний үр дүн*

Утга	Агаар мандлын хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1 /2024.06.08/	Агаар мандлын хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-2 /2024.09.08/
<p><u>БОХШХ-Г-2</u> <u>Усан орчин</u></p>	<p>Зүүн гурвалжин (катион график): 20M-W-01 дээжийг баруун доод талд ойртуулсан байгаа нь кальцийн агууламж өндөртэй гэсэн үг. 20M-W-02 нь гурвалжны төв хэсэгт байрласан бөгөөд энэ нь кальци, магни, натрийн илүү тэнцвэртэй харьцааг харуулж байна. 20M-W-03 дээд хэсэг рүү чиглэж байгаа нь натри, калийн агууламж өндөр байгааг харуулж байна.</p> <p>Зөв гурвалжин (анион график): 20M-W-01 дээжийг зүүн доод талд байрлуулсан нь бикарбонатын агууламж давамгайлж байгааг харуулж байна. 20M-W-02 ба 20M-W-03 гурвалжны төв рүү чиглэж байгаа нь бикарбонат ба хлорид/сульфатын харьцаа ижил байгааг харуулж байна.</p> <p>Усны ерөнхий төрөл: 20M-W-01 нь зүүн доод талд байрлах бөгөөд энэ нь кальцийн бикарбонат төрлийн ус гэдгийг харуулж байна. 20M-W-02 ба 20M-W-03 нь төвийн ойролцоо харагдах боловч натри, хлоридын тал руу бага зэрэг шилжсэн. Энэ нь эдгээр усны сорьцод натри, хлорид эсвэл сульфатын агууламж өндөр байгааг харуулж байгаа нь илүү их эрдэсжилт, ууршилтад орсон усыг илтгэнэ.</p> <p>Худгийн усны дээжид тодорхойлсон нийт элементүүдийн ихэнх нь дээрх усны дээжид илэрсэн бөгөөд зарим нэг нийтлэг элементүүд хэмжилт хийсэн багажийн илрүүлэх хязгаараас бага гарсан байна (Fe, Al, Ba, Cu, Cr, Ti, V, Be, Ag, In, Sn, Sb, Te, La, Ce, Sm, Tb, Ho, Tm, Lu, Hg, Pb, Bi).</p> <p>Тухайн усны дээжид агуулагдаж буй микро элементүүдийн агуулгыг Хүрээлэн байгаа орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартад заасантай харьцуулахад Mg, Mn, Na, Mo, As, Se, U-ийн агуулга өндөр байна.</p> <p>Хөвөө нуурын уснаас авсан усны дээжид агуулагдаж буй микро элементүүдийн агуулгыг MNS4586:1998 стандартад заасантай харьцуулахад P, Mn, Se, Rb, Co, Ni-ийн агуулга өндөр байна. Үүнээс гадна Al, Mg, Na, Sr элементүүдийн агууламж маш өндөр байгаа нь дээжийг авах үед нуурын ус ширгэсэн байсан тул нуурын лаг шавар дээр мал, амьтны хөлд тогтож, шүүрч гарч ирсэн уснаас авсантай холбоотой байна</p>	<p>Катион гурвалжин (Зүүн): 20M-W-01 дээжийг баруун доод талд байгаа нь кальцийн ионы давамгайллыг харуулж байна. 20M-W-02 нь гурвалжны голд илүү байрлалтай байгаа нь кальци, магни, натри + калийн илүү тэнцвэртэй байгааг илтгэнэ. 20M-W-03 гурвалжны оройд ойрхон байгаа нь бусад хоёр катион дээр натри, кали давамгайлж байгааг харуулсан.</p> <p>Анион гурвалжин (баруун): 20M-W-01 зүүн доод талд байрладаг нь бикарбонатын агууламж өндөр байгааг харуулж байна. 20M-W-02 ба 20M-W-03 дээжийг доод төв рүү ойртуулсан нь эдгээр хоёр дээж нь бас их хэмжээний бикарбонаттай боловч хлорид ба сульфатын агууламжаараа бие биеэсээ бага зэрэг ялгаатай болохыг харуулсан.</p> <p>Төв хэсэг: 20M-W-01-ийн зүүн доод талд байрлах байрлал нь кальцийн бикарбонат төрлийн ус болохыг харуулж байна. 20M-W-02 ба 20M-W-03 дээжүүд нь бикарбонат ба сульфат эсвэл хлоридын хольцтой байгаа нь натрийн бикарбонат эсвэл натрийн хлорид/сульфатын төрөл рүү шилжсэн байна.</p> <p>20M-W-01: Энэ усны дээжинд кальци, бикарбонат давамгайлж байгаа нь кальцийн баялаг чулуулгаар тэжээгддэг нуур, горхи зэрэг цэнгэг усны эх үүсвэрээс гаралтай байж магадгүй юм. 20M-W-02 ба 20M-W-03: Эдгээр хоёр дээж нь натрийн давамгайлал, сульфат эсвэл хлоридын агууламж руу шилжиж байгааг харуулж байна. Энэ нь давсжилт ихэссэн эсвэл илүү эрдэсэжсэн эх үүсвэрийн нөлөөг илтгэж магадгүй бөгөөд энэ нь гүний ус, ууршилт, антропоген нөлөөг илтгэнэ.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

<p><u>Зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ</u></p>	<p>Гүний худаг болон гар худгийн гүний усан дахь уран, хүнцэл, селенийн түвшин нэмэгдэх нь геологийн болон хүний хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалдаг.</p> <p>Геологийн тогтцоос шалтгаалах : Усан дахь ураны агууламж нэмэгдэхэд тодорхой чулуулгийн тогтоц, ялангуяа боржин чулуу, занар зэрэг байгальд оршдог чулуулгууд нөлөөлөх ба ялангуяа ашигт малтмалын орд газруудад цаг хугацааны явцад гүний усанд ууссанаар нөлөөлдөг. Хүнцлийн хувьд ихэнхдээ тунамал чулуулаг, галт уулын чулуулаг, хүнцэл агуулсан эрдэс бодис агуулсан хөрсөнд байдаг. Эдгээр чулуулгийн өгөршил, элэгдэл нь хүнцлийг агууламжийг гүний усанд нэмэгдүүлэх боломжтой. Селен нь хүнцэлтэй адил чулуулаг, хөрсөнд үүсэж, өгөршлийн болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас гүний усанд уусдаг. Ашигт малтмалаар баялаг уст үеүд дэх газрын доорх усны хөдөлгөөн нь уран, хүнцэл, селен зэрэг микро элементүүдийг уусгаж, зөөвөрлөж боломжтой байдаг ба гүний худгууд нь ихэвчлэн ашигт малтмал агуулсан чулуулагтай харилцан үйлчлэлтэй уст давхаргад оршдог.</p> <p>Хүний үйл ажиллагаанаас шалтгаалах: Хөдөө аж ахуйн үйл ажиллагааны улмаас бордоо, пестицид, амьтны хог хаягдлыг ашиглах нь урсац эсвэл уусгах замаар хүнцэл эсвэл ураныг гүний усанд оруулах боломжтой байдаг. Уул уурхай, аж үйлдвэрийн үйл ажиллагааны хувьд тухайн бүс нутагт олборлолт явуулж байгаа тохиолдолд геологийн тогтцыг алдагдуулж, эдгээр элементүүдийн гүний усанд ялгарах хэмжээг нэмэгдүүлдэг.</p> <p>Гүний ус дахь эдгээр элементүүдийн агууламжийг бууруулах аргууд</p> <p>Ион солилцоо: Ураны ионыг натри гэх мэт илүү хоргүй ионуудтай солилцох замаар ундны уснаас ураныг үр дүнтэй арилгаж болно.</p> <p>Урвуу осмос (RO): Уран, хүнцэл, селенийг молекулын түвшинд шүүж тодорхой хэсгийг зайлуулдаг өргөн хэрэглэгддэг арга юм.</p> <p>Шингээх арга: Идэвхжүүлсэн хөнгөн цагааны исэл эсвэл мөхлөгт төмрийн исэл шүүлтүүр нь хүнцлийг зайлуулахад тустай байдаг.</p> <p>Мөн өндөр агууламжтай усыг бага бохирдсон эх үүсвэртэй холих нь эдгээр элементүүдийн нийт түвшинг бууруулж болох ч аюулгүй байдлыг хангахын тулд үүнийг сайтар хянаж байх ёстой. Хэрэв уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь бохирдлыг үүсгэж байгаа бол урсац болон хог хаягдлыг арилгах шаардлагатай. Харин хөдөө аж ахуйн үйл ажиллагааны улмаас бохирдож байгаа бол химийн хорт бодис, бордооны хэрэглээг багасгах хэрэгтэй. Цаашид эдгээр элементүүдийн агууламжийг тогтмол хянаж, шинжилгээнд хамруулах нь зүйтэй.</p> <p>Усны тухай хуулийн 6-р зүйл, 6.2.3-д заасны дагуу аж ахуй нэгж байгууллагын усны дотоод хяналтын цэгийг байгуулах</p>
---	---

## **2.6 ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024-Н ГҮЙЦЭТГЭЛ**

### **2.6.1 Хөрсний төлөв байдал**


Матад ХХ талбай нь ухаа гүвээт тал болон хужир мараа бүхий хотос хонхруудыг багтаасан 213.92 км<sup>2</sup> талбай эзлэн байршина. Цаашид газрын тосны олборлолтын үйл ажиллагаа, ажилчдын сууц болон хаягдлын сан, өрмийн зумп зэргийг байгуулах зэргээс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх, хайгуулын талбайн хөрсөн бүрхэвчийн шинж чанар, зонхилох хэв шинжийн хөрсний тархалтыг илрүүлэх зорилгоор хөрсөн бүрхэвчийн суурь судалгааг мониторингийн хамтад нь гүйцэтгэв.

Дорнод аймгийн Матад сумд байрлах “Петро Матад” ХХК-ийн Матад ХХ талбай нь байгалийн мужлалаар Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их мужийн , Монголын дорнод хэсгийн давхаргат болон суурьт өндөрлөг тал, тэгшдүү хотгор, сул сэргэж хэлбэршсэн үлдмэл-цулдам уулс бүхий хотгор гүдгэрийн хэв шинж бүхий Тамсагийн давхаргат өндөрлөг тал, тэгшдүү хотгор бүхий хуурай хээрийн дэд мужид багтана. Матад ХХ-р талбайн гадарга нь Монгол орны хувьд Дорнодын нам дор бүхий газар бөгөөд гадаргын үнэмлэхүй өндөр нь 600-800 м хооронд хэлбэлзэх тэгш тал бүхий талбайд байрлана.

#### **Зорилго:**

Газар ашиглалтын төлөв байдал болон хөрсний мониторингийн судалгаа нь гол зорилго нь төсөл хэрэгжиж буй талбайн хөрсөн бүрхэвчийн зонхилох хэв шинжийг илрүүлэх, хөрсний морфологи бүтэц, хими, физик шинж чанарыг нарийвчлан тодорхойлон, төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг илрүүлэх, түүний нөлөөллийг сааруулах, бууруулах арга ажиллагаа, технологийг төлөвлөх зорилготой.

Зураг 25. Талбайн өндөржилтийн зураг



## Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

Дорнод аймгийн Матад сумын нутаг нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар хотгорын бүсчлэлийн Хангайн их мужийн Монголын дорнод мужийн Мэнэн-Матадын 19-р тойрогт хамрагдана (Үндэсний атлас, 2009). Тус тойрогт үлдмэл шинжтэй нам уул болон ухаа толгодоор сайр чулуурхаг шинжтэй нимгэн ялзмагт давхарга бүхий хар хүрэн хөрс, үлдмэл зоо болон тэгш талархаг нутгаар хүрэн шороон хөрс, үерийн ус хуримтлагддаг хотос, хонхор болон ухаа толгодын дунд үүссэн дэрс бүхий хотгор, жалга судгаар нугархаг болон мараалаг хөрсний хэв шинж давсархаг хөрсний хэв шинж зонхилон тархана.

Матад ХХ талбай нь Далайн нуруу 699м орчим үлдмэл шинжтэй зоо, Овоот уул 720м, Давст уул 730м орчим нам уулс, ухаа толгод болон түүний хажуугаар урсах Бүрдний голын давсархаг хөрс, Улаан хонхор, хөвөө нуур орчмын давст ширгэдэг нуур бүхий хотгоруудын орчимд байрлана. Иймд өндөрлөг тэгш талархаг газруудаар хар хүрэн болон хүрэн шороон хөрсний хэв шинж зонхилох бол нам дор хотос газруудаар давсархаг болон үлдмэл нугархаг хөрсний хэв шинжүүд тархана.

Судалгааны талбайд зонхилон тархсан хүрэн шороон хөрс нь 30-40 см хүртэл зузаан хүрэн өнгийн ялзмаг хуримтлалын давхаргатай, саармаг болон сул шүлтлэг урвалын орчинтой, ихэнх тохиолдолд карбонатгүй, чулуугүй зөвхөн нунтаг шороон хэсгээс бүрддэг нь энэ нутгийн хөрсний үндсэн гол онцлог шинжийг илэрхийлдэг.

### 2.6.2. Судалгааны аргазүй

Хөрсний хээрийн судалгаа 2024 оны 6-р болон 9-р сард урьдчилан төлөвлөсөн маршрутын дагуу Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах “Петро Матад” ХХК-ийн Матад ХХ-р талбайд ажиллан, төслийн талбайн хөрсний чанарын хэмжилтийг 12 цэгт хийж хөрсний морфологи бичиглэлийг хээрийн нөхцөлд тодорхойлж, лабораторийн задлан шинжилгээнд зориулан 25 ш хөрсний дээж авлаа.

Лабораторийн задлан шинжилгээ: Хөрсний хими, физик шинж чанарын үзүүлэлтийг “Ланд Овнер” ХХК-ийн магадлан итгэмжлэгдсэн хөрс судлалын “Green Lab” лабораторид тодорхойлуулсан. Хүнд элемент, цацраг идэвхит изотопын шинжилгээг МУИС-ийн Цөмийн физикийн судалгааны төвд, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээг Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчин, хэмжилтзүйн төв лабораторид тус тус тодорхойуулав.

#### Хүснэгт 25. Хөрсний лабораторийн задлан шинжилгээний аргууд

Но.	Хөрсний үзүүлэлтүүд	Задлан шинжилгээний арга
1	Ялзмаг	Тюрин
2	Урвалын орчин	Потенциометрийн (H <sub>2</sub> O, 1 : 2.5)
3	Карбонат	Эзэлхүүний
5	Хөдөлгөөнт фосфор	Мачигин
6	Хөдөлгөөнт кали	Дөлт фотометр
7	Цахилгаан дамжуулах чанар	Иономер
8	Хуурай үлдэгдэл	Жингийн
9	Давсжилт	Титрийн, дөлт фотометр
10	Механик бүрэлдэхүүн	Качинскийн

Петро Матад ХХК-ийн “Матад ХХ” төслийн талбайд 2024 оны 6 болон 9 сард ажиллан төслийн талбайн газар ашиглалт, хөрсний чанарын мониторингийн хээрийн хэмжилт судалгааг хийсэн. Төслийн талбайн хувьд нэмэлт газрын тосны хайгуул хийгдэж байгаа тул өрөмдлөгийн цэг болон өмнөх цэгүүдийн хаягдлын сан зэрэг цэгэн доройтлын хэлбэрүүд үүссэн шинжтэй байна. Бүс нутгийн хувьд хээрийн бүсийн өвслөг экосистем ялгарна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



*Зураг 1. Матад ХХ талбайн төлөв байдал*

**Судалгааны арга, дээж цуглуулалт:**

Төсөл хэрэгжих талбайн зонхилох хөрсний хэв шинжийг илрүүлэх судалгаанд талбайн хөрсний суурь зураг мөн хөрсний үе давхаргыг ил гаргасан морфологи зүсэлт гүйцэтгэн, хими, физик шинж чанарыг тодорхойлох зорилгоор лабораторийн задлан шинжилгээнд зориулж үе давхарга тус бүрээс дээж авдаг. Матад ХХ талбайн мониторингийн хүрээнд зонхилох хөрсний хэв шинжийн тархалт болон хайгуулын өрөмдлөг, газар ашиглалт, шороон замын сүлжээ зэрэг төлөвлөлттэй уялдан 12 цэг сонгон хэмжилт гүйцэтгэв. Хөрсний мониторингийн судалгаагаар хөрсний хими, физик шинж чанар болон хөрсөн дэх хүнд элементийн агууламжийг тодорхойлох зорилгоор мониторингийн цэгүүдээс өнгөн хөрсний дээж авч “Ланд Овнер” ХХК-ийн магадлан итгэмжлэгдсэн “Green Lab” хөрсний лабораторид холбогдох журам, стандартад заасан аргазүйн дагуу задлан шинжилгээг гүйцэтгэн, лабораторийн задлан шинжилгээний дүнд холбогдон үр дүнгийн боловсруулалтыг хийж гүйцэтгэн, хөрсний шинж чанарын үнэлгээг гүйцэтгэв.

**Дээж цуглуулах арга зүй:**

Төслийн талбайн мониторингийн цэгүүдээс өнгөн хөрсний дээжийг эзлэхүүнт аргаар цуглуулсан. Мониторингийн цэгүүдийн орчимд урьдчилсан ажиглалт гүйцэтгэн, хөрсний тархалтыг хил заагийг ялган тодорхойлж, тухайн цэгийн хамгийн боломжит цэгээс хөрсний гар өрөм болон шугам ашиглан, 0-10 см гүнтэй өнгөн хөрсний 300 гр дээж цуглуулсан. Дээж авахын тулд тухайн талбайд ажиглалт хийж эрүүл хөрс, нөлөөлөлд өртсөн талбай, нөхөн сэргээсэн талбайд дээжлэлт хийсэн. Дээжийн уутанд тэмдэглэл хий, битүүмжийг шалган, лабораторийн шинжилгээнд хүргүүлсэн.

**Багаж тоног төхөөрөмж:**

Хөрсний дээж авах, зүсэлт хийхэд ашиглагдах 2 төрлийн хүрз, хөрсний өнгийг тодорхойлох Munsel book, метр, хөрсний дээжийг хийх уут, маркер, Garmin GPS



*Зураг 2. Хөрсний дээж авах багажууд болон Garmin GPS*




### **2.6.3 Хөрсний мониторинг**

Тухайн төслийн талбайд нийт 12 цэгт мониторингийн хэмжилт гүйцэтгэлээ. Матад ХХ хайгуулын цэгийн төлөвлөлт, газар ашиглалт, төслийн талбайн зонхилох хөрсний шинж чанарыг төлөөлүүлэн, цаашид мониторингийн хяналт хийх цэгээр сонгов.

Матад ХХ талбайн хөрсний өнөөгийн төлөв байдал, элэгдэл, эвдрэл, бохирдолтыг тодорхойлох зорилгоор 6 сард хөрсний 10 мониторингийн цэгийг сонгосон бол 9 сард хөрсний 12 мониторингийн цэгийг сонгосон ба үүнээс 11 цэгт хөрсний зүсэлт хийж хөрсний морфологи бичиглэл, хяналт шинжилгээ ажиглалт хийн хөрсний үржил шимийн ерөнхий үзүүлэлт, механик бүрэлдэхүүнийг тодорхойлсон, 6 цэгт эрүүл ахуйн өнөөгийн агууламж тодруулах зорилготойгоор хөрсний шинжилгээний дээжийг ерөнхий шаардлага (MNS3298:1991) стандартын дагуу авч, магадлан итгэмжлэгдсэн Ланд Овнер ХХК-ийн Грийн лаб лабораторид шинжлүүлсэн. Цэн тогоруу-1, Цэн тогоруу-2, Мазаалай-1, Цагаан зээр-1, Замын уулзвар гэсэн 3 цэгээс хөрсний нефт бүтээгдэхүүний шинжилгээг авч Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид, Цэн тогоруу-1, Цэн тогоруу-2, Мазаалай-1, Цагаан зээр-1, Замын уулзвар, Хогийн цэг гэсэн 7 цэгээс хүнд металл, цацраг идэвхийн дээжийг авч Цөмийн физикийн судалгааны төвийн итгэмжлэгдсэн лабораторид тус тус шинжлүүлсэн.

Зураг 26. Хөрсний судалгаа, морфологи бичиглэлийн цэг




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Хүснэгт 26. Хөрсний дээж авч, бичиглэл хийсэн цэгүүд*

Цэгийн дугаар	Талбай	Хөрсний төрөл	Газарзүйн байршил		Хийсэн шинжилгээний үзүүлэлт
			Өргөрөг	Уртраг	
20M-S-01	Цэн тогоруу-1	Хар хүрэн хөрс	46° 49' 52.7//	116° 08' 35.73//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй, Нефт бүтээгдэхүүн, Цацраг
20M-S-02	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Мараалаг хүрэн хөрс	46° 47' 35.29//	115° 58' 03.79//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-03	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Хар хүрэн хөрс	46° 47' 30.57//	116° 07' 24.48//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-04	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Нугархаг хүрэн хөрс	46° 45' 25.45//	116° 05' 05.03//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-05	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Хужир мараа	46° 44' 52.7//	116° 08' 35.73//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй,
20M-S-06	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Мараалаг хүрэн хөрс	46° 49' 37.89//	116° 03' 05.8//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-07	Цагаан зээр-1	Хүрэн шороон хөрс	46° 49' 28.42//	116° 06' 43.4//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй,
20M-S-08	Ашиглалт төлөвлөгдөөгүй	Хүрэн шороон хөрс	46° 49' 09.01//	116° 14' 38.47//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн
20M-S-09	Замын уулзвар	Хар хүрэн хөрс	46° 49' 06.29//	116° 06' 24.31//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй, Нефт бүтээгдэхүүн, Цацраг
20M-S-10	Хогийн цэг	Хар хүрэн хөрс	46° 49' 52.71//	116° 08' 37.52//	Хөрсний хүнд металл, Эрүүл ахуй, Цацраг
20M-S-11	Цэн тогоруу-2	Хар хүрэн хөрс	46° 49' 16.53//	116° 07' 26.67//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй, Нефт бүтээгдэхүүн, Цацраг
20M-S-12	Мазаалай-1	Хар хүрэн хөрс	46° 49' 9//	115° 58' 50//	Хөрсний ерөнхий хими, Механик бүрэлдэхүүн, Хүнд металл, Эрүүл ахуй, Нефт бүтээгдэхүүн, Цацраг

Зураг 27. Хөрсний дээж авсан цэг



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

1. Хэмжилтийн цэг -1: Өрмийн цооног, нөхөн сэргээсэн талбайн хэмжилтийн цэг  $44^{\circ} 55' 7.37''$   $110^{\circ} 15' 26.61''$  солбицолд оршино. Антропоген нөлөөлөлд хүчтэй өртөгдсөн талбайг төлөөлүүлэн сонгосон.



Зураг 28. Өрмийн зумп, нөхөн сэргээсэн талбайн хяналтын цэг (Цэн тогоруу-1)

2. Хэмжилтийн цэг-2: Нөлөөлөлд өртөөгүй, эрүүл хар хүрэн хөрс бүхий талбай  $N 46^{\circ} 47' 35.29''$   $E 115^{\circ} 58' 03.7''$  солбицолд оршино. Цаашид төслийн үйл ажиллагааны дам нөлөөлөл болох шороон зам, өрмийн цэг бүсэд багтах эрсдэлтэй гэж үзэв.



Зураг 29. Талхаагдалд өртөөгүй талбайн хяналтын цэг (Мараалаг хүрэн хөрс)

3. Хэмжилтийн цэг-3:  $44^{\circ} 47' 30.57''$   $116^{\circ} 07' 24.48''N$  солбицолд оршино. Цаашид төслийн үйл ажиллагааны дам нөлөөлөл болох шороон зам, өрмийн цэг бүсэд багтах эрсдэлтэй гэж үзэв.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



*Зураг 30. Талхагдалд өртөөгүй талбайн хяналтын цэг (Хар хүрэн хөрс)*

4. Хэмжилтийн цэг-4: Эрүүл х өрсний хяналтын цэг  $46^{\circ} 45' 26.18''$   $116^{\circ} 05' 05.11''$  солбилцолд оршино. Төслийн талбайн орчимд хүний үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртсөн талбай хяналтын цэгийн зориулалтаар, мөн байгалийн суурь хөрсний хяналтын цэгээр сонгов.



*Зураг 31. Антропоген талхагдалд өртсөн хөрс (Нугархаг хүрэн хөрс)*

5. Хэмжилтийн цэг-5: Давсархаг хөрсний мониторингийн цэг  $46^{\circ} 44' 52.0''$   $116^{\circ} 08' 35.0''$  солбилцолд оршино. Эндемик ургамлыг хамгаалах зорилгоор хөрсний ерөнхий шинж чанарыг тодорхойлон, цаашид үүсэх өөрчлөлтөөс сэргийлэхээр хяналтын цэг байгуулсан.



*Зураг 32. Давсархаг хөрсний хяналтын талбай (Хужир мараа)*

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

6. Хэмжилтийн цэг-: Нугархаг хүрэн хөрсний хяналтын цэг:  $46^{\circ} 29' 37.8''$   $116^{\circ} 03' 05.8''$  солбилцолд оршино. Төслийн талбайн хүрээнд өнгөн тархалттай нам хотос газруудаар элбэг тохиолдох нугархаг хүрэн хөрсний шинж чанарын өөрчлөлтийг хянах зориулалтаар сонгов.



Зураг 33. Нугархаг хүрэн хөрсний мониторингийн цэг (Мараалаг хүрэн хөрс)

7. Хэмжилтийн цэг-7: Эрүүл хөрсний хяналтын цэг  $46^{\circ} 49' 05.21''$   $116^{\circ} 04' 32.14''$  солбилцолд оршино. Төслийн талбайн хүрээнд өнгөн тархалттай хүрэн хөрсний шинж чанарын өөрчлөлтийг хянах зориулалтаар сонгов.



Зураг 34. Эрүүл хөрсний хяналтын цэг (Цагаан зээр-1)

8. Хэмжилтийн цэг-8: Эрүүл хөрсний хяналтын цэг  $46^{\circ} 46' 09.01''$   $116^{\circ} 14' 38.47''$  солбилцолд оршино. Хайгуулын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх эрсдэлийг хянах зорилгоор сонгов



Зураг 35. Эрүүл хөрсний хяналтын цэг (Хүрэн шороон хөрс)

9. Хэмжилтийн цэг-9: Эрүүл хөрсний хяналтын цэг  $46^{\circ} 49' 52.71''$   $116^{\circ} 08' 37.52''$  солбилцолд оршино. Авто замын уулзвар, машин техникийн нөлөөлөлд өртсөн талбайг хянах зорилгоор сонгов.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



*Зураг 36. Эрүүл хөрсний хяналтын цэг (Замын уулзвар)*

10. Ахуйн хог хаягдлын цэг:  $46^{\circ} 49' 54.0''$   $116^{\circ} 08' 36.0''$  солбилцолд оршино. Хог хаягдлын нөлөөллөөр хөрсний бохирдлын түвшнийг хянах зорилгоор сонгов.



*Зураг 37. Хог хаягдлын цэг*

11. Хэмжилтийн цэг-11: Цэн тогоруу-2 талбай.  $46^{\circ} 49' 16.5''$   $116^{\circ} 07' 26.6''$  солбилцолд оршино. Талхагдалд өртсөн хөрс, өрмийн хайгуул орчмын цэг.



*Зураг 38. Антропоген нөлөөллийн хяналтын цэг*

12. Хэмжилтийн цэг-12: Мазаалай-1 талбай  $46^{\circ} 49' 05.21''$   $116^{\circ} 04' 32.14''$  солбилцолд оршино. Хайгуулын үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг илрүүлэх зорилгоор сонгов.



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



Зураг 39. Антропоген нөлөөллийн хяналтын цэг

**2.6.4 Хөрсний морфологи бичиглэл**

<b>Хэмжилтийн цэг: 20M-S-01</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний нэр:</b> Хар хүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 49'40.86" E: 116° 07'27.75"		
<b>Өндөр д.т.д:</b> 688		
<b>Газар ашиглалт:</b> Газрын тосны худгийн цэг		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> Тэгш талархаг		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> хайгуулын өрөмдлөг, дамжуулах худаг		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Хүчтэй Өрөмдлөгийн үйл ажиллагааны нөлөөгөөр талбай талхагалд өртсөн шинжтэй.		
	<b>A үе</b> 0-11см	Цайвар өнгөтэй, хуурай, сийрэг нийцтэй, ургамлын нарийн үндэстэй, чулуугүй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой бүтэц илрэхгүй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц.
	<b>AB үе</b> 11-23см	Чийгтэй, бараавтар өнгөтэй, улаан туяатай, шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Дарагдаж нягтарсан шинжтэй. Чулуугүй, ургамлын нарийн ганц нэг үндэстэй. Шилжилт нягтаар мэдэгдэхүйц.
	<b>B үе</b> 23- доош гүнд	Хөрс үүсгэгч эх чулуулгийн давхарга. Том ширхэгтэй элсэнцэр бүхий механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой нийцэл ажиглагдахгүй.
<b>Хөрсний бохирдол:</b>		Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй
<b>Ландшафт:</b>		Тал хээрийн ландшафт
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>		пролювийн хурдаст тэгш тал

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

<b>Хэмжилтийн цэг: 20М-S-02</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Мараалаг хүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 47'35.29" E: 115° 58'03.79"		
<b>Өндөр д.т.д:</b> 672		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> Тэгш талархаг		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	<b>A үе</b> 0-17см	Цайвар өнгөтэй, хуурай, сийрэг нийцтэй, ургамлын нарийн үндэстэй, ганц нэг бутлаг ургамлын бүдүүн үндэс нэвтэрсэн. Чулуугүй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой бүтэц илрэхгүй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц.
	<b>AB үе</b> 17-36см	Чийгтэй, бараавтар өнгөтэй, улаан туяатай, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Дарагдаж нягтарсан шинжтэй. Чулуугүй, ургамлын нарийн ганц нэг үндэстэй. Шилжилт нягтаар мэдэгдэхүйц.
<b>Хөрсний бохирдол:</b>	Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй	
<b>Ландшафт:</b>	Тал хээрийн ландшафт	
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>	пролювийн хурдаст тэгш тал	

<b>Хэмжилтийн цэг: 20М-S-03</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хархүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 47'30.57" E: 116° 07' 24.48"		
<b>Өндөр д.т.д:</b> 719		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> Тэгш талархаг		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	A үе 0-17см	Бараавтар өнгөтэй, өлөн чийгтэй, сийрэг нийцтэй, ургамлын нарийн үндэстэй. Чулуугүй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой бүтэц илрэхгүй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц.
	AB үе 17-28см	Чийгтэй, цайвар өнгөтэй, Карбонат хуримтлалын давхарга. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Дарагдаж нягтарсан шинжтэй. Чулуугүй, ургамлын нарийн ганц нэг үндэстэй. Шилжилт нягтаар мэдэгдхүйц.
<b>Хөрсний бохирдол:</b>	Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй	
<b>Ландшафт:</b>	Тал хээрийн ландшафт	
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>	Пролювийн хурдаст тэгш тал	
<b>Хэмжилтийн цэг: 20M-S-04</b>	Төсөл: МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай	


<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Үлдмэл нугархаг хүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай	<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>	
<b>Координат:</b> N: 46° 45' 24.45" E: 116° 05' 5.03"		
<b>Өндөр д.т.д:</b> 719		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> Тэгш талархаг		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	A үе 0-18см	Элсэн хучаас. Цайвар өнгөтэй, хуурай . Өвслөг ургамлын бөөгнөрсөн үндэстэй. Тодорхой бүтэц ялгарахгүй, чулуугүй. Бутлаг ургамлын ганц нэг үндэстэй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Шилжилт өнгөөр болон нягтаар тод.
	AB үе 18-33см	Хуурай, цайвар өнгөтэй. Нягтарч дарагдсан шинжтэй. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Чулуугүй, ургамлын үндэсгүй.
<b>Хөрсний бохирдол:</b>	Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй	
<b>Ландшафт:</b>	Тал хээрийн ландшафт	
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>	Пролювийн хурдаст тэгш тал	



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

<b>Хэмжилтийн цэг: 20М-S-05</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хужир мараалаг хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 44' 03.9" E: 116° 00' 20.01"		
<b>Өндөр д.т.д:</b> 677		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> нугархаг хотгор		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	A үе 0-20см	Хар бараан болон улаавтар толботой. Босоо болон хөндлөн давхарга ялгарсан. Ургамлын нарийн үндэс ихтэй. Хөрсний гадаргад цайвар өнгөтэй давсны хучмал үүснэ. Өнгөн хөрсний дээд үе давхаргад органик хуримтлалын бараан толбо ялгарна
	B үе 20-40см	Хар бараан өнгөтэй. Чийгтэй. Хүнд шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Чулуугүй, ургамлын үндэсгүй. Тодорхой бүтэцгүй. Шилжилт механик бүрэлдэхүүнээр болон нягтаар мэдэгдэхүйц.
	BC үе 40-60см	Чийгтэй, том ширхэгтэй элсэн үе. Плювиал үйл ажиллагааны нөлөөгөөр хуримтлагдсан үе. Ургамлын үндэсгүй, чулуугүй. Тодорхой бүтэц ялгарахгүй.
<b>Хөрсний бохирдол:</b>		Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй
<b>Ландшафт:</b>		Тал хээрийн ландшафт
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>		Пролувийн хурдаст тэгш тал

<b>Хэмжилтийн цэг: 20М-S-06</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Мараалаг хүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай. Цагаан зээр кемп		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 49' 37.89" E: 116° 03' 05.80"		
<b>Өндөр д.т.д:</b> 656		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> нугархаг хотгор		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



	<p>A үе 0-18см</p>	<p>Цайвар өнгөтэй. Хуурай, сийрэг нийцтэй. Чулуугүй, ургамлын нарийн үндсээр торлогдсон шинжтэй. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Шилжилт нягтаар болон механик бүрэлдэхүүнээр мэдэгдэхүйц.</p>
	<p>AB үе 19-60см</p>	<p>Бараан өнгөтэй, чийгтэй. Чулуугүй, Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Ганц ургамлын нарийн үндэстэй. Чулуугүй, бага зэрэг дарагдаж нягтарсан шинжтэй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц</p>
<p><b>Хөрсний бохирдол:</b></p>	<p>Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй</p>	
<p><b>Ландшафт:</b></p>	<p>Тал хээрийн ландшафт</p>	
<p><b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b></p>	<p>Пролювийн хурдаст тэгш тал</p>	

<p><b>Хэмжилтийн цэг: 20M-S-07</b></p>	<p><b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай</p>	
<p><b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хүрэншороон хөрс</p>		
<p><b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай. Цагаан зээр кемп</p>	<p><b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b></p>	
<p><b>Координат:</b> N: 46° 49' 28.42" E: 116° 06' 43.40"</p>		
<p><b>Өндөр д.т.д:</b> 683</p>		
<p><b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай</p>		
<p><b>Талбайн ерөнхий төрх:</b> нугархаг хотгор</p>		
<p><b>Чулуужилт:</b> Бага</p>		
<p><b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй</p>		
<p><b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.</p>		
	<p>A үе 0-14см</p>	<p>Цайвар өнгөтэй. Хуурай, сийрэг нийцтэй. Чулуугүй, ургамлын нарийн үндсээр торлогдсон шинжтэй. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Шилжилт нягтаар болон механик бүрэлдэхүүнээр мэдэгдэхүйц.</p>
	<p>AB үе 14-30см</p>	<p>Бараан өнгөтэй, чийгтэй. Чулуугүй, Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Ганц ургамлын нарийн үндэстэй. Чулуугүй, бага зэрэг дарагдаж нягтарсан шинжтэй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц</p>
	<p>B үе 30-70см</p>	<p>Цайвар өнгөтэй, карбонат хуримтлалын давхарга, өлөн чийгтэй. Чулуугүй. Ганц нэг ургамлын нарийн үндэстэй. Шавранцар механик бүрэлдэхүүнтэй.</p>
<p><b>Хөрсний бохирдол:</b></p>	<p>Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй</p>	
<p><b>Ландшафт:</b></p>	<p>Тал хээрийн ландшафт</p>	
<p><b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b></p>	<p>Пролювийн хурдаст тэгш тал</p>	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

<b>Хэмжилтийн цэг: 20M-S-08</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хүрэншороон хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай. Цагаан зээр кемп		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 49' 09.01" E: 116° 14' 38.47"		
<b>Өндөр д.т.д:</b> 672		
<b>Газар ашиглалт:</b> Хайгуулын талбай		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> нугархаг тал		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	A үе 0-21см	Бараан өнгөтэй. Чийгтэй, сийрэг нийцтэй. Чулуугүй, ургамлын нарийн үндэстэй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Шилжилт нягтаар болон механик бүрэлдэхүүнээр мэдэгдэхүйц.
	AB үе 21-49см	Бараан өнгөтэй, чийгтэй. Чулуугүй, Хөнгөн шавранцар, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Ганц ургамлын нарийн үндэстэй. Чулуугүй, бага зэрэг дарагдаж нягтарсан шинжтэй. Шилжилт өнгөөр болон нягтаар мэдэгдэхүйц
<b>Хөрсний бохирдол:</b>	Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй	
<b>Ландшафт:</b>	Тал хээрийн ландшафт	
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>	Пролювийн хурдаст тэгш тал	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

<b>Хэмжилтийн цэг: 20М-S-09</b>		<b>Төсөл:</b> МАТАД ХХ газрын тосны хайгуул, олборлолтын талбай
<b>Хөрсний Хөрсний нэр:</b> Хархүрэн хөрс		
<b>Байршил:</b> Матад ХХ газрын тосны хайгуулын талбай		<b>Талбайн ерөнхий төрх байдлын зураг:</b>
<b>Координат:</b> N: 46° 49' 06.29" E: 116° 09' 24.31"		
<b>Өндөр д.т.д:</b> 656		
<b>Газар ашиглалт:</b> Сайжруулсан шороон замын дэргэд		
<b>Талбайн ерөнхий төрх:</b> тэгш тал		
<b>Чулуужилт:</b> Бага		
<b>Эвдрэл үүсгэгч:</b> байхгүй		
<b>Элэгдэл эвдрэл:</b> Сул.		
	<b>А үе</b> 0-11см	Хучаас үе. Цайвар өнгөтэй. Хуурай, сийрэг нийцтэй. Чулуугүй, Ургамлын нарийн үндэстэй. Хөрсний өнгөн хэсэг ерөмтсөн шинжтэй. Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Хэврэг бөөмөрхөг бүтэцтэй. Шилжилт нягтаар болон механик бүрэлдэхүүнээр мэдэгдэхүйц.
	<b>AB үе</b> 11-34см	Цайвар өнгөтэй, чийгтэй. Чулуугүй, ургамлын үндэсгүй. Давсны цайвар нэчвмэл толботой. Хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Чулуугүй, бага зэрэг дарагдаж нягтарсан шинжтэй.
	<b>BC үе</b> 35-50см	Бараан өнгөтэй, чийгтэй, дарагдмал шинжтэй. Чулуугүй, ургамлын үндэсгүй, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Тодорхой бүтэц ялгарахгүй.
<b>Хөрсний бохирдол:</b>		Нүдэнд ил ажиглагдах бохирдол үүсээгүй, асгарал байхгүй
<b>Ландшафт:</b>		Тал хээрийн ландшафт
<b>Хөрс үүсвэрийн эх чулуулаг:</b>		Пролювийн хурдаст тэгш тал

### 2.6.3 Хөрсний хяналт шинжилгээний үр дүн

Матад ХХ талбайд зонхилон хөрсний хэв шинжүүдийг урьдчилан тодорхойлж, хээрийн судалгааны ажлын хүрээнд хөрсний морфологи бүтэц болон үе давхаргаас лабораторийн задлан шинжилгээнд зориулан хөрсний дээж цуглуулсан. Одоогийн байдлаар судалгааны талбайд газрын тосны хайгуулын өрмийн цэг, тос дамжуулах худаг, тээврийн шороон зам зэрэг газрын доройтлын хэлбэрүүд илэрнэ.

Зонхилох хэв шинжийн хөрсний хими, физик шинж чанарыг дараах үзүүлэлтээр авч үзэв. Үүнд:

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Хүснэгт 27. Хөрсний химийн үндсэн шинж, 2024 оны 6 сар*

Хөрс	Дээж	гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dSm	CaCO <sub>3</sub> %	Ялзма г, %	Шингээгдсэн эн		Хөдөлгөөнт	
								Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Хархүрэн хөрс	20M-S-01	0-11	8.81	0.04	0.067	2.64	0.75	12.9	9.5	0.9	19
		12-22	8.62	0.05	0.099	5.93	0.6	11.5	5.2	1.4	24
		23-доош	8.13	0.04	0.063	0	1.5	11.1	2.9	0.8	18
	20M-S-03	0-17	7.91	0.02	0.039	0	1.5	11.4	5.6	1.9	31
		18-28	8.08	0.02	0.041	0	1.5	14.2	1.6	1.8	25
	20M-S-09	0-11	8.06	0.04	0.05	0	1.76	11.1	2.3	1.5	26
		12-34	7.87	0.02	0.048	0	1.41	10.8	1.2	1.3	19
35-50		8.38	0.03	0.062	0	1.42	9.4	3.2	1.6	15	
Хүрэншороон хөрс	20M-S-07	0-14	7.97	0.05	0.103	0	1.31	12.6	2.6	3.1	34
		15-30	8.33	0.04	0.086	0.49	1.12	13.7	5.2	2.5	39
		31-70	8.84	0.04	0.079	4.94	1.06	9.9	5.2	0.6	11
	20M-S-08	0-21	7.39	0.04	0.081	0	1.72	12.2	1.2	1.5	29
		21-49	8.04	0.04	0.077	0	1.43	13.2	4.2	2.1	24
Мараалаг хүрэн	20M-S-02	0-17	7.84	0.03	0.065	0	1.41	15.3	1.2	1.6	31
		18-36	8.55	0.05	0.094	0	1.47	19.2	2.4	2.1	29
	20M-S-06	0-18	9.57	0.03	0.054	0	1.53	9.7	3.5	2.5	29
		19-60	7.97	0.01	0.027	0	1.48	10.2	4	1.4	33
Нугархаг хүрэн хөрс	20M-S-04	0-18	7.17	0.03	0.054	0	1.84	13.6	1.2	2.9	35
		19-33	7.1	0.02	0.042	0	2.09	16.2	7.2	2.5	34
Хужир мараа	20M-S-05	0-20	9.52	0.18	0.356	2.31	1.12	6.6	3.7	1.5	16
		21-40	9.9	0.62	1.236	3.62	1.16	13	2	1.6	18
		40-60	9.47	0.33	0.667	0.99	0.26	7.3	0.8	0.4	7

*Хүснэгт 28. Хөрсний химийн үндсэн шинж, 2024 оны 9 сар*

Хөрс	Дээж	гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dSm	CaCO <sub>3</sub> %	Ялзма г, %	Шингээгдсэн суурь			Хөдөлгөөнт суурь		
								Ca	Mg	Σ	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O	Σ
Хархүрэн хөрс	20M-S-01	0-10	8.80	0.02	0.031	0.00	1.06	14.4	1.2	15.6	0.9	14	14.9
		10-45	8.74	0.02	0.037	0.00	0.88	16.6	2.4	19	0.3	15	15.3
		45-доош	9.55	0.03	0.050	5.77	2.41	10.9	5.8	16.7	0.8	13	13.8
	20M-S-03	0-25	9.44	0.02	0.040	4.45	1.13	15.1	2.0	17.1	0.6	13	13.6
		25-доош	9.68	0.02	0.039	2.31	0.25	10.6	5.3	15.9	0.6	17	17.6
	20M-S-09	0-10	8.96	0.01	0.024	0.00	0.21	10.2	1.4	11.6	0.7	13	13.8
		10-20	8.80	0.01	0.024	0.00	0.57	10.8	3.8	12.7	0.6	15	15.7
		40-60	9.35	0.02	0.046	2.64	1.36	8.9	2.2	9	0.4	11	11.6
	20M-S-11	0-20	9.25	0.02	0.049	2.80	1.04	6.8	1.4	17.7	0.8	15	15.4
20-35		9.46	0.02	0.047	3.15	0.59	16.3	5.8	27.4	0.7	15	15.8	



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



	20M-S-12	0-45	9.16	0.02	0.047	0.00	0.91	21.6	6.8	19.8	0.5	11	11.7
		45-доош	9.71	0.02	0.047	0.49	0.19	13	5.8	5.8	0.9	7	7.5
Хүрэншо роон хөрс	20M-S-07	0-35	9.17	0.02	0.046	0.99	1.22	15.2	2.6	17.8	0.6	11	12.3
		35-доош	9.59	0.02	0.047	3.29	0.34	9.2	4.5	13.7	0.7	13	13.6
	20M-S-08	0-10	7.73	0.01	0.017	0.00	1.12	13.4	1.6	15	0.8	11	11.7
		10-30	8.09	0.01	0.022	0.00	1.15	10	3.7	13.7	0.8	13	13.8
Мараалаг хүрэн	20M-S-02	0-10	8.95	0.02	0.031	0.00	1.45	20.4	1.4	21.8	0.4	15	15.4
		10-30	9.02	0.01	0.020	0.00	0.36	16.2	2.2	18.4	0.5	13	13.5
	20M-S-06	0-35	9.24	0.03	0.051	0.00	0.99	19.4	3.3	22.7	0.8	17	17.8
		35-доош	9.58	0.02	0.048	1.48	0.34	7.9	7.8	15.7	1.3	15	15.8
Нугархаг хүрэн хөрс	20M-S-04	0-30	8.58	0.01	0.021	0.00	0.66	8.4	2.6	11	1.2	15	16.2
		30-доош	10.10	0.12	0.235	0.00	1.46	11.8	4.2	16	2.3	19	21.3
Хужир мараа	20M-S-05	0-10	10.80	0.29	0.571	3.13	0.38	7.8	4.4	12.2	1.2	19	20.2
		10-45	10.6	0.53	1.077	1.65	0.21	3.2	7.0	10.2	1.3	17	18.3
		45-доош	10.40	0.75	1.507	4.61	0.16	3.6	8.4	12	1.3	17	18.3

**Хөрсний урвалын орчин:** Хөрсний уусмалын орчин нь хөрсний үе давхаргад агуулагдах уусмалын хүчиллэг болон шүтлэг шинжийг тодорхойлох голлох үзүүлэлт болдог. Хөрсний урвалын орчинг 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.0-6.7 бол сул хүчиллэг, 6.7.-7.3 бол саармаг, 7.4-7.8 орчим сул шүтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүтлэг, 8.5-9.0 хүчтэй шүтлэг гэж ангилсан байдаг (Soil Survey Manual, 2006).


Матад ХХ талбайн ухаа толгод болон тэгш талархаг газраар тархсан хархүрэн хөрсний урвалын орчин 8.5 очрим сул шүтлэг шинжтэй байгаа бөгөөд хөрсний гадаргад үүссэн элсэнцэр хучаас үеийн хөгжилтэй холбоотойгоор хөрсний өнгөн хэсэгт урвалын орчин саармаг шинжтэй болсон байсан бол 9 сард хийсэн хэмжилтийн үр дүнг харахад Мониторингийн цэгүүдэд урвалын орчин ойролцоо утгатай, өөрчлөлт багатай байна. хөрсний мониторингийн ихэнх цэгүүд дээр урвалын орчин нэмэгдэж, иүүү шүтлэг шинжтэй болсон. Ялангуяа 2024 оны хур тунадасны эрчимтэй холбоотойгоор хужир, мараалаг хөрсний үе давхаргад чийгийн агууламж нэмэгдсэнээр урвалын орчинд тодорхой нөлөө үзүүлсэн байх боломжтой. Ялангуяа 20M-S-05, 20M-S-06 цэгүүдэд мараалаг, нугархаг давсархаг хөрсний цэгүүдэд урвалын орчин илүү нэмэгдсэн шинжтэй байна. (график.7).

*График 7. Хяналтын талбайн урвалын орчин*

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



**График 8. Хархүрэн хөрсний урвалын орчин**



**График 9. Хүрэншиороон хөрсний урвалын орчин**

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**




График 10. Мараалаг хүрэн хөрсний урвалын орчин




График 11. Нугархаг хүрэн хөрсний урвалын орчин

График 12. Хужирлаг хөрсний урвалын орчин

Хар хүрэн хөрсний морфологи бүтэцтэй холбоотойгоор хуримтлалын В давхаргад голлох шүлтлэг утга илэрч байгаа бол сийрэг болон элсэнцэр хуримтлал бүхий үе давхаргуудад урвалын орчин саармагжиж байна.


Хүрэн шороон хөрсний хувьд хөрсний өнгөн үе илүү саармаг 7.0 орчим утгатай байгаа бол шилжилтийн В давхарга болон гүний үе давхаргуудад 8.0 болж сул шүлтлэг шинжтэй болж байна. Хүрэн шороон хөрсний угаagdлын горим болон механик бүрэлдэхүүний тархалттай холбоотойгоор доод үе давхаргуудад илүү шүлтлэг шинж илэрнэ (график.8). Хүрэн шороон хөрсний морфологи бүтцийн хөгжилтэй холбоотойгоор шавар үүсэх үйл явц зонхилдог шилжилтийн В давхаргад давс, эрдсийн хуримтлал голчлон хуримтлагддаг байна.

Мараалаг хөрсний урвалын орчин сул шүлтлэг шинжтэй боловч зарим хэв шинжийн хөрсний өнгөн хэсэг нь өрөмтсөн шинжтэй байгаа бөгөөд урвалын орчин 9.0 шүлтлэг шинжтэй болсон байна. Угаagdлаар хуримтлагдах нэмэлт чийгжилтийн нөлөөгөөр хөрсний морфологи бүтэц бүрэлдэн тогтох учир угаagdал хуримтлалын нөлөө тод ялгардаг шинжтэй (график.9). Нугархаг хөрсний хувьд угаagdлын эрчим өндөртэй учир урвалын орчин 7.1 орчим саармаг шинжтэй бөгөөд хөрсний доод үеүүдэд илүү буурах хандлагатай байна (график.10). Давсархаг хөрсний хувьд урвалын орчинд 9.0 дээш буюу хүчтэй шүлтлэг шинжтэй болох бөгөөд хүнд шавранцар механик бүрэлдэхүүнтэй, чийгээр ханасан шинжтэй, исэлдэн ангижрах урвалын нөхцөлтэй холбоотойгоор хөрсний үе давхарга бүхэлдээ шүлтлэг шинжтэй болсон байна.

Судалгааны талбайн хөрсний урвалын орчны тархалтыг авч үзэхэд Бүрдний гол болон давст худаг орчмын давсархаг хотгоруудад шүлтлэг утга голчлон тархах бол Давст ухаа, Далайн нуруу орчмын тэгш зоо маягийн газруудад илүү саармаг утга тархсан байна (зураг.39).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**


Зураг 40. Матад ХХ газрын тосны хайгуулын талбайн урвалын орчин- рН утга



**Хөрсний карбонат ( $CaCO_3$ ):** Хөрсний карбонатын агууламж нь рН буюу хөрсний урвалын орчинтой нягт холбоотой үүсдэг ба хөрсний үе давхаргад агуулагдах карбонатын давсны агууламж, тархалт нь хөрсний үржил шимийн түвшинд нөлөөлөхөөс гадна элэгдэл, эвдрэлд тэсвэртэй байдал, чийгийн агууламж зэрэг шинж чанартай уялддаг. Хөрсний карбонатын агууламжаас илрэх гүн болон агууламжаар ангилан үздэг бөгөөд 0-2% агууламжтай бол сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% хүчтэй карбонатжсан гэж үнэлнэ (Guideline for soil description. 2006). Матад ХХ газрын тосны хайгуулын талбай нь дорнод монголын хээрийн экосистемийн нөлөөнд бүрэлдэн тогтсон, элсэнцэр голлосон механик бүрэлдэхүүнтэй, сийрэг нийцтэй, ургамлын нарийн үндэс ихтэй зуны хур борооны усаар үе үе нэвт угаагддаг шинжтэй учир карбонатын агууламж төдийлөн илрэхгүй байна. Хэмжилтийн талбайд Хархүрэн хөрсний 20M-S-01, хүрэн шороон хөрсний 20M-S-07, хужир мараалаг хөрсний 20M-S-05 цэгүүдэд карбонатын агууламж илрэх боловч өнгөн хөрс болон гүний үе давхаргуудад ихээхэн ялгаатай илэрнэ. Хөрсний өнгөн А үед 0.5-2.0% орчим илрэх бол гүний үе давхаргуудад 5.0% орчим утга хүрнэ (график.8). Карбонатын агууламж нь голчлон шилжилтийн В давхаргад шавар үүсэх үйл явц болон угаагдлын хуримтлалын нөлөөгөөр голчлох хуримтлагдах үйл явц ажиглагдаж байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

График 13. Матад ХХ талбайн хөрсний карбонатын агууламж



**Хөрсний цахилгаан дамжуулалт (EC(dS/m)):** Хялбар уусах давс нь ургамлын ургалт, үндэсний хөгжилт, агаар, ус нэвчих, исэлдэн ангижрах чанартай уялдан хөрсний үржил шимт бодисын хөдөлгөөн, бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг. Хөрсний гадарга өрөмтөх, давсны цайвар өнгө үүсэх зэрэг нь хөрсний доройтлын индикатор үзүүлэлт болдог. Хөрсний хялбар уусах давсны агууламж 0.0-0.75dS/m бол давсжаагүй, 0.75-2.0dS/m бол сул давсжилттай, 2.0-4.0dS/m бол давсны агууламж дунд зэрэг, 4.0-8.0dS/m бол давсны агууламж их, 8.0-15.0dS/m бол давсны агууламж өндөр, >15.0dS/m хэт их давсархаг гэж ангилж үздэг (Guideline for soil description. 2006).

Матад ХХ талбайн хар хүрэн хөрсний хялбар уусах давсны агууламж 0.06-0.09dS/m орчим хэлбэлзэх бөгөөд хэмжилтийн цэгүүдэд хөрсний морфологи бүтцээс шалтгаалсан өөрчлөлт багатай байгаа бөгөөд хар хүрэн хөрсний хувьд морфологи бүтцийн ялгаа сул учир ялгаа төдийлөн үүсэхгүй байна (*график.7*). Хүрэн шорооны хөрсний хялбар уусах давсны агууламжийн хувьд 0.07-0.10dS/m орчим хэлбэлзэх бөгөөд хөрсний шилжилтийн үед шаварлаг фракцын хуримтлалтай холбоотой учир давсны агууламж нэмэгдсэн шинжтэй байна. Нөгөө талаар газар ашиглалт болон бүс нутгийн уур амьсгалын онцлогтой холбоотойгоор хэмжилтийн цэгүүдэд хөрсний гадарга өрөмтсөн шинжтэй учир давсжилтад тодорхой нөлөө үзүүлж байна (*график.8*). Хүрэн шороон хөрсний хэв шинжийн хувьд шилжилтийн В давхаргад давсны агууламж бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна. Мараалаг хүрэн хөрсний хувьд угаагдал, чийгийн горимын онцлогтой холбоотойгоор давсны агууламж 0.04-0.09dS/m орчим хэлбэлзэх бөгөөд шилжилтийн В давхаргад бага зэрэг нэмэгдэх хандлагатай байна (*график.9*). Нугархаг хүрэн хөрсний хувьд гадаргын угаагдлын нөлөөгөөр нэмж хуримтлагдах шинжтэй учир хөрсний үе давхарга бүхэлдээ үе үе усаар угаагддаг шинжтэй учир хөрсний үе давхаргад агуулагдах хялбар уусах давсны агууламж 0.05dS/m орчим утгатай хэлбэлзэж байгаа бөгөөд хөрсний морфологи бүтцээс шалтгаалсан өөрчлөлт багатай байна (*график.10*). Бүрдний голын хөндийд хийсэн

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

давсархаг хөрсний дүнгээс үзэхэд өнгөн үед 0.35dS/m орчим хэлбэлзэх бол шилжилтийн В давхаргад 1.23dS/m орчим өндөр агууламжтай байгаа бол эх чулуулгийн С давхаргад 0.66dS/m орчим байна (график.11).




График 14. Хархүрэн хөрсний цахилгаан дамжуулах чанар




График 15. Хүрэншороон хөрсний цахилгаан дамжуулах чанар




График 16. Мараалаг хүрэн хөрсний цахилгаан дамжуулах чанар





График 17. Нугархаг хүрэн хөрсний цахилгаан дамжуулах чанар

График 18. Хужирлаг хөрсний цахилгаан дамжуулах чанар

## Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

Хялбар уусах давсны тархалтын хувьд Бүрдний голын хөндий дагуух хэмжилтийн цэгт 1.23dS/m орчим утга илэрч байгаа бол үлдмэл зоо болон сайргархаг хүрэн хөрсний хэв шинжүүдэд бага утга 0.03dS/m хүртэл бага агууламжтай байна. Талбайн тархалтын хувьд баруун болон баруун урд хэсгийн нам дор хотос газруудад голчлон давсны агууламж давамгайлж байгаа бол зүүн болон хойд хэсгийн хэмжилтийн цэгүүдэд 0.03dS/m орчим бага утга тархсан шинжтэй байна (зураг.40).

Зураг 41. Матад ХХ газрын тосны хайгуулын талбайн хөрсний хялбар уусах давсны агууламж



**Хөрсний ялзмаг:** хөрсний үржил шимийн гол үзүүлэлт бөгөөд хөрсөнд үлдсэн ургамал, амьтны үлдэгдэл бактерийн үйл ажиллагаагаар задарч, хөрсний үе давхаргад хуримтлагдан, ургамлын өсөлт, хөгжилтөнд зарцуулагддаг. Ялзмагийн агууламж нь ургамлын өсөлт хөгжилтөөс гадна хөрсний жижиг хэсгүүдийг хооронд барьцалдуулан, тогтвортой агрегат бүтэц үүсгэх, гадны нөлөөллийг тэсвэрлэх, биологийн идэвхийг нэмэгдүүлэх, агаар-ус солилцоог эрчимжүүлэх, химийн урвалуудад зохицуулагч үүргээр оролцох зэрэг олон үүргийг хавсарч гүйцэтгэдэг онцлогтой. Хөрсний ялзмагийн агууламжийг Олон улсын практикт хөрсний ялзмагийн агууламжаар нь маш бага буюу <1%, бага буюу 1-2%, дунд буюу 2-5%, их буюу >5% гэж хуваан авч үздэг (<https://njaes.rutgers.edu/soil-testing-lab/organic-matter-levels.php>).

Хөрсний мониторингийн шинжилгээг 2024 оны 06-р сар, 2024 оны 10-р саруудад хийгдсэн бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулан тодорхойллоо. Хөрсний ялзмагийн агууламжийн графикаас үзэхэд 20M-S-04, 20M-S-05, 20M-S-09 цэгүүдэд 6-р сарын ялзмагийн агууламж илүү баялаг шинжтэй байгаа бол 10-р сард 20M-S-01 цэгийн хуримтлалын давхарга илүү өндөр агууламжтай байна. хэмжилтийн цэг 20M-S-02, 20M-S-07, 20M-S-08 цэгүүд дээр ялзмагийн агууламж өөрчлөлт байхгүй тогтвортой агууламжтай байна. 2024 оны 6-р болон 10-р сарын биологийн идэвхитэй холбоотой улиралын ялгаатай холбоотойгоор ургамлын үндэсний хөгжилт, органик бодис, биологийн үйл явцтай холбоотой.

График 19. Ялзмагийн агууламж

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**




Матад ХХ талбайн хархүрэн хөрсний ялзмагийн агууламж 1.5% орчим хэлбэлзэх бөгөөд ургамлын нарийн үндэсний бөөгнөрөл бүхий өнгөн үе давхаргуудад үл ялиг нэмэгдэж 1.7% хүрсэн байна. Хархүрэн хөрсний морфологи бүтцээс шалтгаалсан өөрчлөлт сул ажиглагдаж байна ([график.20](#)). Хүрэншороон хөрсний хувьд ялзмагийн хэмжээ 1.12-1.72% хүртэл хэлбэлзэх шинжтэй бөгөөд морфологи бүтцийн шинж чанараас шалтгаалсан өөрчлөлт илрэхгүй шинжтэй байна ([график.21](#)). Хүрэншороон хөрсний хувьд нэг өвслөг ургамлын үндэсний хөгжилтэй холбоотой өнгөн үеүүдэд голчлох ялзмагийн агууламж илэрнэ.


Мараалаг хүрэн хөрсний хувьд ялзмагийн агууламж 1.4% орчим хэлбэлзэх бөгөөд чийгийн горимын хангамжтай холбоотой ургамал бүрхэвчийн нягтшил өндөртэй тул хөрсний өнгөн хэсгийн ялзмагийн агууламж, органик бодисын нөөц баялаг шинжтэй. Иймд мараалаг хүрэн хөрсний ялзмагийн агууламж үе давхаргаас шалтгаалсан өөрчлөлт багатай, тогтмол шинжтэй байна ([график.22](#)). Давсархаг хужирлаг хөрсний Бүрдний голын татмын системтэй холбоотой чийгсэг ургамал болон давссаг ургамлын бүрхэцтэй холбоотой ялзмагийн агууламж 1.1% орчим тогтмол шинжтэй байгаа бөгөөд доод үе давхаргууд руу буурсан шинжтэй байна ([график.23](#)).




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**




*График 20. Хархүрэн хөрсний ялзмагийн агуудамж*



*График 21. Хүрэншороон хөрсний ялзмагийн агуудамж*



*График 22. Мараалаг хүрэн хөрсний ялзмагийн агуудамж*



*График 23. Нуугархаг хүрэн хөрсний ялзмагийн агуудамж*


*График 24. Хужирлаг хөрсний ялзмагийн агуудамж*

Матад ХХ талбайн хөрсний ялзмагийн агууламжийн тархалтын байдлаас үзэхэд голлох өндөр утга нь ухаа гүвээт тал, толгодын бүсийн хар хүрэн хөрсөнд 2.0% орчим хүрэх бол тэгш талархаг газруудаар тархах хүрэн шороон хөрсний хувьд 1.5% утга зонхилсон

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

шинжтэй байна. Бүрдний гол болон давсархаг нуур бүхий хотгоруудад ялзмагийн хэмжээ 1.1% орчим болж буурж байна (зураг.41).

Зураг 42. Матад ХХ газрын тосны хайгуулын талбайн хөрсний ялзмагийн агууламж



**Хөрсний хөдөлгөөнт суурийн нийлбэр ( $K_2O+P_2O_5$ ):** ургамлын өсөлт, хөгжилтөнд шаардлагатай азот, фосфор, кали зэрэг макро элементүүд байгалийн болон ургамлын задралын үйл явцаас хөрсний үе давхаргад хуримтлагддаг. Эдгээрээс калийн исэл ( $K_2O$ ) фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) ургамлын хэрэгцээт макро элементүүдэд авч үзэх бөгөөд хөдөлгөөнт суурийн нэгдэлд хамааруулдаг. Хөрсний фосфорын пентоксидын агууламж <2мг/100гр хэмжээтэй бол бага хангамжтай, 2-4мг/100гр хэмжээтэй бол сайн хангамжтай гэж үнэлдэг бол калийн ионы агууламжын хувьд <10мг-экв/100гр бол бага хангамжтай, 10-20мг-экв/100гр бол сайн хангамжтай гэж үнэлдэг (Guideline for soil description. 2006).

Хөрсний үржил шимийг илтгэгч үзүүлэлт болох хөрсний шингээгдсэн суурь болон хөдөлгөөнт суурийн нийлбэрийн дүнгээс үзэхэд хөрсний хэв шинж, газар ашиглалтаас шалтгаалсан өөрчлөлт сул ажиглагдаж байгаа бөгөөд нугархаг болон мараалаг хөрсний хэв шинжүүдэд үржил шимийн үзүүлэлт нэмэгдсэн шинжтэй байгаа бол хөдөлгөөнт суурийн нийлбэрийн хувьд калийн ислийн хэлбэлзэлтэй холбоотой хөдөлгөөнт суурийн нийлбэр нэмэгдсэн шинжтэй байна.

Шингээгдсэн суурийн нийлбэрийн хувьд хэмжилтийн 20M-S-04 болон 20M-S-07 цэгүүдэд ихээхэн өөрчлөлт илэрсэн байна. Бүс нутгийн зонхилон тархсан хөрсний механик бүрэлдэхүүн болон элсэнцэр хучаас зэрэгтэй холбоотойгоор шингээгдсэн суурийн нийлбэр ихээхэн тогтвортой шинжтэй байгаа бөгөөд мараалаг болон нугархаг зэрэг ойр орчмын газраас нэмэлт чийг хуримтлагдах боломжтой газруудад бага зэрэг өөрчлөлт үүссэн байна. Цэн тогоруу болон Мазаала өрөмдлөгийн цэгүүдийн орчимд техноген нөлөөллөөс үүдэлтэй талхагдал сул ажиглагдаж байна.

Хөдөлгөөнт суурийн нийлбэрийн хувьд 2024 оны 10-р сарын хэмжилтийн дүнг үзэхэд хөдөлгөөнт суурийн нийлбэр 25-35мг/100гр хэлбэлзэх бөгөөд нугархаг, мараалаг хөрсний хэв шинжүүдэд ихээхэн өсөлт ажиглагдаж байна. Д.Батбаяр 1996 (Хээрийн хүрэн хөрсний агрономи) судалгааны бүтээлд “ ...хээрийн хүрэн хөрсний шим тэжээлийн бодисын

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

агууламж хуурай хээрийн экосистем, хур тунадасны нэвчилт, угаагдлын горимтой холбоотой хэлбэлздэг шинжтэй. Ялангуяа зуны улиралд хур борооны дараа хөрсөнд агуулагдах  $P_2O_5$  болон  $K_2O$  зэрэг эрсүүд хур борооны ус нэвчих явцад задарч ургамалд ашиглагдах хэлбэрт шилждэг байна.

График 25. Хөрсний үржил шимийн үзүүлэлтүүд (хөрсний шингээгдсэн суурийн нийлбэр)





График 26. Хөрсний үржил шимийн үзүүлэлтүүд (Хөдөлгөөнт суурийн нийлбэр)



Матад ХХ хайгуулын талбайн хархүрэн хөрсний фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж хэмжилтийн цэгүүдэд дунджаар 1.0мг/кг хэмжээтэй байгаа бөгөөд хөрсний хэмжилтийн цэгүүдэд ихээхэн хэлбэлзэлтэй буюу 0.9-1.8мг/кг хэмжээтэй байна. Хархүрэн хөрсний калийн исэл ( $K_2O$ ) агууламж 18-31мг/кг хүртэл хэлбэлзэх бөгөөд морфологи бүтцийн

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

тархалтын утгаас үзэхэд шилжилтийн В давхаргад голчлох өндөр утга тархах бол зарим хэмжилтийн цэгүүдэд эх чулуулгийн үед хуримтлал үүссэн шинжтэй байна (*график.2 7*). Хүрэн шороон хөрсний хувьд хөрсний өнгөн А давхаргад фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж 3.0мг/кг хүртэл байгаа бол доод үе давхаргуудад буураж 0.6мг/кг хүрсэн байна. Калийн исэл ( $K_2O$ ) агууламж 29-39мг/кг орчим хэлбэлзэх бөгөөд хөрсний шилжилтийн В давхаргад илүү хуримтлагдсан угагдсан шинжтэй байна (*график.28*). Мараалаг хүрэн хөрсний хувьд фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж 1.4-2.5мг/кг орчим хэлбэлзэх бөгөөд ургамлын үндэсний тархалттай холбоотойгоор шим тэжээлийн бодисын хуримтлал ажиглагдаж байна. Калийн исэл ( $K_2O$ ) агууламж 29-33мг/кг орчим хэлбэлзэх бөгөөд өнгөн үед илүү өндөр агууламжтай байна (*график.29*). Нугархаг хөрсний хувьд чийгжилтийн нөлөөгөөр фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж 2.9мг/кг орчим байгаа бол калийн исэл ( $K_2O$ ) агууламж 35мг/кг агууламжтай байна (*график.30*). Давсархаг хөрсний хувьд фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) агууламж 1.5мг/кг орчим байгаа бол калийн исэл ( $K_2O$ ) агууламж 16мг/кг тус тус агууламжтай байна. Давсархаг болон нугархаг хөрсний хувьд ургамлын нарийн үндэс бүхий өнгөн 5см орчим үед голчлох шим тэжээлийн бодис хуримтлагдсан шинжтэй байна (*график.31*).




График 27. Хархүрэн хөрсний хөдөлгөөнт суурь




График 28. Хүрэншороон хөрсний хөдөлгөөнт суурь

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**




График 29. Мараалаг хүрэн хөрсний хөдөлгөөнт суурь




График 30. Нугархаг хүрэн хөрсний хөдөлгөөнт суурь

График 31. Хужирлаг хөрсний хөдөлгөөнт суурь




График 32. Хархүрэн хөрсний шингээгдсэн суурь




График 33. Хүрэншиороон хөрсний шингээгдсэн суурь

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**




График 34. Мараалаг хүрэн хөрсний шингээгдсэн суурь




График 35. Нугархаг хүрэн хөрсний шингээгдсэн суурь

График 36. Хужирлаг хөрсний шингээгдсэн суурь

Матад ХХ талбайн хөрсний шингээгдсэн суурийн хувьд хархүрэн хөрсний хувьд кальцийн агууламж 11мг-экв/100гр орчим хэмжээтэй байгаа бол магнийн агууламж 4мг-экв/100гр хэмжээтэй хэлбэлзэх бөгөөд өнгөн А үед 9.5мг-экв/100гр хүрэх бол эх чулуулгийн С үед 1.6мг-экв/100гр болж буурсан шинжтэй байна (график.32). Хүрэншороон хөрсний хувьд калцийн агууламж 12мг-экв/100гр орчим хэлбэлзэх бөгөөд морфологи бүтцээс шалтгаалсан өөрчлөлт багатай, тогтмол утгатай байгаа бол кальцийн агууламж ургамалын үндэс бүхий өнгөн үед 2.0мг-экв/100гр орчим бага утгатай байгаа бол шилжилтийн ургамлын үндэс бүхий доод үе давхаргуудад 5.0мг-экв/100гр орчим болж нэмэгдэж байна (график.33). Мараалаг хөрсний кальцийн агууламж өнгөн хэсгээс доод үе давхарга руу 1-3.5мг-экв/100гр болж нэмэгдэж байгаа бол магнийн агууламж 2.5мг-экв/100гр орчим дундаж агууламжтай байна (график.34). Нугархаг хүрэн хөрсний кальцийн агууламж 14мг-экв/100гр байгаа бол магнийн агууламж 1.2мг-экв/100гр тус тус агууламжтай байгаа бөгөөд шилжилтийн В давхаргад 7.2мг-экв/100гр тус тус агууламжтай байна (график.35). Давсархаг хөрсний 7.0мг-экв/100гр орчим хэмжээтэй байгаа боловч хар бараан органик бодисын хуримтлал бүхий АВ давхаргад 13мг-экв/100гр хүрч огцом нэмэгдсэн шинжтэй байна (график.36).

**Хөрсний механик бүрэлдэхүүн:** хөрс үүсгэгч эх чулуулгаас өгөршлийн нөлөөгөөр жижиг үйрмэг чулуулаг болон бутардаг. Хөрсний үе давхаргад агуулагдах жижиг ширхэгч фракцуудыг хэмжээгээр ангилдаг бөгөөд олон улсын хэмжээнд элс 2.0-0.05мм, тоос 0.05-0.002мм, шавар <0.002мм тус тус ангилдаг. Хөрсний механик бүрэлдэхүүний ангиллыг Качинскийн боловсруулсан аргазүйгээр үнэлдэг бөгөөд үүнд голлох фракцаар нь бус хөрсний тогтвортой бүтэц үүсгэгч нарийн ширхэгт тоосны фракцын агууламжаар ангилдаг. Нарийн ширхэгт шаврын агууламж 10%-аас бага агууламжтай үед хөнгөн шавранцар

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

ангилалд авч үзэж бол >10% дээш агууламжтай үед шавранцар ангилалд багтаан үздэг (Ө.Бэхтөр, 1964).

Хүснэгт 29. Хөрсний механик бүрэлдэхүүн, 2024 оны 6 сар

Дд	Дээж	гүн, см	Механик бүрэлдэхүүн, %, ширхэгийн хэмжээ-мм						
			1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Хархүрэн хөрс	20M-S-01	0-11	26.8	43.1	11.3	3.3	10.6	5.0	18.8
		12-22	24.1	44.2	12.4	4.0	8.4	6.8	19.3
		23-доош	28.6	49.9	12.6	1.0	5.9	2.0	9.0
	20M-S-03	0-17	17.9	60.6	7.8	3.1	8.1	2.5	13.7
		18-28	19.2	53.4	9.7	2.9	5.0	9.8	17.7
	20M-S-09	0-11	44.6	40.7	6.7	0.2	6.7	1.1	8.0
12-34		25.3	52.9	7.3	2.7	8.0	3.8	14.5	
35-50		28.2	50.3	4.6	5.3	6.3	5.3	16.9	
Хүрэншороон хөрс	20M-S-07	0-14	28.4	49.2	11.8	2.3	3.3	5.0	10.5
		15-30	24.6	46.0	10.8	2.9	9.6	5.6	18.1
		31-70	15.7	47.7	17.0	4.3	9.8	5.5	19.6
	20M-S-08	0-21	22.0	55.9	6.6	2.9	6.9	5.7	15.5
		21-49	33.8	36.0	8.8	3.7	9.6	8.1	21.4
Мараалаг хүрэн	20M-S-01	0-17	27.5	43.7	14.3	3.2	7.0	4.3	14.6
		18-36	26.4	42.8	12.2	3.8	10.1	4.8	18.6
	20M-S-06	0-18	32.5	48.9	6.5	4.2	6.7	1.2	12.1
		19-60	28.5	47.5	9.3	2.7	8.4	3.6	14.7
Нугархаг хүрэн хөрс	20M-S-04	0-18	35.6	35.2	9.9	4.3	8.4	6.6	19.3
		19-33	53.2	14.2	4.4	5.0	17.3	5.9	28.2
Хужир мараа	20M-S-05	0-20	6.2	51.7	12.3	2.6	19.1	8.2	29.8
		21-40	20.7	37.3	10.1	3.4	21.1	7.4	31.9
		40-60	39.6	46.2	3.9	1.3	6.1	2.9	10.3

Хүснэгт 30. Хөрсний механик бүрэлдэхүүн, 2024 оны 9 сар

Дд	Дээж	гүн, см	Механик бүрэлдэхүүн, %, ширхэгийн хэмжээ-мм						
			1.0-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Хархүрэн хөрс	20M-S-01	0-10	35.3	53.9	1.3	2.6	2.7	4.2	9.5
		10-45	29.0	46.9	6.8	4.4	10.3	2.6	17.3
		45-доош	33.3	33.3	8.1	4.8	16.8	3.6	25.2
	20M-S-03	0-17	17.9	60.6	7.8	3.1	8.1	2.5	13.7
		18-28	19.2	53.4	9.7	2.9	5.0	9.8	17.7
	20M-S-09	0-10	34.6	54.4	4.4	2.5	2.9	1.3	6.7
		10-20	36.4	50.6	5.1	3.5	2.8	1.6	7.9
		40-60	27.7	46.6	10.0	3.5	7.5	4.7	15.7
	20M-S-11	0-20	35.3	37.7	11.5	1.9	7.5	6.1	15.5
		20-35	26.5	47.8	6.9	2.3	10.0	6.5	18.8
	20M-S-12	0-45	30.1	36.5	10.9	2.6	16.8	3.2	22.6
		45-доош	31.9	51.2	4.1	2.6	6.1	4.2	12.9
Хүрэншороон хөрс	20M-S-07	0-35	23.3	52.5	11.2	3.3	77.0	2.0	13.0
		35-доош	28.3	43.6	7.2	2.8	13.0	5.1	20.9
	20M-S-08	0-10	22.9	64.0	2.1	4.7	4.3	2.0	11.0

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Мараалаг хүрэн	20M-S-02	10-30	25.1	51.7	8.0	2.5	8.1	4.5	15.1
		0-10	22.8	50.8	9.1	6.8	6.2	4.3	17.3
		10-30	30.3	44.0	8.4	3.1	10.3	4.0	17.4
Мараалаг хүрэн	20M-S-06	0-35	31.2	44.4	3.6	1.8	13.3	5.8	20.9
		35-доош	30.2	45.0	7.9	3.8	11.7	1.5	17.0
Нугархаг хүрэн хөрс	20M-S-04	0-30	33.1	50.3	5.8	3.1	1.3	6.4	10.8
		30-доош	36.4	34.7	4.8	1.4	19.8	2.9	24.1
Хужир мараа	20M-S-05	0-10	36.8	26.4	2.2	4.0	24.5	6.1	34.6
		10-45	56.0	25.8	4.0	4.2	6.2	3.9	14.3
		45-доош	30.2	31.8	2.7	3.1	28.8	3.5	35.4

Лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд хархүрэн хөрсний үе давхарга дахь том ширхэгт элсэн фракц (2.0-0.005мм) агууламж 78% орчим хэлбэлзэх бөгөөд зарим тохиолдолд элсэн хучаастай хэмжилтийн цэгүүдэд 80% дасан байна. Тоос (0.005-0.002мм) агууламж 13% орчим хэлбэлзэх боловч өнгөн үед 6% хүртэл буурах бол шилжилтийн давхаргад 16% хүртэл хэлбэлзэж байна. Шавар (>0.002мм) агууламж 10% давсан шинжтэй байна (график.37). Хүрэн шороон хөрсний хувьд элсэн фракц (2.0-0.005мм) агууламж хөрсний үе давхаргад 70% орчим хэлбэлзэх бол тоос (0.005-0.002мм) агууламж 10-20% ихээхэн хэлбэлзэлтэй байна. Хүрэн хөрсний үе давхаргын тогтоц, хөрсөнд явагдах хими, биологийн үйл явцтай холбоотойгоор хүрэн хөрсөнд шавар үүсэх үйл явц идэвхтэй явагддаг байна (график.38). Мараалаг хүрэн хөрсний хувьд элсэн фракц (2.0-0.005мм) агууламж 80% хүртэл хэлбэлзэх бөгөөд дунджаар 70% орчим агууламжтай байгаа бол тоос (0.005-0.002мм) агууламж 15% орчим хэлбэлзэнэ. Шавар (2.0-0.005мм) агууламж 10% орчим агууламжтай байна (график.39). Нугархаг хөрсний хувьд элсэн фракц (2.0-0.005мм) агууламж 70% хүртэл хэлбэлзэх бөгөөд дунджаар 70% орчим агууламжтай байгаа бол тоос (0.005-0.002мм) агууламж 15% орчим хэлбэлзэнэ. Шавар (2.0-0.005мм) агууламж 20% орчим агууламжтай байна (график.40). Давсархаг хөрсний хувьд элсэн фракц (2.0-0.005мм) агууламж өнгөн үед 60% орчим байх бол гүний элсэнцэр үед 85% хүрнэ. Тоос (0.005-0.002мм) агууламж 14% орчим байгаа боловч гүний үе давхаргуудад 5% буюу шавар үүсэх, хуримтлагдах үйл явц илрэхгүй байна. Шавар (2.0-0.005мм) агууламж 28% хүртэл өндөр агууламжтай байна (график.41).





**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**




График 38. Хүрэншороон хөрсний механик бүрэлдэхүүн




График 39. Мараалаг хүрэн хөрсний механик бүрэлдэхүүн




График 40. Нугархаг хүрэн хөрсний механик бүрэлдэхүүн




График 41. Хужирлаг хөрсний механик бүрэлдэхүүн

**2.6.4. Хөрсөн дэх хүнд металлын агууламж**

Газрын тосны хайгуул, олборлолтын Матад ХХ талбайгаас цуглуулсан өнгөн хөрсний дээжид өргөн тархалттай хүнд элементүүд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr) агууламжийг тодорхойлуулав. Хөрсний хүнд металлын бохирдлыг үнэлэхдээ бохирдлын индекс ашиглан, MNS5850:2019 стандартад заасан хүлцэх агууламжтай харьцуулан тодорхойллоо.

2024 оны 6-р болон 10-р сарын хөрсний мониторингийн хэмжилтийн дүнгээс үзэхэд өргөн тархалттай хүнд элементүүдийн хувьд өөрчлөлт багатай, тогтмол шинжтэй байгаа бөгөөд ялангуяа өрмийн үйл ажиллагаа, хог хаягдлын цэг, засварын цэг зэрэг газруудад бохирдлын нөлөө, ул мөр илрээгүй болно.

2024 оны 6-р болон 10-р сарын мониторингийн хэмжилтээр төслийн талбайд кадмийн агууламж ядуулаг шинжтэй буюу багажны мэдрэг чанарт бүртгэгдэхгүй ядуулаг агууламжтай байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Хүнд элемент тус бүр дээр 2024 оны 6-р болон 10-р саруудад хийгдсэн мониторингийн дүнгээс үзэхэд Ni-ийн агууламж 6-р сард талбайн хувьд 24-33мг/кг байсан бол 10-р сарын дүнд 15-24мг/кг болж буурсан шинжтэй байна.

Хар тугалганы агууламжийн хувьд 2024 оны 6-р болон 10-р сарын хэмжилт бусад хүнд элементийн агууламжтай ойролцоо шинжтэй буюу 21-28мг/кг очрим утга 13-22мг/кг орчим болж буурсан шинжтэй байна.

Цайрын агууламжийн хувьд 2024 оны 6-р сард ойролцоогоор 40-60мг/кг орчим хэлбэлзэж байсан бол 10-р сарын хэмжилтэнд 30-40мг/кг-ийн хооронд болж буурсан шинжтэй байна.

Хромын агууламжийн хувьд өмнөх мониторингийн хэмжилтэнд 35-56мг/кг орчим байгаа боловч 10-р сарын хэмжилтийн дүнд 21-40мг/кг хүртэл агууламж илэрсэн байна.

Зэсийн агууламжийн хувьд өмнөх 2024 оны 6-р сарын хэмжилтээр 21-30мг/кг агууламжтай байсан бол 10-р сарын хэмжилтээр 17-23мг/кг тус тус агууламжтай байсан байна.

Ийнхүү төслийн талбайд хүнд элементийн агууламж буурсан шинж нь хур тунадасны эрчимтэй холбоотойгоор элсэнцэр болон мараалаг хөрсний үе давхарга үе үе нэвт угаагдах чийгийн горим нь шим тэжээлийн болон эрдэс бодисын шилжилт зөөгдөлд нөлөөлсөн байх боломжтой. Үүний зэрэгцээ бүс нугийн уур амьсгалын онцлогтой холбоотойгоор хөрсний гадаргад элсэн хучаас үе үүсэх үйл явц хөрсний чанарт сөрөг нөлөө үзүүлдэг.

Хүснэгт 31. Хүнд металлын агууламж 2024 оны 6 сар

Дд	Дээж	гүн, см	Хүнд металл, мг/кг					
			Никель	Кадми	Хар тугалга	Зэс	Цайр	Хром
1	20M-S-01	0-11	29.7	0	21.6	21.5	64.6	33.4
2	20M-S-05	0-20	24.2	0	24.2	24.3	70.8	38.7
3	20M-S-07	0-14	28.7	0	24.8	22.8	73.2	30.1
4	20M-S-09	0-11	30.4	0	26.1	26.8	62.1	29.7
5	20M-S-10	0-5	30.2	0	24.3	27.7	68.7	56.9
6	Цэн тогоруу-1	0-5	33.4	0	28.4	30.5	71.7	38.2
<b>MNS5850:2019</b>			150	3	100	100	300	150
<b>Шаварлаг</b>			150	1.5	100	100	300	150
<b>Шавранцар</b>			100	1	70	80	150	100
<b>Элсэрхэг</b>			60	3	50	60	100	60

Хүснэгт 32. Хүнд металлын агууламж 2024 оны 9 сар

Дд	Дээж	гүн, см	Хүнд металл, мг/кг						
			Никель	Кадми	Хар тугалга	Зэс	Цайр	Хром	Хүнцэл
1	20M-S-09	0-10	20	0.43	20	19	38.57	19	10
2	20M-S-10	0-10	24	0.43	22	23	36	40	11
3	20M-S-11	0-10	22	0.43	13	20	42	19	10
4	20M-S-12	0-10	23	0.43	17	20	35	27	10
5	20M-S-07	0-10	18	0.43	17	18	31	37	11

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

6	20M-S-05	0-10	15	0.43	15	13	36	21	7
7	20M-S-01	0-10	18	0.43	19	17	68.7	21	10
<b>MNS5850:2019</b>			<b>150</b>	<b>3</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>300</b>	<b>150</b>	<b>20</b>
<b>Шаварлаг</b>			150	1.5	100	100	300	150	15
<b>Шавранцар</b>			100	1	70	80	150	100	10
<b>Элсэрхэг</b>			60	3	50	60	100	60	20

Хөрсний бохирдлын зэргийн индекс ашиглан хэмжилтийн цэгүүдэд бохирдлын коэффициент буюу хүлцэх агууламжаас хэтэрсэн буюу бохирдолтой цэгийг илрүүлэх тооцооллыг гүйцэтгэсэн. Хөрсний бохирдлын индексээс үзэхэд Матад ХХ талбайн хүрээнд хүнд металлын бохирдлын индексийн утга нийт элементийн утга 2 буюу хүлцэх агууламжаас давсан утга илрээгүй буюу бохирдолгүй байна.


Хүснэгт 33. Бохирдлын индекс

Гүн, см	Хүнд металл мг/кг					
	Ni	Cd	Pb	Cu	Zn	Cr
<b>20M-S-01</b>	1.2	1.0	1.2	1.2	1.2	1.2
<b>20M-S-05</b>	1.2	1.0	1.2	1.2	1.2	1.3
<b>20M-S-07</b>	1.2	1.0	1.2	1.2	1.2	1.2
<b>20M-S-09</b>	1.2	1.0	1.3	1.3	1.2	1.2
<b>20M-S-10</b>	1.2	1.0	1.2	1.3	1.2	1.4
<b>Цэн тогоруу-1</b>	1.2	1.0	1.3	1.3	1.2	1.3

**Хөрсөн дэх никелийн агууламж**

Хүнд элемент тус бүр дээр 2024 оны 6-р болон 10-р саруудад хийгдсэн мониторингийн дүнгээс үзэхэд Ni-ийн агууламж 6-р сард талбайн хувьд 24-33мг/кг байсан бол 10-р сарын дүнд 15-24мг/кг болж буурсан шинжтэй байна.

График 42. Хөрсөн дэх никелийн агууламж




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

**Хөрсөн дэх хар тугалганы агууламж**

Хар тугалганы агууламжийн хувьд 2024 оны 6-р болон 10-р сарын хэмжилт бусад хүнд элементийн агууламжтай ойролцоо шинжтэй буюу 21-28мг/кг очрим утга 13-22мг/кг орчим болж буурсан шинжтэй байна.


График 43. Хөрсөн дэх хар тугалганы агууламж



**Хөрсөн дэх цайрын агууламж**

Цайрын агууламжийн хувьд 2024 оны 6-р сард ойролцоогоор 40-60мг/кг орчим хэлбэлзэж байсан бол 10-р сарын хэмжилтэнд 30-40мг/кг-ийн хооронд болж буурсан шинжтэй байна.

График 44. Хөрсөн дэх цайрын агууламж




**Хөрсөн дэх хромын агууламж**

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Хромын агууламжийн хувьд өмнөх мониторингийн хэмжилтэнд 35-56мг/кг орчим байгаа боловч 10-р сарын хэмжилтийн дүнд 21-40мг/кг хүртэл агууламж илэрсэн байна.


График 45. Хөрсөн дэх хромын агууламж



**Хөрсөн дэх зэсийн агууламж**

Зэсийн агууламжийн хувьд өмнөх 2024 оны 6-р сарын хэмжилтээр 21-30мг/кг агууламжтай байсан бол 10-р сарын хэмжилтээр 17-23мг/кг тус тус агууламжтай байсан байна.

График 46. Хөрсөн дэх зэсийн агууламж




**Хөрсөн дэх хүнцлийн агууламж**

Матад ХХ хайгуулын талбайн хөрсөнд болон Монгол улсын зүүн бүсийн хөрсөнд хүнцэл (As) ихээхэн хэлбэлзэх бөгөөд О.Батхишиг нар 2012 судалгааны тайланд зүүн бүсийн хөрсний хүнцлийн суурь агууламж 17-36мг/кг орчим хэлбэлзэх бөгөөд энэхүү агууламж нь бүс нутгийн хөрс үүсгэгч эх чулуулаг болон хөрсөн явагдах төмрийн FeO<sub>3</sub> ислийн задралтай холбон үзсэн байна. Сүүлийн жилүүдэд давсархаг нуур болон чийглэг хөрсөнд

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

хүнцэл (As) агууламж ихээхэн хэлбэлзэж байгаа бөгөөд байгалийн хүнцлийн эх үүсвэрт одоогоор дөрөвдөгчийн залуу боржин болон эртний далай тэнгисийн үлдмэл цав хурдсуудыг хамаатуулж үзэж байна. Иймд цаашид төслийн талбайд мараалаг болон эртний үлдмэл цав хэлбэрийн хөрсний ашиглалтыг бууруулах, бүс нутгийн хэмжээнд хотгоруудад илэрдэг мараалаг, нугархаг хөрсний хэв шинжүүдэд ашиглалтыг бууруулах нь илүү үр ашигтай гэж үзэж байна.


График 47. Хөрсөн дэх хүнцэлийн агууламж



**Хөрсөн дэх никелийн агууламж**

Хүнд элемент тус бүр дээр 2024 оны 6-р болон 10-р саруудад хийгдсэн мониторингийн дүнгээс үзэхэд Ni-ийн агууламж 6-р сард талбайн хувьд 24-33мг/кг байсан бол 10-р сарын дүнд 15-24мг/кг болж буурсан шинжтэй байна.

График 48. Хөрсөн дэх никелийн агууламж



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

**2.6.5. Хөрсөн дэх микробиологийн агууламж**

Хөрсний нянгийн бохирдлын түвшинг үнэлэхэд хүн болон амьтны гаралтай гэдэсний бүлгийн эмгэг төрөгч бактери (*Salmonella*) болон савханцрууд (*E.Coli*), агааргүй орчинд үрждэг (*Cl. perfringens*) анаэроб бактери гэсэн гурван үзүүлэлтүүдийг нянгийн бохирдлын ерөнхий үнэлгээний үзүүлэлт болгон ашигладаг. Хөрс өвчин үүсгэгч бактериар бохирдох нөхцөл, эх сурвалж нь тухайн өвчнөөр өвчилсөн амьтны ялгадас болон сэг зэм, өвчин тээгч хүний ялгадас зэргээр шууд болон усаар дамжин хөрсөнд ордог. Матад ХХ талбайн хувьд цаашид ажилчид оршин суух учир хөрсний нянгийн суурь түвшинг үнэлэх зорилгоор өнгөн хөрсний дээжид нянгийн агууламжийг тооцоолсон. Судалгааны талбайн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор төслийн нөлөөлөлд өртөх талбайн хүрээнд хэмжилтийн цэгээс өнгөн хөрсний дээж цуглуулан, нянгийн шинжилгээнд хамруулсан.

Лабораторийн шинжилгээний дүнгээс үзэхэд хэмжилтийн цэгүүдэд нийт нянгийн тоо  $2.7-4.4 \cdot 10^4$ , *E Coli* гэдэсний савханцар, *Cl. Perfingers* анаэробын титр  $>0.4$  орчим агууламжтай буюу бохирдлын түвшин цэвэр буюу бохирдолгүй байгаа бол Хогийн цэг 20M-S-10 хэмжилтийн цэгт нийт нянгийн тоо  $6.4 \cdot 10^5$ , *E Coli* гэдэсний савханцар илэрсэн буюу өвчин үүсгэгч савханцраар бага зэрэг бохирдсон байсан бол 9 сард очсон судалгаагаар бүх цэгүүдэд гэдэсний савханцар, нян, анаэробын титр аль нь ч илрээгүй цэвэр байсан (хүснэгт 33, 34). Энэ нь 6 сард хогийн цэг орчим мал амьтан үхсэн сэг зэмийг хаясан нь бүрэн задралд ороогүй нян илэрч байсан бол 9 сард талбайд байсан бүх сэг зэм бүрэн задралд орж байхгүй байгаатай холбоотой гэж таамаглаж байна.

Хүснэгт 34. Хөрсөн дэх гэдэсний өвчин үүсгэгч нян, бактери

ID	Дээж	Нянгийн тоо		Гэдэсний савханцарын титр (E.Coli)		Анаэробын титр (Cl.Perfringens)	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	
1	20M-S-01	$4.4 \cdot 10^4$	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
2	20M-S-05	$2.7 \cdot 10^5$	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
3	20M-S-07	$3.2 \cdot 10^5$	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
4	20M-S-09	$2.8 \cdot 10^5$	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр	
5	20M-S-10	$6.4 \cdot 10^5$	1.0	Бага зэрэг бохирдолтой	0.1<	Цэвэр	

Хөрсний мониторингийн шинжилгээний биологийн дүнгээс үзэхэд 2024 оны 10-р сарын хэмжилтийнц цэгүүдэд нийт нянгийн тоо  $1.5-4.0 \cdot 10^4$ , *E Coli* гэдэсний савханцар, *Cl. Perfingers* анаэробын титр 1.0 орчим агууламжтай буюу бохирдлын түвшин цэвэр байна. Агааргүй орчинд үрждэг *Cl. Perfringens* бактери төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй талбайд  $<0.1$  хэмжээтэй буюу цэвэр түвшинд байна

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Хүснэгт 34. Хөрсөн дэх гэдэсний өвчин үүсгэгч нян, бактери (2024 оны 9 сар)

ID	Дээж	Нянгийн тоо			Гэдэсний савханцарын титр (E.Coli)		Анаэробын титр (Cl.Perfringens)	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг		
1	20M-S-01	4.0*10 <sup>4</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр		
2	20M-S-05	2.2*10 <sup>5</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр		
3	20M-S-07	1.5*10 <sup>5</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр		
4	20M-S-10	3.1*10 <sup>5</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр		
5	20M-S-11	4.4*10 <sup>5</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр		
6	20M-S-12	2.5*10 <sup>5</sup>	1.0	Цэвэр	0.1<	Цэвэр		

**Гэдэсний савханцрын нян:** Матад ХХ талбайн хөрсний нийт мониторинг цэгүүдэд нянгийн бохирдлын үзүүлэлт илрэхгүй байгаа бөгөөд 2024 оны 6-р сарын хэмжилтэнд Цэн тогоруу кемп орчмын 20M-S-10 хэмжилтийн цэгт нийт нянгийн тоо  $2.8 \times 10^7$ , *E Coli* гэдэсний савханцар  $>0.4$  хэмжээтэй илэрсэн байна (хүснэгт.1). Хайгуулын өрөм болон ажилчидын үйл ажиллагаатай холбоотой бохирдол үүсэх эрсдэлтэй тул төвлөрсөн хогын цэг багуулах, бохирын цэг- нүхэн жорлон (MNS5924:2015) стандартын дагуу байгуулах, ариутгал, халдваргүйжүүлэлтэд шинэ технологи, био бэлдмэлийг зохих стандартын дагуу устгал, ариутгал хийх зэрэг ажлуудыг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган, холбогдох зардал, төлөвлөгөөг хийх хэрэгтэй. 2024 оны 10-р сарын мониторингийн хэмжилтэнд нянгийн бохирдол илрээгүй болно (хүснэгт.34).

**Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян:** Хөрсний мониторинг цэгүүдэд гэдэсний бүлгийн эмгэг төрөгчийн нян илрээгүй, төслийн талбай болон хайгуулын өрмийн цэг орчимд органик болон хүн амьтны гаралтай ялгадас, материалаар бохирдоогүй байна үзэж болох юм.

### 2.6.6. Хөрсөн дэх нефт бүтээгдэхүүн

Матад ХХ талбайн Цэн тогоруу-1, Цагаан зээр-1, Замын уулзвар гэсэн 3 цэгээс хөрсний нефт бүтээгдэхүүний шинжилгээг авч Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид шинжлүүлсэн.

Хөрсөнд дэх нефть, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээг нийт хөрсний мониторингийн цэгүүдэд хийлгэсэн бөгөөд нефтийн бүтээгдэхүүн ямар нэгэн хэмжээгээр илрээгүй болно. Нефтийн бохирдлын зэргийг тодорхой заагдсан бүс нутаг дахь бохирдоогүй “эрүүл” хөрсний фон утгатай харьцуулан авч үнэлгээ хийж гүйцэтгэдэг. Монгол улсын хөрсний бохирдлын стандарт, хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850-2019 стандартад газрын тосны бүтээгдэхүүний хүлцэх агууламжийг 2.0г/кг гэж заасан байдаг. ОХУ-ын “Росгидромета”-гаас боловсруулсан арга зүйн зөвлөмжинд нефть олзворлодоггүй газруудад хөрсөн дэх нефть бүтээгдэхүүний фон /эрүүл хөрсний/ агуулга 40 мг/кг, нефть олзворлодог районд 100 мг/кг байхаар тогтоосон байна. Матад ХХ хайгуулын талбайн хөрсний мониторингийн хэмжилтэнд нефтийн бүтээгдэхүүний үлдэгдэл 0.1-0.4гр/кг орчим буюу хүлцэх



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

агууламжаас хэтрээгүй байна. Олон улсын түвшинд хөрсөн дэхь нефтийн үлдэгдлийг 100-500мг/кг байгаа тохиолдолд эрүүл хөрсний фон утга гэж үздэг байна.

*Хүснэгт 35. Нефт бүтээгдэхүүний дээж авсан хөрсний цэгийн байршил*

Цэгийн дугаар	Талбай	Хөрсний төрөл	Газарзүйн байршил	
			Өргөрөг	Уртраг
20M-S-01	Цэн тогоруу-1	Хар хүрэн хөрс	46° 49' 52.7"	116° 08' 35.73"
20M-S-07	Цагаан зээр-1	Хүрэн шороон хөрс	46° 49' 28.42"	116° 06' 43.4"
20M-S-09	Замын уулзвар	Хар хүрэн хөрс	46° 49' 06.29"	116° 06' 24.31"
20M-S-11	Цэн тогоруу-2	Хар хүрэн хөрс	46° 49' 16.53"	116° 07' 26.67"
20M-S-12	Мазаалай-1	Хар хүрэн хөрс	46° 49' 9"	115° 58' 50"

Хөрсний шинжилгээний хариунаас харахад хөрсөнд агуулагдах нефт бүтээгдэхүүний агууламж 20M-S-01 цэгт 6-р сард 0.7 гр/кг, 9-р сард 0.1 гр/кг, 20M-S-07 цэгт 6-р сард 0.2 гр/кг, 9-р сард 0.1 гр/кг, 20M-S-09 цэгт 6-р сард 0.2 гр/кг, 9-р сард 0.3 гр/кг, 20M-S-11 цэгт 9-р сард 0.3 гр/кг, 20M-S-12 цэгт 9-р сард 0.4 гр/кг, байгаа нь MNS5850:2019 стандартад заасан хөрсөнд агуулагдах газрын тосны бүтээгдэхүүний хүлцэх агууламж 2 гр/кг-аас хэтрээгүй байна.

*Хүснэгт 36. Хөрсөн агуулагдах газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээ*

Цэгийн дугаар	Талбай	Нефт бүтээгдэхүүн гр/кг		MNS5850:2019 стандарт	
		2024 он 6 сар	2024 он 9 сар	Хүлцэх агууламж	Хортой агууламж
<b>20M-S-01</b>	Цэн тогоруу-1	0.7	0.1	2.0	8.0
<b>20M-S-07</b>	Цагаан зээр-1	0.2	0.1		
<b>20M-S-09</b>	Замын уулзвар	0.2	0.3		
<b>20M-S-11</b>	Цэн тогоруу-2	-	0.3		
<b>20M-S-12</b>	Мазаалай-1	-	0.4		

Хэрэв хөрс нефт бүтээгдэхүүнээр бохирдсон бол хөрсийг бохирдлоос цэвэрлэх тусгай арга хэмжээнүүдийг хөрсний бохирдлын түвшин их (10000-50000 мг/кг) буюу маш их бохирдолтой (>50000 мг/кг) байх тохиолдолд хөрс сайжруулах арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай. Хөрс болон газрын гүн дэх бохирдсон усыг цэвэрлэх арга технологийг сонгон явуулж бохирдлыг цэвэрлэсний дараа бохирдлын түвшинг заавал байгалийн “фон” хэмжээнд хүртэл цэвэрлэх боломжгүй юм. Иймээс хөрсөн дэх үлдэгдэл бохирдуулагчийн хортой агууламжийг 1000-1500 мг/кг, усанд 1,0-1,5 мг/л хүртэл бууруулахад цаашид хөрс өөрөө аяндаа байгалийнхаа хүчин зүйлийн нөлөөгөөр хүний хяналтан дор бүрэн цэвэрших боломжтой гэж үздэг. Дэлхийн зарим улс орнуудад хийсэн судалгаанаас харахад хөрсний

## Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

бохирдлын түвшин 5000-10000 мг/кг –ийн хязгаарт байх тохиолдолд хөрсийг цэвэрлэж нөхөн сэргээх арга хэмжээг авах зайлшгүй авах шаардлагатай гэж үздэг байна

### 2.6.7. Хөрсний цацраг идэвх

Матад ХХ талбайн цацрагийн дэвсгэр түвшин тогтоох зорилгоор сонгосон цэгүүдээс авсан хөрсний дээж дэх байгалийн ба үүсмэл цацраг идэвхт изотопуудын бүрэлдэхүүн, тэдгээрийн хувийн идэвхийг гамма спектрометрээр тодорхойлов. Тухайн төслийн талбайгаас авсан хөрсний дээжид цацраг идэвхт элементүүдийн хувийн идэвхийг тодорхойлох хэмжилтэд өндөр ялгах чадвартай цэвэр хагас дамжуулагч германи детектор, 4096 сувагтай анализатор бүхий гамма спектрометр ашигласан.

Талбайн хөрсний 6 цэгээс хөрсний 5 см гүн, 15 см x15 см талбайгаас хөрсний дээж авав. Дээжээ детекторт углаж ордог 700 см<sup>3</sup> эзлэхүүнтэй Маринеллийн саванд хийж, түүнийг 1 цаг хэмжив. Гамма спектрометр гаргаж авсан гамма спектрээс хөрсөн дэх цацраг идэвхт изотопуудын хувийн идэвхийг бүрэн шингээлтийн пикийн талбайгаар олохдоо дараах томъёог ашигласан. (Норов Н, Даваа С, Шагжамба Д, МУИС Эрдэм шинжилгээний бичиг №5 138 х.19-26, 1998)

$$A = \frac{N(E_i)}{k \cdot \varepsilon_0(E) \cdot k_\gamma \cdot m \cdot t}$$

Үүнд: А- изотопын хувийн идэвх (Бк/кг);

N(E)- гамма квантын бүрэн шингээлтийн пикийн талбай;

k<sub>γ</sub>- гамма квантын гаралт

ε<sub>0</sub>(E)- усны хувьд (ρ=1г/см<sup>3</sup>) олсон детекторын үнэмлэхүй бүртгэх чадвар;

k- дээжид гамма квантын сулралтыг тооцсон тогтмол (туршлагаар тодорхойлсон)

m - дээжний жин (кг)

t - хэмжсэн хугацаа (с).

Цөмийн зэвсгийн ил туршилт хийж байсан үед агаар мандалд хаягдаж, улмаар газрын хөрсөнд бууж хуримтлагдсан <sup>137</sup>Cs-ийн хувийн идэвхийг тодорхойлов. Хөрсөн дэх <sup>226</sup>Ra-ийн хувийн идэвхийг байгалийн цацраг идэвхт <sup>238</sup>U-ын бүлийн изотопуудын үүсгэх шугамуудаас хамгийн эрчимтэй 609.31кэВ (<sup>214</sup>Pb) шугамаар нэлээд нарийн тодорхойлогдоно.

<sup>232</sup>Th-ийн хувийн идэвхийг тодорхойлохдоо 583,19 кэВ (<sup>208</sup>Tl), 911,16 кэВ (<sup>228</sup>Ac) энергитэй гамма туяаг бүртгэсэн. <sup>40</sup>K, <sup>137</sup>Cs изотопуудын хувийн идэвхийг тэдгээрийн 1460.75 кэВ, 661.66 кэВ энергитэй гамма цацрагийн шугамуудаар тодорхойлов.

Байгалийн цацрагийн дэвсгэр түвшин дараах 3 хүчин зүйлсээс бий болно. (Белозерский Н.Г. , 2008) Үүнд:

1. Сансрын туяа
2. Дэлхийн царцдас, хөрс, агаар, ус болон байгалийн бусад зүйлд агуулагдах цацраг идэвхт нуклидуудаас цацрах төрөл бүрийн цацраг.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

3. Дэлхийн гадарга дээр ил цөмийн зэвсгийн туршилт хийх үед болон цөмийн түлшний циклийн ослын үед гадаад орчинд хаягдах үүсмэл цацраг идэвхт нуклидаас цацрах цацраг зэрэг болно.

*Хүснэгт 37. Цацрагийн дээж авсан хөрсний цэгийн байршил*

Цэгийн дугаар	Талбай	Хөрсний төрөл	Газарзүйн байршил	
			Өргөрөг	Уртраг
20M-S-01	Цэн тогоруу-1	Хар хүрэн хөрс	46° 49' 52.7"	116° 08' 35.73"
20M-S-07	Цагаан зээр-1	Хүрэн шороон хөрс	46° 49' 28.42"	116° 06' 43.4"
20M-S-09	Замын уулзвар	Хар хүрэн хөрс	46° 49' 06.29"	116° 06' 24.31"
20M-S-10	Хогийн цэг	Хар хүрэн хөрс	46° 49' 52.71"	116° 08' 37.52"
20M-S-11	Цэн тогоруу-2	Хар хүрэн хөрс	46° 49' 16.53"	116° 07' 26.67"
20M-S-12	Мазаалай-1	Хар хүрэн хөрс	46° 49' 9"	115° 58' 50"

Тус тусгай зөвшөөрлийн талбайгаас авсан хөрсний дээжид байгалийн болон үүсмэл цацраг идэвхт изотопуудын хувийн идэвхийг гамма спектрометрийн аргаар тодорхойлсон дүнг 10-р хүснэгтэд үзүүлэв. Төслийн талбайн хөрсөн дэх үүсмэл цацраг идэвхт <sup>137</sup>Cs-ийн хувийн идэвх, байгалийн цацраг идэвхт элементүүдийн агуулалт, хөрсөнд агуулагдах байгалийн цацраг идэвхт элементүүдийн хувийн идэвхийн хэмжээг ашиглан газрын хөрснөөс 1 м өндөрт агаарт шингэсэн цацрагийн тунгийн чадлыг дараах томъёогоор тооцно. (Норов Н, Даваа С, Шагжамба Д, МУИС Эрдэм шинжилгээний бичиг №5 138 х.19-26, 1998)

$$P=0,427A_U +0,662 A_{Th}+0.043 \cdot A_K$$

Үүнд: P – шингэсэн цацрагийн тунгийн чадал (нГр/цаг);

$A_U, A_{Th}, A_K$  – <sup>238</sup>U, <sup>232</sup>Th, <sup>40</sup>K-ийн хувийн идэвх (Бк/кг).

*Хүснэгт 38. Талбайн хөрсний дээжийн цацраг идэвхт изотопуудын хувийн идэвх, элементийн агуулалт, агаарт шингэсэн цацрагийн тунгийн чадал (2024 оны 6 сар)*

№	Дээжийн дугаар	Изотопын идэвх, Бк/кг				Элементийн агуулалт			Радийн эквивалент, Бк/кг
		<sup>226</sup> Ra	<sup>232</sup> Th	<sup>40</sup> K	<sup>137</sup> Cs	U, г/т	Th, г/т	K, %	
1	20M-S-01	17	14	804	6	1.4	3.5	2.7	50
2	20M-S-07	15	11	787	2	1.2	2.7	2.6	46
3	20M-S-09	15	12	768	<1.1	1.2	3.0	2.6	46
4	20M-S-10	24	11	678	5	1.9	2.7	2.3	46
Дундаж		17.75	12	759.25	4.33	1.425	2.975	2.55	
Дэлхийн дундаж		25[1]	25[1]	370[1]	7.9[2]	2.0	5.2	1.2	

(United Nations Scientific Committee on the Effects of the Atomic Radiation Report, 1993)

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

6 сард хийсэн хөрсний дээж дэх байгалийн цацраг идэвхт элемент ураны дундаж агуулалт 1.2-1.9 г/т, торын дундаж агуулалт 2.9 г/т байгаа нь дэлхийн дунджаас бага, калийн дундаж агуулалт 2.5% байгаа нь дэлхийн дунджаас 2 дахин их байна.

*Хүснэгт 40. Талбайн хөрсний дээжийн цацраг идэвхт изотопуудын хувийн идэвх, элементийн агуулалт, агаарт шингэсэн цацрагийн тунгийн чадал (2024 оны 9 сар)*

№	Дээжийн дугаар	Изотопын идэвх, Бк/кг				Элементийн агуулалт			Радийн эквивалент, Бк/кг
		<sup>226</sup> Ra	<sup>232</sup> Th	<sup>40</sup> K	<sup>137</sup> Cs	U, г/т	Th, г/т	K, %	
1	20M-S-01	13	12	736	2	1.0	3.0	2.5	44
2	20M-S-05	17	11	625	3	1.4	2.6	2.1	40
3	20M-S-07	12	13	735	<1.1	1.0	3.2	2.5	44
4	20M-S-09	12	11	792	<1.1	1.0	2.7	2.6	46
5	20M-S-10	26	15	800	3	2.1	3.7	2.7	54
6	20M-S-11	18	13	667	4	1.5	3.1	2.2	44
Дундаж		16.33333	12.5	725.833	3	1.333	3.05	2.433	
Дэлхийн дундаж		25[1]	25[1]	370[1]	7.9[2]	2.0	5.2	1.2	

9 сард хийсэн хөрсний дээж дэх байгалийн цацраг идэвхт элемент ураны дундаж агуулалт 20M-S-01, 20M-S-05, 20M-S-07, 20M-S-09, 20M-S-10 цэгүүд дээр 1.0-1.5 г/т байгаа нь дэлхийн дундаж 2.0 г/т гэж зааснаас бага байгаа бол 20M-S-10 буюу Цэн тогоруу-2 талбай дээр 2.1 г/т байгаа нь дэлхийн дундаж агууламжаас 0.1-ийн агууламжаар их байна, торын дундаж агуулалт 2.6-3.7 г/т байгаа нь дэлхийн дунджаас бага, калийн дундаж агуулалт 2.4 % байгаа нь дэлхийн дунджаас 2 дахин их байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 39. хөрсний хяналт шинжилгээний үр дүн

Утга	Хөрсний мониторингийн цэгийн дугаар	Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-1 /2024.06.08/	Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-2 /2024.09.08/
БОХШХ-ГЗ: Хөрсөн бүрхэвч	20М-S-01	<p>“Цэн Тогоруу-1” талбайн хэмжилтийн цэг-1 талбайд сайргархаг хүрэн хөрсний хувьд сийрэг нийцтэй, элсэн хучаас үе, бараандуу өнгөтэй ялзмаг хуримтлалын давхарга, шиилжилтийн АВ давхарга тус тус ялгарна. Хэмжилтийн цэгийн хөрсний үе давхаргад хөрсний хучаас сийрэг элсэн хуус үед шим тэжээлийн болон эрдэс бодисын агууламж байгаа боловч ялзмагийн А болон шилжилт хуримтлалын АВ үед угаagdлын нөлөөгөөр бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна.</p>	
		<p>Ялзмагийн агууламж хучаас үед 0.7% байгаа бол А үед 0.6%, АВ үед 1.5% тус тус агууламжтай байна. Шингээгдсэн суурийн нийлбэр 14-22мг-экв/100гр хэлбэлзэж, хөрсний үе давхаргад кальцийн ион давамгайлсан шинжтэй байна. Хөдөлгөөнт суурийн нийлбэр 18-25мг/100гр байгаа бөгөөд калийн ион давамгайлсан шинжтэй байна. Хөрсний урвалын орчин 8.13-8.81 орчим сул шүлтлэг, хүчтэй шүлтлэг шинжтэй, өнгөн болон А давхаргын карбонатын хуритлал 2.64-5.93% орчим илрэх бол АВ үед илрэхгүй. Хялбар уусах давсны агууламж 0.04dS/m орчим ядуулаг шинжтэй байгаа бол хуурай давсны үлдэгдэл 0.08% хэмжээтэй байна.</p> <p>Физик шинж чанар: хөрсний үе давхаргын ширхгийн бүрэлдэхүүний хувьд том ширхэгт элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 68-78% хэмжээтэй эрс давамгайлсан шинжтэй байгаа бол тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 16.4%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь өнгөн үед 15%, А үед 15%, АВ үед 8% болж тус тус нэмэгдсэн шинжтэй байна. Тухайн хэмжилтийн цэг нь механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: хэмжилтийн цэгийн хувьд никел (Ni) 29.7мг/кг, кадми (Cd) агууламж багажийн мэдрэг чанарт бүртгэгдэхгүй бага агууламжтай, хар тугалга (Pb) 21.6мг/кг, цайр (Zn) 64.6мг/кг, хром (Cr) 33.4мг/кг, зэс (Cu) 21.5мг/кг тус тус агууламжтай байна. Эдгээр агууламжууд нь Монгол орны стандарт MNS5850:2008-д</p>	<p>Ялзмагийн агууламж хучаас үед 1.0% байгаа бол А үед 08%, АВ үед 2.4% тус тус агууламжтай байна. Шингээгдсэн суурийн нийлбэр 15-19мг-экв/100гр хэлбэлзэж, хөрсний үе давхаргад кальцийн ион давамгайлсан шинжтэй байна. Хөдөлгөөнт суурийн нийлбэр 13-15мг/100гр байгаа бөгөөд калийн ион давамгайлсан шинжтэй байна. Хөрсний урвалын очрин 8.7-9.5 орчим сул шүлтлэг, хүчтэй шүлтлэг шинжтэй, зөвхөн АВ шилжилтийн давхаргад карбонатын хуримтлал 5.7% орчим илрэх бол өнгөн үед илрэхгүй. Хялбар уусах давсны агууламж 0.02dS/m орчим ядуулаг шинжтэй байгаа бол хуурай давсны үлдэгдэл 0.03% хэмжээтэй байна.</p> <p>Физик шинж чанар: хөрсний үе давхаргын ширхгийн бүрэлдэхүүний хувьд том ширхэгт элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 75-89% хэмжээтэй эрс давамгайлсан шинжтэй байгаа бол тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 11.3%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь өнгөн үед 6%, А үед 12%, АВ үед 20% болж тус тус нэмэгдсэн шинжтэй байна. Тухайн хэмжилтийн цэг нь механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: хэмжилтийн цэгийн хувьд никел (Ni) 18мг/кг, кадми (Cd) агууламж багажийн мэдрэг чанарт бүртгэгдэхгүй бага агууламжтай, хар тугалга (Pb) 15мг/кг, цайр (Zn) 68.7мг/кг, хром (Cr) 21мг/кг, зэс (Cu) 17мг/кг, хүнцэл (As) 10мг/кг тус тус агууламжтай байна. Эдгээр агууламжууд нь Монгол орны стандарт MNS5850:2008-д</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдол үүсээгүй байна.	заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдол үүсээгүй байна.
20M-S-02	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 1.4% орчим хэлбэлзэх бөгөөд карбонатын агууламж илрэхгүй. Ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурь (<math>P_2O_5+K_2O</math>) -ийн нийлбэрт 32мг/100 гр хүрэх бөгөөд калийн ион илт давамгайлна. Солилцох суурийн (Ca+Mg) нийлбэр 16экв-мг/100 гр байх бөгөөд кальцийн ион 15мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Хөрсний урвалын орчин 7.8 шүлтлэг шинжтэй байгаа ба хялбар уусах давсны агууламж 0.065ds/m байна.</p> <p>Физик шинж чанар: хэмжилтийн цэгт механик бүрэлдэхүүний хувьд дунд шавранцар шинжтэй байна. Элсэн (2.0-0.05 мм) хэсгийн эзлэх хувь 71%, тоос (0.05-0.002 мм)-ны агууламж эзлэх хувь 17%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 11% тус тус хэмжээтэй байна. Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.</p>	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 0.1.4% орчим хэлбэлзэх бөгөөд карбонатын агууламж илрэхгүй. Ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурь (<math>P_2O_5+K_2O</math>) -ийн нийлбэрт 15мг/100 гр хүрэх бөгөөд калийн ион илт давамгайлна. Солилцох суурийн (Ca+Mg) нийлбэр 21экв-мг/100 гр байх бөгөөд кальцийн ион 20мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Хөрсний урвалын орчин 8.9 шүлтлэг шинжтэй байгаа ба хялбар уусах давсны агууламж 0.031ds/m байна.</p> <p>Физик шинж чанар: хэмжилтийн цэгт механик бүрэлдэхүүний хувьд дунд шавранцар шинжтэй байна. Элсэн (2.0-0.05 мм) хэсгийн эзлэх хувь 74%, тоос (0.05-0.002 мм)-ны агууламж эзлэх хувь 15%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 10% тус тус хэмжээтэй байна. Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.</p>
20M-S-03	<p>Хими шинж чанар: хөрсний ялзмагийн бодисын агууламж 1.5% байгаа бөгөөд хөдөлгөөнт суурийн (<math>P_2O_5 +K_2O</math>)-ийн нийлбэр 26.8-32.9мг/100гр орчим хэлбэлзэж, шингээгдсэн суурийн нийлбэр Ca+Mg 15.8-16мг-экв/100гр тус тус агууламжтай байна. Хөрсний үе давхаргад карбонат илрээгүй. Хөрсний урвалын орчин рН=7.4 буюу шүлтлэг шинжтэй, хялбар уусах давсны агууламж 0.039ds/m ядуулаг шинжтэй байна.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 72-78%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 11%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 10% тус тус агууламжтай байна. Тухайн талбайн механик бүрэлдэхүүний хувьд дунд шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.</p>	<p>Хими шинж чанар: хөрсний ялзмагийн агууламж өнгөн үед 1.13%, АВ үед 0.25% хүртэл буураж байгаа бөгөөд хөдөлгөөнт суурийн (<math>P_2O_5 +K_2O</math>)-ийн нийлбэр 13-17мг/100гр орчим хэлбэлзэж, шингээгдсэн суурийн нийлбэр Ca+Mg 15-17мг-экв/100гр тус тус агууламжтай байна. Хөрсний үе давхаргад карбонатын агууламж А үед 4.45%, АВ үед 2.3% тус тус агууламжтай байна. Хөрсний урвалын орчин рН=9.4 буюу шүлтлэг шинжтэй, хялбар уусах давсны агууламж 0.02ds/m ядуулаг шинжтэй байна.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 71-80%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 11%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 13% тус тус агууламжтай байна. Тухайн талбайн механик бүрэлдэхүүний хувьд дунд шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

20M-S-04	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 1.8-2% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (<math>P_2O_5+K_2O</math>) хөрсний үед 36.5-37.9мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 29мг/100гр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Са+Mg агууламж нь 14-23мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж илрэхгүй. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=7.1 хүчтэй шүлтлэг шинжтэй.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05мм) хэсгийн агууламж 70%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 14%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 15% ,тоосны агууламж 9%, шавар 23% ихээхэн хэлбэлзэлтэй байна. Тухайн талбайн механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.</p>	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 0.6-1.4% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (<math>P_2O_5+K_2O</math>) хөрсний үед 16-21мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 19мг/100гр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Са+Mg агууламж нь 11-16мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж илрэхгүй. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=8.5-10 хүчтэй шүлтлэг шинжтэй.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05мм) хэсгийн агууламж 80%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 8%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 7% тус тус агууламжтай байгаа боловч АВ шилжилтийн үед элсний агууламж 71%, тоосны агууламж 6%, шавар 22% ихээхэн хэлбэлзэлтэй байна. Тухайн талбайн механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.</p>
20M-S-05	<p>Хэмжилтийн цэг-5 нь давсархаг, мараалаг хөрсний хэв шинжийг илтгэх бөгөөд өнгөн <math>A_m</math> үе, АВ үе, шилжилтийн В давхарга тус тус ялгарна.</p> <p>Хими шинж чанар: Хөрсний үе давхаргад ялзмагийн бодисын агууламж 0.26-1.16% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (<math>P_2O_5+K_2O</math>) 7.4-19.6мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 7-16мг/100гр хэмжээтэй илт давамгайлна.Солилцох сууриудын нийлбэр Са+Mg агууламж нь 10мг-экв/100 гр хүрнэ. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=9 хүчтэй шүлтлэг орчныг үзүүлж байна. Хуурай давсны агууламж 0.1-0.6% орчим хэлбэлзэх бол хялбар уусах давсны агууламж 0.3-1.2dS/m хүртэл өндөр агууламжтай байна.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 57-85%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 5-15%, физик</p>	<p>Хэмжилтийн цэг-5 нь давсархаг, мараалаг хөрсний хэв шинжийг илтгэх бөгөөд өнгөн <math>A_m</math> үе, АВ үе, шилжилтийн В давхарга тус тус ялгарна.</p> <p>Хими шинж чанар: Хөрсний үе давхаргад ялзмагийн бодисын агууламж 0.16-0.38% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (<math>P_2O_5+K_2O</math>) 18-20мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 17-19мг/100гр хэмжээтэй илт давамгайлна.Солилцох сууриудын нийлбэр Са+Mg агууламж нь 12мг-экв/100 гр хүрнэ. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=10 хүчтэй шүлтлэг орчныг үзүүлж байна. Хуурай давсны агууламж 0.2-0.7% орчим хэлбэлзэх бол хялбар уусах давсны агууламж 0:5-1.5dS/m хүртэл өндөр агууламжтай байна.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 60-80%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 6-8%, физик шавар (&gt;0.002</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 9-28% тус тус агууламжтай байгаа бөгөөд хөрсний үе давахрад шаврын агууламж өндөр учир механик бүрэлдэхүүний ангилалаар хүнд шавранцар шинжтэй байна.</p> <p>Хүнд элемент: төслийн талбайд өргөн тархалттай Ni, Cd,Pb, Zn, Cr, Cu зэрэг элементүүдийг тодорхойллоо. Хүнд элемент тус бүрийн агууламжаас үзвэл никел (Ni) 24.2мг/кг, кадми (Cd) агууламж багажны мэдрэг чанарт бүртгэгдэхгүй бага агууламжтай, хар тугалга (Pb) 24мг/кг, цайр (Zn) 70.8мг/кг, хром (Cr) 38.7мг/кг, зэс (Cu) 24.3мг/кг тус тус агууламжтай байна. Эдгээр агууламжууд нь Монгол орны стандарт MNS5850:2008-д заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдол</p>	<p>мм)-ын эзлэх хувь 10-30% тус тус агууламжтай байгаа бөгөөд хөрсний үе давахрад шаврын агууламж өндөр учир механик бүрэлдэхүүний ангилалаар хүнд шавранцар шинжтэй байна.</p> <p>Хүнд элемент: төслийн талбайд өргөн тархалттай Ni, Cd,Pb, Zn, Cr, Cu зэрэг элементүүдийг тодорхойллоо. Хүнд элемент тус бүрийн агууламжаас үзвэл никел (Ni) 15мг/кг, кадми (Cd) агууламж багажны мэдрэг чанарт бүртгэгдэхгүй бага агууламжтай, хар тугалга (Pb) 15мг/кг, цайр (Zn) 36мг/кг, хром (Cr) 21мг/кг, зэс (Cu) 13мг/кг, хүнцэл (As) 7мг/кг тус тус агууламжтай байна. Эдгээр агууламжууд нь Монгол орны стандарт MNS5850:2008-д заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдол үүсээгүй байна.</p>
20M-S-06	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 1.48-1.53% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (P<sub>2</sub>O<sub>5</sub>+K<sub>2</sub>O) 31-34мг/100гр байгаа бөгөөд калийн ион 29мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Ca+Mg агууламж нь 13мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж өнгөн үед илрээгүй байна. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=9.5 буюу шүлтлэг шинжтэй байна.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 81%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 10%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 7% тус тус эзлэхүүнтэй байна. Тухайн хэмжилтийн цэгийн хувьд механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.</p>	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 0.3-0.9% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (P<sub>2</sub>O<sub>5</sub>+K<sub>2</sub>O) 15-17мг/100гр байгаа бөгөөд калийн ион 17мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Ca+Mg агууламж нь 22мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж өнгөн үед илрэхгүй бол хуримтлалын В давхарга 1.4% орчим агууламжтай байна. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=9.5 буюу шүлтлэг шинжтэй байна.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 75%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 11%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 19% тус тус эзлэхүүнтэй байна. Тухайн хэмжилтийн цэгийн хувьд механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.</p>
20M-S-07	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 1.31% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (P<sub>2</sub>O<sub>5</sub>+K<sub>2</sub>O) 37мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 34мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна.</p>	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 1.22% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (P<sub>2</sub>O<sub>5</sub>+K<sub>2</sub>O) 12мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 11мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна.</p>



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>Солилцох сууриудын нийлбэр Са+Mg агууламж нь 15мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж бага бөгөөд хөрсний доод үед 4.94% орчим илрэнэ. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=7.9 буюу шүлтлэг орчныг үзүүлж байна. Хуурай давсны үлдэгдэл 0.05% хүрэх бол хялбар уусах давсны агууламж 0.103dS/m орчим хэлбэлзэнэ.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 77%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 14%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 8% тус тус эзлэхүүнтэй байна. Тухайн талбайн механик бүрэлдэхүүний хувьд хүнд шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: төслийн талбайд өргөн тархалттай Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu зэрэг элементүүдийг тодорхойллоо. Хүнд элемент тус бүрийн агууламжаас үзвэл никел (Ni) 28мг/кг, кадми (Cd) агууламж багажны мэдрэг чанарт бүртгэгдэхгүй ,хар тугалга (Pb) 24.8мг/кг, цайр (Zn) 73.2мг/кг, хром (Cr) 30мг/кг, зэс (Cu) 22.8мг/кг тус тус агууламжтай байна. Эдгээр агууламжууд нь Монгол орны стандарт MNS5850:2008-д заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдол үүсээгүй байна.</p>	<p>Солилцох сууриудын нийлбэр Са+Mg агууламж нь 17мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж бага бөгөөд хөрсний доод үед 3.2% орчим илрэнэ. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=9.5 буюу шүлтлэг орчныг үзүүлж байна. Хуурай давсны үлдэгдэл 0.02% хүрэх бол хялбар уусах давсны агууламж 0.046dS/m орчим хэлбэлзэнэ.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 75%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 14%, физик шавар (&gt;0.002 мм)-ын эзлэх хувь 18% тус тус эзлэхүүнтэй байна. Тухайн талбайн механик бүрэлдэхүүний хувьд хүнд шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана.</p> <p>Хүнд элемент: төслийн талбайд өргөн тархалттай Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu зэрэг элементүүдийг тодорхойллоо. Хүнд элемент тус бүрийн агууламжаас үзвэл никел (Ni) 18мг/кг, кадми (Cd) агууламж багажны мэдрэг чанарт бүртгэгдэхгүй бага агууламжтай 043мг/кг, хар тугалга (Pb) 17мг/кг, цайр (Zn) 31мг/кг, хром (Cr) 37мг/кг, зэс (Cu) 18мг/кг, хүнцэл (As) 11мг/кг тус тус агууламжтай байна. Эдгээр агууламжууд нь Монгол орны стандарт MNS5850:2008-д заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдол үүсээгүй байна.</p>
20M-S-08	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 1.72% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (P<sub>2</sub>O<sub>5</sub>+K<sub>2</sub>O) 30мг/100г байгаа бөгөөд калийн ион 29мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Са+Mg агууламж нь 13мг-экв/100г орчим байгаа бөгөөд кальцийн ионы агууламж 12мг-экв/100гр хэмжээтэй давамгайлсан шинжтэй байна. Хөрсний үе давхаргад карбонатын агууламж илрэхгүй. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=7.3-8 буюу сул шүлтлэг орчныг үзүүлж байна. хуурай давсны агууламж 0.04% ядуулаг бол хялбар уусах давсны агууламж 0.081dS/m орчим бага шинжтэй байна.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 77%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 9%, физик шавар</p>	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж 1.12% орчим байх ба ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (P<sub>2</sub>O<sub>5</sub>+K<sub>2</sub>O) 13мг/100г байгаа бөгөөд калийн ион 11мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Са+Mg агууламж нь 15мг-экв/100г орчим байгаа бөгөөд кальцийн ионы агууламж 13мг-экв/100гр хэмжээтэй давамгайлсан шинжтэй байна. Хөрсний үе давхаргад карбонатын агууламж илрэхгүй. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=7.7-8.0 буюу сул шүлтлэг орчныг үзүүлж байна. хуурай давсны агууламж 0.01% ядуулаг бол хялбар уусах давсны агууламж 0.027dS/m орчим бага шинжтэй байна.</p> <p>Физик шинж чанар: ширхгийн бүрэлдэхүүний хувьд элсэн (2.0-0.05 мм) хэсгийн агууламж 86%, тоос (0.05-0.002 мм)-ны хэсгийн агууламж 14%, физик шавар (&gt;0.002 мм)-</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	(>0.002 мм)-ын эзлэх хувь 12% тус тус эзлэхүүнтэй байна. Тухайн талбайн механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана. Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.	ын эзлэх хувь 9-18% тус тус эзлэхүүнтэй байна. Тухайн талбайн механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар голлосон хэв шинжид хамаарагдана. Хүнд элемент: Хэмжилтийн цэгт газрын доройтол, техноген нөлөөлөл илрэхгүй учир хүнд металлын шинжилгээ хийгээгүй болно.
20M-S-09	Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж өнгөн үеүдэд 1.4-1.7% байна. Хөрсний ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр ( $P_2O_5+K_2O$ ) 16-27мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 26мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Ca+Mg агууламж нь 13мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж илрэхгүй бөгөөд хөрсний хуримтлалын үед 2.6% орчим илрэнэ. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт pH=8.06 буюу шүлтлэг орчныг үзүүлж байна. Хуурай давсны үлдэгдэл 0.04% хүрэх бол хялбар уусах давсны агууламж 0.05dS/m орчим хэлбэлзэнэ.	Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж өнгөн үеүдэд 0.2-0.5% орчим байх боловч хуримтлалын В давхаргад 1.3% хүрнэ. Хөрсний ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр ( $P_2O_5+K_2O$ ) 11-15мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 13мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Ca+Mg агууламж нь 15мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж илрэхгүй бөгөөд хөрсний хуримтлалын үед 2.6% орчим илрэнэ. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт pH=9.5 буюу шүлтлэг орчныг үзүүлж байна. Хуурай давсны үлдэгдэл 0.02% хүрэх бол хялбар уусах давсны агууламж 0.046dS/m орчим хэлбэлзэнэ.
20M-S-10	Хүнд элемент: төслийн талбайд өргөн тархалттай Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu зэрэг элементүүдийг тодорхойллоо. Хүнд элемент тус бүрийн агууламжаас үзвэл никел (Ni) 30мг/кг, кадми (Cd) агууламж багажны мэдрэг чанарт бүртгэгдэхгүй бага агууламжтай 0.43мг/кг, хар тугалга (Pb) 24мг/кг, цайр (Zn) 68мг/кг, хром (Cr) 56мг/кг, зэс (Cu) 27мг/кг тус тус агууламжтай байна. Эдгээр агууламжууд нь Монгол орны стандарт MNS5850:2008-д заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдол үүсээгүй байна.	Хүнд элемент: төслийн талбайд өргөн тархалттай Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu зэрэг элементүүдийг тодорхойллоо. Хүнд элемент тус бүрийн агууламжаас үзвэл никел (Ni) 22мг/кг, кадми (Cd) агууламж багажны мэдрэг чанарт бүртгэгдэхгүй бага агууламжтай 0.43мг/кг, хар тугалга (Pb) 13мг/кг, цайр (Zn) 42мг/кг, хром (Cr) 19мг/кг, зэс (Cu) 20мг/кг, хүнцэл (As) 11мг/кг тус тус агууламжтай байна. Эдгээр агууламжууд нь Монгол орны стандарт MNS5850:2008-д заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.
20M-S-11	Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж өнгөн үед 1.0% орчим байх боловч хуримтлалын В давхаргад 0.5% болж буурна. Хөрсний ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр ( $P_2O_5+K_2O$ ) 15мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 15мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Ca+Mg агууламж нь 17-27мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж өнгөн үед 2.8% байгаа бол шилжилтийн үед 3.1% болно. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт pH=9.2 буюу хүчтэй шүлтлэг орчныг үзүүлж байна. Хуурай давсны үлдэгдэл 0.02% хүрэх бол хялбар уусах давсны агууламж 0.046dS/m орчим хэлбэлзэнэ.	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

20M-S-12	<p>Хими шинж чанар: Ялзмагийн бодисын агууламж өнгөн үед 0.9% орчим байх боловч хуримтлалын В давхаргад 0.1% болж буурна. Хөрсний ургамалд ашиглагдах хөдөлгөөнт суурийн нийлбэр (<math>P_2O_5+K_2O</math>) 11мг/100 гр байгаа бөгөөд калийн ион 11мг/100гр хэмжээтэйгээр илт давамгайлна. Солилцох сууриудын нийлбэр Ca+Mg агууламж нь 28мг-экв/100 гр хүрнэ. Карбонатын агууламж өнгөн үед илрэхгүй бол шилжилтийн үед 0.4% болно. Хөрсний урвалын орчны дундаж үзүүлэлт рН=9.2 буюу хүчтэй шүлтлэг орчныг үзүүлж байна. Хуурай давсны үлдэгдэл 0.02% хүрэх бол хялбар уусах давсны агууламж 0.046dS/m орчим хэлбэлзэнэ.</p>
<b>Зөвлөмж</b>	<p><b>Хөрсний цацраг идэвхи:</b> 6 сард хийсэн хөрсний дээж дэх байгалийн цацраг идэвхт элемент ураны дундаж агуулалт 1.2-1.9 г/т, торын дундаж агуулалт 2.9 г/т байгаа нь дэлхийн дунджаас бага, калийн дундаж агуулалт 2.5% байгаа нь дэлхийн дунджаас 2 дахин их байна.</p> <p>9 сард хийсэн хөрсний дээж дэх байгалийн цацраг идэвхт элемент ураны дундаж агуулалт 20M-S-01, 20M-S-05, 20M-S-07, 20M-S-09, 20M-S-10 цэгүүд дээр 1.0-1.5 г/т байгаа нь дэлхийн дундаж 2.0 г/т гэж зааснаас бага байгаа бол 20M-S-10 буюу Цэн тогоруу-2 талбай дээр 2.1 г/т байгаа нь дэлхийн дундаж агууламжаас 0.1-ийн агууламжаар их байна, торын дундаж агуулалт 2.6-3.7 г/т байгаа нь дэлхийн дунджаас бага, калийн дундаж агуулалт 2.4 % байгаа нь дэлхийн дунджаас 2 дахин их байна.</p> <p><b>Гэдэсний савханцрын нян:</b> Матад ХХ талбайн хөрсний нийт мониторинг цэгүүдэд нянгийн бохирдлын үзүүлэлт илрэхгүй байна.</p> <p><b>Гэдэсний бүлгийн эмгэгтөрөгч нян:</b> Хөрсний мониторинг цэгүүдэд гэдэсний бүлгийн эмгэг төрөгчийн нян илрээгүй, төслийн талбай болон хайгуулын өрмийн цэг орчимд органик болон хүн амьтны гаралтай ялгадас, материалаар бохирдоогүй байна үзэж болох юм.</p> <p><b>Нефт бүтээгдэхүүн:</b> Хэрэв хөрс нефт бүтээгдэхүүнээр бохирдсон бол хөрсийг бохирдлоос цэвэрлэх тусгай арга хэмжээнүүдийг хөрсний бохирдлын түвшин их (10000-50000 мг/кг) буюу маш их бохирдолтой (&gt;50000 мг/кг) байх тохиолдолд хөрс сайжруулах арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай. Хөрс болон газрын гүн дэх бохирдсон усыг цэвэрлэх арга технологийг сонгон явуулж бохирдлыг цэвэрлэсний дараа бохирдлын түвшинг заавал байгалийн “фон” хэмжээнд хүртэл цэвэрлэх боломжгүй юм. Иймээс хөрсөн дэх үлдэгдэл бохирдуулагчийн хортой агууламжийг 1000-1500 мг/кг, усанд 1,0-1,5 мг/л хүртэл бууруулахад цаашид хөрс өөрөө аяндаа байгалийнхаа хүчин зүйлийн нөлөөгөөр хүний хяналтан дор бүрэн цэвэрших боломжтой гэж үздэг. Дэлхийн зарим улс орнуудад хийсэн судалгаанаас харахад хөрсний бохирдлын түвшин 5000-10000 мг/кг –ийн хязгаарт байх тохиолдолд хөрсийг цэвэрлэж нөхөн сэргээх арга хэмжээг авах зайлшгүй авах шаардлагатай гэж үздэг байна</p>

## 2.7 АМЬТНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024 -Н ГҮЙЦЭТГЭЛ

### 2.7.1. Газарзүйн байршил

Дорнод аймгийн Матад сумын төв нь Улаанбаатар хотоос зүүн тийш 720 километр, Дорнод аймгийн төв Чойбалсангаас урд зүгт 150 километр далайн төвшнөөс дээш 698 м өндөрт хээрийн бүсэд байрлана.

Мониторинг хийсэн талбай нь физик газарзүйн мужлалаар Дорнод Монголын хээрийн мужид хамаарна. Энэ муж нь Дундад халхын тэгш өндөрлөг, Хэрлэн голын хойд биеийн тал, Өндөрхаан-Баруун уртын цав толгод, Мэнэнгийн тал гэсэн дэд мужуудад хуваагдана. Эзлэх талбай 239 728,1 км<sup>2</sup> буюу 15,3% юм (Батчулуун, 2020. Х-416).

*Зураг 43. Мониторингийн талбайн ерөнхий байдал*



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Зураг 44. Мониторингийн талбайн ерөнхий байдал 9 сар*



Монгол орны дорнод хэсэг ландшафтын хувьд харьцангуй сайн судлагдсан нутгийн нэг юм. Хээрийн ландшафт нв дорнод Монголыг бүхэлд нь хамарч дотроо нугат хээр, жинхэнэ хээр, хуурай хээр гэсэн 3 дэд хэв шинжид хуваагддаг байна. Монголын хээрийн ялгагдах нэг онцлог нь хэд хэдэн зүйл харгана, агь зэрэг хуурайсаг сөөг, сөөгөнцөр ихтэй.



Энэ нутагт хэдэн зуугаар бэлчих цагаан зээрийн (*Procarpa gutturosa*) сүрэг бол хээрийн экосистемийн салшгүй хэсэг юм (зураг 25).

*Зураг 25. Мониторингийн талбайд бэлчих цагаан зээрийн сүрэг 2024.09.07.*

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**




Мэнэнгийн талд (600-800 м) ухаа гүвээ, хонхор хотос бараг байхгүй, тэгш тал голлож баруун хэсгээр гадарга ялимгүй ухаа гүвээтэй болно (зураг 26). Мониторингийн талбай яг энэ ухаа гүвээтэй хэсгийг хамарч байна.

*Зураг 26. Мониторингийн талбай дах кэтпийн ерөнхий байдал 2024.09.07.*



Зураг 45. Амьтан ажиглагдаж тэмдэглэл хийсэн цэгүүдийн байршил



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

**2.7.2. Шавж**

Шавж байгаль дээр экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул олон янзын экологийн онцлогтой.

Бидний судалгаа хийсэн нутгийн шавжийн анги нь хуурай хээрийн бүлгэмдэлд хамаарах бөгөөд нийт шавжийн тоо нэн олон боловч тархалт нь жигд биш байдгаараа онцлог ажээ. Хавар ба зуны эхэн үед зүйлийн бүрэлдэхүүн хамгийн олон янз болдог байна. Энэхүү бүлгэмдэлд хөдөө аж ахуйн хортон шавжаас *Chrysops ricordoce*, *Haematopota turkestanica turkestanica*, *H. desertorum* зэрэг 12 зүйл хөх түрүү түгээмэл тархалттай бол шөвгөн хушуут эрээн царцаа (*Aeropedellatus variegatus*), дорнын шөвгөн сахалт (*Myrmeleotettix palpalis*), модлог идэшт шавжаас сибирийн хүр (*Dendrolimus superans sibiricus*) зэрэг бэлчээрийн хортон зонхилдог. Иксод хачиг *Dermacentor nuttalli*, *Ixodes crenulatus* газар сайгүй тархдаг ажээ (БНМАУ-ын атлас).

Матад сумын нутагт орших мониторингийн талбайн 2 удаагийн хээрийн мониторинг судалгааны явцад тааралдсан 8 баг, 13 овгийн шавжийн зураг, амьдрах орчны онцлогийн талаарх товч мэдээлэл оруулав (хүснэгт 33).

*Хүснэгт 33. Судалгааны талбайд тааралдсан зарим шавж*

<b>ORTHOPTERA</b>	<b>Баг: Шулуун далавчтан</b>
<b>Tettigoniidae</b>	<b>Овог: Голионы овог</b>
Монгол голиотой харьцуулахад биеэр жижиг. Биеийн үндсэн хэлбэр царцаатай төсөөтэй. Царцаанаас ялгагдах чухал шинж нь сахал юм. Олон тооны үеэс тогтсон утаслаг сахлынх нь урт биеийнхээ талаас үргэлж илүү байдаг. Эм Седаковын голио нь ногоовтор өнгөтэй байдаг. Энэ голио нь олон өнгөний хувилбартай. Голио Цэн тогоруу -1 болон Мазаалай -1 цэгт тааралдсан болно.	
<b>Acrididae</b>	<b>Царцаа</b>
	



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**








Барабений таршаа

Манай оронд 160 гаруй шулуун далавчтан тэмдэглэгдээд байна. Царцааны овгийн төлөөлөгчид хамгийн түгээмэл тархалттай бөгөөд зүйлийн бүрэлдэхүүнээр баялаг юм. Нийт царцааны 20 гаруй зүйл нь бэлчээр, ХАА-н таримал ургамлын ургацад хөнөөл учруулдаг байна. Эрдэмтдийн судалснаар нэг царцаа өдөрт өөрийнхөө жингээс 1.5-2 дахин их хоол тэжээл хэрэглэдэг ажээ. Царцаа нь шулуун далавчтаны бүлэгт багтдаг л даа. 28 үетэй, богино сахалтай, гурван үет сарвуутай, хэвлийнхээ нэгдүгээр цагаригт сонсох эрхтэнтэй, дэгээ хэлбэрийн хоёр хос өндөг булагчтай байдаг. Царцаа өндгөө бүлгээр нь бортогонд хадгалдаг онцлогоороо голио, хүрэлзгэнэ мэтийн бусад шулуун далавчтанаас ялгардаг. Царцааг ургамлын хортон шавж болохыг одоогоос 3000 гаруй жилийн өмнө олж тогтоосон.

<b>LEPIDOPTERA</b>	<b>Хайрсан далавчтан</b>
<b>Nymphalidae</b>	<b>Мөлхөө эрвээхэй</b>
	
Харгана дээрх эрвээхэйн авгалдай	Цагаан зээрийн сэг дээрх авгалдай
<b>Pieridae</b>	<b>Цагаан эрвээхэйн овог</b>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	
<p>Энэ овогт багтах хайрсан далавчтанууд нь нол төлөв цагаан, шар, улаан шар өнгөтэй. Хүүхэлдэйнүүд нь биеийн хойд хэсгээр ялгарах шүүсээр мод, ургамал дээр наалдаж байна. Хүрэнцэрүүд нь элдэв ургамлаар хооллоно. Манай оронд цагаан эрвээхэйн овгийн 20 зүйл мэдэгдэж байна. Энэ овгийн эрвээхэйн зарим хүрэнцэрүүд таримал ургамал, сөөгнүүдийг идэж гэмтээнэ.</p>	
<p><b>COLEOPTERA</b></p>	<p><b>Баг: Цохын баг</b></p>
<p><b>Coccinellidae</b></p>	<p><b>Овог: Шүрэн цох</b></p>
	<p>Ойролцоогоор 5 мм урт биетэй, жижиг цох. Биеийн гадаад хэлбэр, богино, зууван, нуруу тал нь дээшээгээ товойж бөмбөлөг хэлбэрийг олсон байдаг. Хэвлий тал нь хавтгай. Биеийн гадаргууд элдэв өргөс, үслэггүй, богинохон сахалтай, сахлын үзүүрт булцуутай. Шүрэн цохууд нь ургамлын бүүрэг, бөөс зэргээр хооллох бөгөөд ургамлын хортонь тоо толгойг цөөрүүлдэг ашигтай шавж юм.</p>
<p><b>Melioidae</b></p>	<p><b>Мелябрийн буглаа цох</b></p>
	
<p>Буглаа цохын авгалдайнууд царцааны өндгийг иддэг бөгөөд ингэснээр ургамлын хөнөөлт шавжийн тоо толгойг цөөрүүлж өгдөг.</p>	
<p><b>Хар цохын овог</b></p>	<p><b>Tenebrionidae</b></p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



Монгол оронд тэмдэглэгдсэн нийт 161 зүйл хар цохын 101 зүйл буюу 62,7% нь манай орны нутаг дэвсгэрээс гадна ямар ч нутагт тархаагүй байна.

Хар цохууд цөл, заримдаг цөл ба хээр талын бүсэд ихээр амьдарна. Ихэнх хар цохууд хатсан хагд ургамлаар хооллож уг хагд ургамалд химийн нэгдлийн байдалтай байгаа усыг биендээ шингээж түүгээр ундаалдаг физиологийн зохилдолгоотой болсон байна.

Хар цохууд зүйлийн бүрдлээр баялаг, тоогоор олон тул байгалийн биоценозод чухал нөлөө холбогдолтой. Ургамлын ялзмаг, хагд ургамлаар хооллодог эдгээр цохууд байгаль дахь органик бодисын өөрчлөлт ба эргэлтийг хурдасгагч нөлөө үзүүлнэ. Энэ цохууд хуурай, гандуу нөхцөлд сайн зохилдсон учраас бороо багатай жилүүдэд олшрон үржиж, таримал ургамлын үндс иш, навч зэрэг хэсгийг гэмтээнэ. Харин говь цөл нутагт элсний нүүдлийг саатуулж, хөрсийг эвдрэлээс хамгаалан бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой бутлаг ургамлыг жил бүр гэмтээж их хэмжээний сүйтгэл учруулна.



Хужир мараат чийглэг хотгорт, цох sp

**HYMENOPTERA**

**Сарьсан далавчтан**

*Forimicidae*

**Шоргоолжийн овог**



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



Эмэгчин ба эрэгчин шоргоолжуудад хос далавч хөгжсөн байгааг 2024.06.07-ны өдөр ажиглагдав.



**Таних шинж:** Сахал 12-13 үеэс тогтох бөгөөд тохой үүсгэж нугарсан байна. Цээж хэвлий хоёрыг холбож байдаг нарийхан шилбэ нь хоёр зангилаа үүсгэж тогтсон байх буюу эсвэл дээшээ харсан сэртэнтэй. Нийгэмч шавж. Үүрээ газарт буюу өмхөрсөн модлогт байгуулна. Дэлхийд 5000 гаруй зүйл бий. Хоол тэжээлдээ ургамлын үлдэгдэл, төрөл бүрийн амьтанг ашигладаг. Шоргоолж хөрс үүсэх процесст оролцдог. Манай орны ойт хээр, хээрийн бүсэд ойн махчин шоргоолж (*Formica rufa*) өргөн тархжээ.

<b>DIPTERA</b>	<b>Ялаатан</b>
----------------	----------------

<b>Muscidae</b>	<b>Жинхэнэ ялааны овог</b>
-----------------	----------------------------

Энэ багт ялаа, шумуул хамаарагдана. Ялаанууд амьтан, ургамлын гаралтай ялзмаг, цэцгийн балаар, шумуулууд ургамлын шүүс, амьтны цус сорж амьдарна. Махчин ялаанууд ч олон бий.




<b>Limonidae</b>	<b>Лимонид ялааны овог</b>
------------------	----------------------------



Энэ овгийн ялаанууд тэмээлзгэнэтэй төстэй боловч биеэр жижиг юм. Зуны дулаан улиралд чийгтэй газар, намаг, нугаар амьдарна. Өндгөө ус намганд гаргана. Манай орны лимонид овгийн ялааны ангилал зүй, тархалт, экологийн талаа Е.Н. Савченко (1972) судалсан бөгөөд 30 зүйл

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

тэмдэглэгдснээс 28 нв голын хөндий, чийгтэй газраар, 2 нь Баруун Монголын өндөр уулын хуурай, сэрүүн бүсээр тохиолддог гэжээ.

	<p>Хос далавчтаны хүн ба байгальд үзүүлэх нөлөө, холбогдол маш олон янз. Зарим нь элдэв амьтдын хүүр, сэг, ялзмагийг байгалиас цэвэрлэж, эмнэлэг-санитарын үүрэг гүйцэтнэхэд зарим нь хүн ба амьтдын цус сорж зовооно. Нөгөө хэсэг нь зэрлэг болон таримал ургамлыг хөнөөж гэмтээнэ.</p>
<p><b>ARACHNOIDEA</b> <b>Opiliones</b></p>	<p><b>Аалз хэлбэртний анги</b> <b>Аалз</b></p>
	<p><b>Аалз</b> нэгж орон зайд орших нягтшилаараа хүний гайхал төрүүлж сонирхол татна. Сэрүүн бүсийн гол мөрний татмын ерийн нэг га нугад 5 000 0000 орчим аалз байдаг. Аалз ус, агаар, хөрсний бүхий л орчин нөхцөл амьдрахаас гадна өвс ургамал, хад чулуу, мод бутанд авирч амьдардаг. Тухайлбал, Дунд Европын холимог ойн нэг нарсанд 78, гацуурт 222, царсанд 595, хусанд 76 ширхэг аалз байгааг тоолжээ. Аалз хоногт үй олон ялаа барьж иддэг болохыг эрдэмтэд тогтоожээ.</p>
<p><b>HEMIPTERA буюу HEMEROPTERA</b></p>	<p><b>Хагас хатуу далавчтан буюу бясаны баг</b></p>
	<p>Энэ багт хамаарагдах шавжууд нь хуурай газар ба усанд амьдарна. Монгол оронд 10 овгийн 173 зүйлийн хуурай газрын баясаа бүртгэгджээ. Хуурай газар амьдардаг бясан ургамлын шим, шүүсийг сорж хөдөө аж ахуйд багагүй хохирол учруулна.</p>

**Цөгөрцөний баг**

Өнөөгийн байдлаар 9 овгийн 430 төрөлд хамаарах 2300 орчим мөргөөлж шинжлэх ухаанд тэмдэглэгдсэн. Манай оронд одоогоор 5 төрлийн 5 зүйл бүртгэгдсэн байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Цөгөрцгөнө махан идэшт шавж бөгөөд амьдралын энэ хэв маягт нилээд дасан зохицсон байдаг. Барьсан амьтнаасаа зөвхөн үйрмэгтөдий зүйл л үлдээж бүхэлд нь идэж дуусгана (зураг 28).

Ердийн мөргөөлж ихэвчлэн өдрийн цагаар идэвхтэй байж төрөл бүрийн шавж, аалз болон бусад үет хөлтнүүдээр хооллодог. Тэд байгаль дээрх маш олон зүйл ялаа, аалзны тоо толгойг зохицуулах ажил гүйцэтгэдэг.

Цөгөрцгөнө нь бидний 9 сарын мониторинг судалгааны явцад хайгуулын талбайн хужир мараат хөндий, 2-р цэг, 4-р цэг зэрэгт тааралдав.

*Зураг 28. Ердийн мөргөөлж 2024.09.07. Мэнэнгийн тал*



Энэ нутгийн шавжийн судалгааг нарийвчлан хийх шаардлагатай. Тухайлбал, цөгөрцгөнө хэмээх энэ зүйл амьтны амьдралын түүхийг нарийвчлан судлах шаардлагатай болохыг Монгол улсын Шинжлэх ухааны академи, Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн Шавж судлалын лабораторитор санал дэвшүүлсэн байдаг (Шавьжийн амьдрал, 2016).

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

Хүснэгт 40. Шавжийн мониторингийн талбай дах тархалт 6 болон 9 сард

№	Баг, овгийн нэр	Ажиглалтын цэг																	Бүгд	
		5-р цэг буюу хужир мараат хөндий		2-р цэг		6-р цэг		7-р цэг		8-р цэг		Замын уулзвар-9 цэг		Цэн тогоруу		Кемп		Мазаалай - 1		
		Үл. 8	ИХ. 8	Үл. 8	ИХ. 8	Үл. 9	ИХ. 9	Үл. 9	ИХ. 8	Үл. 9	ИХ. 8	Үл. 9	ИХ. 8	Үл. 9	ИХ. 8	Үл. 8	ИХ. 8	Үл. 8		ИХ. 8
<b>I</b>	<b>ORTHOPTERA- Шулуун далавчтан</b>																			
1	<i>Tettigoniidae</i> Голионы овог													1					1	2
2	<i>Acrididae</i> Царцааны овог	6				14				1									4	25
<b>II</b>	<b>LEPIDOPTERA-Хайрсан далавчтан</b>																			
3	<i>Nymphalidae</i> Мөлхөө эрвээхэйн овог	1				8							2	1						12
4	<i>Pieridae</i> Цагаан эрвээхэйн овог	1											6	8		2				17
<b>III</b>	<b>COLEOPTERA - Цохын баг</b>																			
5	<i>Coccinellidae</i> Шүрэн цохын овог	2																		2
6	<i>Melioidae</i> Мелябрийн буглаа цох																			
7	<i>Tenebrionidae</i> Хар цохын овог	1						3				1								5
<b>IV</b>	<b>HYMENOPTERA - Сарьсан далавчтан</b>																			
8	<i>Forimicidae</i> Шоргоолжийн овог					12														12
<b>V</b>	<b>DIPTERA - Ялаатан</b>																			
9	<i>Muscidae</i> Жинхэнэ ялааны овог	Судалгааны бүх цэгт тааралдана.																		
10	<i>Limonidae</i> Лимонид ялааны овог		32																	
<b>VI</b>	<b>ARACHNOIDEA - Аалз хэлбэртний анги</b>																			
11	<i>Opiliones</i> Аалз																			
<b>VII</b>	<b>HEMEROPTERA - Бясааны баг</b>	1																		1
<b>VIII</b>	<b>Цөгөрцгөний баг</b>		1		1															2

### 2.7.3. Хоёр нутагтан, мөлхөгчид

Монгол оронд 2 баг, 4 овог, 4 төрөлд багтах 6-8 зүйлийн хоёр нутагтан тэмдэглэгджээ [8, 9, 10, 11]. Манай оронд 3 овог, 7 төрөл, 9 зүйлийн могой тэмдэглэгджээ. Монгол орны мөлхөгчдийн зүйлүүдийн ихэнх нь өмнөд нутгийн гандуу, хуурай бүс нутагт амьдардаг.

Матад ХХ талбайн нутаг дэвсгэр нь Монгол орны амьтдын тархцын зургаас үзвэл Дорнод Монголын тойрогт хамаарах бөгөөд тухайн нутагт тархсан мөлхөгчдийн тархац, байршлын талаар Х.Мөнхбаяр, Х.Тэрбиш, М.Мөнхбаатар (1991, 2001, 2005, 2010) нарын бүтээлд дурдсан байна. Тэдгээр судлаачдын бүтээлээс үзэхэд монгол бах (*Bufo raddei*), монгол гүрвэл (*Eremias argus*), рашааны могой (*Elaphe dione*), бамбай хоншоорт могой (*Gloydius halys*) зэрэг хоёр нутагтан, мөлхөгчид тархсан хэмээн тэмдэглэжээ. Харин энэ удаагийн бидний судалгааны явцад монгол гүрвэл (*Eremias argus*) хэмээх нэг зүйлийн мөлхөгч уг бүс нутагт тархан амьдарч байна.

Монгол гүрвэл (*Eremias argus*) нь хайгуулын талбайн судалгааны 4 цэгт тааралдав. Тэдгээрийн орогнон орших нүх нь мэрэгчийн орхигдсон нүх, үхсэн амьтны сэг болон байгалийн хөрсөнд өөрсдийн ухсан нүх зэрэг байв (зураг 29; 30).

Зураг 29. Монгол гүрвэл (*Eremias argus*), түүний орогнох орчин. Зургийг Н. Цэгмид 2024.06.09





Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



Зураг 30. Монгол гүрвэл (*Eremias argus*), түүний орогнох орчин адууны сэг задарсан байдал. Зургийг Н. Цэгмид 2024.09.07



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Монгол гүрвэл (*Eremias argus*) нь мониторингийн судалгааны явцад хайгуулын талбайн 4, 8 болон Мазаалай-1 цэгт тус тус тааралдав.

Монгол орны хоёр нутагтан, мөлхөгч амьтдын хувьд амьдрах орчны хомсдол, бохирдол нь ховордуулах үндсэн гол шалтгаан болж байна. Ихэнх тохиолдолд байгалийн нөөцийн олборлолт, ашиглалтын улмаас орчны хомсдол, доройтол нүүрлэж байна. Уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын хөрс эвдэрснээс болж тархац тоо толгой хомсдох магадлалтай.

*Хүснэгт 41. Мөлхөгчийн мониторингийн талбай дах тархалт 6 болон 9 сард*

№	Баг, овог, зүйлийн нэр		Ажиглалтын цэг									
			Талбайн баруун талын хужир мараат хөндий		7-р цэг		8-р цэг		Замын уулзвар-9 цэг		Мазаалай - 1	
			2024 он									
		ҮI. 8	IX. 8	ҮI. 9	IX. 8	ҮI. 9	IX. 8	ҮI. 9	IX. 8	ҮI. 8	IX. 8	
I	<b>Хайрстны баг</b>											
	<b>Жинхэнэ гүрвэлийн овог</b>											
1	Монгол гүрвэл	<i>Eremias argus</i>	3		нүх			12	нүх	1		4

**2.7.4. Хайгуулын талбай дах шувуудын зүйлийн бүрдэл**

Бидний судалгаанд хамрагдсан нутаг нь Монгол орны шувууны газарзүйн мужлалаар Евразийн хээрийн дэд муж, Монгол-Дагуурын провинцийн хуваарилалд хамаарагдана. Энд бүртгэгдсэн шувууд хээр тал, ус намаг, барилга байгууламж зэрэг экологийн янз бүрийн орчинд оршин амьдардаг шувууд байгаа нь тус нутагт олон янзын ландшафтийн хэв шинжтэй болохыг илтгэн харуулна.

Биднээс өмнө энэ нутаг болон Дорнод Монголын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хамгийн анхны шувууны судалгааг Оросын Холбооны Улсын шувуу судлаач эрдэмтэн А.Я. Тугаринов (1932), Монгол-Зөвлөлтийн биологийн экспедиции В.А. Остапенко ба бусад (1976-1977), В.Е. Фомин., А. Болд (1975), Н. Цэвээнмядаг (2001) нар хийж өөрсдийн тайлан, бүтээлдээ нийтлүүлжээ (хүснэгт 34).

*Хүснэгт 34. Дорнод Монголын шувуудын зүйлийн тоо*

№	Судлагдсан газрын нэр	Зохиогч	Судлагдсан он	Зүйлийн тоо	
				Бүгд	Ялалт баг
1.	Налайх, Чойр, Батхан, Бойр, Халхын гол	Тугаринов А.Я.	1932	185	21
2.	Ховд, Их нууруудын хотгор, Буйр нуур, Халхын гол, Бөөн	Остапенко В.А., Гаврилов В.М.,	1980	36	18

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	цагаан нуур, Таацын цагаан нуур, Улаан нуур	Фомин В.Е., Болд А., Цэвээнмядаг Н.			
3.	Монголын бүх бүс, бүслүүр	Фомин В.Е., Болд А.	1991	415	118
4.	Дорнод аймаг	Цэвээнмядаг Н.	2001	330	-


А.Я. Тугариновын «Птицы Восточной Монголии по наблюдениям экспедиции 1928 г.» бүтээлд 21 зүйлийн шувууд Халхын гол, Буйр нуур орчимд бүртгэгдснээс 4 зүйл (шилийн сар, монгол болжмор, адууч чогчиг, бүжимч чогчиг) шувууд адил байв.

В.А. Остапенко ба бусад «Характер пребывания, территориальное размещение и некоторые черты экологии куликов Монголии» бүтээлд хиазатынхан овгийн шувуудын тархалтыг Ховд хотоос Халхын гол хүртэлх уудам нутагт хийгдснээрээ онцлог ба нийт 36 зүйлийн шувууг судлан тэмдэглэснээс Халхын гол, Буйр нуур орчимд 18 зүйлийн шувууны үржил, экологийн онцлогийн тухай бичиглэл хийжээ. Бидний судалгааны явцад уг нутагт 3 зүйлийн хиазатынхан овгийн шувуудын оршин амьдардаг болох нь тогтоогдов.

В.Е. Фомин, А. Болд нарын «Каталог птиц Монгольской народной Республики » бүтээлд Монгол орны бүх нутаг дэвсгэрт оршин амьдрах 415 зүйлийн шувуудын тархалтыг багтаасан манай орны шувуу судлалын шинжлэх ухааны тулгуур судалгааны материал нэг юм.

Бидний судалгаагаар хайгуулын талбай, түүний орчмын тал хээрт хийгдсэн экологийн олон янзын орчинд амьдардаг (хээр тал, барилга байгууламж, ус намаг, говь цөл, хад асга, мод бутны) нийт 10 баг, 19 овог, 38 төрөлд хамаарах 43 зүйл шувуу бүртгэв (хүснэгт 35). Эдгээр шувуудын 14 зүйл (33%) нь суурин, 29 зүйл нь нүүдлийн шувууд байна. Энэ нутагт бүртгэгдсэн шувуудын 21 зүйл буюу 50% нь бор шувуутан юм. Амьдрах орчноор нь ангилвал хээр талын-13 (31%), мод бутны-12 (29%), ус намгийн-11 (24%), хад асганы-4 (9%), барилга байгууламж, суурин газрын-2 (5%), говь цөлийн-1 (2%) зүйл шувууд тус тус байна (зураг 31). Энэ нутаг дахь шувуудын 13 зүйл (42%) нь хээр талын орчныг шүтэн амьдардаг байна.

*Зураг 31. Шувуудын амьдрах орчны ялгаатай байдал*



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Хүснэгт 35. Хайгуулын талбай орчимд зуны улиралд тааралдах шувууд

№	Зүйлийн нэр	Оршин амьдрах хэлбэр	Амьдрах орчин	Гарал үүсэл Штегман, 1938	Ажиглалтын цэгүүд																Бүгд	Элбэгшил, %				
					Талбайн баруун талын хужир мараат хөндий		Морины зүчээтэй өвөлжөө		4-р цэг (жижиг шал үүссэн)		3-р цэг (шатсан газар)		Матад төв		Талбай руу явах замд		Замын уулзвар-9 цэг		Цэн тогоруу				Хуучин кемп		Хогийн цэг	
					2024 он																					
					ҮЛ. 8	ИХ. 8	ҮЛ. 8	ИХ. 8	ҮЛ. 8	ИХ. 8	ҮЛ. 8	ИХ. 8	ҮЛ. 9	ИХ. 8	ҮЛ. 9	ИХ. 8	ҮЛ. 9	ИХ. 8	ҮЛ. 9	ИХ. 8			ҮЛ. 9	ИХ. 8	ҮЛ. 8	ИХ. 8
1	<i>Coturnix japonica</i>	өз	ХТ	Мон		1			1		1												3	0.58		
2	<i>Tadorna ferruginea</i>	өз	УН	Мон								2											2	0.39		
3	<i>Tadorna tadorna</i>	өз	УН	Мон								2											2	0.39		
4	<i>Anas zonorhyncha</i>	өз	УН	Хят				6															6	1.17		
5	<i>Circus macrourus</i>	өз	ХТ	Ев										1									1	0.19		
6	<i>Accipiter nisus</i>	өз	МБ	ПА								1											1	0.19		
7	<i>Buteo hemilasius</i>	с	ХТ	Мон	1				1					1	1								4	0.78		
8	<i>Aquila nipalensis</i>	с	ХТ	Мон					2														2	0.39		
9	<i>Aegypius monachus</i>	с	ХА	Мон								4											4	0.78		
10	<i>Grus virgo</i>	өз	ХТ	Мон	2																		2	0.39		
11	<i>Charadrius dubius</i>	өз	УН	ПА	1																		1	0.19		
12	<i>Charadrius veredus</i>	өз	УН	ГдТ				4		2													6	1.17		
13	<i>Vanellus vanellus</i>	өз	УН	ПА		8			8														16	3.11		
14	<i>Himantopus himantopus</i>	өз	УН	Мон					2														2	0.39		
15	<i>Gallinago gallinago</i>	өз	УН	ПА					2														2	0.39		
16	<i>Sterna hirundo</i>	өз	УН	ПА				2															2	0.39		
17	<i>Syrrhaptes paradoxus</i>	с	ГЦ	Мон								2		6									8	1.56		
18	<i>Columba livia</i>	с	ББ	ГдТ						46	26												72	14		
19	<i>Athene noctua</i>	с	МБ	Мон															1				1	0.19		
20	<i>Apus apus</i>	өз	ХА	Ев						30													30	5.84		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

21	<i>Apus pacificus</i>	өз	ХА	Хят								12												12	2.33		
22	<i>Pica pica</i>	с	МБ	Ев								2													2	0.39	
23	<i>Pyrhocorax pyrrhocorax</i>	с	МБ	Мон								4	8												12	2.33	
24	<i>Corvus corax</i>	с	МБ	Ев				1																	1	0.19	
25	<i>Hirundo rustica</i>	өн	ББ	ПА		6												1	2						9	1.75	
26	<i>Alauda arvensis</i>	өз	ХТ	ПА	10+1juv					4				4	2										10	1.95	
27	<i>Eremophila alpestris</i>	с	ХТ	Арк	12	2	4	4	4		6	8			20	4		4							70	13.6	
28	<i>Melanocorypha mongolica</i>	с	ХТ	Мон	18	4		4	4		12	2			20	18	2						2	2	88	17.1	
29	<i>Saxicola maurus</i>	н	МБ	ПА																			1		1	0.19	
30	<i>Oenanthe oenanthe</i>	өз	ХТ	ПА		2																			2	0.39	
31	<i>Oenanthe isabellina</i>	өз	ХТ	Мон		2	2	2				4		2											12	2.33	
32	<i>Ficedula narcissina</i>	н	МБ	Хят																			1		1	0.19	
33	<i>Ficedula albicilla</i>	н	МБ	Сиб														1							1	0.19	
34	<i>Muscicapa sibirica</i>	н	МБ	Сиб											1			2							3	0.58	
35	<i>Muscicapa dauurica</i>	н	МБ	Сиб													2		1						3	0.58	
36	<i>Passer montanus</i>	с	ХТ	ПА		8						12	6				2								28	5.45	
37	<i>Petronia petronia</i>	с	ХА	ГдТ								4													4	0.78	
38	<i>Pyrgilauda davidiana</i>	с	ХТ	Мон	6	4				14	4	12			14	10		2							66	12.8	
39	<i>Motacilla cinerea</i>	н	УН	ПА						8					2											10	1.95
40	<i>Motacilla alba</i>	н	УН	ПА				2																	2	0.39	
41	<i>Anthus godlewskii</i>	өн	ХТ	Мон					2														1		3	0.58	
42	<i>Carpodacus erythrurus</i>	н	МБ	Хят														1							1	0.19	
43	<i>Emberiza yessoensis</i>	н	МБ	Хят														6							6	1.17	
<b>Нийт</b>					40	19	22	12	18	45	28	23	114	40	10	61	43	5	8	13	4	5	2	2	514	100	

**Тайлбар:**

**Амьдрах орчин:** УН-ус намгийн, МБ-мод бутны, ХТ-хээр талын, ХА-хад асганы, ББ- барилга байгууламж, төв суурин газрын;


**Оршин амьдрах хэлбэр:** өз-нүүдлийн өндөглөн зусдаг, с-суурин

**Гарал үүсэл:** Т-гүй-Гарал үүсэл тодорхойгүй, ПА-палеарктикийн, Мон-Монголын, Сиб-Сибирийн, Арк-Арктикийн, Ев-Европын, Сиб-Сибирийн, ГдТ-Газар дундын тэнгисийн; Хят-Хятадын.

## Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I

Мониторингийн талбай, түүний орчимд оршин амьдрах шувуудыг гарал үүслээр нь авч үзвэл: Монголын-33% (n=14), Транспалеарктикийн – 29% (n=12), Хятадын - 12% (n=5), Европын - 10% (n=4), Сибирийн – 7% (n=3), Газар дундын тэнгисийн - 7% (n=3), Арктикийн 2% (n=1) зүйл шувууд байна (зураг 32).

Зураг 32. Шувуудын гарал үүслийн тойм



### Шувуудын тоо толгойн байдал


Матад сумын нутагт орших хайгуулын талбай, түүний орчимд нийт 42 зүйлийн 511 толгой шувуудыг 2024 оны 6 болон 9 сард тоолж бүртгэв. Үүнийг сар тус бүрээр ангилбал 2024 оны 6 сард 24 зүйлийн 291 толгой шувуу тоолсон бол 2024 оны 9 сард 25 зүйлийн 220 толгой шувууг тоолж бүртгэсэн байна.

Хайгуулын бүх талбайд боролзой богширго, шооронэвэрт болжмор, монгол болжмор, бужимч чогчиго, монгол божирог тогтмол тааралдаж байв.

Хайгуулын талбай, түүний орчмын шувуудын элбэгшлийг баллаар үнэлэхэд элбэг 9% (n=4) хөхвөр тагтаа, шоорон эвэрт болжмор, монгол болжмор, монгол божирог, ердийн 31% (n=13) зүйл, ховор 60% (n=25) зүйл байна (зураг 33). Тухайн нутаг дахь шувуудын давамгайлал зүйл нь монгол болжмор -17,2%, шооронэвэрт болжмор -13,7% байна.

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

Зураг 33. Шувуудын элбэгшлийн баллын үнэлгээ



Дорнод Монголын тал хээрт хиазатынхан овгийн шувуудаас 3 зүйл бүртгэгдсний нэг зүйл нь дорнын хиазат (*Charadrius veredus*) юм. Хайгуулын талбайн судалгааны 3 цэгт тааралдав (зураг 34).

Зураг 33. Дорнын хиазат (*Charadrius veredus*)



Зураг 34. Нарийн хиазат (*Charadrius dubius*)-ын амьдрах орчин

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



Нарийн хиазат (*Charadrius dubius*)-ын мөр



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



Есөн сард энд умардын хавтгаалж тааралдав. Зуны улиралд хур бороо элбэг байсныг илгэж байв.

**Намрын нүүдлийн шувууд**

**Мазаалай-1, 3** болон 4-р мониторингийн талбайд наран бөднө (*Coturnix japonica*) тархан амьдарна. Хээрийн маршрут судалгааны явцад баталгаажуулсан зургийг оруулав. Зуны судалгааны явцад энд боролзой боширго шувууны дэгдээхэй тааралдсан болно (зураг 35).

*Зураг 35. Наран бөднө (Coturnix japonica) шувууны идээшил нутаг*



Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



Боролзой боширго шувууны дэгдээхэй

**Хогийн цэг**, энд эгэл шулганаа, годлевскийн шийхнүүхэй хэмээх 2 зүйл шувуудтай тааралдав. Монголын хээр тал нутгаар нүүдэллэн өнгөрөх шувууд юм (зураг 36).

*Зураг 35. Амарч буй эгэл шулганаа (Saxicola taurus)*



Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



**Цэн тогоруу-2** шинээр байгуулагдаж буй өрмийн талбай болон ажилчдын суурь юм. Энд үдээс өмнө асрын алтанхараацай, хурган намнаахай болон улаавар бужмар тус бүр 1 бодгаль суурингийн хашаан дээр сууж байв (зураг 37). Хуучин хайгуулын цооног бүхий орчинд шимт хөрс овоолсон овоолго дээр маш их цагаан лууль ургасан байх бөгөөд энд наран хөмрөг, шивэр намнаахай маш идэвхтэй хооллож байв.

*Зураг 37. Амарч буй улаавар бужмар (Carpodacus erythrinus), хурган намнаахай (Хурган намнаахай)*



Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



Улаавар бужмар



Хурган намнаахай



Наран хөмрөг



Шивэр намнаахай

**Цэн тогоруу-1** цэг дээр зуны судалгааны явцад асрын алтанхараацай, шооронэвэрт болжмор тааралдасан бол 9 сард наран намнаа 1 бодгаль, дагуур намнаахай мөн хотны бүгээхэй тааралдав (зураг 38).

*Зураг 38. Амарч буй дагуур намнаахай (Muscicapa dauurica), хотны бүгээхэй (Athene noctua)*

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Мониторингийн **4-р талбай** жижиг нуур үүссэн. Энд, шөвгөн хараалж, эгэл хилэнжигүүр, уулын цэгцгий, умардын хавтгаалж, шилийн сар, эгэл бөднө, хон хэрээ, монгол божирог, тарважи бүргэд, зэрлэгшир нугас шувууд намрын нүүдлийн хугацаанд оршин амьдарна (зураг 39).

*Зураг 39. Мониторингийн 4-р талбай ус намаг бүхий орчин уулын цэгцгий (Motacilla cinerea), эгэл хараалж (Gallinago gallinago)*



Мониторингийн **4-р талбай** 6 сар



Мониторингийн **4-р талбай** 9 сар



*Уулын цэгцгий (Motacilla cinerea)*

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



*Эгэл хараалж (Gallinago gallinago)*

**Замын уулзвар мониторингийн 9-р цэг**, хээрийн сахиа, шилийн сар зэрэг махчин шувууд тархан амьдардаг талбай юм. Учир нь тэдгээрийн хоол тэжээл болох чичүүлийн нүх замын даланд тааралдаж байв (зураг 40).

*Зураг 40. Мониторингийн 9-р талбай замын уулзвар хээрийн сахиа (Circus macrourus)*



Энэ нутагт Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай “CITES”-ийн конвенцын [2000] 2-р хавсралтад 7 зүйл шувуу дээрх акт баримтад тусгагдсан байна. Тухайлбал: хээрийн сахиа (*Circus macrourus*), Морин харцага (*Accipiter nisus*), шилийн сар (*Buteo hemilasius*), *Тарважи бүрэгэд (Aquila nipalensis)*, Нөмрөг тас (*Aegypius monachus*), өвөгт тогируу (*Grus virgo*), Хотны бүгээхэй (*Athene noctua*) зэрэг шувууд юм.

Зун болон намрын улиралд мониторингийн талбайд оршин амьдрах зарим зүйл шувууны нэр, өнгөт зураг (судалгааны хугацаанд өөрсдийн авсан зураг), биеийн хэмжээ, идэш тэжээл, байршлын талаарх тайлбар бүхий жагсаалыг оруулав (Хүснэгт ). Шувуу нэг бүрийн зүйлийн нэрийг монгол болон шинжлэх ухааны гэсэн дараалалтай байрлуулав. Шувууны

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

биеийн уртыг миллометрээр, биеийн жинг том шувуудыг килограмм, жижгийг граммаар тус тус үзүүллээ. Биеийн уртыг **L**, биеийн жинг **P** үсгээр тус тус тэмдэглэв.

**Хүснэгт 36. Матад сумын нутагт орших хайгуулын талбай, түүний нутагт тохиолдох зарим шувууд**

	<p><b>Наран бөднө - <i>Coturnix japonica</i></b>  <b>L</b> 160-200 мм. <b>P</b> 75-150 г.</p> <p>Чийглэг нуга, голын хөндийгөөр тархсан амьдарна. Шавж болон ургамлын ургал эрхтнээр хооллоно.</p>
	<p><b>Анхидал ангир-<i>Tadorna tadorna</i></b>  <b>L</b> 550-650 мм. <b>P</b> 0.8-1.65 кг.</p> <p>Хужиртай нуур, тойром дагаж тархана. Гүехэн усны ёроолын амьтан, ургамлаар хооллоно. Багавтар устай нууранд хооллож байв.</p>
	<p><b>Хээрийн сахиа <i>Circus macrourus</i></b></p> <p><b>L</b> 410-510 мм. <b>P</b> 0,5-0,75 кг.</p> <p>Хуурай, задгай газар, хээр, уулын хээрийн доод бүсэд тохиолдоно. Үүрээ газар засна. Жижиг биет сээр нуруутан, шавжаар хооллоно.</p>
	<p><b>Шилийн сар- <i>Buteo hemilasius</i></b></p> <p><b>L</b> 610-720 мм. <b>P</b> 1-1.3 кг.</p> <p>Уулын хээр, хээр, хээржсэн цөлөөр амьдарна. Замын хажуугийн овоолсон шороон дээр сууж байв. Монгол чичүүлийн нүх замын хажуугаар элбэг тааралдана.</p>



Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



**Нөмрөг тас - *Aegyptus monachus***  
L 1000-1200 мм. P 7.5-12.0 кг. Нэг удаад 1-2.5 кг цул мах иднэ. Нэг өндөг гаргана.  
**Идэш тэжээл:**  
Сэг зэмээр хооллоно.



**Өвгөт тогируу-*Antropoides virgo*** L 950-985 мм. P 2.0-3.0 кг.  
Үүрээ газар дээр ямарч дэвсгэргүй засч, 2 өндөг гаргана. Хорхой, шавж, зөөлөн биетэн, үр, ургамлын найлзуур үндсээр хооллоно. Хялганат хээрт хооллож байв.



**Эгэл хилэнжигүүр- *Himantopus himantopus*** L 330-370 мм. P 150 г. Газар дээр үүрлэж, 4 өндөг гаргана. Задгай хаялага, эрэгтэй, павстай ба цэнгэг уст томоохон нуур цөөрөм дагаж амьдарна.



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

**Шөвгөн хараалж - *Gallinago gallinago*** L 230-280 мм. P 145 г. Үүрээ өвсөн дунд, сондуул дээр засч 4 өндөг гаргана. Чийглэг нуга, намаг, голын татам, ойн цоорхойд амьдарна. Шавж, хавч хэлбэртэн, хорхойгоор хооллоно.



**Хотны бүгээхэй - *Athene noctua***

L 230-280 мм. P 160-180 г.

Хад чулуурхаг нутаг, суурин газарт амьдардаг.

Бүрэнхийд авд гарч шувуу, жижиг мэрэгчтэн, гүрвэл, шавж барьж иднэ.



**Асрын алтанхараацай - *Hirundo rustica***

L 170-210 мм. P 11-23 г.

Голцуу суурин газрыг бараадана. Их төлөв чийглэг орчинд нутаглана.

Нисдэг шавжаар хооллоно.



**Монгол болжмор - *Melanocorypha mongolica***

L 180-212 мм. P 41-67 г.

Хээржсэн цөл, тал хээрт амьдардаг. Ургамлын үр, шавжаар хооллоно.

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

	<p><b>Шоорон эвэртболжмор-<i>Eremophila alpestris</i></b></p> <p>L 160-190 мм. P 30-45 г.</p> <p>Говь, хээр, уулын хээр, модгүй уулсаар амьдардаг. Шавж, үрээр хооллоно.</p>
	<p><b>Боролзой богширго - <i>Alauda arvensis</i></b></p> <p>L 170-200 мм. P 29-50 г. Говь, хээр, уулын хээр, модгүй уулсаар амьдарна. Шавж, үрээр хооллоно.</p> <p>Доорх зураг боролзой богширгоны дэгдээхэй</p>
	<p><b>Годлевскийн шийхнүүхэй- <i>Anthus godlewskii</i></b></p> <p>L 155-170 мм. P 23-28 г. Чийглэг нугаар амьдарна. Шавж, үрээр хооллоно.</p>

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

	<p><b>Дагуур намнаахай - <i>Muscicapa dauurica</i></b></p> <p>L 120-130 мм. P 10,5-14 г.</p> <p>Гол төлөв навчит, холимог ойд амьдарна. Үндсэн тэжээл нь шавж.</p>
	<p><b>Эгэл шулганаа - <i>Saxicola maurus</i></b></p> <p>L 115-130 мм. P 12,5-17,6 г.</p> <p>Хээр, уулархаг газрын чийглэг нуга, өндөр өвст доворхог газар тархана. Шавж, аалз, хорхой, зөөлөн биетнээр хооллоно.</p>
	<p><b>Адууч чогчиго - <i>Oenanthe oenanthe</i></b></p> <p>L 140-165 мм. P 19-35 г.</p> <p>Хээр, уулын хээрээр амьдарна. Янз бүрийн үет хөлтнөөр хооллоно.</p>

	<p><b>Хурган намнаахай - <i>Ficedula albicilla</i></b></p> <p>Л 110-120 мм. Р 8,5-13,5 г.</p> <p>Янз бүрийн ойн бүлгэмдэлд тохиолдоно.</p> <p>Шавж идэшт шувуу юм.</p>
	<p><b>Шивэр намнаахай - <i>Muscicapa sibirica</i></b></p> <p>Л 120-130 мм. Р 13-16 г.</p> <p>Холимог ба армаг тармаг ойд амьдарна.</p> <p>Шавж, жижиг үет хөлтнөөр хооллоно.</p>
	<p><b>Хээрийн бор шувуу - <i>Passer montanus</i></b></p> <p>Л 125-150 мм. Р 19-29 г. Бут сөөгт бүх нутгаар амьдарна. Янз бүрийн үет хөлтөн, ургамлын үрээр хооллоно.</p>

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



Улаавар бужмар - *Carpodacus erythrinus*

L 135-150 мм. P 17,5-26 г.

Уулын дээд бүслүүр, бүт сөөгт нуга, татам, ойд амьдарна.

Шавж, үр, жимсээр хооллоно.



**Наран хөмрөг - *Emberiza yessoensis* L 140-150 мм.**

Судалгаа хийгдсэн нутагт 118 зүйлийн шувууд бүртгэгдсэнээс бидний зун болон намар хийсэн мониторинг судалгааны дүнг нэгтгэхэд 43 зүйлийн шувуудтай тааралдсан болно.

### 2.7.5. Хөхтөн амьтад

Дэлхийн бөмбөрцөг дээр одоо 4500 гаруй зүйл хөхтөн амьтан тархсанаас 140 гаруй зүйл зэрлэг хөхтөн амьтад манай оронд тархан амьдарч байгааг судлаачид тогтоосон байна [1, 2, 3]. Монгол орны уугуул 128 зүйл хөхтөн амьтныг үнэлснээс 16 хувь нь бүс нутгийн хэмжээнд ховордлын ангилалд орсны 2 хувь нь **устаж байгаа**, 11 хувь нь **устаж болзошгүй**, 3 хувь нь **эмзэг** ангилалд хамрагдсан болохыг тогтоожээ.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Дорнод аймгийн Матад сумын нутгийн хөхтөн амьтдын судалгаа Монгол орны хөхтөн, амьтдын судалгааны хүрээнд багтаж иржээ. Тухайлбал, А.Г.Банников (1950), В.Е.Соколов, В.Н.Орлов (1980), С.Дуламцэрэн (1970, 2005) зэрэг эрдэмтдийн Монгол орны хөхтөн амьтдын талаарх тулгуур бүтээлүүдэд тус нутгийн хөхтөн амьтдын талаарх мэдээлэл багтжээ. Эдгээр бүтээлд хөхтөн амьтдын тархцын мужлалаар Дорнод Монголын тойрогт хамаарагдана.

Матад сумын нутаг буюу Дорнод Монголын хээрт 26 зүйлийн хөхтөн амьтад оршин амьдардаг болохыг судлан тогтоожээ.

Хэвлэлийн мэдээнээс үзэхэд тус нутагт тархан амьдрах хөхтөн амьтад дагуур зараа, бэсрэг атаахай, өөдсөн атаахай, азийн малтаахай, бор туулай, дагуур огдой, монгол тарвага, дагуур зурам, мэрэгчтнээс хэргэлзий огтоно, үлий цагаан огтоно, хөх шишүүхэй, орог зусаг, монгол чичүүл, гэрийн хулгана, сибирь алагдаага, махан идэшт амьтаас нохой элбэнх, хярс, шар үнэг, саарал чоно, халздай дорго, өмхий хүрнэ, хотны үен, цагаан үен, хээрийн солонго, мануул зэрлэг туруутнаас цагаан зээр зэрэг хээрийн иж бүрдлийг бүрдүүлэн сэргээн зохицуулагчид нутагладаг тухай (Цэвэгмид, Цэнджав, 1989; Дуламцэрэн, 2006; Батсайхан нарын, 2014) хэвлэлийн мэдээ байна.

Бид хайгуулын талбайн орчимд цагаан зээр, бор туулай, халздай дорго зэргийг бүртгэсэн болно. Энэ нутаг бол цагаан зээрийн хувьд түүний өвөлждөг гол нутаг болохыг тэнд газар бүр алхам тутамд тааралдах сэг илтгэн харуулна (зураг 41). Цэг тогоруу хайгуулын цооногийн хамгаалалтын зурваст байсан цагаан зээрийн сэг 9 сард очиход зурвасыг сэргээн хагалахад өртөж үлдэгдэл яс үйрч бутарсан байв.

Хайгуул хийж буй талбай бол цагаан зээрийн бэлчээр нутаг болохыг маршрут судалгааны явцад алхам бүрт тааралдах ялгадас илтгэнэ.

*Зураг 41. Цагаан зээрийн сэг. Зургийг Н. Цэгмид 2024.06.8-9 өдрүүд*



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



*Зураг 46. Зээрийн сэг, үйрсэн байдал 2024,09,08*



Энэхүү олон цагаан зээрийн сэг нь 2023-2024 оны өвөл цас ихтэй байснаас тал нутагт хоол тэжээлгүй их хүйтний улмаас үхсэн байна. Зарим нь хаврын түймэрт шатаж үхсэн байна. Нэг цагаан зээрийг саарал чоно барьж идсэн ул мөр илрэв (зураг 42).

*Зураг 42. Цагаан зээрийн сэг. Зургийг Н. Цэгмид 2024.06.8*





**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Ус мараа бүхий орчинд цагаан зээрийн мөр тааралдав (зураг 43). Цагаан зээр нь намхан уул толгод, гүвээ бүхий хялганат хээрт байршин амьдардаг. Ус болон бэлчээрийн хомсдолоос шалтгаалан байршлаа сэлгэнэ. Иймд хайгуулын талбайд орших энэхүү ус мараа бүхий орчин бол цагаан зээрийн хувьд маш чухал газар юм. Энэ газрыг хамгаалан авч үлдэхэд анхаарах зайлшгүй шаардлага байна. Учир нь цагаан зээр ч биш биологийн олон янз байдал хамгаалагдана. 2024 оны 9 сард хийсэн мониторинг судалгааны явцад энэхүү ус мараат газарт бор туулайн мөр тааралдав.

*Зураг 43. Ус мараа бүхий орчинд цагаан зээр болон бор туулайн мөр Зургийг Н. Цэгмид 2024.06.8; 2024.09.8*



Зуны төрх



Намрын төрх



Зуны улирал дах цагаан зээрийн мөр

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



Намрын улирал дах бор туулайн мөр

### Цагаан зээр (*Procapra gutturosa*)

*Амьдралын онцлог.* Олноороо сүрэглэж амьдарна. Нам уулсаар олон толгойгоор сүрэглэнэ. Голдуу үет ургамал, шаваг иднэ. Ус болон бэлчээрийн хомсдлоос шалтгаалан байршлаа сэлгэнэ. Ороо нийллэг 11-р сарын дунд үеэс 1-р сарын сүүлч хүртэлх хугацаанд болно. Нэг ооно олон шаргачинг хээлтүүлнэ. Хээл тээх хугацаа 180 хоног. Шаргачин 6-7 сард голдуу нэг, хааяа ихэр янзага төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 6-7 жил насална. 2 настайгаасаа бэлэг боловсорно.

*Амьдрах орчин.* Намхан уул толгод, гүвээ бүхий хялганат хээрт байршин амьдарна (зураг 44).

*Зураг 47. Талбайн хойд хэсэгт 2024.09.08*



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Зураг 44. Ус мараа бүхий хотгор дах цагаан зээрийн сүрэг.(Талбай дотор, 20М-S-05 цэгийн ойролцоо)*



*Нисгээгүй төхөөрөмжөөр, 2024.09.08*

*Зураг 45. Хөвөө нуурын урд. 2024.06.08. 20:38 цаг.*

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



*Амьдралын ул мөр.* Ус уусан газрынхаа ойролцоо шавар шалбааг дээр мөр үлдээнэ. Бэлчээр нутагтаа хоргол, хэвтэр, үс үлдээсэн байдгаар нь таньж болно (зураг 46).

*Зураг 46. Цагаан зээрийн үлдээсэн ул мөр*



*Зургийг Н. Цэгмид 2024.09.8 өдөр*

### **Бор туулай - *Lepus tolai***

Манай орны ойгоос бусад бүх нутагт түгээмэл тархсан амьтны нэг. Бүрэнхий шөнөөр гүйж бут, харгана, өвслөг ургамал, дэрсээр хооллоно. Түүнчлэн бор туулай ойт хээр, хээр, говь цөлд өргөн дэлгэр тархацтай, голын хөндий, хээрийн ургамалтай задгай газар болон гол горхи, баян бүрд дагаж амьдрах бөгөөд үетэн, хунчир, тарваган шийр, шаваг, таана зэрэг шүүст өвслөг ургамлаар хооллоно. Хавар зонхилон дэрсний үндэс ухаж идэх дуртай гэж судлаачид (Цэнджав нар, 1989) тэмдэглэсэн байна. Ороо нийллэг 3-р сарын дунд үед болж, эм туулай 42 орчим хоног хээлээ тээдэг. Жилд 2 удаа төллөх ба нэг удаа дунджаар 2-6 бүжин төрүүлнэ. Нэг настай үржилд ордог. Байгалийн нөхцөлд 7 хүртэл жил насална. Бор туулай агнуурын ач холбогдолтой (Зураг 47).



*Зураг 47. Бор туулайн ялгадас болон мөр*

Хярс (*Vulpes corsak*)

Монголд өргөн тархацтай, элбэг мах идэштэн. Биеийн урт 50-60 см, сүүлний урт 25-36 см, чихний урт 6-9 см, биеийн жин 2-3 кг. Биеийн өнгө төрхөөрөө үнэгтэй төстэй боловч биеэр

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

илэрхий жижиг. Биеийн өнгө хул-шаргалдуу саарал. Сор үсний үзүүр цагаан тул мөнгөлөг туяатай харагдана. Нуруун тал нь хүрээтэр. Цээж болон хэвлий шаргал туяа бүхий цайвар. Сүүл богино, үзүүр нь хар. Өвлийн үс тод улаан шаргал, зуны үс улбар цайвар. Хярс үнэг нь Хэнтий, Хөвсгөлийн тайга, Алтай Хангайн өндөр уулс, Их Хянганы салбар уулс, Алтайн өвөр говийн хамгийн цөлөрхөг хэсэг зэрэг нутгаас бусад хээр, ойт хээр, уулын хээрийн ихэнх нутагт түгээмэл тархсан (Дуламсүрэн, 1970). Жинхэнэ тал хээрийн амьтан (зураг 48). Шөнө гөрөөлнө, өдөр нүхэнд орж, орой бүрэнхий болмогц идэш тэжээл эрж үүр цайтал гөрөөлнө. Зун, намар, хавар зонхилон жижиг мэрэгч, шувуу түүний өндөг, ангаахай, дэгдээхэй, заримдаа царцаа дэвхрэг, өвсний үр, амьтны сэг иднэ. Гээгдсэн суран чөдөр, хазаар, ногт, уургын хуйв зэргийг ч иддэг амьтан. Гэвч аль ч улиралд тэжээлийн 70-90%-ийг бэлчээрийн хортон үлийн цагаан оготно эзэлдэг. Ороо хөөцөө 2-р сард болж, 5 сард 2-5, заримдаа түүнээс ч олон гавар гаргадаг. Гавар хоёр долоо хоногийн дараа нүдээ нээж, сар шахам эхийгээ хөхнө. Сарын дараа бор хоолонд дасгадаг. Хавар гарсан зулзагууд зуны дунд сараас бие даан нэг нэгээрээ явж гөрөөлөх боловч төрсөн нүх болон бие биеэсээ нэн их холдохгүй.

*Зураг 48. Хялгана дээрх хярсны ялгадас*



Саарал чоно, түүний ялгадас нь нохдын овгийн бусад махчин амьтдынхаас хэмжээгээр том, бараан, бүдүүн, үс ноос, хялгас, ясны хэлтэрхий ихтэй байдгаараа амархан ялгагдана (Зураг 49).

*Зураг 49. Чонын ялгадас. Цэн тогоруу 1 талбайд*



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Төслийн талбайд тарвага амьдарч байжээ. Бидний олсон хавх бол он удаан жил хаягдаж хавхны тал нь шороонд дарагдсан байв. Хавх гар хийцийнх бөгөөд гинжээр аргамжсан байв (зураг 50). Монгол тарваганы тархалтын зургаас үзвэл энэхүү хайгуулын талбайд тарвага тархан амьдардаг болохыг тэмдэглэсэн байна.

Зураг 50. Хавх



**Монгол чичүүл (*Meriones unguiculatus*)**

**Амьдралын онцлог.** Хоногийн турш идэвхтэй. Бүлээр амьдардаг, социаль зан төрхтэй. Нийлмэл бүтэцтэй нүхэнд амьдрах ба гүн нь 150 см хүрнэ. Үлийн цагаан оготны хуучин нүхийг ашиглана. Ургамлын янз ыүрийн хэсгээр хооллох боловч зуны улиралд ургамлын ногоон хэсэг, өвөл, хавар үр голлоно. Идэш тэжээлээ нөөцлөнө. Өвөл ичихгүй. Сонор соргог амьтан. Нүхний гадна идээшлэх нь бага, хоолоо голдуу нүх рүүгээ зөөнө. Хээлээ тээх хугацаа 25-30 хоног. Жилд 1-2 удаа төллөх бөгөөд төрөх бүрдээ 3-8 гөлчгий гаргана. Байгалийн нөхцөлд 1-2 насална.

**Амьдрах орчин.** Говь, хуурай хээрийн бүсээр тархах ба гол мөрний хөндий дагаж ойт хээрт нэвтэрнэ. Уулын хээрт ч тохиолдоно. Үет ургамал, харгана, бударгана бүхий элсэрхэг говь, хуурай хээрт хамгийн элбэг. Хот суурин газрын ойролцоо ч тохиолдоно.

**Амьдралын ул мөр.** Монгол чичүүлийн амьдрахад тохиромжтой газарт байгаа нүх, суурьшлаар (колони) нь таньж болно. Суурьшил нь ойр ойрхон байрласан олон амсар, шинэхэн гаргасан шороогоор таньж болно.

Замын уулвар буюу мониторингийн 9-р цэгт монгол чичүүлийн нүх элбэг тааралдана (зураг 51).

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Зураг 48. Монгол чичүүлийн нүх, 2024.06.08*



**Халздай дорго (*Meles leucurus*)**

*Амьдралын онцлог.* Суусрын овгийн дотроос нийлмэл бүтэцтэй нүх ухаж ганц нэгээр, хосоор, бүлээр амьдардаг онцлогтой. Шөнийн болон бүрэнхийн идэвхтэй. Элдэв идэштэн. Ихэвчлэн шавж, зөөлөн биетэн, чийгийн хорхой зэргээр хооллох ба жижиг сээртэн, жимс жимсгэнээр хооллоно. Ичээнд орохын өмнө их хэмжээний өөх хуримтлуулна. Намар 10 сараас дараа оны 4 сар хүртэл ичээлнэ. Ичээндээ төрнө. Нэг төрөлтөөр 1-6 ганьс гаргана. Хээл тээх хугацаа урт. Төрсний дараахан ороо орно. Орооны үе хавраас намар хүртэл үргэлжилнэ. Далд үетэйгээ нийлээд хээл тээх хугацаа 1 сар орчим үргэлжилнэ.

*Амьдрах орчин.* Ойт хээр, хээр, говийн бүсээр чийглэг, нам дор газар, голын хөндий, баянбүрд бараадан амьдарна.

*Амьдралын ул мөр.* Том хүчирхэг тавхай, урт хумстай тул цас, шавар дээрх мөрөөр таньж болно. Нүхний ойролцоо янз бүрийн сээр нуруунгүйтны үлдэгдэл бүхий баас үзэгдэнэ.

*Зураг 49. Халздай дорго 2024.06.07-ны шөнө*



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Хүснэгт 42. Хөхтөн тааралдсан мониторингийн цэгүүд 6 болон 9 сард

№	Баг, овог, зүйлийн нэр		Ажиглалтын цэг															
			Талбайн баруун талын хужир мараат хөндий		3-р цэг		4-р цэг		7-р цэг		8-р цэг		Замын уулзвар-9 цэг		Цэн тогоруу-2		Мазаалай-1	
			2024 он															
			ҮИ. 8	IX. 8	ҮИ. 9	IX. 9	ҮИ. 8	IX. 8	ҮИ. 9	IX. 8	ҮИ. 9	IX. 8	ҮИ. 9	IX. 8	ҮИ. 8	IX. 8	ҮИ. 8	IX. 8
<b>I</b>	<b>LAGOMORPHA - ТУУЛАЙТАН</b>																	
1	Бор туулай	<i>Lepus tolai</i>		мөр					ялгас			ялгас						
<b>II</b>	<b>RODENTIA - МЭРЭГЧТЭН</b>																	
2	Монгол чичүүл	<i>Meriones unguiculatus</i>							нүх				нүх					
<b>III</b>	<b>CARNIVORA - МАХЧТАН</b>																	
3	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>							ялгас									
4	Саарал чоно	<i>Canis lupus</i>									ялгас							
5	Халздай дорго	<i>Meles leucurus</i>		1														
<b>IV</b>	<b>ARTIODACTYLA - ТУРУУТАН</b>																	
6	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	сэг+мөр	3000 сэг	6ad+2 juv	сэг	2000	3 ad	3ad+1juv	сэг	1ad+1juv	сэг	мөр	сэг	1ad+1juv	сэг	60	




## 2.8 УРГАМЛАН НӨМРӨГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024 -Н ГҮЙЦЭТГЭЛ

### 2.8.1. Судалгааны материал

Бид хээрийн судалгааг 2024 оны 6-р сард 13, 9-р сард нийт 14 цэгт ургамлын мониторинг цэгүүдэд бичиглэл хийж, материал цуглуулав.

Зураг 50. Ургамлын хээрийн судалгааны мониторинг цэг



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

**2.8.2. Судалгааны арга зүй**

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэлийн ажлын ургамлын судалгаанд ургамлын буюу геоботаникийн бичиглэлийг 100 м<sup>2</sup> талбайд хийж дараах судалгааг хийсэн:

- Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхойлох,
- Ургамлын бүрхэц тодорхойлох /халцгай, хад чулууны бүрхэц/
- Ургац тодорхойлох

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн фото зургийг авахдаа 1м<sup>2</sup>-ын тор тавьж, эгц дээрээс нь авах бөгөөд фото зургийг тайланд оруулахдаа дараах мэдээллийн хамт бичсэн.

- Аймгийн/нийслэлийн нэр
- Сумын/ дүүргийн нэр
- Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар
- Солбицол
- Он сар өдөр

**Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тогтоох арга:** Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо 100 ам метр /10м x 10м/ газрын дөрвөн өнцөгт нь ялгах тэмдэг тавьж, нэг өнцгөөс нөгөө өнцгийг чиглэн диагалдан явж тохиолдох бүх ургамлыг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн нэршлийг Монгол орны гуурст дээд ургамлын бүртгэл бичигт (И.А.Губанов, 1996) болон ургамал таних бичигт (В.И.Грубов, 2008) зааснаар нэрлэж, олон улсын СИ системийн нэршлээр филогенетик системийн дагуу жагсаан бичсэн.

Зүйл ургамлын арвийг өгөхдөө харьцуулах үндсэн мэдээнд аль аргыг хэрэглэснээс хамааран 2.1, 2.2-р хүснэгтэд үзүүлсэн шатлалыг хэрэглэн ургамал тус бүрийн арвийг талбайгаа 100 % гэж үзэн нүдэн баримжаагаар тооцоолон хувилж өгсөн.

Зүйлийн жагсаалт хийх үед танихгүй юмуу эргэлзээтэй ургамал тааралдвал цуглуулгад авч дугаар, болзолт нэр, хугацаа, ургамал цуглуулсан газар ба бэлчээрийн хэв шинжийн нэрийг жижиг цаасан дээр бичиж хавсаргав.

*Хүснэгт 43. Друдегийн үнэлгээ*

Бүрхэцийн хэмжээ		Зүйлийн баялгийн онцлог	Хоорондын зай, см
Кодоор	Хувь		
Сop <sup>2-3</sup>	30 дээш	Нэн арвин	<20
Сop <sup>1</sup>	10-25	Арвин	20-40
Sp	5-10	Тармагдуу	40-100
Sol	1-5	Дунд зэрэг	100-150
R	1	Нэн ховор	>150

**2. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц, халцгай газар, хагд, хад чулууны хэмжээг тодорхойлох:** Газрын гадарга дээрх ургамлан нөмрөгийн бүрхэц, халцгай газар, хайрга чулуу, хагдны хэмжээг тодорхойлохдоо: Л.Г.Раменскийн 1м<sup>2</sup> -ийн трансектын тороор ургамлан нөмрөгийн бүрхэц тодорхойлох уламжлалт аргыг хэрэглэсэн.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Ажиглалтын талбай дотроо дурын цэгийг сонгон трансектын торыг ашиглан тодорхойлсон. Торны 1 нүд 1%-тай тэнцэнэ.

Торны эгц дээрээс нь харж, зогсоо байдлаас хөрсний гадаргын бүрхцийг торны 1 нүдийг 1 хувь гэж тооцон нүд болгоноор тоолон ургамлын бүрхэц, халцгай газрын хэмжээ, хад чулууны хэмжээ, хагдны бүрхцийг хувилж гарган доорх нүдэнд бичсэн.



Зураг 51. Трансектын тор, 6-р сар

Трансектын тор, 9-р сар

**Хүснэгт 44. Ургамлан нөмрөгийн төлөв байдал**

Бэлчээрийн хэв шинж	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц, %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцгай газрын хэмжээ, %	Хад, чулууны хэмжээ, %	Хагдны хэмжээ, %	Ургац ц/га
	1 м <sup>2</sup> талбайд,	1 м <sup>2</sup> талбайд,	100 м <sup>2</sup> талбайд					
Давталт 1								
Давталт 2								
Давталт 3								
Давталт 4								
Давталт 5								

**3. Ургац тодорхойлох арга.** Ургацын дээжийг бүрхэц тодорхойлсон цэгээс (1 м<sup>2</sup> талбай) ургамлыг газрын хөрснөөс 0 см-ийн түвшинд хагд, ногоог аж ахуйн бүлгээр ялган, хайчлан авч сүүдэр газар тавьж хатаан 0,01 нарийвчлалтай жингээр хуурай жинг жигнэж тогтоов. 5 давталтын тоог дундажлан талбайн ургацын тон мэдээг гаргасан. Хэмжилтийг хүснэгтэд нэгтгэн давталтын дундаж гр-аар хэмжигдсэн ургацыг ц/га гэсэн нэгжид шилжүүлэн тооцож тэмдэглэв.

**4. Бэлчээрийн талхагдал**

Бэлчээрийн талхагдалыг ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт ба ургамлын тусгац бүрхэц болон ургацаар тодорхойлсон. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлтийг Друдегийн аргаар, ургамлын тусгац бүрхэвчийг Л.Г.Раменскийн аргаар тус тус тодорхойлсон.

## **Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Бэлчээрийн талхлагдалыг дараах 3 зэрэглэлд хуваасан. Үүнд:

- Сул талхлагдсан
- Дунд талхлагдсан
- Хүчтэй талхлагдсан

Сул талхлагдсан бэлчээр: Үндсэн бүлгэмдлийн зохилогч, дэд зохилогч нь ценоз /бүлгэмдэл/ үүсгэх үүрэг өөрчлөгдөхгүй. Сул талхагдалд орсон бол бэлчээрийн зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт бага зэрэг орж, үетний тоо буурч, алаг өвсний тоо ихсэх хандлагатай.

Дунд зэрэг талхлагдсан бэлчээр: Зонхилогч ургамлын ариг багасаж, агь, ишгүй гичгэнэ /навтуул/, арзгар согсоолж, нэг наст шарилжууд ариг ихтэй ургана. Дунд талхагдалд орсон бол зүйлийн бүрэлдэхүүний тоо мэдэгдэхүйц цөөрч, ургамлын бүрхэц багасаж, бүрхцэд талхагдлын заагуур ургамлын арви ихэссэн.

Их талхлагдсан бэлчээр: Үндсэн бүлгэмдэл зохилогч ургамлууд цөөрөн ганц нэг болон сийрэгжиж оронд нь агь, адамсийн шарилж, ширэг улалж, амманы сэдэргэнэ зэрэг мал иддэггүй хог ургамлын ариг нэмэгдэнэ. Их талхагдалд орсон бол зүйлийн бүрэлдэхүүний тоо эрс цөөрч, тухайн бэлчээрт 2-3 талхагдлын заагуур ургамал давамгайлсан зонхилогч болсон.

### **2.8.3 Ургамалжлын мониторинг судалгааны үр дүн**

#### **Ургамлан нөмрөгийн төлөв байдал**

**Ургамалжлын бичиглэл:** Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд ургамалжлын 14 бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь

Х-хээрийн Хялгана-улалж-хазаарт (106 /Х-I-2-5), Хялганат (110 /Х-I-2-9), Хялгана-хиагт (105 / Х-I-2-4), Хялгана-биелэгт (108/ Х-I-2-7), Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт (126 / Х-II-2-5), Үетэнт- жижиг улалжит (120 / Х-I-4-1), Хялгана-харганат (129 / Х-II-2-8) бүлгэмдэл байна.

Н-Нам хотосын Улалж-дэрст (228 / Н-III-5-1), Үетэн-жижиг улалж-бударганат (219/ Н-III-2-3), Дэрс -өлөнгөт (222 / Н-III-3-3) бүлгэмдэл байна.

Тус мониторингийн талбай нь газрын гадаргын төрх байдлын хувьд ландшафтын ялгарлаар хээрийн цэвэр өвслөг ургамалтай 168.72 га, бүс дундын нугын 45.2 га талбай байна.

Тус мониторингийн талбайн ургамлан нөмрөгийн 100 м<sup>2</sup> талбайд 7-18 зүйл, 1м<sup>2</sup> талбайд 3 - 10 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын тусгаг бүрхэц 2024 оны 6-р сарын 20, 21-ны байдлаар хээрээр 53.0-75.0%, дэрст нугадаа 64.4-87.4%, га –ийн ургац хээрээр 3.644-6.396 центнер, нугадаа 2.55-4.828 центнер байсан бол 9-р сарын 8-ны байдлаар хээрээр 71.2-84.6%, дэрст нугадаа 77.0-90.2%, га –ийн ургац хээрээр 9.976-12.11 центнер, нугадаа 7.126-10.07 центнер байсан.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Хүснэгт 45. Ургамалжлын бичиглэл, 2024 он 6 сар

№	Бэлчээрийн төрөл	Бэлчээрийн ургамалжлын шалгуур үзүүлэлт							
		Зүйлийн тоо (100м <sup>2</sup> талбайд)	Зүйлийн тоо (1м <sup>2</sup> талбайд)	Ургамлын бүрхэц, %	Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хад, хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац, ц/га
1	Хялгана-улалж-хазаарт (106 /X-I-2-5))	12	4-6	53.0	5.2	19.8	0.0	27.2	3.838
2	Хялганат (110 /X-I-2-9)	14	4-6	75.0	3.2	19.6	-	5.4	6.396
3	Хялгана-хиагт (105 / X-I-2-4)	9	3-5	53.8	16.6	29.4	2.4	14.4	3.828
4	Улалж-дэрст (228 / Н-III-5-1	7	6-7	87.4	1.0	7.4	0.0	5.2	4.828
5	Үетэн-жижиг улалж-бударганат (219/ Н-III-2-3)	10	3-5	64.4	11.8	28.4	0	7.2	2.55
6	Дэрс -өлөнгөт (222 / Н-III-3-3)	18	5-10	74.6	12.0	15.2	2.2	8.0	4.312
7	Хялгана-биелэгт (108/ X-I-2-7)	11	5-6	60.4	2.8	12.0	0.0	27.6	5.37
8	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт (126 / X-II-2-5)	9	5-6	55.6	23.4	32.6	1.4	10.4	3.644
9	Үетэнт- жижиг улалжит (120 / X-I-4-1)	7	4-5	66.6	5.0	19.6	0.0	13.8	3.864
10	Хялгана-харганат (129 / X-II-2-8)	29	5-10	54.6	32.0	35.2	2.2	8.0	4.312


Хүснэгт 46. Ургамалжлын бичиглэл, 2024 он 9 сар

№	Ургамлан ургамалжил, нөмрөгийн бэлчээрийн төрлөөр	Ургамалжлын мониторинг шалгуур үзүүлэлт							
		Зүйлийн тоо (100м <sup>2</sup> талбайд)	Зүйлийн тоо (1м <sup>2</sup> талбайд)	Ургамлын бүрхэц, %	Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хад, хайрга, чулуу, %	Хагд, %	Ургац, ц/га
14	<i>Carex duriuscula</i> C.A.Меу.-Ширэг улалж	Cop <sup>2</sup>	1, 2, 3, 4, 5,
3	<i>Iridaceae</i> Juss.-Цахилдагны овог		
12	<i>Iris</i> L.		
15	<i>Iris lactea</i> Pall.- Цагаалин цахилдаг	Sol	5

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

4	<i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог		
13	<i>Chenopodium</i> L.		
16	<i>Chenopodium aristatum</i> L. - Сортой лууль	Cop <sup>2</sup>	7
17	<i>Chenopodium album</i> L.-Цагаан лууль	Cop <sup>2</sup>	2
18	<i>Chenopodium acuminatum</i> Willd.- Шоргор лууль	Cop <sup>1</sup>	6
14	<i>Corispermum</i> L.		
19	<i>Corispermum declinatum</i> Steph.-Өнхрүүш хамхуул	Cop <sup>2</sup>	10
15	<i>Kalidium</i> Moq.		
20	<i>Kalidium gracile</i> Fenzl.- Гоолиг шарбударгана	Cop <sup>1</sup>	5
16	<i>Salsola</i> L.		
21	<i>Salsola collina</i> Pall.-Толгодын бударгана	Cop <sup>1</sup>	2
5	Тоонолжин цэцэгтэний овог ( <i>Cruciferae</i> Juss.)		
17	<i>Lepidium</i> L.		
22	<i>Lepidium densiflorum</i> Schrad.-Бөөн цэцэгт цангуу	Cop <sup>1</sup>	1
18	<i>Dontostemon</i> Andrz.		
23	<i>Dontostemon integrifolius</i> (L.) С.А.Меу -Бүхэл навчит багдай	Sol	3
6	<i>Papaveraceae</i> Juss. -Намуугийн овог		
19	<i>Chiazospermum</i> Bernh.		
24	<i>Chiazospermum erectum</i> L.-Цэх галуун таваг	Sol	2
7	<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог		
20	<i>Potentilla</i> L.		
25	<i>Potentilla bifurca</i> L.-Имт гичгэнэ	Cop <sup>1</sup>	1, 3, 5,
26	<i>Potentilla tanacetifolia</i> Willd.ex Schlecht.-Марал навчит гичгэнэ	Cop <sup>1</sup>	10
27	<i>Potentilla multifida</i> L.- Хузмэл гичгэнэ	Sol	2
8	<i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог		
21	<i>Thermopsis</i> R.Br.		
28	<i>Thermopsis lanceolata</i> R.Br.-Юлдэн тарваган шийр	Sol	6
22	<i>Medicago</i> L.		
29	<i>Medicago falcata</i> L.- Шар царгас	Cop <sup>1</sup>	10
23	<i>Melilotus</i> Mill.		
30	<i>Melilotus suaveolens</i> Ldb.-Үнэрт хошоон	Sol	10
24	<i>Caragana</i> Lam.		
31	<i>Caragana pygmaea</i> (L.) DC.-Тарваган харгана	Sol	1, 2
32	<i>Caragana microphylla</i> (Pall) Lam.- Жижиг навчит харгана	Sol	4, 10
25	<i>Astragalus</i> L.		
33	<i>Astragalus galactites</i> Pall.-Цагаан хунчир	Sol	1
34	<i>Astragalus adsurgens</i> Pall.-Нумраа хунчир	Sol	6
26	<i>Glycyrrhiza</i> L.		

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

35	<i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.-Урал чихэр өвс	Sol	1, 2
27	<i>Lespedeza</i> Michx.		
36	<i>Lespedeza dahurica</i> (Laxm.) Schingdl.-Дагуур хошоонбут	Sol	3
9	<i>Rutaceae</i> Juss. -Сүлүүгийн овог		
28	<i>Haplophyllum</i> Juss.		
37	<i>Haplophyllum dahuricum</i> (L.) G. Don – Дагуур хүж өвс	Sol	3
10	<i>Boraginaceae</i> Juss. - Ноцоргонын овог		
29	<i>Lappula</i> Fabr.		
38	<i>Lappula intermedia</i> (Ldb.) M.Pop.- Завсрын ноцгоно	Cop <sup>1</sup>	4, 10
11	<i>Scrophulariaceae</i> Juss. -Иршимбийн овог		
30	<i>Cymbaria</i> L.		
39	<i>Cymbaria dahurica</i> L.- Дагуур хатны цэцэг	Sol	2
12	<i>Asteraceae</i> Dumort. -Гол гэсэртэний овог		
31	<i>Filifolium</i> Kitam.		
40	<i>Filifolium sibiricum</i> (L.) Kitam.- Сибирь зүр өвс	Cop <sup>2</sup>	10
32	<i>Artemisia</i> L.		
41	<i>Artemisia mongolica</i> Fisch. ex Nakai -Монгол шарилж	Sol	5, 7, 8, 10
42	<i>Artemisia frigida</i> Willd.-Агь	Cop <sup>3</sup>	6
43	<i>Artemisia Sieversiana</i> Willd.-Сиверсийн шарилж	Cop <sup>1</sup>	4
44	<i>Artemisia Adamsii</i> Bess.-Адамсын шарилж	Cop <sup>1</sup>	6
45	<i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.-Ямаан шарилж	Cop <sup>1</sup>	1, 5, 6
46	<i>Artemisia dracuncululus</i> L.-Ишгэн шарилж	Cop <sup>1</sup>	9
33	<i>Taraxacum</i>		
47	<i>Taraxacum dissectum</i> (Ldb.) Ldb.- Цуулбар багваахай	Cop <sup>1</sup>	1
	12 овог, 33 төрөл, 47 зүйл		

Ургамлын ангиллын үндсэн бүлгийн бүтэц. Уг талбайд бүртгэгдсэн зүйл ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд ойм, шивэрсэн, шивлээ, нүцгэн үртэний хүрээний хүрээний зүйл ургамалгүй, далд үртэний хүрээний 47 зүйл (үүнээс нэг талтан 15 зүйл, хос талтан 32 зүйл) байна (хүснэгт 87) [10].

*Хүснэгт 88. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайн ургамлуудын ангиллын үндсэн бүлгийн бүтэц*

Ангиллын үндсэн бүлгүүдийн нэр	Овгийн тоо	Төрлийн тоо	Зүйлийн	
			тоо	эзлэх хувь (%)
Далд үртний хүрээ	12	33	47	100.0
Үүнээс:				
а. Нэг талт үрт ургамлын анги	3	12	15	31.91
б. Хос талт үрт ургамлын анги	9	21	32	68.09

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**


Энд бүртгэгдсэн ургамлаас үетэн, буурцагтан, голгэсэртэн, лууль, сарнай, тоонолжин цэцэгтэний овгууд нь төрөл, зүйлийн тоогоор эхний 6 –д жагсаж байгаа [9, 10] бөгөөд бусад овгууд ганц зүйлтэй байна. Эхний 6 овогт багтах зүйл ургамлууд судалгааны талбай орчмын бүх зүйлийн ихэнхийг буюу 87.24% -ийг бүрдүүлж байна (Хүснэгт 59).

*Хүснэгт 89. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд бүртгэсэн ургамлын ангиллын бүтэц*

№	Овог	Төрлийн тоо	Зүйлийн тоо	Эзлэх хувь, %
1	<i>Gramineae</i> Juss.-Үетэний овог	10	13	27.66
2	<i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог	7	9	19.15
3	<i>Asteraceae</i> Dumort. -Гол гэсэртэний овог	3	8	17.02
4	<i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог	4	6	12.77
5	<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог	1	3	6.38
6	<i>Тоонолжин цэцэгтэний овог (Cruciferae</i> Juss.)	1	2	4.26
	Нийт зүйлийн	26	41	87.24

Ургамлын амьдралын хэлбэр. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд ургаж байгаа 47 зүйл ургамлын амьдралын хэлбэрээр ялгахад 10 зүйл нэг наст өвслөг ургамал (21.28%), 32 зүйл олон наст өвслөг ургамал (68.09%), 5 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (10.64%) байна.

*График 59. Ургамлын амьдралын хэлбэр*



Ургамлын ач холбогдол ба хор холбогдол. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбай дахь бүх зүйл ургамлаас 11 овгийн 32 төрлийн 45 зүйл бэлчээрийн (95.74%), 8 овгийн 10 төрлийн 13 зүйл эмийн ашигт ургамал (27.66%), 10 овгийн 15

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

төрлийн 20 зүйл хөл газрын ургамал (42.55%) бүртгэгдсэн [4, 5, 10, 12] байна (хүснэгт 60).

*Хүснэгт 90. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбай дахь зүйлийн бүрдлийн онцлог*

Ач холбогдол ба хор холбогдол	Ангилал зүйн нэгж			Эзлэх хувь
	овог	төрөл	зүйл	
Бэлчээр тэжээлийн ургамал	11	32	45	95.74%
Эмийн ашигт ургамал	8	10	13	27.66%
Хөл газрын ургамал	10	15	20	42.55%

Бэлчээрийн ургамлаас малд онц сайн идэмжтэй Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Нугын биелэг өвс (*Poa pratensis* L.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Нангиад түнгэ (*Leymus chinensis* (Trin.) Tzvel.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.), Ахарсорт арвай (*Hordeum brevisubulatum* (Trin.) link.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), Shult.), Агь (*Artemisia frigida* Willd.), Жижиг навчит харгана (*Caragana microphylla* (Pall) Lam.), Нумраа хунчир (*Astragalus adsurgens* Pall.), зэрэг ургамлууд байна .

**Ургамлын зүйл хамгаалал.** Ургамал судлаач У.Лигаа, Ш.Дариймаа, П.Цэрэннадмид, төслийн багийн гишүүд Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Б.Бат-Энэрэл нарын хамт (2008 онд) Монгол орны нэн ховор ургамлын зурагт лавлахад 53 овог, 99 төрлийн 133 зүйл ургамал бүртгэсэн байдаг. 2009 онд У.Лигаа ахлагчтай эрдэмтэн судлаач Ш.Дариймаа, Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Х.Жамъяндорж, Б.Бат-Энэрэл нар Монгол орны ховор ургамлын зурагт лавлахад 355 зүйл ховор ургамлын ангилал зүй, таних шинж, тархац, ургах орчин, үржил, нөөц хомсдох шалтгаан, хамгаалах арга хэмжээ зэргийг бичсэн байна [6, 7, 8].

Дээрх судлаачдын бүтээлийн дагуу Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбай дотор ургаж байгаа нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын бүртгэлийг гаргахад нэн ховор ургамал бүртгэгдээгүй, ховор ургамал Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch.), Монголын унаган ургамал Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.) 1 зүйл, Монголд байгаа завсрын унаган ургамал Жижиг навчит харгана (*Caraganamicrophylla* (Pall) Lam.), эртний цөлийн үлдэц Дагуур хүж өвс (*Haplophyllum dahuricum* (L.) бүртгэгдсэн байгаа нь бүх ургамлын 8.52% нь хамгаалалтад авах шаардлагатай ургамалд багтаж байна (хүснэгт 90).

*Хүснэгт 91. “Матад ХХ” талбай дахь зүйлийн бүрдлийн онцлог*

Ургамал хамгааллын статус	Ангилал зүй			Эзлэх хувь
	Овог	Төрөл	Зүйл	
Нэн ховор ургамал	0	0	0	0.0%
Ховор ургамал	1	1	1	2.13%
Монголын унаган ургамал	1	1	1	2.13%
Монголд байгаа завсрын унаган ургамал	1	1	1	2.13%
Үлдвэр ургамал	1	1	1	2.13%
Бүгд				8.52%






**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд ургаж байгаа элбэг ургамлууд. Уг талбайд ургаж байгаа ургамлын фото зураг, ангилал зүй, статус, биологийн таних шинж, тархац, ургах орчны талаарх мэдээллийг доорх хүснэгтээр харуулав (Хүснэгт 62).

*Хүснэгт 92. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайн ургамлын таних шинж*

ХОВОР УРГАМАЛ	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Чихэр -өвсний төрөл (<i>Glycyrrhiza</i> L.)  Зүйл: <i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.-Урал чихэр өвс  Статус: Ховор ургамал  Биологийн онцлог:Иш эгц босоо мөчирлөг бус, 40-100 см өндөр, навчис 4-8 хос, өндгөрхүү зуувгар, цавуулаг булчирхайтай, цэцэг том, цайбар нил, богинохон цацаг үүсгэнэ, буурцаг том хавчгар, мушгирч тахийсан. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт. өвөр., Алаш., Өмнөговь дахь тархалт: Цагаан хад, Булан Сухайт, Наранбулаг, Улаан нуурын хөндий, Номгон сумын дэнгийн худаг, Ургах орчин: Чийглэг марцлаг нуга, марц, хужиртай элс, элсэрхэг хээр, нуур, голын хөндийд ургана. Ашигт чанар:Ногоон үед нь тэмээ сайн, хонь, ямаа дунд зэрэг иддэг. Эмийн гоц ашигт ургамал.</p>
МОНГОЛЫН УНАГАН (ЭНДЕМИК) УРГАМАЛ	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  <i>Astragalus galactites</i> Pall.-Цагаан Хунчир  Статус: Монголд байгаа завсарын унаган ургамал  Биологийн онцлог: Навчинцар 6-8 хос, сондгой өдөлсөн нийлмэл. Цэцэг бойтгорхуу хэлбэртэй, цагаан өнгөтэй, олон цэцэг газарт шигдэж ургасан харагддаг. Дэгнүүл үүсгэдэг олон наст өвслөг ургамал. Мал идвэл хорддог.. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд, Монг.-Алт, Дунд.Халх, Дорн.-Монг., Дунд. Халх., Говь-Алт. Алаш.</p>
МОНГОЛД БАЙГАА ЗАВСРЫН УНАГАН (СУБЭНДЕМИК) УРГАМАЛ	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Харганын төрөл (<i>Caragana</i> Lam.)  Жижиг навчит харгана (<i>Caraganamicrophylla</i> (Pall) Lam.  Биологийн онцлог:Шаравтар саарал холтостой эгц босоо найлзууруудтай 40-60 см өндөр сөөгөн ургамал. Үндэслэг ишээр үржиж сийрэгдүү сондуулархуу бут үүсгэнэ. Дагавар навчис нь моджиж доошоо нугарсан зүгс үүсгэнэ. Жижигхэн саарлавтар ногоон өнгийн зуван бөгөөд бараг нүцгэн 5-10 хос навч хан бүхий хос бус өдлөг навчнуудтай .Тархалт: Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Дунд. Халх, Дор. Монг. Ургах орчин: Элсэрхэг хээр, хээрийн хайргархаг, чулуурхаг хажуу, товцог,</p>




**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	сэвхүүл элс, хад, нуранганд ургана.
<b>ҮЛДЭЦ УРГАМАЛ</b>	
<i>Rutaceae</i> Juss. -Сүлүүгийн овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Rutaceae</i> Juss. -Сүлүүгийн овог  Хүж өвсний төрөл (<i>Haplophyllum</i> Juss.)  Зүйл: <i>Haplophyllum dahuricum</i> (L.) G. Don - Дагуур хүж өвс  Статус: Ховор, үлдэц ургамал  Биологийн онцлог: Доод хэсэгтээ модожсон, оло, нарийхан, саваархуу иштэй, 10-20 см өндөр ургадаг, эгц шулуун салаархаг, навчис 7-15 мм урт, нарийн зуувгар, булчирхайлаг, цэцэг шар, 5 гишүүнт, бамбай баг цэцэгт нэгдэг, хонхорцог таван мооо салбанлаг, нүцгэн.  Амьдралын хэлбэр: Заримдаг сөөгөнцөр. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг. –Даг., Хянг., Ховд., Дунд. Халх., Дорн. -Монг., Олон н., Говь –Алт. Цөлөрхөг хээрийн үйрмэг чулуут ба чулуурхаг хажуу, бэл хормой, хад асганд ургана. Ашигт чанар: Тэмээ хавраас намар хүртэл дунд зэрэг иддэг.</p>
<b>Эмийн ашигт ургамал</b>	
<i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог  Гичгэнийн төрөл (<i>Potentilla</i> L.)  Зүйл: <i>Potentilla bifurca</i> L.-Имт гичгэнэ  Статус: Элбэг  Биологийн онцлог: Үндэслэг иштэй, ёзоороосоо эхлэн салаалсан 5-25 см өндөр иштэй, навчис сондгой өдлөг нийлмэл, навчинцарууд үзүүртээ им адил оньтой ухагдсан байдаг, өтгөн налчгар үслэгтэй ургамал. Цэцэг тод шар. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дор. Говь., Говь –Алт., Зүүнгар. Ургах орчин: Марцлаг нуга, үйрмэг чулуурхаг хажуу, голын эргээрд ургана. Ашигт чанар: Бог мал ногоон үед нь сайн, үхэр, адуу тааруу, тэмээ дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Rosaceae</i> Juss. -Сарнайн овог  Гичгэнийн төрөл (<i>Potentilla</i> L.)  <i>Potentilla tanacetifolia</i> Willd.ex Schlecht.-Марал навчит Гичгэнэ  Биологийн онцлог: Салаалсан үндэстэй, 20-80 см өндөр иштэй, навчис сондгой өдөлсөн нийлмэл, налчгар ширүүн үсэрхэг. Том тод шар, хүрдэрхүү цэцэгтэй, цөөн цэцэгт баг цэцэг үүсгэдэг. Самранцар жимстэй.  Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг, Өүя., Ӓóя.Ӓàëб., Дорн.-Монг. Ургах орчин: Хээрийн нуга, уулын хайрга чулуутай хажуу, хээрийн сөөгөн ширэнгэн дунд ургана.</p>




Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

Leguminosae Juss. - Буурцагтаны овог	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Харганын төрөл (<i>Caragana</i> Lam.)  Жижиг навчит харгана (<i>Caraganamicrophylla</i> (Pall) Lam.  Биологийн онцлог: Шаравтар саарал холтостой эгц босоо найлзууруудтай 40-60 см өндөр рсөөгөн ургамал. Үндэслэг ишээр үржиж сийрэгдүү сондуулархуу бут үүсгэнэ. Дагавар навчис нь моджиж доошоо нугарсан өргөсүүсгэнэ. Жижигхэн саарлавтар ногоон өнгийн зууван бөгөөд бараг нүцгэн 5-10 хос навч хан бүхий хос бус өдлөг навчнуудтай. Тархалт: Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Дунд. Халх, Дор. Монг. Ургах орчин: Элсэрхэг хээр, хээрийн хайргархаг, чулуурхаг хажуу, товцог, сэвхүүл элс, хад, нуранганд ургана.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  <i>Medicago falcata</i> L. - Шар Царгас  Үндсэн шинж: Бутаар ургадаг олон наст ургамал. Иш 40-60 см өндөр, олон нумраа, эсвэл өндиймөл. Гурвалсан нийлмэл навчтай. Навчинцар үсэрхэг, 10-20 мм урт, нарийн шаантгархуу, уртавтар, дундаас дээш юмуу орой тус газраа шүдэрхэг. 20-30 тод шар цэцгүүд нь толгойрхуу нягт багцагт нэгдэнэ. Буурцаг 7-12 мм урт, 3 мм өргөн, гонзгойвтор, ихэвчлэн хадуур лугаа адил махир, хааяа шулуун, нүцгэн, эсвэл үсэрхэг. Цэцэглэж үрлэх хугацаа: VII -VIII сар. Тархалт: Хэнт., Монг. -Даг., Дорн. -Монг., Хянг., Дунд. Халх., Олон н., Дорн. Говь. Ургах газар, орчин нөхцөл: Хээржүү нуга ба хажуу, хуурай ойн цоорхойн элсэрхэг болоод шаварлаг хөрс, эргийн хайр ба элс, тариа ногооны талбайд ургана. Эмийн ач холбогдол: Газар дээрх биеийг бөөр ба уушигны өвчинд ууна.</p>
	<p>Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Хошооны төрөл (<i>Melilotus</i> Mill.)  Зүйл: <i>Melilotus suaveolens</i> Ldb.-Үнэрт хошоон  Статус: Элбэг  Биологийн онцлог: Голлосон үндэстэй, 20-50 см өндөр ургадаг, гурвалсан нийлмэл навчтай, навчинцар гонзгойдуу тонгоруу өндгөрхүү, хоёр хажуугаараа 6-11 жижигхэн жигд бус шүдлэгтэй, шар өнгийн бойтгорхуу цэцэгтэй, цацаг баг цэцэгт нэгддэг, буурцаг өндгөрхүү, торлог, ганц үртэй. Амьдралын хэлбэр: Хоёр наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Ханг., Монг. -Даг., Хянг., Монг.-Алт., Дунд Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь. -Алт., Ургах орчин: Голын эргийн марзлаг нуга, элстэй газар, элсэрхэг хээр, уулын нугат хажууд ургана. Ашигт чанар: Үхэр адуу иддэг. Тарималжуулах боломжтой.</p>



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Leguminosae</i> Juss. - Буурцагтаны овог  Тарваганшийрийн төрөл (<i>Thermopsis</i> R. Br.)  Зүйл: <i>Thermopsis lanceolata</i> R.Br.-Юлдэн тарваган шийр  Статус: Элбэг ургамал.  Биологийн онцлог: Мөлхөө үндэслэг иштэй, 10-40 см өндөр ургадаг, богино налчгр сэрэвгэр үсэрхэг, гурвалсан нийлмэл гонзгой юлдэрхүү навчтай, шар өнгийн бойтгорхуу цэцэгтэй, 2-3 –аараа тойруулгаар байрладаг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. -Монг., Олон н., Дорн. говь. Ургах орчин: Хайргархаг чулуурхаг хээржүү хажуу, бэл хормойд ургана. Ашигт чанар:Газар дээрх бие, үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
<p><b>Asteraceae Dumort. -Гол гэсэртэний овог</b></p>	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)  Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)  Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae</i> Dumort.)  Зүр өвсний төрөл (<i>Filifolium</i> Kitam.)  Зүйл: <i>Filifolium sibiricum</i> (L.) Kitam.- Сибирь Зүр өвс  Статус: Элбэг  Биологийн онцлог: Иш 20-60 см өндөр ургадаг. Бүдүүн ташуу үндэслэг иштэй, урт бариултай хар ногоон, хошоод өдлөг цуулбар навчтай, навчны үзүүрийн салбан утсархуу. Цэцэг шар, сагснуулд нийлмэл бамбайд нэгддэг. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Дорн.-Монг. Ургах орчин: Хуурай хээр, уулын чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Бог мал, адуу, үхэр хавар зундаа дунд зэрэг иддэг.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)  Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)  Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae</i> Dumort.)  Төрөл: Шарилж (<i>Artemisia</i> L.)  Зүйл: <i>Artemisia frigida</i> Willd.-Агь  Статус: Элбэг  Биологийн онцлог: Богино үндэслэг иштэй, өтгөн бутгаар ургадаг, 10-40 см өндөр цайвар саарал хуурайсаг ургамал. Навчис налчгар торгомсог цайвар үслэгээр өвс хучигдмал, өдлөөг цуулбар, сагснууд нийлж унжгардуу цацаг баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Сөөгөнцөр. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Дорн. говь. Ургах орчин: Уул толгодын чулуурхаг ба хайргархаг хажуу, бэл хормой, хадархаг газар ургана. Ашигт чанар: Аль ч улиралд мал сайн иддэг, шимт чанар өндөр ургамал. Газар дээрх бие, үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Цуулбар багваахай (<i>Taraxacum dissectum</i> (Ldb.) Ldb.)          Үндсэн шинж: Сум иштэй, 5-20 ургадаг, сум иштэй. Навч гүнзний гол судалдаа хүртэл өдлөг цуулбар юмуу өдлөг хагалбар, юлдэрхүү юмуу шугаман юлдэрхүү хэлбэртэй. Цэцэг нь шар өнгөтэй, сагс баг цэцэгтэй, ороолтын гадаад навчинцар сэртэнгүй, захаараа цэцэглэх үедээ ороолцолдсон үстэй байснаа сүүлдээ гууждаг. Цэцэглэж үрлэх хугацаа: VI –VII сар.          Тархалт: Хөвс., Ханг., Хэнт., Монг-Даг., Дорн. Монг., Ховд., Монг. Алт. Ургах орчин: Голын эргийн хайргатай газар</p>
<p><b>Бэлчээрийн ургамал</b></p>	
	<p>Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог          Түнгийн төрөл (<i>Leymus</i> Hochat.)          Зүйл: <i>Elytrigia repens</i> (L.) Desv. ex Nevski.-Мөлхөө хиэг          Статус: Элбэг          Биологийн онцлог: Урт мөлхөө найлзууртай, 20-100 см өндөр ургадаг, навчис тэнэгэр хавтгай, өргөн шугамархуу, түрүүхэйн хайрс хөх ногоон, 3-7 тод судалтай, түрүү бортгорхуу, түрүүхэйнүүд жид цувраа байрлалтай. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.          Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар, Алт. –өвөр. Ургах орчин: Нугархаг хауу хээрээр ургана. Ашигт чанар: Үхэр хавар маш сайн, өвөл дунд зэрэг, адуу, бог мал, тэмээ аль ч улиралд сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)          Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог          Биелэгийн төрөл (<i>Poa</i> L.)          Зүйл: <i>Poa botryoides</i> Trin.-Цацаглаг биелэг өвс          Биологийн онцлог: Газар доор мөлхөө найлзуургүй, нягт дэгнүүл үүсгэдэг, иш 25-55 см өндөр ургадаг, 3 хүртэл цөөн үетэй, ишний 1/2-1/4 хүртэл навчтай, навч нарийн шугаман, хумираа, навчны хэлхэн 1-2 мм урт, давхар шүдлэг, залаа урт нарийн, шигүү, хүрэн ягаан туяатай ногоон, цэцгийн доод хайрс 5 бүдэг судалтай, хянга 1/2, захын судал 1/3 хүртэл богино зөөлөн үслэгтэй, каллус цөөн урт багц үстэй, амуу жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар. Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажууд ургана. Ашигт чанар: Бог мал хавар сайн, зун дунд зэрэг, адуу, үхэр зун сайн иддэг.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог          Биелэгийн төрөл (<i>Poa</i> L.)  <i>Зүйл: Poa pratensis</i> L.-Нугын биелэг өвс          Биологийн онцлог: Газар доор мөлхөө найлзууртай, зарим нь сийрэг дэгнүүл үүсгэдэг, иш 25-90 см өндөр ургадаг, 3-4 үетэй, ишний 2/3 навчтай, навч 4 мм өргөн, шугаман, хавтгай, навчны хэлхэн 0,5-2,0 мм урт, дугуйдуу бүтэн, залаа пирамид хэлбэртэй, ногоон өнгөтэй, цэцгийн доод хайрс 5 тод судалтай, хянга 1/2, захын судал 1/3 хүртэл богино зөөлөн үслэгтэй, судал хооронд үслэггүй, каллус өтгөн орооцолдсон бөөн багц үстэй, амуу жимстэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их.н., Говь-Алт., Зүүнгар. Ургах орчин: Голын эргийн чийглэг нугад ургана. Ашигт чанар: Тэмээнээс бусад мал өвлөөс бусад улиралд сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог          Хазаар өвсний төрөл (<i>Cleistogenes</i> Keng.)  <i>Зүйл: Cleistogenes squarrosa</i> (Trin.)Keng.-Дэрвээн хазаар өвс          Статус: Элбэг          Биологийн онцлог: Элсэн дугтуй бүхий сахлаг үндэстэй, жижиг сийрэг бутаар ургадаг, иш 5-10 үетэй, 15-30 см өндөр, навч хавтгай шугаман, юлдэрхүү, ширүүн, залаа баг цэцэг нь 5-7 см, 3-10 мм өргөн, түрүүхэй 2-4 цэцэгтэй, бор ногоон өнгөтэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт. Ургах орчин: Уулын чулуурхайг хайргархаг хажуу, хээр талаар ургана. Ашигт чанар: Тэмээнээс бусад мал зундаа сайн иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>  <i>Gramineae</i> Juss. –Үетэний овог          Хялганын төрөл (<i>Stipa</i> L.)  <i>Зүйл: Stipa Krylovii</i> Roshev.-Крыловын хялгана          Статус: Элбэг          Биологийн онцлог: 30-70 см өндөр 3 үетэй иштэй, сахлаг үндэстэй, нягт бутаар ургадаг, хуурайсаг ургамал. Навчны илтэсний дотогшоо хумираа, нарийн шугаман, залаа 10-20 см урт, түрүүхэйдээ нэг цэцэгтэй, шивээний сор 10-15 см урт, хошоод нугархай, нүцгэн. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Олон н., Дорн. говь., Говь-Алт.. Ургах орчин: Чулуурхаг хууйха хээр, элсэрхэг хайргархаг хуурай хажууд ургана. Ашигт чанар: Жилийн аль чулиралд тэмээнээс бусад мал сайн иднэ.</p>

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)          Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог          Дааган сүүлийн төрөл (<i>Koeleria</i> Pers.)          Зүйл: <i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schult.-Том цэцэгт дааган сүүл          Биологийн онцлог: Найлзуурын угийг хучиж буй хагдарсан навчны угларга тууш ширхэглэгээр салбарч цуурдаггүй, навчны илтэс үсэрхэг юмуу нүцгэн, залаа ногоовтор юмуу нил ягаавтар туяатай, түрүүхэй 3.5-5.5 мм урт, цэцгийн доод хайрс нүцгэн юмуу тачир үсэрхэг, тоосовч 1.5-2.3 мм урт. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Дорн.-Монг., Ховд., Монг. Алт., Хянг., Дунд. Халх., Дорн.Монг., Олон н., Говь-Алт. Ургах орчин: Уулын чулуурхаг хажууд ургана. Ашигт чанар: Адуу, бог мал хавар сайн, үхэр дунд зэрэг, тэмээнээс бусад мал өвөл, хавартаа муу иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)          Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)  <i>Gramineae</i> Juss. -Үетний овог          Түнгийн төрөл (<i>Leymus</i> Hochat.)          Зүйл: <i>Leymus chinensis</i> (Trin.) Tzvel.- Нангиад түнгэ          Статус: Элбэг          Биологийн онцлог: Үндэслэг иштэй, сийрэг дэгнүүл үүсгэдэг, шугамархуу шулуун навчтай, 15 см хүртэл урттай түрүү баг цэцэгтэй, түрүүхэй 1-2 (3), цэцгийн доод хайрс үсгүй юмуу богино өргөсөнцөртэй. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. Монг., Их.н., Олон.н., Дорн говь., Говь-Алт. Өмнөговь дахь тархалт: Ханбогд сумын бага мод. Ургах орчин: Нуга, цайдам, элс хайргатай тойромд ургана. Ашигт чанар: Бүх төрлийн мал өвөл дунд зэрэг, адуу, үхэр хавар, зун маш сайн, тэмээ, бог мал сайн иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)          Нэг талт үрт ургамлын анги (<i>Monocotyledonae</i>)  <i>Gramineae</i> Juss. -Үетэний овог          Арвайн төрөл (<i>Hordeum</i> L.)          Зүйл: <i>Hordeum brevisubulatum</i> (Trin.) link.-Ахарсорт арвай          Биологийн онцлог: Богино үндэслэг иштэй, 40-80 см өндөр ургадаг, 2-3 үетэй, навчны илтэс хавтгай шулуун, түрүү 3-9 см урт, цэцгийн доод хайрсны дээд бие богино өргөсөнцөртэй, доод бие гөлгөр, үзүүртээ 3-5 мм хүртэл урт сортой. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.          Тархалт: Хөвс., Ойёд., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн.Монг., Их н., Олон н., Говь Алт., Дорн. говь, Зүүнгар. Ургах газар, орчин нөхцөл: Голын хөндий, тойром, цайдамын хужирлаг нугад ургана. Ашигт чанар: Хавраас намар бүх төрлийн мал сайн иддэг. Тэжээлийн чанараар өндөр ургамал.</p>
<p><i>Iridaceae</i> Juss.-Цахилдагны овог</p>	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>          Iridaceae Juss.-Цахилдагны овог          Цахилдагны төрөл (<i>Iris L.</i>)          Зүйл: <i>Iris lactea</i> Pall.- Цагаалин цахилдаг          Статус: Элбэг          Биологийн онцлог: 20-50 см өндөр ургадаг, нягт дэгнүүлтэй, навчис 4-8 мм өргөн, сэлмэрхүү зузаан, цэцэг хөх ягаан, хучаас навч түнтгэр биш. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд.Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Алаш. Ургах орчин: Уулын гол, булгийн марзлаг эргээр ургана. Ашигт чанар: Хатсаны дараа үхэр дунд зэрэг, бог мал, тэмээ сайн иддэг, хадаж тэжээлд хэрэглэдэг. Үндэс, цэцэг, үрийг эмэнд хэрэглэнэ.</p>
<p><b>Cyperaceae Juss. - Улалжийн овог</b></p>	
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  <i>Нэг талт үрт ургамлын анги (Monocotyledonae)</i>          Cyperaceae Juss. – Улалжийн овог овог          Улалжийн төрөл (<i>Carex L.</i>)          Зүйл: <i>Carex duriuscula</i> С.А.Мей.-Ширэг улалж          Статус: Элбэг          Биологийн онцлог: Урт нарийхан үндэслэг иштэй, өтгөн багц найлзуур үсгэдэг, түрүүнцэр нарийн, уутанцар өргөн өндгөрхүү, шадар хайрс цайвар хүрэн.          Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт, Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн.говь., Говь –Алт. Ургах орчин: Элсэрхэг газар, хээржүү хажууд ургана. Ашигт чанар: Зун, намар адуу, бог мал маш сайн, үхэр сайн, тэмээ дунд зэрэг иддэг. Хөрс хучигч ургамал.</p>
<p><b>ХӨЛ ГАЗРЫН УРГАМАЛ</b></p>	
<p><b>Asteraceae Dumort. -Гол гэсэртэний овог</b></p>	
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгэсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Төрөл: Шарилж (<i>Artemisia L.</i>)  <i>Artemisia mongolica</i> Fisch. ex Nakai -Монгол шарилж          Үндсэн шинж: Навч гонзгойгоом өргөн өндгөрхүү хэлбэртэй, дээд тал нь нүцгэн, доод тал нь цагаан орооцолдсон үслэгтэй.          Цэцэглэж үрлэх хугацаа: VI –VII сар.          Тархалт: Хөвс., Ханг., Хэнт., Монг.-Даг., Хянг., Дорн. Монг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт. Ургах орчин: Эрэг орчмын ба уулын нуга, хээр, голын эргийн сөөгөн ширэнгэ, чулуурхаг хавцал, элсэн уурхай, сайрын хажууд, байшин, булаг, худаг, шуудуу, тариалан, орхигдсон газарт ургадаг.</p>



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгээсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Төрөл: Шарилж (<i>Artemisia L.</i>)          Зүйл: <i>Artemisia Sieversiana</i> Willd.-Сиверсийн шарилж          Статус: Элбэг          Биологийн онцлог: Иш 20-100 см өндөр, навчис өргөн гурвалжин, анхдагч сегмент өдлөг, үзүүрийн салбанцар гонзгой өндгөрхүү, сагс 4-7 мм өргөн, сийрэг залаа үүсгээг. Амьдралын хэлбэр: Нэг наст өвлөг ургамал.          Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Дорн говь., Говь-Алт. Ургах орчин: Чулуурхаг хажуу, хээр хөндийгөөр ургана. Ашигт чанар: Ногоон үед нь мал иддэггүй.</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгээсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Төрөл: (<i>Artemisia L.</i>)  <i>Artemisia Adamsii</i> Bess.-Адамсын шарилж          Үндсэн шинж: Сийрэгдүү саарал ногоону үмхий үнэртэй ургамал Навчис 1.5-6 см урт, 0,8-3,5 см өргөн, хошоод шурвантаа өдлөг цуулбар. Илтэс нь үзүүр хэсэг рүүгээ заримдаа цөөвтөр жижгэрсэн сегментүүдтэй, сагс шар том.          Тархалт: Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг.-Алт, Дунд.Халх, Дорн.-Монг., Олон н., Говь-Алт.          Ургах газар, орчин нөхцөл: Уулын чулуурхаг, хайргархаг хажуу, голын эрэг, хээр тал, хөндийгөөр</p>
	<p>Хүрээ: Бүрхүүл үрт ургамлын (<i>Angiospermae</i>)          Анги: Хос талт үрт ургамлын (<i>Dicotyledonae</i>)          Овог: Голгээсэртэний (<i>Asteraceae Dumort.</i>)          Төрөл: Шарилж (<i>Artemisia L.</i>)          Зүйл: <i>Artemisia dracunculus L.</i>-Ишгэн шарилж          Статус: Элбэг          Биологийн онцлог: Үндэслэг иш модожсон, 20-150 см өндөр сүрлэн шар иштэй, навчис шугаман юлдэрхүү, шовх, суурь орчимдоо хааяа үзүүр хэсэгтээ 3 салбантай, сагс унжуу шилбэтэй, өтгөн дэрэвгэр залаа баг цэцэгт нэгддэг. Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. Тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь – Алт., Алт. өвөр., Зүүнгар., Дорн. говь.          Ургах орчин: Уулын чулуурхаг хажуу, бэл, асга нураг, голын хайр, элсэнд ургана. Ашигт чанар: Тэмээ сайн, үхэр дунд, бог мал, адуу арай дутмаг иддэг. Навч, найлзуурыг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.</p>
<p><i>Chenopodiaceae Vent.</i> - Луулийн овог</p>	

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог  Хамхуулын төрөл (<i>Corispermum</i> L.)  Зүйл: <i>Corispermum declinatum</i> Steph.-Өнхрүүш хамхуул  Статус: Монголын завсрын унаган ургамал  Биологийн онцлог: Дээшээ дэрэвгэр мөчиртэй, хамхуул үүсгэдэг, навчис өргөн, нарийн тонгоруу өндгөрхүү юмуу зуувгар, үзүүрээдээ хурц, цэцгийн дагавар навчис шугаман юлдэрхүү, жимс гонзгойвтор тонгоруу өндгөрхүү, өвөр тал нь гүдгэр, дундуураа хөндлөн нугалаастай. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал. Тархалт: Ханг., Монг.-Даг., Дунд. Халх., Ургах орчин: Суурин газар хог хэлбэртэй ургахаас гадна, элсэрхэг хээр, жалга гуу дагаж ургана. Ашигт чанар:Тэмээ зундаа тааруу, намар, өвөл сайн иддэг. Бог мал муу иддэг.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог  Луулийн төрөл (<i>Chenopodium</i> L.)  Зүйл: <i>Chenopodium aristatum</i> L. - Сортой лууль  Статус: Элбэг  Биологийн онцлог: 5-30 см өндөр, ёзоороосоо эхлэн салаалж бөмбөгөр бут үүсгэдэг, намар улаавтар өнгөтэй болдог, навчис юлдэрхүү, бүтэн захтай, мухар оройтой, баг цэцгийн мөчрөнцөрийн үзүүр сортой. Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.  Тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг. Алт., Дунд. Халх, Дорн.-Монг., Их н., Дорн. Говь., Говь Алт., Алт. Өвөр., Алаш. Ургах орчин: Чулуурхаг хайргархаг хажууд ургана.  Ашигт чанар:Ногоон байхад нь тэмээ дунд зэрэг иднэ.</p>
	<p>Бүрхүүл үрт ургамлын хүрээ (<i>Angiospermae</i>)  Хос талт үрт ургамлын анги (<i>Dicotyledonae</i>)  <i>Chenopodiaceae</i> Vent. - Луулийн овог  Луулийн төрөл (<i>Chenopodium</i> L.)  Зүйл: <i>Chenopodium album</i> L-Цагаан лууль  Статус: Элбэг  Биологийн онцлог: 15-100 см өндөр, салаалсан эгц иштэй, навчис 2-6 см урт, 2-3.5 см өргөн, гурвалжин өндгөрхүү юмуу гонзгойвтор хэлбэртэй, цэцгүүд нийлж түрүүхүү баг цэцэг болж, тэдгээр нь нийлж залаа баг цэцэг үүсгэдэг, цэцгийн шадар эрхтэн өнгөрлөг хучаастай, жимс нь цэцгийн шадар эрхтэнтэйгээ цуг байх бөгөөд ерөнхийдөө эрхэрхүү байдалтай, нуруун талаасаа бөмбөгөрдүү, нөгөө тал нь хотгор, цайвар саарал өнгөтэй..Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг ургамал.Тархалт: Хөвс., Ханг., Монг. –Даг., Хянг., Х оvd, Монг.-Алт., Дунд. Халх, Дорн.- Монг., Говь-Алт.Ургах орчин: Суурин газар болон талхлагдсан дортойосн газар ургана. Ашигт чанар: Ногоон ба хатсан үед нь тэмээ дуртай, хонь, үхэр дунд зэрэг иддэг. Газар дээрх биеийг эмэнд хэрэглэнэ.</p>
<p><i>Boraginaceae</i> Juss. - Ноцоргонын овог</p>	

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II



Бүрхүүл үрт ургамлын хүрээ (*Angiospermae*)

Хос талт үрт ургамлын анги (*Dicotyledonae*)

*Boraginaceae* Juss. - Ноцоргонын овог

Ноцгонын төрөл (*Lappula* Fabr.)

Зүйл: *Lappula intermedia* (Ldb.) M.Pop.- Завсрын ноцгоно

Статус: Элбэг

Биологийн онцлог: Зөвхөн дээд хэсэгтээ салаархаг, ширүүн урт үсэрхэг, 5-15 см өндөр ургамал. Навч гонзгой, иш, навч үсэрхэг, цэцэг цэнхэр, мушгиа баг цэцэгтэй, самранцар гурвалжин, нуруун тавцан хянгагүй, товруулаг эмжээртэй, дээрээ нарийхан өргөстэй.

Амьдралын хэлбэр: Нэг наст ургамал

Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Монг. Алт., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Говь-Алт., Дорн. говь. Ургах орчин: Уул толгодын чулуурхаг энгэр хажуу, нуур, голын эргийн хайрганд, сайрын оёорт талд ургана. Ашигт чанар: Тэмээ зундаа дунд зэрэг иддэг.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

**ДУГНЭЛТ**

Утга	Ургамлын нөмрөгийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-2
<p><b>БОХШХ-Г6</b> Ургамлан нөмрөг</p>	<p>Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Матад ХХ” талбайд ургамалжлын 14 бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь хээрийн Хялгана-улалж-хазаарт (106 /X-I-2-5), Хялганат (110 /X-I-2-9), Хялгана-хиагт (105 / X-I-2-4), Хялгана-биелэгт (108/ X-I-2-7), Хялгана-жигжиг дэгнүүлт үетэнт (126 / X-II-2-5), Үетэнт- жижиг улалжит (120 / X-I-4-1), Хялгана-харганат (129 / X-II-2-8), нам хотосын Улалж-дэрст (228 / Н-III-5-1), Үетэн-жигжиг улалж-бударганат (219/ Н-III-2-3), Дэрс -өлөнгөт (222 / Н-III-3-3) бүлгэмдэл байна.</p> <p>Судалгааны талбайн ургамлан нөмрөгийн 100 м<sup>2</sup> талбайд 7-18 зүйл, 1м<sup>2</sup> талбайд 3 -10 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын тусгагын бүрхэц 2024 оны 6-р сарын 20, 21-ны байдлаар хээрээр 53.0-75.0%, дэрст нугадаа 64.4-87.4%, га –ийн ургац хээрээр 3.644-6.396 центнер, нугадаа 2.55-4.828 центнер байсан бол 9-р сарын 8-ны байдлаар ургамлын тусгагын бүрхэц хээрээр 71.2-84.6%, дэрст нугадаа 77.0-90.2%, га –ийн ургац хээрээр 9.976-12.11 центнер, нугадаа 7.126-10.07 центнер болж нэмэгдсэн байна.</p>
<p><b>Дүгнэлт</b></p>	<p>“Матад ХХ” талбай дотор 12 овог, 33 төрөл, 47 зүйл ургаж байгаагаас 45 зүйл бэлчээрийн (95.74%), 8 овгийн 10 төрлийн 13 зүйл эмийн ашигт ургамал (27.66%), 10 овгийн 15 төрлийн 20 зүйл хөл газрын ургамал (42.55%) бүртгэгдэж байгаагаас харахад хүн ба малын хөлөөр олшрогч хөл газрын ургамал нэмэгдэх хандлагатай байна.</p> <p>Тус талбай дотор 10 зүйл нэг наст өвслөг ургамал (21.28%), 32 зүйл олон наст өвслөг ургамал (68.09%), 5 зүйл сөөг, заримдаг сөөгөнцөр ургамал (10.64%) ургаж байгаагийн дотор нэн ховор, ховор, унаган, үлдвэр ургамлын бүртгэлийг гаргахад нэн ховор ургамал бүртгэгдээгүй, ховор ургамал Урал чихэр өвс (<i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.), Монголын унаган ургамал Цагаан хунчир (<i>Astragalus galactites</i> Pall.) 1 зүйл, Монголд байгаа завсрын унанаган ургамал Жижиг навчит харгана (<i>Caraganamicrophylla</i> (Pall) Lam.), эртний цөлийн үлдэц Дагуур хүж өвс (<i>Haplophyllum dahuricum</i> (L.) бүртгэгдсэн байгаа нь бүх ургамлын <b>8.52%</b> нь хамгаалалтад авах шаардлагатай ургамалд багтаж байна.</p>
<p><b>Зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ:</b></p>	<p>Тус талбайн тусгай зөвшөөрлийн талбайн байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд Дэрэвгэр жиргэрүү (<i>Saposhnikovia divaricata</i> (Turcz.) Schischk. ) ховор ургамал ургадаг тухай бичсэн боловч бидний судалгаагаар талбайд бүртгэгдээгүй, харин ховор ургамал Урал чихэр өвс (<i>Glycyrrhiza uralensis</i> Fisch.) нэлээд нөөцтэй ургаж байгааг хамгаалалтад авах, улмаар үр түүж тарималжуулах ажил хийхийг зөвлөж байна.</p>

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

## 2.9 НИЙГМИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ 2024 -Н ГҮЙЦЭТГЭЛ

Матад ХХ талбай нь 213.92 км.кв буюу өргөн уудам газар нутгийг хамарч байна. 2024 оны 6-р сарын байдлаар Цэн тогоруу-1 цооногийн нөхөн сэргээлтийг хийсэн байсан бол 9 сард Цэн тогоруу-2 цооногийг өрөмдөн үйл ажиллагаа явуулж эхэлж байсан ба Мазаалай-1 цооногийг өрөмдөж үйл ажиллагааг эхлүүлэхээр тоног төхөөрөмжийг буулгаж байв. Цэн тогоруу-1 талбайн манаачаар тухайн нутгийн иргэн (айл) ажиллаж байна.

*Зураг 63. Манаач айл (Цэн тогоруу-1)*



Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлснээр талбай дээр нийт 10 айл (өвөлжөө, зуслан эсэх тодорхойгүй) байна. Координатыг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 93. Төслийн талбайд байх айл, өрхүүд*


№	Нэр/эзэмшигч	Уртраг	Өргөрөг
1	Гантулга	116° 3' 42.265" E	46° 49' 58.594" N
2	Ганбаатар	116° 2' 50.284" E	46° 49' 45.792" N
3	Гантулга	116° 2' 16.704" E	46° 49' 17.180" N
4	Өнөржаргал	116° 1' 57.856" E	46° 48' 58.118" N
5	Саранхүү	116° 1' 42.862" E	46° 48' 44.203" N

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

6	Жаргалсайхан	115° 56' 41.131" E	46° 45' 32.015" N
7	Энхболд	115° 56' 49.279" E	46° 45' 20.018" N
8	Буянжаргал	116° 0' 24.349" E	46° 49' 54.537" N
9	Ганбат	115° 56' 23.018" E	46° 43' 47.294" N
10	Ганзориг	116° 4' 59.909" E	46° 46' 24.911" N


Эдгээр 10 айлын байршлыг дараах зурагт гаргав.

*Зураг 64. Талбай дээр тоологдсон айл өрхүүд*



Дээрх зургийн дагуу төслийн талбай баруун хойд зэрэгцээ байршиж буй 6 айлуудын байршил дээр бүгд нүүсэн хоосон гэрийн буурь байсан ба 4 гэрийн буурь шатсан байна. 1 гэрийн буурийг тойроод 5 үхэр 1 цагаан зээр үхсэн ба тодорхой хэмжээгээр шатсан байна. Тухайн айл нүүхэд зудад муудсан үхэр босож чадахгүй буурин дээр үлдэж үхсэний дараа хээрийн түймэрт өртсөн гэж таамаглаж байна.

Зураг 65. Айлын буурь



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Дараах гэрийн буурийг тойроод 5 үхэр 1 цагаан зээр үхсэн ба тодорхой хэмжээгээр шатсан байна. Тухайн айл нүүхэд зудад муудсан үхэр босож чадахгүй буурин дээр үлдэж үхсэний дараа хээрийн түймэрт өртсөн гэж таамаглаж байна.

*Зураг 66. Гэрийн буурь дээр үхсэн мал, 6 сар*



Төслийн талбай дээгүүр зам дагаж үхсэн мал (үхэр, адуу) нэлээд олон таарсан ба мөн цагаан зээр нэлээн их үхсэн байна. Үүнийг тухайн жилийн цаг уур, уур амьсгалын нөхцөл байдалтайгаар цас ихээр орж идэш тэжээл хомсодсоноос буюу зудад өртсөн гэж үзэж байна.



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Зураг 67. Зудад өртөж үхсэн мал, амьтан, 6 сар*



Мөнтүүнчлэн төслийн талбайн зүүн урд 4 сарын сүүл 5 сарын эхээр хэсгээр хээрийн түймэр гарсан байна.

*Зураг 68. Шатсан талбай, 2024 оны 6 сар*



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**



Шатсан талбайн хуучин хагд өвс шатаж, шинэ өвс ургасан байгаа тул тод ногоон өнгөөр ялгарч харагдаж байна.

*Зураг 69. Шатсан талбайн сэргээсэн байдал, 2024 оны 9 сар*



Мониторингийн ажлын хээрийн судалгаанд явж байхад тоологдсон айл өрхүүдийг доорх зурагт үзүүлэв.

Зураг 70. Хээрийн судалгаанд тоологдсон айл өрхүүд



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуулын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-I**

Төслийн талбай дотор, талбайн зүүн урд хэсэгт модон байшин, малын төмөр хашаа, морины зүчээ бүхий айл байна. Тухайн айл нь цоожтой байсан санал асуулга авч чадаагүй болно.

*Зураг 71. Төслийн талбай дотор талбайн зүүн урд хэсэгт байрлах айл*



Төслийн талбай дотор компанийн агуулахын баруун хойд талд 2 монгол гэртэй айл зузаж байна. Тухайн айл нь Эзэннайрамдал гэх хүний малчин өрх байна. Малчин өрхийн гэрийн эзэн Батчөдөр, гэргий Ууганцэцэг нар нь 2 хүүхэдтэй. Ойролцоогоор 150 орчим үхэр, 200 орчим адууг маллаж байна.

**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Зураг 72. Петро Матадын агуулахын баруун хойд талын айл*



*Зураг 73. Санал асуулга авч буй явц*



Төслийн талбай дотор талбайн урд хэсэгт Цайдам хэмээх газрын зүүн талд дугуйтай чирдэг контейнер бүхий айл байна. Тухайн айл мөн эзгүй цоожтой байгаа ба харин түүний малчин Баяраа хэмээх хүнтэй малаа усалж буйтай таарч санал асуулга авав. Тухайн айлын эзний гэрийг Өнөржаргал, эзэгтэйг Ариунаа гэх ба тэднийх 400 орчим үхэр, 10 хэдэн азарга адуутай. Өвлийн улиралд гэрээ барьж өвөлждөг<sup>3</sup>.

<sup>3</sup> Малчин Баяраагийн өгсөн санал асуулгаар

Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II

Зураг 74. Контейнер бүхий айл



Тухайн худагас нутгийн иргэд унданд хэрэглэдэггүй зөвхөн мал усалгаанд хэрэглэдэг байна.

Зураг 75. Мал усалгааны худаг,  $116^{\circ} 5' 54.24'' E 46^{\circ} 44' 31.77'' N$



**Петро Матад ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Газрын тосны хайгуул, ашиглалтын Матад ХХ талбайн Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн гүйцэтгэл 2024-II**

*Зураг 76. Малчин иргэнээс санал асуулга авч буй байдал*



Төслийн талбайн гадна талд, талбайн зүүн урд зүгт байрлах мониторингийн 20М-W-03 малчны худгаас усны дээж авч байгаад тухайн худгийн эзэн болох Хүрэлбаатарын Ганзоригтой таарч санал асуулга асав. Ганзориг нь ам бүл 5, эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг. Тухайн өрх маань 25 орчим адуу, 15 үхэр малладаг байна. Тухайн худгийг 61 метрийн гүнээс өрөмдөж гаргасан.

*Зураг 77. Санал асуулгын явц*



